



Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгаа

Судалгааны тайлан



Улаанбаатар, 2022 он

МЭДЭГДЭЛ

Энэхүү судалгааг IRIM судалгааны хүрээлэнгийн баг 2020 оны 4-р сараас 2021 оны 10-р сарын хооронд Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага (ОУШХБ)-ын 2020-2022 оны хугацаанд хэрэгжүүлж буй **“Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх Монгол Улсын хүчин чармайлтыг бэхжүүлэх нь”** төслийн хүрээнд хийж гүйцэтгэлээ.

Уг тайлангийн үр дүн, дүгнэлт нь зөвхөн судалгааны багийн байр суурийг илэрхийлэх бөгөөд ОУШХБ-ын байр суурийг илэрхийлэхгүй болно. Мөн тайланд буй бүхий л тодорхойлолт болон үзүүлэх материал нь аливаа улс орон, газар нутаг, хот суурин болон эдгээрийн удирдлагын эрх зүйн байдал, хил хязгаарын талаарх ОУШХБ-ын үзэл санааг илэрхийлээгүй болно.

Энэхүү тайланг ОУШХБ-аас албан ёсоор хянан засварлаагүй болно.

Нүүр зураг: www.unsplash.com сайтаас авсан болно.

©2022 International Organization for Migration (IOM)

Бүх эрхийг хуулиар хамгаалав. Тайлангийн аль ч хэсгийг зохиогчоос бичгэн байдлаар зөвшөөрөл авалгүйгээр хуулбарлах, хайлтын системд байршуулах, цахимаар дамжуулах, хувилах, бичлэг хийх зэрэг аливаа хэлбэрээр түгээхийг хориглоно.



Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгаа

Судалгааны тайлан



СУДАЛГААНЫ БАГ

Гүнсэнчоймболын Амаржаргал	Багийн ахлагч, IRIM судалгааны хүрээлэнгийн зөвлөх
Нарангийн Болдмаа	Ахлах судлаач, IRIM судалгааны хүрээлэнгийн зөвлөх
Дамдинсүрэнгийн Оюунсүрэн	Ахлах судлаач, IRIM судалгааны хүрээлэнгийн зөвлөх
Дэлгэрсамбуу Мөнхцэцэг	Дата шинжээч, IRIM судалгааны хүрээлэнгийн зөвлөх
Ганзоригийн Жаргалмаа	Зохицуулагч, IRIM судалгааны хүрээлэнгийн төслийн менежер
Жаргалсайханы Жавхлан	Туслах судлаач, IRIM судалгааны хүрээлэнгийн судлаач
Алтанхуягийн Очбадрал	Дата шинжээч, IRIM судалгааны хүрээлэнгийн судлаач

ТАЛАРХАЛ

Энэхүү тайлан нь уншигчдад Монгол Улс дахь ХХГХ-ийн нөхцөл байдал, шалтгаан, иргэдийг ХХГХ-т өртөхөд нөлөөлж буй хүчин зүйлсийн талаар ерөнхий дүр зургийг танилцуулах болно. Тус тайланг боловсруулахын тулд олон талын эх сурвалжийн мэдээлэлд үндэслэсэн бөгөөд тус салбарт хийгдэж байгаагүй тоон шинжилгээг хийхийг зорьсноороо онцлог байлаа.

Судалгааны багийн зүгээс тус судалгааг гүйцэтгэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан дараах байгууллагуудад талархлаа илэрхийлж байна. Үүнд:

- ХЗДХЯ, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба, орон нутгийн салбар зөвлөлүүд,
- Шүүхийн ерөнхий зөвлөл,
- Улсын ерөнхий прокурорын газар,
- Цагдаагийн ерөнхий газар (ЦЕГ),
- Гадаадын иргэн харьяатын газар (ГИХГ),
- Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Эд эрхтэн шилжүүлэн суулгах ажлыг зохицуулах алба
- Хүйсийн тэгш эрхийн төв (ХТЭТ), Талита Ази, Анбаунд Монгол, ЭКПАТ Үндэсний сүлжээ, Иргэдэд туслах хүний эрх төв, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх Монгол Улсын хүчин чармайлтыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд энэхүү судалгааг амжилттай явуулахад шаардлагатай туслалцаа, дэмжлэг үзүүлсэн Нидерланд улсын Засгийн Газарт онцгойлон гүн талархал илэрхийлье. Мөн ялангуяа судалгааны явцад дэмжлэг үзүүлж, хамтран ажилласан ОУШХБ-ын Монгол дахь салбарын хамт олон, ялангуяа энэхүү тайланд өөрийн үнэтэй зөвлөгөө, хувь нэмрээ оруулсан ОУШХБ-ын төслийн менежер Вероника Скаротца (Veronica Scarozza), төслийн ажилтан С.Мөнхчулуун мөн Олон улсын зөвлөх Жон Мартин МакГоган нарт талархлаа.

Үзэл бодол, туршлагаа хуваалцсан нийт судалгаанд оролцогчдод мөн судалгааны багийн зүгээс баярласан талархсанаа илэрхийлж байна.

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	10
СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ	11
ТАНИЛЦУУЛГА	25
Хүн худалдаалах гэмт хэргийн тодорхойлолт.....	25
Судалгааны арга зүй.....	30
Судалгааны түүвэр	31
Судалгааны хамрах хүрээ, хязгаарлагдмал тал	32
НЭГ: ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДЭХЭД НӨЛӨӨЛЖ БҮЙ ЭРСДЭЛТ БОЛОН ХАМГААЛАГЧ ЗҮЙЛС	33
Хэсэг 1: Хувь хүний түвшний эрсдэлт болон хамгаалагч хүчин зүйлс.....	37
Хэсэг 2: Өрхийн түвшний эрсдэлт болон хамгаалагч хүчин зүйлс	43
Хэсэг 3: Олон нийтийн түвшний эрсдэлт болон хамгаалагч хүчин зүйлс	46
Хэсэг 4: Бүтцийн түвшний эрсдэлт болон хамгаалагч хүчин зүйлс	54
4.1 ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх, тэмцэх тогтолцооны түвшний эрсдэлт болон хамгаалагч хүчин зүйлс.....	54
4.2 Нийгэм, эдийн засаг, соёл болон бусад салбарын түвшинд нөлөөлж буй бүтцийн эрсдэлт болон хамгаалагч хүчин зүйлс	65
ХОЁР: ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, УРСГАЛ ЧИГЛЭЛ, ЧИГ ХАНДЛАГА	69
Хэсэг 1: Монгол Улс дахь ХХГХ-ийн төлөв байдал	69
Хэсэг 2: ХХГХ-ийн эмзэг байршил, урсгал чиглэл.....	77
Хэсэг 3: ХХГХ-ийн чиг хандлага, өөрчлөлт	82
ГУРАВ: ХОХИРОГЧ ХАМГААЛАЛ, ХОХИРОГЧИД ШААРДЛАГАТАЙ ДЭМЖЛЭГ ТУСЛАЛЦАА	85
Хэсэг 1: Хохирогчид үзүүлж буй үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдал	87
Хэсэг 2: ХХГХ-ийн хохирогчид шаардлагатай дэмжлэг, туслалцаа.....	89
ДҮГНЭЛТ	91
САНАЛ, ЗӨВЛӨМЖ	96
Ашигласан материалын жагсаалт	104
Нэр томъёоны жагсаалт	107
Хавсралт 1. Ажлын даалгавар	111
Хавсралт 2. Тоон судалгааны хэрэглэгдэхүүн	113
Хавсралт 3. Мэдээлэл цуглуулалтын хамрах хүрээ	130
Хавсралт 4. ХХГХ-т өртөмтгий байдалд нөлөөлөгч хүчин зүйлсийн шинжилгээ	131
Хавсралт 5. Илрүүлэх судалгааны үр дүн (дан тоололт)	134



Зураг, хүснэгт болон шигтгээний жагсаалт

Зураг 1.	ХХГХ-ийг тодорхойлох гурван бүрэлдэхүүн	26
Зураг 2.	ХХГХ-т өртөх эрсдэлийг таних асуултуудын үр дүн (n=423).....	34
Зураг 3.	ХХГХ-ийн хэлбэрүүдэд өртсөн байдлыг таних асуултуудын үр дүн (n=423).....	35
Зураг 4.	ХХГХ-т өртөх эрсдэлийг танихад чиглэсэн болзолт нөхцөлийг зөвшөөрч буй оролцогчид, хүйсээр	35
Зураг 5.	ХХГХ-т өртөмтгий байдлын индексийн хистограмм, (n=423).....	36
Зураг 6.	ХХГХ-т өртөмтгий байдлын хистограмм, хувиар, (n=120)	36
Зураг 7.	ХХГХ-ийн шинжтэй үйлдлүүдэд өртүүлсэн аргууд, хүйсээр, (n=120).....	37
Зураг 8.	ХХГХ-т эмзэг өртөмтгий байдал, насны бүлгээр, (n=120)	37
Зураг 9.	ХХГХ-т өртөх эрсдэлийг танихад чиглэсэн болзолт нөхцөлийг зөвшөөрч буй оролцогчид, харьяа орон нутагтаа бүртгэлтэй эсэхээр	40
Зураг 10.	Шилжилт хөдөлгөөний чиглэл (n=92)	41
Зураг 11.	Шилжилт хөдөлгөөнд орсон зорилго, (n=92)	41
Зураг 12.	Хувь хүний түвшинд ХХГХ-т өртөх эрсдэлд нөлөөлж буй хүчин зүйлс	42
Зураг 13.	ЦЕГ-т бүртгэгдсэн ГБХ-ийн гэмт хэрэг болон зөрчлийн тоо, 2017-2020.....	44
Зураг 14.	Өрхийн онцлог, шинжээс хамаарч ХХГХ-т өртөх байдлыг тайлбарлах хүчин зүйлс .	46
Зураг 15.	Орон нутагт зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэх боломж (n=423).....	49
Зураг 16.	Хувь хүний эмзэг байдалд нөлөөлж буй нийгмийн үйлчилгээ (n=423)	50
Зураг 17.	Орон нутаг дахь хүчирхийлэл, гэмт хэргийн тархалт (n=423), иргэдийн хариултаар.	50
Зураг 18.	Байгалийн гамшиг болон COVID-19 нөхцөл байдал нь иргэдийн амьжиргааг дордуулахад нөлөөлж буй байдал (n=423), иргэдийн хариултаар	52
Зураг 19.	COVID-19 цар тахалтай холбоотой гэр бүлийн амьдралд тулгамдаж буй хүндрэл бэрхшээл (n=423)	52
Зураг 20.	ХХГХ-ийн эрсдэлд нөлөөлж буй олон нийтийн түвшний хүчин зүйлс.....	54
Зураг 21.	Монгол Улс дахь ХХГХ-тэй тэмцэх үндэсний тогтолцооны бүдүүвч	55
Зураг 22.	Судалгааны зорилгоор танилцсан 7 хэргийн шийдвэрлэгдсэн хугацаа	59
Зураг 23.	Шилжин ирэгсдийн урсгал, бүс нутгаар	66
Зураг 24.	Хүн амын боловсролын түвшин, хүйсээр, 2020, хувиар	67
Зураг 25.	Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо (жилээр)	69
Зураг 26.	ХТЭТ-д хандаж тусламж дэмжлэг авсан үйлчлүүлэгчдийн тоо	70
Зураг 27.	ХХГХ болон бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн хохирогч, холбогдогчийн тоо, 2018-2020/06	70
Зураг 28.	Бэлгийн мөлжлөгийн хохирогчдын ерөнхий профайл (n=131)	71
Зураг 29.	Хөдөлмөр мөлжлөгийн хохирогчдын ерөнхий профайл	74
Зураг 30.	Дотоодод бүртгэгдсэн ХХГХ-ийн хохирогчдын харьяа орон нутаг, байршлууд.....	79

Зураг 31.	Монгол Улсын иргэд ХХГХ-т өртсөн улс орнууд, ХХГХ-ийн төрлөөр	80
Зураг 32.	2018-2020 онд ХХГХ-ийн хохирогч эгүүлэн татсан улс орнууд	81
Зураг 33.	ХХГХ-т насанд хүрээгүй хүүхэд өртсөн байдал, 2018-2020	83
Зураг 34.	Судалгааны зорилтот байршлууд.....	130
Хүснэгт 1.	Судалгааны арга зүйн тойм	12
Хүснэгт 2.	ХХГХ-ийн тодорхойлолт, Палермогийн протокол ба Эрүүгийн хуулийн харьцуулалт.....	27
Хүснэгт 3.	Эрүүгийн хуульд заасан зүйл заалтуудад оногдуулсан эрүүгийн хариуцлагын харьцуулалт, хүндрүүлэх нөхцөл байдал	28
Хүснэгт 4.	Түүврийн хэмжээ, оролцогч талуудаар	31
Хүснэгт 5.	ХХГХ-т өртөмтгий байдлын индекс (НТИ) тооцсон шалгуур үзүүлэлт.....	33
Хүснэгт 6.	Олон нийтийн түвшин дэх ХХГХ-т өртөх эмзэг байдлыг нэмэгдүүлж буй хүчин зүйлс, вариацийн шинжилгээний үр дүн, ач холбогдлын түвшингээр.....	47
Хүснэгт 7.	ХХГХ-ийн гаралт дахь COVID-19 цар тахлын нөлөө, оролцогч талуудын хариултаар.....	53
Хүснэгт 8.	Монгол Улсын Нийгмийн халамжийн үзүүлэлтүүд, оноор	68
Хүснэгт 9.	ХХГХ-ийн илгээгч болон хүлээн авагч улс орнууд	77
Хүснэгт 10.	Монгол Улсын иргэд худалдаалагдсан улс орнууд.....	80
Хүснэгт 11.	2018-2020/09 хооронд эгүүлэн татсан ХХГХ-ийн хохирогчдын тоо	80
Хүснэгт 12.	Гадаад иргэд Монголд эрхэлж буй нийтлэг ажлын байр.....	81
Хүснэгт 13.	Хохирогчийг тодорхойлсон тодорхойлолтууд.....	85
Хүснэгт 14.	ТББ-ын хохирогчид үзүүлж буй үйлчилгээнүүд.....	88
Хүснэгт 15.	Хохирогчид шаардлагатай тусламж, үйлчилгээ.....	90
Хүснэгт 16.	Хүвь хүний түвшинд нөлөөлөгч хүчин зүйлсийн шинжилгээ	131
Хүснэгт 17.	ХХГХ-т өртөмтгий байдалд нөлөөлөгч өрхийн онцлог, хүчин зүйлсийн шинжилгээ.....	132
Хүснэгт 18.	ХХГХ-т өртөмтгий байдалд олон нийтийн түвшинд нөлөөлөгч хүчин зүйлс	133
Хүснэгт 19.	ХХГХ-т өртөх эрсдлийг таних асуултуудын үр дүн.....	134
Хүснэгт 20.	ХХГХ-ийн эрсдлийг таних шууд чиглэсэн асуултуудын үр дүн	135

Шигтгээ 1. Гэр бүлийн таарамжгүй харилцаанаас үүдсэн сэтгэл зүйн тогтворгүй байдал нь эрсдэлтэй шийдвэр гаргахад нөлөөлсөн талаар.....	39
Шигтгээ 2. Биеэ үнэлэгч эмэгтэйчүүд ХХГХ-ийн хохирогч болж буй талаар.....	39
Шигтгээ 3. Гэр бүлийн таагүй харилцаа нь эрсдэлтэй алхам хийхэд нөлөөлсөн талаар.....	43
Шигтгээ 4. Олон нийтийн түвшинд иргэдийн ХХГХ-т өртөх эрсдэлийг нэмэгдүүлж буй хүчин зүйлсийн талаар.....	48
Шигтгээ 5. Амьдарч буй орон нутагт нь хөдөлмөр эрхлэх боломж хязгаарлагдмал байх нь иргэдийн хөдөлмөрийн эрсдэлтэй сонголт хийхэд нөлөөлж буй талаар.....	49
Шигтгээ 6. Орон нутаг дахь эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийн талаар.....	50
Шигтгээ 7. ГБХ нь ХХГХ-ийн эрсдэлийг нэмэгдүүлж буй талаар.....	51
Шигтгээ 8. Хил хаагдсан нь дотоодод бэлгийн мөлжлөгийн хэргийг нэмэгдүүлж буй талаар.....	53
Шигтгээ 9. Төрийн албан хаагчдад чиглэсэн чадавх бэхжүүлэх сургалтын хэрэгцээний талаар.....	58
Шигтгээ 10. Салбар хоорондын байгууллагууд дунд мэдээллийн урсгал дутмаг байгаа талаар.....	61
Шигтгээ 11. Мэдээллийн ил тод байдал, мэдээллээ түгээх, хуваалцах зохион байгуулалт дутмаг байгаа талаар.....	62
Шигтгээ 12. Өндөр цалин хөлс амлах замаар хохирогчийг хууран мэхэлж элсүүлсэн талаар.....	71
Шигтгээ 13. Бэлгийн мөлжлөгийн хэрэгт эрэгтэй хүүхэд өртсөн талаар.....	72
Шигтгээ 14. ХХГХ үйлдсэн бүлэг этгээтүүдийн талаар.....	73
Шигтгээ 15. Гадаад улсын иргэд Монголд ХХГХ-ийн хохирогч болж буй талаар.....	75
Шигтгээ 16. Эс эд эрхтэний наймаанаас урьдчилан сэргийлэх зорилгоор Донорын тухай хуульд тусгагдсан заалтын талаар.....	76
Шигтгээ 17. Эд эрхтэний наймааны нөхцөл байдлын талаар.....	76
Шигтгээ 18. Дотооддоо бэлгийн мөлжлөгийн хохирогч болсон эмэгтэйн кейс.....	77
Шигтгээ 19. Гадаад улсын иргэд бичиг баримтын зөрчлийн асуудал нь ХХГХ-т өртүүлэх эмзэг байдлыг нэмэгдүүлж буй талаар.....	82
Шигтгээ 20. Цахим хуудсуудыг ХХГХ-ийн хохирогчийг элсүүхэд ашиглаж буй талаар.....	84

Товчилсон үгийн тайлбар

АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар
ГИХГ	Гадаадын иргэн харьяатын газар
ГХУСАЗЗАА	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын алба
ГХЯ	Гадаад харилцааны яам
ИНБ	Иргэний нийгмийн байгууллага
COVID-19	Корона вируст халдвар (Ковид-19)
ОУБ	Олон улсын байгууллага
ОУХБ	Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага
ОУШХБ	Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага
ОХУ	Оросын Холбооны Улс
ТББ	Төрийн бус байгууллага
УЕПГ	Улсын ерөнхий прокурорын газар
ФБЯ	Фокус бүлгийн ярилцлага
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
ХБЯ	Хагас бүтэцлэгдсэн ярилцлага
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХТЭТ	Хүйсийн тэгш эрх төв
ХЭҮТ	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
ХХГХ	Хүн худалдаалах гэмт хэрэг
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ШХА	Швейцарын хөгжлийн агентлаг
ЭЗХАХБ	Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭЦА	Эрүүгийн цагдаагийн алба
DoVM	Determinants of Vulnerability Model /Эмзэг байдлыг тодорхойлох загвар/

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Энэхүү суурь судалгааг Олон Улсын Шилжилт Хөдөлгөөний Байгууллага (ОУШХБ)-ын 2020-2022 оны хооронд хэрэгжүүлж буй **“Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх Монгол Улсын хүчин чармайлтыг бэхжүүлэх нь”** төслийн хүрээнд IRIM судалгааны хүрээлэн 2020 оны 4-р сараас 2021 оны 10-р сарын хооронд хийж гүйцэтгэлээ. Энэхүү судалгаагаар Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт хэрэг (ХХГХ)-ийн шалтгаан, өнөөгийн байдлыг судалж, Монголчуудын ХХГХ-т өртөх эмзэг байдалд нөлөөлж буй эрсдэлт болон хамгаалагч хүчин зүйлсийг тодорхойлохыг зорьсон бөгөөд дараах зорилтуудын хүрээнд судалгааг гүйцэтгэсэн болно. Үүнд¹:

- **Зорилт 1.** ОУШХБ-ын **“Эмзэг байдлыг тодорхойлох загвар (DoMV)”**²-ыг ашиглан Монгол Улсын иргэдийн ХХГХ-т өртөх эмзэг болон тэсвэртэй байдлыг үүсгэж буй эрсдэлт болон хамгаалагч хүчин зүйлсийг судлах;
- **Зорилт 2.** Монгол Улс дотоодод болон Монгол Улсаас гадагшаа чиглэсэн ХХГХ-ийн чиглэл, чиг хандлага, хэв шинжийг тодорхойлох;
- **Зорилт 3.** Монгол Улс дотоодод болон хилийн чанадад ХХГХ-ийн хохирогч болсон иргэдэд шаардлагатай дэмжлэг туслалцааг тодорхойлох, ялангуяа эмэгтэй хохирогч, хүүхэд зэрэг эмзэг бүлгийн иргэдийн тусгай хэрэгцээг судлах;
- **Зорилт 4.** Гаднын болон дотоодын албадан хөдөлмөр эрхлүүлэх, бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэхэд үр дүнтэй байж болох тэргүүлэх бодлого, хөтөлбөрийн үйл ажиллагааг тодорхойлох.

Дээрх зорилтуудын хүрээнд уг судалгааг гүйцэтгэхдээ Монгол Улс дотоодод үйлдэгдэж буй болон хилийн чанадад тэвэрлэгдэн ХХГХ-ийн хохирогч болсон иргэдийн мэдээлэлд тулгуурласан. Үүнээс гадна Монгол Улсад ХХГХ-ийн хохирогч болж буй гадаадын иргэдийн нөхцөл байдлыг тоймлон судалсан болно.

Суурь судалгааг хийхдээ ХХГХ-ийн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тодорхойлолт болох Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцын нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколын тодорхойлолтыг баримтлав.³

Судалгааны өгөгдөл цуглуулах ажлыг Дархан-Уул, Дорнод, Өмнөговь аймаг болон Улаанбаатар хотын Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэгт явуулсан. ХХГХ-тэй тэмцэх үндэсний тогтолцооны оролцогч талууд болон уг гэмт хэрэгт өртөх эрсдэлтэй иргэдээс тоон болон чанарын аргыг хослуулан өгөгдөл цуглуулсан. Доор дурдсан түүврээс өгөгдөл цуглуулах ажлыг 2020 оны 6-р сард зохион байгуулсан. Үүнд:

¹ Судалгааны багт өгөгдсөн ажлын даалгавартай Хавсралт 1-ээс танилцана уу.

² “Эмзэг байдлыг тодорхойлох загвар” нь хүчирхийлэл, дарамт, хөдөлмөрийн мөлжлөгт өртөх эрсдэлтэй, өртсөн иргэдийг тодорхойлох, хамгаалах, туслах, тэдгээр иргэдийн эмзэг байдлыг бууруулахад чиглэсэн интервенц боловсруулж, хэрэгжүүлэхэд чиглэсэн загвар юм. Тус загварт хувь хүний хүчин зүйлс, гэр бүлийн хүчин зүйлс, олон нийтийн хүчин зүйлс болон нийгмийн бүтцийн хүчин зүйлс зэрэг дөрвөн хэмжигдэхүүн дээр үндэслэн эрсдэлт хүчин зүйлс (эмзэг байдалд нөлөөлдөг) болон хамгаалах хүчин зүйлс (хор хөнөөлөөс зайлсхийх, даван туулах буюу хэвийн байдалдаа эргэн орох чадварыг сайжруулдаг)-ийг авч үздэг бөгөөд тэдгээрийн хоорондын харилцан хамаарлыг мөн авч үздэг. Илүү дэлгэрэнгүйг *IOM Handbook on Protection and Assistance for Migrants Vulnerable to Violence, Exploitation and Abuse*, (Geneva, 2019), p. 5-8. –аас үзнэ үү.

³ Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцийн нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол, Нью Йорк, 2000 оны 11 -р сар

Хүснэгт 1. Судалгааны арга зүйн тойм

Судалгаанд оролцогчид	Мэдээлэл цуглуулсан арга, түүврийн хэмжээ
<ul style="list-style-type: none"> Төрийн албан хаагчид (Шүүх, Прокурор, Цагдаа, ГИХГ, Хилийн шалган нэвтрүүлэх алба) Үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд (ТББ, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвүүд) Эрсдэлт бүлгийн иргэд (Биеэ үнэлэгч, гадаадын иргэд, асуумжийн дагуу эрсдэлтэй болох нь илэрсэн бусад иргэд) 	<ul style="list-style-type: none"> Хагас бүтэцлэгдсэн ярилцлага (n=29) Ганцаарчилсан ярилцлага (n=13) Фокус бүлгийн ярилцлага (n=6) Шүүхээр шийдвэрлэгдсэн хавтаст хэргийн материал (n=7) Эрсдэлт бүлгийн иргэдээс авсан асуумж (n=423)

ХХГХ-т өртөмтгий болон тэсвэртэй байдлыг үүсгэж буй эрсдэлт ба хамгаалагч хүчин зүйлсийг судлахын тулд ОУШХБ-ын “Эмзэг байдлыг тодорхойлох загвар” (DoMV)-ыг ашигласан. DoMV загварын дагуу хувь хүн, гэр бүл, олон нийт, бүтцийн гэсэн дөрвөн өөр түвшинд эрсдэлт ба хамгаалагч хүчин зүйлсийг шинжиллээ.

Тоон өгөгдлийг хоёр үе шаттайгаар цуглуулсан. Нэгдүгээр шатанд, ХХГХ-ийн төрөл хэлбэрт өртөх эрсдэлт бүлгийн⁴ 467 иргэдийн эрсдэлийг тодорхойлох судалгаа зохион байгуулснаас 423 (91 хувь) нь эрх зүйн баримтад үндэслэн⁵ боловсруулсан эмзэг байдлын шалгуурыг хангасан тул эрсдэлтэй иргэд хэмээн тодорхойлсон. Хоёрдугаар шатанд хувь хүмүүсийн эмзэг байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг DoMV загварын дагуу үнэлж, олон хувьсагчийн регрессийн загвар ба хүчин зүйлийн шинжилгээ (ANOVA)-нд үндэслэн эконометрик шинжилгээ хийв.

Судалгаанд оролцогчдын ХХГХ-т өртөмтгий байдлын түвшинг тооцоолохын тулд судалгааны баг ХХГХ-т өртөмтгий байдлын индексийг (НТИ) боловсруулсан. Уг индексийн дундаж үзүүлэлт 0.10⁶ гарсан нь судалгаанд хамрагдсан оролцогчдын ХХГХ-т өртөх эмзэг байдал өндөр байгааг харуулж байв. Түүнчлэн эрсдэлт бүлгийн иргэдийн 28.4 хувь (дөрвөн хүн тутмын нэг) нь хүн ХХГХ-ийн эрсдэлтэй элементэд⁷ наад зах нь нэг удаа өртсөн байх магадлалтай байна.

DoMV загварын дагуу гүйцэтгэсэн шинжилгээний үр дүнд үндэслэн дараах хэсэгт Монгол Улсад ХХГХ-т өртөх эрсдэлтэй хүмүүсийн ерөнхий хэв шинжийг тодорхойлов.

Монгол Улсад ямар хүмүүс ХХГХ-т өртөх эрсдэлтэй байдаг вэ?

Тогтмол бус орлоготой эсвэл шилжиж очсон газартаа бүртгэлгүй, улирлын чанартай цагийн ажил эрхэлдэг оюутнууд, ажил хайж байгаа хүмүүс зэрэг 18-30 насны эрэгтэй болон эмэгтэй хүмүүс (Цагдаагийн ерөнхий газарт бүртгэгдсэн ХХГХ-ийн хохирогчдын профайлыг авч үзвэл 14 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүд өндөр эрсдэлтэй байгаа хэдий ч судалгааны хязгаарлагдмал⁸ байдлаас

⁴ Баримт бичгийн судалгааны үр дүнгээр ХХГХ-т өртөмтгий зорилтот бүлгийн иргэдийг (зорилтот түүврийн аргаар) аймаг, дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн дэмжлэгтэйгээр судалгаанд хамруулсан. Үүнд: биеэ үнэлэгчид, бүртгэлгүй шилжин ирэгсэд, ажилгүй болон бичиг баримтгүй иргэд, өрх толгойлсон эцэг эхчүүд, амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой өрхүүд, хүчирхийллийн хохирогч болж байсан зэрэг бүлгийн иргэдийг хамруулав.

⁵ Илрүүлэх судалгаанд ХХГХ-ийн төрлүүдэд өртсөн болон өртөх эрсдэлтэй иргэдийг таних 25 асуулт бүхий асуумж ашигласан. Эрсдэлт түвшний иргэнийг тодорхойлох шалгуурыг тогтоохдоо (1) өртсөн иргэдийг тодорхойлох 7 асуултын нэгд нь “тийм” гэж хариулсан бол, (2) өртөх эрсдэлтэй иргэдийг таних 18 асуултын гурваас дээш асуултад “тийм” гэж хариулсан бол тухайн оролцогчийг эрсдэлтэйд тооцсон. Илрүүлэх асуумж болон илрүүлэх шалгуурыг тодорхойлохдоо “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” (MNS 6418:2013) стандартын Хавсралт 1-ээр батлагдсан ХХГХ-ийн хохирогчийг тодорхойлох жишиг маяг болон ХЗДХЯ-аас баталсан хүн худалдаалах хэргийн эрсдэлийг таних 9 асуултад үндэслэсэн. Илрүүлэх судалгааны хэрэглэгдэхүүнтэй Хавсралт 2-оос танилцах боломжтой.

⁶ Индекс тооцооллыг 0-1 хүртэлх утгаар хэмжсэн ба, 0 рүү дөхөх тусам эмзэг байдал өндөр, 1 рүү дөхөх тусам эмзэг байдал буурах буюу ХХГХ-т тэсвэртэй байх нөхцөлөөр үнэлсэн.

⁷ ХХГХ-т өртөмтгий байдлын индекс (НТИ)-ийг Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуульд заасан ХХГХ-ийн тодорхойлолтод үндэслэн боловсруулсан. Хуулийн тодорхойлолтод зуааснаар дараах элементүүд/аргуудаар хэргийг үйлдсэн эсэхийг ХХГХ-ийг тодорхойлох нэг бүрэлдэхүүн гэж үздэг. Үүнд: 1) Хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах (2) Залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, (3) Өөр хүнийг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, хахуульдах аргаар хүнийг элсүүлэх, тээвэрлэх, нуун далдлах, дамжуулах, хүлээн авах.

⁸ Дэлгэрэнгүй тайлбарыг энэхүү тайлангийн 34-р хуудас дахь “Судалгааны хамрах хүрээ, хязгаарлагдмал тал” хэсгээс харна уу.

шалтгаалан уг судалгаанд 18-аас доош насны иргэдийг хамруулаагүй болно) ХХГХ-т өртөх эрсдэлтэй байна. Эрсдэлтэй хүмүүс ихэвчлэн амьдралынхаа туршид бие махбодын болон сэтгэл зүйн хүндрэл, бэрхшээлтэй асуудалтай тулгарч байсан, гэр бүл салсан эсвэл ганц бие хүмүүс байна.

ХХГХ-т өртөх эрсдэлтэй эдгээр хүмүүс ихэвчлэн гэр бүлийн хүчирхийллийн гэрч буюу хохирогч болж байсан өгүүлэмжтэй байх бөгөөд өрхийн аль нэг гишүүн нь удаан хугацаагаар ажил хийх, суралцах зорилгоор шилжин суурьшсан байх тохиолдол түгээмэл. Тэдний ихэнх нь орлого бага, санхүүгийн чадавх сул гэр бүлээс гаралтай байх боловч санхүүгийн чадавх сайтай гэр бүлд төрж өссөн хэдий ч гэр бүлийн хүчирхийлэлтэй байх, нийгэм хамт олны нэгдмэл байдал бага мэдэрдэг байх, эдийн засгийн боломж, баталгааг мэдрэхгүй байх зэрэг бусад гэр бүлийн болон бүтцийн хүчин зүйлээс үүдэн эмзэг байдал нь нэмэгдэж байна.

Түүнчлэн эдгээр хүмүүс нь бусдын зүгээс өөрсдийг нь хөгжлийн бэрхшээлтэй, эсвэл боловсролын түвшин доогуур, нийгмийн доод давхаргаас гаралтай гэж ханддаг орон нутаг, олон нийтийн дунд амьдардаг. Амьдарч буй орон нутагт нь удаан хугацаанд хөдөлмөр эрхлээгүй эсвэл орлого багатай иргэдэд амьжиргаагаа дээшлүүлэх эдийн засгийн боломж хомс байдаг тул бусад газар руу шилжин суурьшихаас аргагүйд хүрдэг бөгөөд албан ёсоор харьяа орон нутагтаа бүртгүүлээгүй байх, эсвэл үйлчилгээний хүртээмж хангалтгүй байдгаас нийгмийн суурь үйлчилгээг авахад бэрхшээлтэй тулгардаг. Ихэнх хүмүүс Монголын нийгэмд гэр бүлийн хүчирхийлэл ноцтой асуудал болсныг хүлээн зөвшөөрдөг хэдий ч олон нийтийн дунд бэлгийн мөлжлөг болон ХХГХ-ийн талаар ойлголт маш бага эсвэл огт ойлголтгүй байна.

COVID-19 нь хувь хүн, гэр бүлийн түвшинд иргэдийн амьжиргааг доройтуулснаар, цар тахлын өмнөх үед ч байсан ХХГХ-ийн өртөмтгий байдлыг нэмэгдүүлж байсан эмзэг байдлын хүчин зүйлсийг улам гүнзгийрүүлж байна. Эдгээр хүчин зүйлст иргэдийн орлого багасах болон ажлын байрны олдоц буурах, сэтгэл зүйн стресс нэмэгдэх, нийгмийн сүлжээний хэрэглээ өсөх зэрэг хүчин зүйлүүд багтах ба цагдаагийн байгууллагын мэдээлснээр ХХГХ-ийн хохирогчдыг цахимаар дамжуулан элсүүлэхтэй тэмцэх сорилтыг бий болгож байна.

ОЛОН ТАЛТ ТҮВШИНД ГАРЧ БУЙ САЛБАР ДУНДЫН НИЙТЛЭГ АСУУДАЛТАЙ ХОЛБООТОЙ СУДАЛГААНЫ ГОЛ ҮР ДҮН, ЕРӨНХИЙ ЗӨВЛӨМЖҮҮД

Энэхүү судалгаа нь DoMV загварын дагуу Монгол Улс дахь ХХГХ-т өртөх эмзэг болон тэсвэртэй байдлыг тодорхойлох аргачлалд суурилсан бөгөөд тоон судалгааны үр дүнг баримт бичгийн шинжилгээ болон чанарын өгөгдлөөр баталгаажуулсан болно. Энэхүү холимог аргачлалын үр дүнд судалгааны явцад нийтлэг шинжтэй хэд хэдэн гол асуудлууд байгаа нь харагдсан бөгөөд Монгол Улсад ХХГХ-тэй холбоотой нэн тэргүүнд шийдвэрлэх ёстой, хамгийн тулгамдсан асуудлуудыг долоон үндсэн үр дүнд тоймлон харууллаа. Дараагийн бүлэгт ХХГХ-тэй тэмцэх засгийн газрын үйл ажиллагаанд анхааралдаа авч үзэх судалгааны гол үр дүнгүүд болон холбогдох зөвлөмжийг тусгалаа.

Эдгээр үр дүнг судалгааны тайланд нарийвчлан шинжилж, тайлбарласан байх ба үр дүн тус бүрийн дагуу авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны нарийвчилсан саналыг тайлангийн Санал зөвлөмж хэсэгт тусгасан болно.

Үр дүн 1: Хөдөлмөрийн мөлжлөг нь Монгол Улсад улам нэмэгдэж буй чиг хандлага болж байгаа боловч хууль эрх зүйн хязгаарлагдмал байдал, тогтолцооны түвшинд энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, тэмцэх үйл ажиллагаа дутмаг байгаагаас хөдөлмөр мөлжлөгийн хэрэг нь илэрч, зохих ёсоор хуулийн дагуу шийдвэрлэгдэхгүй байна.

Энэхүү судалгаагаар Монголчуудын хөдөлмөр мөлжлөгийн гэмт хэрэгт өртөмтгий байдал өндөр байгаа нь тогтоогдсон. ХХГХ-т өртөх эрсдэлтэй болох нь тогтоогдсон 423 хүний шинжилгээний дүнгээс

үзэхэд **хоёр хүн тутмын нэг⁹ нь өмнө нь хөдөлмөрийн мөлжлөгт өртсөн байх шинжтэй** байна. Судалгааны өгөгдлөөс үзэхэд судалгаанд оролцогчдын 60 хувь нь өмнө нь ямар нэгэн хөдөлмөрийн болон бусад хэлбэрийн гэрээ байгуулалгүй ажиллаж байсан, 86 хувийнх нь бичиг баримтыг ажил олгогч нь хурааж авч байсан, 43 хувь нь нэмэлт цалин хөлсгүйгээр илүү цагаар ажиллаж байсан, 36 хувь нь анх тохирсон цалингаа авч чадаагүй буюу ажил олгогч нь үндэслэлгүйгээр цалин хөлсийг нь бууруулж байсан байна. Цаашилбал, судалгаанаас үзэхэд хувь хүмүүс санхүүгийн нөхцөл байдлаа сайжруулахын тулд эрсдэлтэй алхам хийх зан үйл өндөр байсан ба тодруулбал судалгаанд оролцогчдын 72 хувь (n=305) өндөр цалинтай ажилд зуучлах, 43 хувь (n=182) гадаадад зорчиход нь туслах санал тавибал эргэлзэлгүй зөвшөөрнө гэж хариулснаас харагдаж байв. Эндээс үзэхэд санхүүгийн эмзэг байдал, түүнээс үүдэлтэй ядуурал нь иргэдийг гэмт хэрэгтнүүдийн гарт орох эмзэг байдлыг нэмэгдүүлж буй гол хүчин зүйл болж байна.

Энэхүү дүгнэлтийг Монгол Улс дахь ХХГХ-ийн хохирогчдод үйлчилгээ үзүүлдэг гол байгууллагуудын нэг болох Хүйсийн тэгш эрхийн төвөөс гаргасан тоо баримт давхар нотолж байгаа юм. 2003-2018 оны хооронд тус төвөөр үйлчлүүлсэн нийт иргэдийн 22 хувь нь хөдөлмөр мөлжлөгийн хохирогчид байна. Баримт бичгийн судалгаагаар Монголчууд хилийн чанадад хөдөө аж ахуй, аж үйлдвэр, урлагийн салбаруудад голлон хөдөлмөр мөлжлөгийн хохирогч болох эрсдэл өндөр байгааг онцолсон. Харин Монгол Улсад байгаа гадаадын иргэдийн хувьд ялангуяа албан ёсны бүртгэлгүй, байнгын бус статустай иргэд хөдөө аж ахуй, барилга, гар үйлдвэрлэл болон ойн аж ахуй, машин засвар, уул уурхай зэрэг салбарт хөдөлмөрийн мөлжлөгт өртөх эрсдэлтэй байна. Тухайлбал, Филиппин, Вьетнам, Мьянмар Улсын иргэд Монгол Улсад гэрийн үйлчлэгч, авто үйлчилгээ, саун, массажны газарт ирж ажилладаг нь судалгаанд оролцогчдын ярианд дурдагдаж байсан. Зарим тохиолдолд тэдгээр иргэд бие махбодын хүчирхийлэл, дарамт шахалтад өртдөг бөгөөд цалин хөлсийг нь өгөхгүй байх, эсвэл бичиг баримтын зөрчилтэй иргэдийг Гадаадын Иргэн Харьяатын Газар (ГИХГ)-т мэдэгдэнэ гэх сүрдүүлэгт өртдөг байна¹⁰. Хөдөлмөр мөлжлөгийн гэмт хэрэг нь салбар бүрд харилцан адилгүй хэв маягаар үйлдэгдэж байгаа боловч мэдээллийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан эдгээр хэв маягийг бүрэн тодорхойлох боломж хязгаарлагдмал хэвээр байна.

Энэхүү судалгаагаар хөдөлмөр мөлжлөгийн гэмт хэргийн эмзэг өртөмтгий байдал газар авч байгаа нь тодорхой болсон төдийгүй ХТЭТ-өөс туслалцаа авсан хүмүүсийн дунд хөдөлмөр мөлжлөгийн гэмт хэрэгт өртсөн тохиолдлууд бүртгэгдсэн боловч Монгол Улсын Эрүүгийн хуулийн 13.1 (хүн худалдаалах гэмт хэрэг)-р зүйлийн дагуу 2018-2020 онд цагдаагийн байгууллагаас илрүүлсэн ХХГХ-ийн 131 хохирогчийн дотор хөдөлмөр мөлжлөгтэй холбоотой тохиолдол байхгүй байна. Эрүүгийн хуулийн 13.13-т албадан хөдөлмөрийг бие даасан гэмт хэрэгт тооцохоор заасан. Тоо баримтаас харахад Эрүүгийн хуулийн 13.13-р зүйлд заасан хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны түвшин доогуур байгаа бөгөөд цагдаагийн байгууллагад 2018 онд албадан хөдөлмөр эрхлэлтийн ганцхан тохиолдол бүртгэгдсэн бол 2019 онд хоёр, 2020 онд нэг л тохиолдол бүртгэгдсэн байна. Өнөөдрийг хүртэл эдгээр хэргээс нэг нь ч шүүхээр шийдэгдээгүй байна. Эдгээр тоо баримт нь Монгол Улсад албадан хөдөлмөр мөлжлөг болон албадан хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэргийг мөрдөн шалгах, хэргийг хянан шийдвэрлэх чадавх хязгаарлагдмал байгааг харуулж байна.

Хууль эрх зүйн өнөөгийн хязгаарлагдмал байдал нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны түвшин доогуур байгаад нөлөөлж байж болзошгүй юм. Тухайлбал, Монголын Өмгөөлөгчдийн холбооны тэмдэглэснээр Эрүүгийн хуулийн 13.13-р зүйлд албадан хөдөлмөрийг тодорхойлохдоо "...эрхшээлдээ оруулж, цалин хөлсгүй хөдөлмөр эрхлүүлсэн" гэж тодорхойлсон байдаг нь ажилчдыг бусад төрлийн албадлага, хүчирхийлэл, эрүүл мэндэд хохирол учруулах нөхцөл байдалд, бага цалин хөлсөөр эсвэл цалин хөлсийг нь бууруулан ажиллуулсан хэргийг хамааруулан авч үзэх боломжгүйгээр тодорхойлсон

⁹ Асуумжийг "ХХГХ-ийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага" (MNS 6418:2013) стандартын ХХГХ-ийн хохирогчийг тодорхойлох жишиг маягт болон ХЗДХЯ-наас баталсан ХХГХ-ийн эрсдэлийг таних 9 асуултад үндэслэж боловсруулав.

¹⁰ 2020 оны 6 -р сарын 22-нд ГИХГ-ын төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас.

байгааг дурджээ.

2021 оны байдлаар улсын хэмжээнд ердөө 87 хөдөлмөрийн байцаагч байгаа бөгөөд Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт зургаа, нийслэлд 35, үлдсэн нь аймаг орон нутагт ажиллаж байна. Бодит байдал дээр цогц хяналт шалгалт хийхэд хүний нөөцийн хувьд энэ нь хангалтгүй тоо юм. Мөн албадан хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэргийг хянаж шалгах байцаагчдад зориулсан сургалт дутмаг байна. Тухайлбал, 2018-2021 оны хугацаанд хөдөлмөрийн байцаагч нарт чиглэсэн ХХГХ-тэй тэмцэх арга хэмжээний талаар ганцхан удаа сургалт зохион байгуулсан байна¹¹.

Одоогийн байдлаар хөдөлмөрийн байцаагчид Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу гэнэтийн хяналт шалгалт хийх эрхгүй байна. Хуулийн дагуу аливаа байгууллагад хөдөлмөрийн хяналт шалгалт хийхээс тав хоногийн өмнө зайлшгүй бичгээр урьдчилан мэдэгдэх ёстой байдаг нь байгууллагуудад аливаа зөрчлөө нуун дарагдуулах боломжийг олгож байж болзошгүй юм¹². Уг судалгааг гүйцэтгэж байх хугацаанд Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах ажил үргэлжилж байсан ба уг нэмэлт өөрчлөлтөд хөдөлмөрийн байцаагчдын гэнэтийн хяналт шалгалт хийх эрхтэй холбоотой зохицуулалт туссан талаар холбогдох мэргэжилтнүүд мэдээлсэн.

Зөвлөмж: Хөдөлмөр мөлжлөгийн талаарх иргэдийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, шүүх болон хөдөлмөрийн хяналтын байгууллагуудын чадавхыг бэхжүүлэх замаар хөдөлмөр мөлжлөгийн гэмт хэргийг илрүүлэх, хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг сайжруулах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэхтэй холбоотой санал болгож буй үйл ажиллагаа:

Богино хугацааны зөвлөмж:

1. Салбар тус бүр дэх хөдөлмөр мөлжлөгийн чиг хандлага, хэв маягийг тодорхойлохын тулд нарийвчилсан судалгаа хийх.
2. Хөдөлмөр мөлжлөгийн гэмт хэргийг мөрдөн шалгах, хэрэг хянан шийдвэрлэх, ял шийтгэл онооход тулгарч буй хүндрэл бэрхшээлийг олж тогтоох эрх зүйн дүн шинжилгээ хийх, мөрдөн байцаах, хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг зохион байгуулахтай холбоотой стратеги удирдамж, зааварчилгаа боловсруулах.
3. Нотолгоонд суурилсан мөрдөн байцаалтын стратегид тулгуурласан хөдөлмөр мөлжлөгийн хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах чиглэлээр хууль сахиулах байгууллагуудыг чадавхжуулах үйл ажиллагаа явуулах.
4. Прокурор болон шүүхийн стратегийг харгалзан хөдөлмөр мөлжлөгийн гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх асуудлаар прокурор, шүүгчдийг чадавхжуулах үйл ажиллагаа явуулах.
5. Ажлын орчинд ХХГХ-ийн эрсдлээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх зорилгоор хөдөлмөрийн байцаагч, цагаачлалын албаны гэнэтийн хяналт шалгалт хийх чадавхыг бэхжүүлэх үйл ажиллагаа явуулах.
6. Хөдөлмөр мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэргийн талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх кампанит ажил зохион байгуулах.

Дунд болон урт хугацаанд зөвлөмж:

7. Хөдөлмөр мөлжлөгийн хэргийг илрүүлэх чиглэлээр ГИХГ, Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газар, ЦЕГ, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар хоорондын хамтын ажиллагааг сайжруулах, бэхжүүлэх.

¹¹ 2021 онд Улаанбаатар хот болон аймгуудын 112 хөдөлмөрийн байцаагч, хөдөлмөрийн эрүүл ахуйн байцаагчдыг "ХХГХ, албадан хөдөлмөр, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай сургалт"-д хамруулсан.

¹² АНУ-ын Төрийн департаментын 2020 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тайлан

8. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5.9-д заасны дагуу аж ахуйн нэгж, байгууллагын ажилчдыг албадан хөдөлмөрлүүлэх буюу албадан хөдөлмөрт, боолчлол болон түүнтэй адилтгах нөхцөлд байлгаж байгаа эсэхэд Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар бүрэн эрхийнхээ хүрээнд хяналт тавин ажиллах боломжийг хангах.
9. Хөдөлмөрийн гэнэтийн хяналт шалгалтыг явуулах боломжийг хангахын тулд холбогдох журамд өөрчлөлт оруулах.
10. Хууль эрх зүйн баримт бичгүүдэд туссан албадан хөдөлмөр/хөдөлмөрийн мөлжлөгийн тодорхойлолтыг хянаж эргэлзээтэй, буруу ойлголт төрүүлэхүйц агуулгыг залруулах.

Үр дүн 2: Монгол Улсад эрэгтэй, эмэгтэй аль аль хүйсийн иргэд ХХГХ-т өртөж байна.

ЦЕГ-ын албан ёсны бүртгэл, мэдээллээс үзэхэд Монгол Улсад ХХГХ-ийн хохирогчоор тогтоогдсон хүмүүсийн дийлэнх нь эмэгтэйчүүд байдаг. Гэвч уг судалгаагаар ХХГХ-ийн дийлэнх хувийг эмэгтэй хохирогчид эзэлдэг боловч эрэгтэй хүмүүс энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болох, ялангуяа хөдөлмөрийн мөлжлөгт өртөх эрсдэл өндөр байна. Тодруулбал, уг судалгаанд хамрагдсан ХХГХ-т өртөх эрсдэл бүхий **423 хүний 42 хувь нь (n=178) эрэгтэйчүүд** байна.

ХХГХ-т өртөмтгий байдлын индекс (НТИ)-ээр ХХГХ-ийн аль нэг элементэд өртсөн байж болзошгүй гэх 120 хүний өгөгдлийг судалж үзэхэд эмэгтэйчүүдэд ажил олгогчдын зүгээс дарамт үзүүлэх, хүчирхийлэх, хорих буюу хорихоор заналхийлэх зэрэг үйлдлүүдэд өртөж байсан бол эрэгтэйчүүдийн хувьд ажил олгогчдоо хууртсан тохиолдлууд илүү өндөр байв. DoMV загварын дагуух тоон судалгаагаар мөн хүйсийн ялгаатай байдал нь ХХГХ-т өртөмтгий байдлын индекс нөлөөгүй буюу хувь хүний эмзэг байдалд хүйсийн ялгаатай байдал нь статистикийн ач холбогдол бүхий ялгаа ажиглагдаагүй. Энэ нь аль ч хүйсийн хүмүүс аливаа хэлбэрийн мөлжлөгт хууртагдах/албадан байдлаар өртөх эрсдэлтэй болохыг харуулж байв.

Энэхүү үр дүн нь үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын өгсөн мэдээллээр мөн батлагдсан, тухайлбал, 2003-2018 оны хооронд ХТЭТ-өөс туслалцаа авсан ХХГХ-ийн хохирогчдын 13 хувь нь эрэгтэй байсан ба мөн урт хугацааны хамгааллын үйлчилгээ үзүүлдэг Талита Ази ТББ 2019-2020 онд бэлгийн мөлжлөгийн хохирогч болсон эрэгтэй хүүхдэд туслалцаа үзүүлж байжээ.

Одоогийн үзүүлж буй үйлчилгээ, хөтөлбөрүүд нь ихэвчлэн эмэгтэй хохирогчдод чиглэсэн, ХХГХ-ийн эрэгтэй хохирогчдод туслалцаа үзүүлэх чадавх үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын хязгаарлагдмал байна. Үйлчилгээ үзүүлэгчидтэй хийсэн ярилцлагаас харахад зөвхөн Талита Ази ТББ нь ХХГХ-ийн хохирогч болсон эрэгтэй хохирогчдод туслалцаа үзүүлэх байртай боловч одоогоор санхүүжилт, хүний нөөцийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үйл ажиллагаагаа явуулж чадахгүйд хүрээд байна. ХТЭТ зэрэг бусад байгууллагууд эрэгтэй хохирогчдод туслалцаа чадавхтай боловч эмэгтэй хохирогчдоос тусад нь байрлуулах байргүй тул эрэгтэй үйлчлүүлэгчдийг хүлээн авч чаддаггүй байна.

Зөвлөмж: Хэдийгээр ХХГХ-ийн хохирогчдын дийлэнх нь эмэгтэйчүүд байгаа хэвээр боловч хохирогч байж болзошгүй эрэгтэйчүүдийг илрүүлэхэд анхаарал хандуулах шаардлагатай. Мөн төрийн болон төрийн бус оролцогч талууд ХХГХ-ийн эсрэг урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрэгтэйчүүдийн онцлог хэрэгцээг харгалзсан байдлаар зохион байгуулж, эрэгтэй хохирогчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн хохирогч хамгааллын үйлчилгээг хүргэхийн тулд шаардлагатай нөөцийг хуваарилах хэрэгтэй.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэхтэй холбоотой санал болгож буй үйл ажиллагаа:

Богино хугацааны зөвлөмж:

1. ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх олон нийтийн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх. 14-25 насны эмэгтэйчүүд бэлгийн мөлжлөгт өртөх магадлал өндөр, 14-40 насны хүмүүс, ялангуяа эрэгтэйчүүд

хөдөлмөрийн мөлжлөгт өртөх эрсдэл илүү өндөр байдгийг харгалзан зорилтот бүлгийн хүмүүст хүртээмжтэй сувгийг ашиглан мэдээлэл түгээх.

2. Эрэгтэйчүүдийн ХХГХ-ийн талаарх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх зорилгоор ХХГХ-ийн эсрэг кампанит ажил, арга хэмжээ, хууль сахиулах байгууллагуудын оролцоотой хэлэлцүүлэг зэрэг нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах.

Дунд болон урт хугацааны зөвлөмж:

3. Эрэгтэй хохирогчид үзүүлэх үйлчилгээг өргөжүүлэхийн тулд анхан шатны түвшинд нөхөн сэргээх үйлчилгээ, нийгмийн ажлын үйлчилгээ болон нийгэмшүүлэх үйлчилгээ зэрэг хохирогч хамгааллын үйлчилгээгээр мэргэшсэн байгууллагуудад санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

Үр дүн 3: Санхүүгийн хязгаарлагдмал байдал, хөдөлмөр эрхлэх боломж хомс байгаа нь мөлжлөгт өртөх нөхцөлийг бүрдүүлж, олон талт түвшинд иргэдийг ХХГХ-т өртөх эмзэг байдлыг нэмэгдүүлж байна.

DoMV загварын дагуу санхүүгийн чадавх дутмаг байх, ажил эрхлэх боломж хомс байх хүчин зүйлс нь ХХГХ-т өртөх эмзэг байдлыг хувь хүн, гэр бүл, олон нийт зэрэг түвшин бүрд нэмэгдүүлдэг болох нь статистик шинжилгээгээр батлагдсан.

Ялангуяа, хувь хүний түвшинд санхүүгийн эмзэг байдал нь томоохон эрсдэлт хүчин зүйл болж байна. Судалгааны үр дүнгээр орлогын эх үүсвэр нь тасалддаг буюу тогтмол орлогогүй, санхүүгийн чадавх муу байгаа хүмүүс ХХГХ-т өртөх илүү эрсдэлтэй байгааг нотолсон¹³.

Гэр бүлийн түвшинд мөн ижил өрхийн санхүүгийн чадавх сул байх нь өрхийн гишүүдийн ХХГХ-т өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байв. Судалгаанд хамрагдсан 423 хүний 7.1 хувь нь (n=30) өдөр тутмын хоол хүнсээ ч бүрэн авч чаддаггүй, 24.8 хувь (n=105) зөвхөн өдөр тутмын хоол хүнсээ л авах боломжтой, үлдсэн оролцогчдын хувьд харьцангуй хангалттай өрхийн орлоготой байсан. Сонирхолтой нь, судалгаагаар гэр бүл/өрхийн санхүүгийн чадавх сайн байх нь ХХГХ-ээс хамгаалах баталгаа болж чадахгүй байгааг тогтоосон. Тодруулбал, өрхийн гишүүдийн ХХГХ-т өртөмтгий байдлыг бууруулж буй буюу хамгаалалт болж буй хүчин зүйлсэд санхүүгийн тогтвортой байдал нь ач холбогдол бүхий нөлөө үзүүлэхгүй байсан бол нийгмийн (хамт олон, олон нийтийн) эв нэгдэл, гэр бүлийн уур амьсгал, хүчирхийлэлтэй харилцаа бий эсэх зэрэг бусад өрхийн түвшний хүчин зүйлүүд өрхийн орлогоос илүү нөлөөлж байв. Уг үр дүнг тайлбарлахтай холбоотойгоор хувь хүн болон гэр бүлийн нөхцөл байдал нь тухайн өрхийн амьдарч буй газрын нийгэм, эдийн засаг, соёл, нийгмийн бүтэц болон эдгээр орчинд эзлэх тухайн гэр бүлийн байр суурь чухал нөлөөтэй байдгийг энд тэмдэглэх нь чухал юм.

Олон нийтийн түвшинд хийсэн шинжилгээгээр амьдарч буй орон нутагт нь хөдөлмөр ажил эрхлэх боломж хомс байх нь тухайн орон нутгийн иргэдийн ХХГХ-т өртөмтгий байдлыг нэмэгдүүлэх хүчин зүйл болж байгаа нь тогтоогдсон бөгөөд нийт судалгаанд хамрагдсан иргэдийн 43 хувь нь одоогийн амьдарч буй орон нутагт нь хөдөлмөр эрхлэх боломж хязгаарлагдмал гэж үзсэн байна. Ялангуяа, уг нөхцөл байдал нь орлого багатай иргэд (61.2 хувь), урт хугацаанд ажил эрхлээгүй хүмүүст (60.5 хувь) илүү нөлөөтэй байдаг байна.

Ийнхүү хөдөлмөр эрхлэх боломж бага байх нь иргэдийг эдийн засгийн боломжийн нөхцөлийн төлөө өөрсдийгөө болон гэр бүлээ эрсдэлд оруулах буюу эрсдэлтэй ажлын саналыг хүлээж авахад нөлөөлж байдаг тул санхүүгийн боломж хязгаарлагдмал байх нь иргэдийг ХХГХ-ийн хохирогч болоход түлхэх хүчин зүйл болж байгаа нь олон нийтийн түвшинд батлагдаж байв. ХХГХ-ийн шүүхийн хавтаст хэргийн материалтай танилцахад орон нутагтаа хөдөлмөр эрхлэх боломжгүй, ажил олдоогүйгээс Улаанбаатар хот руу шилжин ирсэн хэд хэдэн хохирогч хотод ирээд ажлын байртай болоход ихээхэн

¹³ Санхүүгийн хүнд байдалтай холбоотой хувьсагчийн тооцоолсон утга нь статистикийн хувьд ач холбогдолтой байв (утга = 0.117)

бэрхшээл тулгарсан талаар дурдсан байв. Уг нөхцөл байдал нь тэднийг хуурамч ажлын зарын дагуу гэмт хэрэгтнүүдтэй холбогдох, улмаар хууртагдах, хүчээр биеийг нь үнэлүүлж, бэлгийн мөлжлөгт өртүүлэхэд хүргэсэн тохиолдлууд байна. Энэхүү судалгаагаар ХХГХ-т холбогдсон долоон хэргийн хохирогч болсон 14 хүний хөдөлмөр эрхлэлтийн байдалд дүн шинжилгээ хийхэд 11 нь тогтсон ажилгүй, санхүүгийн бэрхшээлтэй байсан нь хохирогч болоход ихээхэн түлхэц болжээ¹⁴.

Түүгээр ч зогсохгүй энэхүү судалгаагаар хөдөлмөрийн зах зээлийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан дээд боловсролтой хүмүүс ч аюултай/мөлжлөгийн шинжтэй ажлын саналыг хүлээн зөвшөөрөхөд хүрч байгаа нь хувь хүний боловсролын түвшин нь хамгаалагч хүчин зүйл болж чадахгүй байгааг тогтоосон. Албан эх сурвалжийн мэдээллээр¹⁵ Монгол Улсад насанд хүрсэн гурван хүн тутмын хоёр нь бүрэн дунд боловсрол эзэмшсэн байна. Нэг хүн дунджаар 15 жил суралцаж байгаа¹⁶ нь бусад улс орнуудтай харьцуулахад харьцангуй өндөр үзүүлэлт юм. Гэсэн хэдий ч ажилгүйдэл нь Монгол Улсад, ялангуяа ажил хайхаар шилжин суурьшигчид ихээр ирдэг Улаанбаатар хотод гол тулгамдсан асуудал хэвээр байна. 2020 онд ажилгүйчүүдийн 49 хувийг 30-44 насны хүн ам эзэлж байсны дийлэнх хувийг эрэгтэйчүүд эзэлж байв. 15-24 насныхны ажилгүйдэл жилээс жилд буурч байгаа хэдий ч энэ насны бүлгийн эмэгтэйчүүдийн ажилгүйдэл өндөр хэвээр байна¹⁷.

Зөвлөмж: Иргэдийг ХХГХ-т өртөхөд хүргэж буй хувь хүн, өрх, олон нийт, бүтцийн түвшинд тодорхойлогдсон эдийн засгийн суурь шалтгааныг шийдвэрлэхтэй холбоотой арга хэмжээ авах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэхтэй холбоотой санал болгож буй үйл ажиллагаа:

- Хөдөлмөр эрхлэх боломж хомс байгаа нь хүмүүс эрсдэлтэй ажлын саналыг хүлээн авч, ХХГХ-ийн хохирогч болох эрсдэлийг нэмэгдүүлдэг. Иймд орон нутгууд дахь хөдөлмөр эрхлэх боломжийг нэмэгдүүлэх, хөдөлмөр эрхлэхэд шаардлагатай ур чадвар олгох сургалтын чанарыг сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатай.

Үр дүн 4: Бүртгэлгүй шилжин ирэгсэд ХХГХ-т илүү өртөмтгий байна.

Өмнө дурдсан Үр дүн 3 дээр нэмээд хөдөө орон нутагт ажил эрхлэх боломж хомс байгаа нь хот руу шилжихэд хүргэж, улмаар ХХГХ-т өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Тоон судалгааны үр дүнгээр амьдарч буй орон нутагтаа албан ёсны бүртгэлтэй эсэх нь хувь хүний ХХГХ-т өртөх эрсдэлд нөлөөтэй байгаа нь батлагдсан. Тодруулбал, судалгаагаар ХХГХ-т өртөх эрсдэлтэй 423 иргэнээс одоогийн оршин суугаа газартаа албан ёсны бүртгэлтэй эсэхийг тодруулахад оролцогчдын 20.8 хувь (n= 88) албан ёсны бүртгэлгүй байв. Байршлын хувьд Улаанбаатар хотод ихэнх нь буюу 30 хувь (n=71), Өмнөговь аймаг 17.5 хувь (n=11) хамгийн их бүртгэлгүй оршин суугчтай байв. Бүртгэлтэй болон бүртгэлгүй оролцогчдын өгөгдлийг харьцуулж үзэхэд бүртгэлгүй иргэд ХХГХ-т илүү өртөмтгий шинжтэй байна¹⁸.

Бүртгэлгүй шилжин ирэгсдийн ерөнхий профайл мэдээллийг авч үзэхэд хөдөө орон нутгаас Улаанбаатар хот руу ажил хийх зорилгоор шилжин ирсэн 18-25 насны эмэгтэйчүүд ихэнх хувийг

¹⁴ 2014-2018 онд шүүхээр шийдвэрлэсэн хүн худалдаалах гэмт хэргийн 14 хохирогчтой долоон хэргийн Эрүүгийн төв архив дахь хавтаст хэрэгтэй танилцсан үр дүнгээс.

¹⁵ Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын хураангуй үр дүн, ҮСХ, 2020.

¹⁶ Монгол Улсын боловсролын статистикийн өнөөгийн байдал, ҮСХ

¹⁷ Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын нэгдсэн үр дүн, ҮСХ, 2020.

¹⁸ coef = 0.044; robust s.e = 0.023; p-value= 0.060.

1. Coef=Регрессийн коэффициент нь регрессийн тэгшитгэл дэх үл хамааран хувьсагчдын нэгжийн өөрчлөлтөд харгалзах хамааран хувьсагчийн утгын өөрчлөлтийн харуулдаг.
2. Robust s.e= Үнэлэгдсэн регрессийн загварууд нь гетероскедастик шинжийг харуулсан (стандарт алдаа - алдааны магадлалын хуваарилалт хэвийн бус) бөгөөд үүнийг robust-аар засварлаж үнэлэв.
3. Р-утгууд нь түүвэр дээр ажиглаж буй хамаарал эх олонлогод байгаа эсэхийг тодорхойлоход тусалдаг. Бие даасан хувьсагч бүрийн р-утга нь хамааран хувьсагчтай огт хамааралгүй гэсэн таамаглалыг шалгадаг. Хэрэв хамаарал байхгүй бол бие даасан хувьсагчийн өөрчлөлт ба хамааран хувьсагчийн шилжилт хооронд ямар нэгэн холбоо байхгүй болно. Өөрөөр хэлбэл эх олонлогын түвшинд нөлөөлж байна гэж дүгнэх нотлох баримт хангалтгүй гэж үзнэ.

нь эзэлж байна. Бүртгэлгүй шилжин ирэгсэд бүртгэлтэй хүмүүстэй харьцуулахад өндөр цалин хөлс, гадаадад ажиллах болон бусад эрсдэлтэй ажлын саналыг хүлээж авах нь илүү өндөр байв.

Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой өөр нэгэн судалгааны үр дүн нь, DoMV загварын шинжилгээгээр урьдчилан төлөвлөж, сайтар бэлдсэн гэр бүлийн шилжилт хөдөлгөөн нь ХХГХ-ээс өрхийн гишүүдийг хамгаалах хүчин зүйл болж байв. Судалгаанд хамрагдсан 423 хүнээс 21.5 хувь (n= 91) нь сүүлийн гурван жилд 30 хоногоос дээш хугацаагаар буюу урт хугацааны шилжилт хөдөлгөөнд орсон. Эдгээр өрхийг өрхийн зөвхөн нэг гишүүн нь урт хугацааны шилжилт хөдөлгөөнд орсон өрхтэй харьцуулахад ХХГХ-т өртөх эрсдэл бага байв¹⁹. Цаашлаад хороо буюу орон нутаг, тэр дундаа засаг захиргааныхаа нэгж байгууллагуудаар тогтмол үйлчлүүлдэггүй гэр бүл/өрхүүд хороотойгоо тогтмол харилцаатай байдаг буюу үйлчлүүлдэг бүлэгтэй харьцуулахад ХХГХ-т илүү өртөмтгий байв²⁰.

Монгол Улсын дотоод шилжилт хөдөлгөөн 1990-ээд оны эхэн үеэс эрчимжсэн. Шилжилт хөдөлгөөний чиглэлийн хувьд хот суурин газар, ялангуяа нийслэл Улаанбаатар хот уруу шилжин ирж буй өрхийн хувь өндөр байдаг. Уг нөхцөл байдалтай холбоотойгоор, Нийслэлийн ЗД-ын захирамжаар 2017 оноос Улаанбаатар хот руу чиглэсэн шилжин хөдөлгөөнийг хориглосон²¹ нь шилжин ирэгсэд хотод оршин суугчаар бүртгүүлэх, орон сууц болон ажлын байр олох, нийгмийн үндсэн үйлчилгээнд хамрагдахад хүндрэл учруулж, улмаар нийгэм, эдийн засгийн боломжуудын хоцроход хүргэсэн. ОУШХБ-аас 2020 онд гүйцэтгэсэн “Улаанбаатар хотын шилжилт хөдөлгөөний хязгаарлалтын үр нөлөө болон шилжин суурьшигчдын эмзэг байдлын судалгаа”-ны үр дүнгээр 2017 оноос хойш хот руу нүүж ирсэн өрхийн Олон талт эмзэг байдлын индекс хориг тавигдахаас өмнөх жилүүдэд хот руу нүүж ирсэн өрхүүдээс 1.3 хувиар бага гарсан байна²². Энэхүү үр дүн нь албан ёсны бүртгэлгүй байх нь нийгмийн олон төрлийн үйлчилгээ авах боломжийг хязгаарлаж байгаа нь иргэдийн эмзэг байдлыг нэмэгдүүлж байгааг харуулж байна.

Улаанбаатар хотын шилжилт хөдөлгөөн болон ядуурлын түвшинг харьцуулж үзвэл Улаанбаатар хотын ядуурлын түвшин буурахгүй байгаад шилжин ирэгсдийн урсгал жил тутам нэмэгдэж байгаа нь нөлөө үзүүлж байна гэж үзэж болохоор байна. Тодруулбал, Монгол Улсын ядуу таван хүн тутмын гурав нь Улаанбаатар хотод амьдардаг бөгөөд тэдний ихэнх нь шилжин ирэгсэд байдаг. Ажилгүйдлийн түвшин өндөр байгаа нь иргэд өрхийн амьжиргаа, санхүүгийн нөхцөл байдлаа сайжруулахын тулд хөдөлмөрийн эрсдэлтэй сонголт хийх, ХХГХ-т өртөх эрсдэл байна гэсэн үг юм.

Зөвлөмж: Бүртгэлгүй шилжин ирэгсэд болон өрхийн эмзэг байдлыг бууруулах арга хэмжээг ХХГХ-т өртөх эрсдэлийг бууруулах суурь алхам болохыг харгалзан хүчин чармайлтаа эрчимжүүлэх.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэхтэй холбоотой санал болгож буй үйл ажиллагаа:

- Бүртгэлгүй шилжин ирэгсэд, тэр дундаа эцэг эх нь хөдөлмөр эрхлэхийн тулд хүүхдээ гэртээ хараа хяналтгүй орхиход хүрч буй өрхүүдэд ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх мэдлэг, ойлголт түгээх төсөл, хөтөлбөр санаачилгуудыг дэмжих

¹⁹ Өрхийн шилжилт хөдөлгөөн гэдэг хувьсагчийн сөрөг утга нь өрх гэр бүлээрээ шилжсэн бол өрхийн нэг гишүүн нь шилжилт хөдөлгөөнд орсон гэр бүлтэй харьцуулахад ХХГХ-т өртөх эрсдэл бага байгааг илтгэж байна.

²⁰ Монгол Улсын нийслэл, Улаанбаатар хотын захиргааны нэгж.

²¹ Нийслэлийн Засаг даргын 2017 оны захирамжаар Нийслэлийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, орчны бохирдлоос сэргийлэх зорилгоор орон нутгаас нийслэлийн нутаг дэвсгэрт байнгын оршин суугчаар шилжин ирэх хөдөлгөөнийг хязгаарласан. Уг хязгаарлалтыг 2018 онд 2020 он хүртэл сунгасан.

²² Улаанбаатар хотын шилжилт хөдөлгөөний хязгаарлалтын үр нөлөө болон шилжин суурьшигчдын эмзэг байдлын судалгаа, ОУШХБ болон IRIM судалгааны хүрээлэн, 2020. Тус судалгааны хүрээнд өрхүүдээс цуглуулсан тоон мэдээллийг ашиглан Олон талт эмзэг байдлын индекс (ОТЭБИ)-ийг тооцоолсон. ОТЭБИ-ийн дээд утга 1 байх бөгөөд Алкир болон Фостерийн (2011) “хослосон хязгаарлалтын (dual cutoff)” арга зүйн дагуу өрх 0.67-оос бага оноо авсан тохиолдолд тухайн өрхийг “эмзэг” гэж тодорхойлсон. Судалгааны үр дүнгээр шилжих хөдөлгөөний хязгаарлалт тавьсан үед (2017-2020) шилжин суурьшсан өрхүүдийн олон талт эмзэг байдлын индекс бусад онуудад шилжин суурьшсан өрхтэй харьцуулахад 1.3 хувиар бага байна.

- Бүртгэлгүй шилжин ирсэн өрхийн хүүхдүүд болон гэр бүлийн гишүүдэд сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжих үйлчилгээ үзүүлэх
- ОУШХБ-ын «Улаанбаатар хотын шилжилт хөдөлгөөний хязгаарлалтын үр нөлөө болон шилжин суурьшигчдын эмзэг байдлын судалгаа» болон түүнтэй ижил судалгааны үр дүнд тулгуурлан дотоод шилжилт хөдөлгөөнийг үр дүнтэй зохицуулах урт хугацааны шийдлүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх.

Үр дүн 5: Улаанбаатар хот, орон нутгуудаас Өмнөговь, Дорноговь, Дорнод аймгуудад ХХГХ-ийн эрсдэл өндөр байгаа боловч ХХГХ-тэй тэмцэх Монгол Улсын хүчин чармайлт Улаанбаатар хотод голчлон төвлөрч байна.

Ядуурал, ажилгүйдлийн түвшин, шилжилт хөдөлгөөний урсгал, уул уурхай дагасан зах зээл зэрэг бүтцийн түвшиндээ ХХГХ-ийн эрсдэлийг нэмэгдүүлж буй хүчин зүйлсийг харгалзвал дотооддоо **Улаанбаатар хот болон Өмнөговь, Дорноговь, Дорнод аймгууд нь** ХХГХ-ийн хамгийн эрсдэл өндөр байршлууд байна. Харин хилийн чанадад худалдаалагдсан ХХГХ-ийн хохирогчдын мэдээлэлд үндэслэвэл Монгол Улсын иргэд Зүүн болон Зүүн Өмнөд Азийн орнууд уруу худалдаалагдсан урсгал чиглэл давамгайлж байна²³.

Цагдаагийн байгууллагын тоо баримтаас харахад дотоодод үйлдэгдэж буй гэмт хэргийн хувьд бэлгийн мөлжлөгийн зорилгоор худалдаалах хэлбэр давамгайлах ба гол төлөв Улаанбаатар хотод төвлөрч байна. Оролцогч талуудтай хийсэн чанарын ярилцлагаар биеэ үнэлэгчдийг хотоос аймгийн төв рүү, зарим тохиолдолд Өмнөговь, Дорноговь, Дорнод зэрэг аймгийн хил орчмын сумдад²⁴ аваачин биеийг нь үнэлүүлсэн талаар мэдээлэл гарсан. Энэ нь хохирогчдыг хотоос гадна хөдөө орон нутаг уруу зөөн, бэлгийн мөлжлөгт өртүүлдэг зуучлагч, зохион байгуулалттай бүлэг байж болзошгүйг харуулж байв.

Мөн, чанарын мэдээллээр хил орчмын уул уурхайн бүс нутагт ХХГХ-ийн эрсдэл өндөр, ялангуяа эдгээр бүс нутагт үйлчилгээний эрэлт өндөр байдагтай холбоотой биеэ үнэлэгчид мөлжлөгт өртөх, мөн хилээр нүүрс тээвэрлэдэг ачааны машины жолооч нар хөдөлмөр мөлжлөгт өртөх эрсдэл байна.

Өмнөговь, Дорноговь, Дорнод аймгуудад ХХГХ-ийн тохиолдол бүртгэгдэх эрсдэл ажиглагдаж байгаа хэдий ч уг гэмт хэргийг илрүүлэх хүчин чармайлт нийслэлд илүү төвлөрсөн. Тухайлбал, 2018-2020 оны хооронд Эрүүгийн цагдаагийн албад бүртгэгдсэн ХХГХ-ийн 131 хэргийн 66 хувь нь (n= 87) Улаанбаатар хотод, Өмнөговь аймагт зургаа, 38 нь гадаадад үйлдэгдсэн тохиолдлууд байна.

2017-2019 оны хооронд олон улсын төрийн бус байгууллага улсын хэмжээнд 19 удаагийн сургалтаар дамжуулан 720 орчим хууль сахиулах байгууллагын албан тушаалтныг чадавхжуулах ажлыг зохион байгуулсан. Сургалтад эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 51 шүүгч, 96 прокурор, 232 цагдаа, 212 хилийн цэрэг, 118 цагаачлалын алба хаагч нар хамрагдсан байна. 2017 онд ХХГХ-ээр ял шийтгүүлсэн хүн огт байхгүй байсан бол 2020 онд найм болж нэмэгдсэн байгаа нь чадавхжуулах ажлын үр нөлөөг тодорхой хэмжээнд харуулж байна. Гэвч эдгээр хэргүүд бүгд Улаанбаатар хотод шийдвэрлэгдсэн байна. Иймд судалгаанд хамрагдсан оролцогч талууд чадавхжуулах сургалтыг Улаанбаатар хотоос бусад орон нутгуудад тогтмол зохион байгуулах хэрэгцээ шаардлага бийг онцлон дурдаж байв.

Монгол Улсын Дотоод хэргийн их сургуулийн цагдаа, мөрдөгчийн сургалтын хөтөлбөрт үндэстэн дамнасан гэмт хэрэг мөрдөн шалгах багцын хүрээнд «Хүн худалдаалах, болон соёлын өвийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх арга зүй « сэдэвт хоёр кредит цагийг сонгон суралцах хичээлийг хөтөлбөрт багтаасан байдаг боловч уг хичээл нь сонгон судлах хичээлийн багцад багтдаг буюу хууль сахиулахаар суралцаж буй оюутнуудаас зөвхөн сонирхсон оюутнууд л уг хичээлийг судалж байна.

²³ 2018-2020 оны хооронд хилийн чанадаас эгүүлэн татсан хохирогчдын ЦЕГ-ын ЭЦА болон ГХЯ-аас авсан тоон мэдээлэлд үндэслэв.

²⁴ Монгол Улсын орон нутгийн засаг захиргааны хоёр дахь шатлалын нэгж. Аймаг нь сумдад хуваагддаг. Нэг сумд нь дунджаар 5000 орчим оршин суугчтай.

Одоогийн байдлаар, ЦЕГ нь ХХГХ-тэй тэмцэх тусгайлсан нэгжтэй ганц байгууллага боловч уг нэгж нь зөвхөн нийслэлд төвлөрөн үйл ажиллагаа явуулдаг. Харин ХХГХ-тэй тэмцэх чиг үүрэг бүхий дэд зөвлөлийн гишүүн бусад байгууллагуудад ХХГХ-тэй тэмцэх бие даасан бүтэц бий болоогүй, тухайн асуудлыг дагнан хариуцдаг мэргэжилтэн байхгүй тул бусад албан хаагчид өөр асуудлуудтай хавсран хариуцдаг байна. Чанарын өгөгдлөөс харахад төрийн албан хаагчид болон хууль сахиулах байгууллагын ажилтнуудын нэг албан тушаал дээрх тогтвор суурьшил бага байдаг нь ХХГХ-ийг илрүүлж, шүүхээр шийдвэрлэхэд сөргөөр нөлөөлж байна.

Хохирогч хамгааллын нөхцөл байдлын хувьд, Улаанбаатар хотод ХХГХ-ийн хохирогчийг хүлээн авч, үйлчилгээ үзүүлдэг ТББ-ын хоёр хамгаалах байр байна. Уг хоёр нь 10 эмэгтэй, хоёр эрэгтэй үйлчлүүлэгч хүлээн авах хүчин чадалтай²⁵. Гэвч санхүүгийн болон боловсон хүчний хязгаарлагдмал байдал нь эрэгтэй хохирогчид үйлчилгээ үзүүлэх боломжид сөргөөр нөлөөлж байна. Гэмт хэргийн эрсдэл өндөр аймгууд болох Өмнөговь, Дорноговь, Дорнод аймгуудад тус тусын Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтсийн дэргэд түр хамгаалах байрууд ажилладаг. Гэвч өнөөдрийн байдлаар, зөвхөн Дорноговь аймгийн Замын-Үүд дэх хамгаалах байранд нэг удаа ХХГХ-ийн хохирогч байрлаж, үйлчилгээ авч байсан нь орон нутгуудад энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэлт, түүнийг дагасан үйлчилгээний чадавх сул байгааг харуулж байв.

Зөвлөмж: ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг Монгол Улс дотоод дахь болон хилийн чанад дахь эрсдэл өндөр, эмзэг байршлууд уруу чиглүүлэх шаардлагатай. ХХГХ-ийн эрсдэл нэмэгдэж буй байршлуудад ХХГХ-ийг таних, илрүүлэх, мөрдөн байцаах ажиллагааг сайжруулах, хохирогч хамгааллын үйлчилгээг сайжруулах, хүчин чармайлтыг нэмэгдүүлэх.

Богино хугацааны зөвлөмж:

- Зорилтот орон нутгуудад (ХХГХ-ийн эрсдэл өндөр байршлууд) ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, тэмцэхтэй холбоотой мэдээллийг түгээж, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах.
- Хууль сахиулах байгууллагын болон ХХГХ-тэй тэмцэх чиг үүрэг бүхий байгууллагын ажилтнууд зайлшгүй судалсан байх ХХГХ-ийн асуудлаарх нэгдсэн сургалтын хөтөлбөр боловсруулах.
- ХХГХ-ийн эрсдэл өндөр, эмзэг байршлууд дахь холбогдох оролцогч талуудад зохион байгуулж буй сургалтуудыг үргэлжлүүлэх, сургалтын давтамж, тоог нэмэгдүүлэх.

Дунд болон урт хугацааны зөвлөмж:

- ХХГХ-ийн эрсдэл өндөр, эмзэг байршлууд, ялангуяа хил орчмын бүс нутагт хохирогч хамгааллын үйлчилгээг сайжруулах.
- Хилийн чанадад худалдагдсан хохирогчдын талаар мэдээлэл солилцох, хохирогчдыг олж илрүүлэх, шилжүүлэх ажлыг сайжруулах зорилгоор хөрш орнуудтай хил дамнасан хамтын ажиллагаа, албан болон албан бус солилцоо, туршлага солилцох, хамтарсан чадавх бэхжүүлэх үйл ажиллагаануудыг нэмэгдүүлэх,
- Нийслэл хотоос бусад ХХГХ-ийн эрсдэл өндөр орон нутагт ХХГХ-тэй тэмцэх чиг үүрэг бүхий тусгай нэгж байгуулах асуудлыг судлах.

Үр дүн 6: Хуулийн заалтууд өөр хоорондоо зөрчилтэй, уялдаа холбоо хангалтгүй, санхүүжилт дутмаг зэргээс болж хохирогчдод үзүүлэх тусламж үйлчилгээ хязгаарлагдмал байна.

²⁵ ХТЭТ-ийн Улаанбаатар хотод байрлах хамгаалах байр нь нэг дор зургаан үйлчлүүлэгч, Талита Ази ТББ-ын хамгаалах байр нь нэг дор дөрвөн эмэгтэй, хоёр эрэгтэй үйлчлүүлэгч хүлээн авах хүчин чадалтай.

Баримт бичгийн судалгаагаар үндэсний эрх зүйн баримт бичгүүдэд «хохилогч»-ийг тодорхойлсон тодорхойлолтууд нь ялгаатай туссан болох нь харагдсан. Уг байдал нь шүүхийн байгууллагаас албан ёсоор тухайн хүнийг хохирогчоор тогтоосон эсэхээс хамаарч хохирогч хамгааллын тусламж үйлчилгээ авах боломжийг хязгаарлаж байна. Түүнчлэн «Төлбөрийн чадваргүй хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх журам», «Хохирогчдод учирсан сэтгэл зүйн хохирлыг тооцох аргачлал» зэрэг хохирогчийг хамгаалах үйлчилгээг сайжруулахад шаардлагатай хэд хэдэн журам батлагдаагүй байна²⁶.

Хууль сахиулах үйл ажиллагааны явцад эрх зүйн туслалцааг үнэ төлбөргүй авах нь Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд заасан хохирогчийн үндсэн эрх юм. Гэвч улсын төвлөрсөн төсөвт уг үйлчилгээтэй холбогдох зардлыг тусгадаггүй, ХХГХ-ээр мэргэшсэн, төлбөргүй үйлчилгээ үзүүлдэг өмгөөлөгч байхгүй зэргээс шалтгаалан хохирогчид үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх заалт өнөөг хэр нь хэрэгжээгүй байна.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд хохирогч хамгааллын үйлчилгээнд нөхөн сэргээх үйлчилгээг хохирогчид үзүүлэхээр заасан боловч бодит байдал дээр хамгийн хэрэгцээтэй, нэн тэргүүнд үүсдэг яаралтай тусламж (анхан шатны тусламж үйлчилгээ)-г хэн хэрхэн үзүүлэх талаар хуульд бүрэн тусгаагүй тул эдгээр үйлчилгээг үзүүлэх үүрэг хуулиар зохицуулагдаагүй байна. Одоогийн байдлаар үндэсний ТББ-ууд олон улсын байгууллагуудын төсөл хөтөлбөрийн хүрээнд, тэдний санхүүгийн дэмжлэгээр анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлж байна. Эдгээр байгууллагууд санхүүжилт дутмаг, гаднын санхүүжилтээс хараат байдлаас үүдэн үйлчилгээ тогтмол үзүүлэх боломж хязгаарлагдмал байна. Мөн түүнчлэн, одоогийн байдлаар үйлчилгээ үзүүлж буй хамгаалах байрууд нь эрэгтэй хохирогчийг хүлээн авах чиглэлд тохижуулагдаагүй байна.

Хэдийгээр үндэсний ТББ-ууд нь урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа, мэдээлэл түгээх үйл ажиллагаа явуулдаг боловч байгууллагуудын үйл ажиллагаануудын дунд нэгдсэн стратегийн зохицуулалт дутмагаас, хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоотой төлөвлөлт сул, байгууллага бүрийн чадавх, санхүүжилтийн хэмжээнээс шалтгаалан ажлууд тодорхой төсөл хөтөлбөрийн хүрээнд хэрэгждэг. Иймд цаашдаа урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг уялдуулж нэгдсэн бодлого төлөвлөлтөд оролцогч бүх талууд хувь нэмрээ оруулахын тулд системтэй удирдлага, зохион байгуулалтыг хэрэгжүүлж, байгууллагуудын амжилттай сайн туршлагаудыг дэмжиж, бусад байгууллагуудад таниулах замаар ТББ-ыг дэмжих шаардлагатай.

Зөвлөмж: ХХГХ-ийн хохирогчдод анхан шатны болон нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэх, үүнд төр болон үйлчилгээ үзүүлэгч ТББ-ын ажлын уялдаа холбоог дээшлүүлэх цогц арга хэмжээг хэрэгжүүлэх.

Богино хугацааны зөвлөмж:

- ХХГХ-ийн хохирогчдод үзүүлэх анхан шатны болон нөхөн сэргээх үйлчилгээнд холбогдох төрийн байгууллагуудын оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлэх.
- ХХГХ-ийн хохирогчид, түүний дотор эрэгтэй хохирогчид туслалцаа үзүүлэх чиглэлээр төрийн байгууллагууд (Нэг цэгийн үйлчилгээний төвүүд)-ын чадавхыг бэхжүүлэх.
- Засгийн газар болон ТББ-уудын хооронд мэдээлэл солилцох, үйл ажиллагаагаа уялдуулан төлөвлөх байдлыг дээшлүүлэх, тэр дундаа албан бус харилцаа холбооны механизмыг бий болгох замаар дээшлүүлэх.

Дунд болон урт хугацааны зөвлөмж:

²⁶ Баримт бичгийн судалгааны үр дүнд тулгуурлав.

- ХХГХ-ийн хохирогчийн туслалцаа дэмжлэг авах боломжийг хязгаарлаж буй хуулийн заалтуудын зөрчилтэй байдлыг арилгахын тулд эрх зүйн баримт бичгүүд дэх «хохирогч»-ийг авч үзсэн хуулийн тодорхойлолтыг эргэн харах.
- ХХГХ-ийн хохирогчид нөхөн төлбөр олгох хуулийн заалт, зохицуулалтыг оруулах талаар судлах.
- ХХГХ-ийн хохирогчид анхан шатны тусламж үзүүлэх төсөв хуваарилах.
- Про боно буюу үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх өмгөөлөгчдийн жагсаалтыг гаргах, тэдгээр өмгөөлөгчдийг хөдөлмөр мөлжлөг, албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийн хохирогчдод туслалцаа үзүүлэх чиглэлээр чадавхжуулах.

Үр дүн 7: COVID-19 цар тахлын эсрэг авч хэрэгжүүлж буй шийдвэр, урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь иргэдийн ХХГХ-т өртөх эмзэг байдлыг нэмэгдүүлж, ХХГХ-ийн чиг хандлагад нөлөөлж байгаа нь тодорхой боловч уг асуудлыг тусгайлан авч үзсэн судалгаа хийгдээгүй байна.

COVID-19 цар тахал нь нийгмийн бүх бүлэгт өргөн хүрээнд нөлөөлж байгаа боловч тодорхой бүлгийн иргэдэд илүү нөлөө үзүүлж байна. Тухайлбал, цар тахлын тархалт нь эрсдэлтэй бүлгийн иргэдийн амьжиргааг дордуулснаар цар тахлаас өмнөх үеийн ХХГХ-ийн эрсдэлийг нэмэгдүүлж буй хүчин зүйлсийг улам нэмэгдүүлж буй нь судалгааны үр дүнгээс харагдсан. Тоон судалгаанд хамрагдсан оролцогчдын 71 хувь (n=300) нь COVID-19 тэдний эмзэг байдлыг нэмэгдүүлсэн, 37 хувь (n=156) орлого, ажлын боломж буурсан, 19.3 хувь (n=82) сэтгэл зүйн хувьд стресст орж, уур бухимдалтай болсон, 12.4 хувь (n=52) гэр бүлийн гишүүдийн нийгмийн сүлжээ ашиглах байдал өссөн гэж хариулсан. Нийгмийн сүлжээний хэрэглээ өссөн нь ХХГХ үйлдэгчдэд цар тахалтай холбоотойгоор тавигдсан хязгаарлалтуудад зохицон зайнаас буюу өмнөх үеэс өөр арга барилаар ажиллаж, илүү олон хохирогчдыг цахимаар элсүүлэх боломжийг бүрдүүлсэн. Тодруулбал, Цагдаагийн байгууллагын ажилтнуудын мэдээлснээр цар тахлын үед бүх нийтийн сошиал сүлжээний хэрэглээ нэмэгдсэнээс гэмт хэрэгтнүүд цахимаар хохирогчийг элсүүлэх, интернэтээр дамжуулан илүү далд хэлбэрээр хэрэг үйлдэх байдал нэмэгдсэн байна.

Мөн цар тахлын үед гэр бүлийн хүчирхийлэл улам нэмэгдэж байгаа нь ХХГХ-ийн эрсдэлийг нэмэгдүүлэх нөлөөтэй. Уг судалгааны үр дүнгээр гэр бүлийн хүчирхийлэлтэй, гэр бүлийн харилцаа уур амьсгал тогтворгүй байх нь өрхийн гишүүдийн ХХГХ-т өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байгаа нь статистик шинжилгээгээр батлагдсан. Тэгвэл Цагдаагийн байгууллагаас авсан мэдээллээр цар тахлын цаг үед гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, бүртгэгдсэн хэргийн тоо нэмэгдсэн байна.

Цар тахал нь олон улсын болон дотоод шилжилт хөдөлгөөний урсгалыг алдагдуулж, ХХГХ үйлдэгдэх чиг хандлагад нөлөөлж байгаа боловч өнөөг хүртэл уг асуудлыг нарийвчлан судалж чадаагүй байгаа нь цар тахлын үе дэх ХХГХ-ийн нөхцөл байдлыг бүрэн дүүрэн тайлбарлахад хүндрэлтэй хэвээр байна. Уг нөхцөл байдлаас үүдэн хохирогчдыг олж илрүүлэхэд шинэ сорилт бэрхшээл тулгарч болзошгүй юм. Дээр дурдагдсан судалгааны гол үр дүнг харгалзвал цар тахлын цаг үед төрийн байгууллагуудын ХХГХ-тэй тэмцэх чадавх хязгаарлагдах, иргэд олон нийтийн эдийн засгийн чадавх суларч, эмзэг байдал нэмэгдэж буйг гэмт хэрэгтнүүд, зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүд давуу тал болгон ашиглах боломжтой.

Зөвлөмж: COVID-19 цар тахлын ХХГХ-т үзүүлэх нөлөөллийн талаар системтэй судалгаа хийх. Үүнд:

- Цар тахал болон түүнтэй холбоотой нийгэм эдийн засгийн хямрал нь Монгол Улс дахь ХХГХ, болон бусад мөлжлөгийн чиг хандлагад хэрхэн нөлөөлж буйг судлах.

- Үндэсний болон орон нутгийн түвшин дэх ХХГХ-тэй тэмцэх үйл ажиллагаанд COVID-19-өөс үүдэлтэй хямралын нөлөөг үнэлэх.
- ХХГХ, түүнтэй тэмцэх асуудал, хариу арга хэмжээнд COVID-19 цар тахлын үзүүлж буй нөлөөллийн талаар үндэсний хэмжээнд ашиглагдаж буй анхан шатны болон хоёрдогч эх сурвалжуудын мэдээллийн зөрүүг олж тогтоох, зааг ялгааг арилгах арга замыг зөвлөх
- Судалгааны үр дүнд тулгуурлан ХХГХ-ийн эсрэг оролцогч талуудын авч хэрэгжүүлэх үр дүнтэй арга хэмжээ, хариу арга хэмжээний талаар зөвлөмж гаргах.

ТАНИЛЦУУЛГА

Монгол Улс нь далайд гарцгүй орон бөгөөд ОХУ, БНХАУ-тай ойролцоогоор 1,565 мянган хавтгай дөрвөлжин км² нутаг дэвсгэрээр хиллэдэг. Нийт 3.2 сая хүн амтай бөгөөд тэдгээрийн 50.8 хувь нь эмэгтэйчүүд. Харьцангуй залуу хүн амтай буюу нийт хүн амын 30.4 хувийг 0-14 насныхан, 65.7 хувийг 15-64 насныхан эзэлдэг²⁷. Үндэс угсааны хувьд, хүн амын дийлэнх хувийг Халх²⁸ (85 хувь), удаад нь Монгол Улсын хамгийн баруун хэсэгт оршдог Баян-Өлгий аймагт амьдардаг Казахууд²⁹ (7 хувь) эзэлдэг. Үлдсэн 8 хувийг Тува (Цаатан), Дархад, Буриад зэрэг нийгэм, соёлын цөөнх бүлгүүд эзэлж байна³⁰.

Нийт хүн амын дийлэнх нь (66.4 хувь) хот суурин газар, уул уурхай төвлөрсөн нутаг дэвсгэрт, харин 33.6 хувь нь хөдөө орон нутагт амьдардаг³¹. Уул уурхайгаас улбаалсан түүхий эдийн арвин нөөцтэйн улмаас 1999 оноос хойших 20 гаруй жилийн хугацаанд уул уурхайд түшиглэсэн эдийн засаг эрчимтэй өссөн. Дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт 2016 онд 1.2 байсан бол 2017 онд 5.3 хувь, 2018 онд 7.2 хувь, 2019 онд 5.1 хувиар өсөж, Монгол Улсын эдийн засгийн үзүүлэлт эдгээр жилүүдэд мэдэгдэхүйц сайжирсан хэдий ч хөгжлийн ахиц дэвшил жигд бус байгаа ба бүс нутаг, хүн амын бүлгийн хоорондын ялгаа их, ядуурлын түвшин өндөр хэвээр, бүс нутгийн ялгаатай байдал, ядуурлын асуудал хүнд сорилт хэвээр байна³². 2018 онд Монгол Улсын ядуурлын үндэсний түвшин 28.4 хувь байсан нь 2016 оны тооцооллоос 1.2 пунктээр буурсан үзүүлэлт юм³³. 2019 оны байдлаар Монгол Улс Хүний хөгжлийн индексээр дэлхийн 189 орноос 92 дугаарт жагсаж байна³⁴.

Гэмт хэргийн гаралтын хувьд, 2018 оны байдлаар жилд дунджаар 16 ба түүнээс дээш насны 100.000 хүн тутамд дунджаар 1,686 гэмт хэрэг ноогдож байгаа нь хүн амын хэмжээтэй харьцуулахад гэмт хэргийн гаралт өндөр орны тоонд тооцогдож байна³⁵.

Нэг цагдаагийн албан хаагчид ногдох хүний тоо 371, энэ нь дэлхийн бусад орны дунджаас өндөр байна. Гэмт хэрэг, зөрчил шалгах эрх бүхий албан хаагчдын ажлын ачаалал их, долоо хоногт 70 хүртэлх цаг ажиллаж байгаа нь Хөдөлмөрийн тухай хуульд заасан хэмжээнээс 75 хувиар илүү буюу албан хаагчдын ажлын ачаалал маш өндөр орны тоонд орж байна³⁶.

Хүн худалдаалах гэмт хэрэг (ХХГХ)-ийн нөхцөл байдлын хувьд Монгол Улс нь хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгт ашиглах зорилгоор үндэстэн дамнасан ХХГХ-ийн илгээгч, хүлээн авагч, дамжуулагч орны тоонд багтаж байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн тодорхойлолт

ХХГХ-ийг илрүүлэх, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг судлах, хэргийг мөрдөн шалгах, хянан шийдвэрлэхийн тулд улс орнууд хамтран ажиллах үндэс суурь нь тус гэмт хэргийн талаар нэгдсэн ойлголттой байх явдал юм. Иймд уг судалгааг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тодорхойлолтод тулгуурлан гүйцэтгэхийг зорисон. Ингэснээр үндэсний хууль тогтоомж нь олон улсын тодорхойлолттой нийцтэй эсэхийг таних, улмаар олон улсын тодорхойлолтоор авч үзэхэд ХХГХ-т өртөх эрсдэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодруулах замаар судалгааны харьцуулагдахуйц, найдвартай байдлыг хангахыг зорив.

²⁷ Хүн ам, өрхийн бүртгэлийн мэдээлэл

²⁸ Монголчуудын дийлэнх хувийг эзлэх хамгийн том үндэстэн

²⁹ Төв Азийн хойд хэсгээс Монгол Улсад нүүдэллэн ирж суурьшсан Түрэг хэлт угсаатны бүлэг

³⁰ НҮБ-ын Хүүхдийн сангийн 2012-2016, 2017-2021 оны хөтөлбөрүүдэд хийсэн хүртээмжтэй суурь боловсролын үнэлгээ

³¹ НҮБ-ын Хөгжлийн тусламжийн хүрээ 2017-2021 Монгол улс

³² НҮБ-ын Хүүхдийн сангийн 2012-2016, 2017-2021 оны хөтөлбөрүүдийн хүртээмжтэй суурь боловсролын үнэлгээ

³³ Монгол Улсын эдийн засгийн мэдээлэл. Өсөлтийг хангах төсвийн орон зай. Улсын хөрөнгө оруулалтын үр өгөөж. 2018/7

³⁴ НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн Хүний хөгжлийн 2019 оны тайлан

³⁵ Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр, ЗГ-ын 2020 оны 141-р тогтоолын хавсралт

³⁶ Ibid.

ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр олон улсын гол тулгуур баримт бичиг нь 2008 оны 05 дугаар сарын 16-нд НҮБ-ын Ерөнхий ассамблейгаас батлан гаргасан *Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцын нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол* (Цаашид Палермогийн протокол гэх) юм³⁷. Уг протоколын 3-р зүйлд ХХГХ-ийг тодорхойлохдоо:

- (a) *“Хүн худалдаалах гэмт хэрэг” гэдэг нь хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, хууран мэхлэх, залилах, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, эсхүл бусдыг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрөлийг авахын тулд төлбөр төлөх, хахуульдах аргаар хүнийг элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуун далдлах буюу хүлээж авах үйлдлийг хэлнэ.* Хүнийг мөлжих гэдэгт биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөгт оруулах, албадан хөдөлмөрлүүлэх, боолчлох буюу түүнтэй төстэй нөхцөлд байлгах, эд эрхтэнийг нь авах үйлдлийг ойлгоно³⁸.
- (b) Дээрх аргуудын аль нэгийг ашигласан тохиолдолд хохирогч өөрийг нь дээр дурдсан аргаар мөлжих гэж байгааг зөвшөөрсөн эсэхийг үл харгалзан хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэн гэж үзнэ.
- (c) Мөлжих зорилгоор хүүхдийг элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуун далдлах буюу хүлээж авсан аливаа үйлдэл нь дээр дурдсан аргаар үйлдсэн байхыг шаардахгүйгээр хүн худалдаалах гэмт хэрэгт тооцно гэжээ.

Протоколын уг тодорхойлолтыг задалбал ХХГХ-ийг тодорхойлоход үйлдэл, арга, зорилго гэсэн гурван бүрэлдэхүүн шинжийг авч үздэг. Эдгээр нь:

Зураг 1. ХХГХ-ийг тодорхойлох гурван бүрэлдэхүүн



- **Үйлдэл (юу хийсэн болох):** Үүнд аливаа нэг газраас нөгөө рүү тээвэрлэх процесс буюу Хүнийг элсүүлэх, тээвэрлэх, орогнуулах, дамжуулах, нуун далдлах, хүлээж авах зэрэг үйлдлүүдийг ойлгодог. Ингэхдээ улс дотроо болон улсын хилээр давсан байж болох ба хилээр давсан байх нь элсүүлэх, тээвэрлэх зэрэг үйлдлийг тодорхойлж хохирогч ХХГХ-т өртсөн болохыг илэрхийлдэг.
- **Үйлдлийн арга (хэрхэн хийсэн болох):** Үүнд хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, хууран мэхлэх, залилах, эрх мэдлээ урвуулах, эмзэг байдлыг нь далимдуулах ашиглах, эсхүл бусдыг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, хахуульдах зэрэг аргуудыг ойлгодог. Тухайн хүнийг мөлжихийн тулд мөлжлөгийн газарт авчрахын тулд ямар арга хэрэглэснийг илэрхийлдэг.

³⁷ Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц <https://www.unodc.org/unodc/en/organized-crime/intro/UNTOC.html>

³⁸ ХХГХ-тэй холбогдох бусад олон улсын гол конвенц, баримт бичгүүдийг дараах холбоосоос харна уу. <https://www.unodc.org/e4j/en/tip-and-som/module-6/key-issues/international-legal-framework.html>



- **Зорилго (яах гэж хийсэн болох):** Үүнд дээрх үйлдэл болон аргыг ямар зорилгоор хийсэн буюу ашиг олох, мөлжих санаа зорилгыг хамаарч авч үздэг. ХХГХ-ийн зорилгын шинж тэмдгүүд нь тухайн хүнд юу тохиолдсон, яагаад тохиолдсон гэдэг дээр төвлөрдөг. Ялангуяа бэлгийн болон хөдөлмөрийн мөлжлөг, албадан хөдөлмөр эсвэл үйлчилгээ үзүүлэх, хүчээр гэрлүүлэх зэргээр хүнийг мөлжиж, ашиг орлого олох сэдэл давамгайлдаг. Ихэнх хохирогчид мөлжлөгт өртсөнийхөө дараа хохирогчоор тогтоогддог бөгөөд мөлжлөг олон хэлбэрээр явагдаж болдог.

Монгол Улсад 2000 оны эхээр өрнөсөн эрх зүйн шинэтгэлийн бодлогын хүрээнд батлагдсан 2002 оны Эрүүгийн шинэ хуулийн 113 дугаар зүйлд “Хүн худалдах, худалдан авах” гэмт хэргийг анх шинээр тусгасан. Ийнхүү Эрүүгийн хуульд бие даасан зохицуулалт болж орсон хэдий ч хүн худалдах, худалдан авах гэмт хэрэг үйлдсэн этгээд хүнийг мөлжих зорилгоор худалдаалахдаа элсүүлэх, тээвэрлэх, орогнуулах, дамжуулах, хүлээн авах гэсэн таван үе шатыг заавал дамжсан байхыг шаардсан нь энэ төрлийн гэмт хэрэг бүртгэгдэж, шалгагдахгүй байх нөхцөлийг бий болгож байжээ.

Улмаар, Монгол Улс 2008 онд Палермогийн протоколд нэгдэн орсонтой холбоотойгоор тухайн үед мөрдөгдөж байсан Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйлд өөрчлөлт оруулж, 2015 онд батлагдсан Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд, ХХГХ-ийг хуульчлахдаа уг протоколын тодорхойлолттой үндэсний тодорхойлолтыг зөрчилдөөнгүй болгосон нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрүүгийн эрх зүйнд нэг том алхам болсон гэж үздэг.

Хүснэгт 2. ХХГХ-ийн тодорхойлолт, Палермогийн протокол ба Эрүүгийн хуулийн харьцуулалт

НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцын нэмэлт Палермогийн протокол	Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулгын 13.1-р зүйл/
<p>“Хүн худалдаалах” гэдэг нь хүнийг мөлжих зорилгоор хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хүч хэрэглэх, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эмзэг байдлыг нь ашиглах, эсхүл өөр этгээдийг хяналтдаа байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр хийж буюу ашиг олгон хахуульдах зэрэг аргаар хүмүүсийг урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуугдуулах буюу хүлээж авах үйлдлийг хэлнэ.</p>	<p>Хүн худалдаалах гэдэг нь “Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтэнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлэх, тээвэрлэх, орогнуулах, дамжуулах, хүлээн авах үйлдлийг хэлнэ.</p>
ХХГХ-ийн гурван бүрэлдэхүүний дагуу дээрх хоёр тодорхойлолтыг нарийвчлан задалбал:	
<p>Үйлдэл/Акт хүмүүсийг урвуулан элсүүлэх, тээвэрлэх, дамжуулах, нуугдуулах буюу хүлээж авах</p>	<p>Үйлдэл/Акт элсүүлсэх, тээвэрлэх, орогнуулах, дамжуулах, хүлээн авах</p>
<p>Үйлдлийн арга/Means</p> <ul style="list-style-type: none"> • хүч хэрэглэхээр заналхийлэх буюу хүч хэрэглэх, эсхүл хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглах, • хулгайлах, • залилах, • хууран мэхлэх, • эрх мэдлээ урвуулан ашиглах буюу эмзэг байдлыг нь ашиглах, • эсхүл өөр этгээдийг хяналтдаа байлгаж буй этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр хийх буюу ашиг олгон хахуульдах, 	<p>Үйлдлийн арга/Means</p> <ul style="list-style-type: none"> • хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, • хулгайлах, • хууран мэхлэх, • итгэл эвдэх, • эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, эсхүл • хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлөх, хахуульдаж эрхшээлдээ оруулах,
<p>Зорилго/Purpose Хүнийг мөлжих зорилгоор</p>	<p>Зорилго/Purpose Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтэнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор</p>

Хүснэгт 2-д харуулсанчлан Монгол Улсын Эрүүгийн хуулийн тодорхойлолт нь Палермогийн протоколтой агуулгын хувьд бүрэн нийцсэн болох нь харагдаж байна. Гэвч уг хуульд ХХГХ-ийг тухайлан зүйлчилсэн боловч түүний төрөл хэлбэрүүдийг бага ялтайгаар бие даасан гэмт хэрэг болгон давхар зүйлчилсэн байна. Улмаар эдгээр гэмт хэргийн төрлүүдийг ялгахад хуулийн зүйл заалтыг нэг мөр ойлгох асуудал эргэлзээтэй, тодорхойгүй байгаа нь гэмт хэрэгтнүүдэд ял завших боломж олгох нөхцөл болох талтай. Тодруулбал, Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд ХХГХ-т бэлгийн мөлжлөгт оруулах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих, эд эрхтэнийг авах зэрэг үйлдлийг тооцохоор заасан хэдий ч эдгээр гэмт хэргийг хуульд бие даасан гэмт хэргээр давхар зүйлчилж оруулсан. Ингэхдээ эдгээр гэмт хэргийн тодорхойлолтод мөлжлөгийн зорилгоор үйлдсэн эсэх, мөн хохирогч тухайн нөхцөлд хэрхэн хүрснийг илтгэх гэмт хэргийг үйлдсэн арга, үйлдэл (act, means) зэргийг илэрхийлэх томъёоллуудыг тусгасан нь найруулга, хэл зүйн хувьд эргэлзээтэй нөхцөл байдлыг үүсгэж байна. Тухайлбал: 2015 оны Эрүүгийн хуулийн:

- 12.3 Бэлгийн мөлжлөг,
- 13.13 Албадан хөдөлмөрлүүлэх,
- 15.3 Хүний цус, эс, эд, эрхтэнийг хууль бусаар авах,
- 16.4 дүгээр зүйл. Хүүхдээр гуйлга гуйлгах
- 16.6 дугаар зүйл. Хүүхэд худалдах
- 16.8 дугаар зүйл. Хүүхэд садар самууныг сурталчлах, уруу татах
- 16.9 дүгээр зүйл. Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах
- 16.10 дугаар зүйл. Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх зэрэг ХХГХ-ийн төрөл хэлбэрүүдийг бие даасан байдлаар хуульчилжээ.

Хүснэгт 3. Эрүүгийн хуульд заасан зүйл заалтуудад оногдуулсан эрүүгийн хариуцлагын харьцуулалт, хүндрүүлэх нөхцөл байдал

Эрүүгийн хуулийн зүйл	Тодорхойлолт	Ял шийтгэл
12.3 дугаар зүйл. Бэлгийн мөлжлөг	1. Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорчих эрхийг хязгаарлахгүйгээр бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан бол	Нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял
	2. Энэ гэмт хэргийг хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор: 1.1 14-18 насанд хүрээгүй хүнийг албадан оруулж; 1.2 урьд энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн; 1.3 хохирогчид мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис хэрэглүүлж; 1.4 хохирогчийг жирэмсэн болгож; 1.5 хоёр, түүнээс олон хүний эсрэг; 1.6 байнга тогтвортой үйлдсэн бол	Хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял
	3. Энэ гэмт хэргийн улмаас: 3.1.ураг зулбасан; 3.2.арван зургаан насанд хүрээгүй хүнийг жирэмсэн болгосон бол	5-12 жил хүртэл хугацаагаар хорих ял
	4. Энэ гэмт хэргийг хохирогчийн биеийг үнэлүүлж ашиг олох зорилгоор: 3.1 бага насны хүүхдийг албадан оруулж; 3.2 зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол	12-20 жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ.

13.1 дүгээр зүйл. Хүн худалдаалах	1. Биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, эд, эрхтэнийг авах, албадан хөдөлмөрлүүлж мөлжих зорилгоор хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, хулгайлж, хууран мэхэлж, итгэл эвдэж, эрх мэдлээ урвуулан ашиглаж, эмзэг байдлыг нь далимдуулж, эсхүл хяналтдаа байлгаж байгаа хүнд төлбөр төлж, хахуульдаж хүнийг эрхшээлдээ оруулан элсүүлсэн; тээвэрлэсэн; орогнуулсан; дамжуулсан; хүлээн авсан бол	Хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял
	2. Энэ гэмт хэргийг: 1.1 хүүхэд, жирэмсэн эмэгтэйг мэдсээр байж; 1.2 хоёр, түүнээс олон хүнийг худалдаалж; 1.3 Монгол Улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн бол	5-12 жил хүртэл хугацаагаар хорих ял
	3. Энэ гэмт хэргийг: 3.1. байнга тогтвортой; 3.2. зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол	12-20 жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял
13.13 дугаар зүйл. Албадан хөдөлмөрлүүлэх (буюу хөдөлмөр мөлжлөг)	1. Бусад хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, илт хохиролтой болзол, нөхцөл тулгаж, эсхүл хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулан эрхшээлдээ оруулж цалин хөлсгүй хөдөлмөр эрхлүүлсэн бол	5,400-27,000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох (5,400,000-27,000,000 төгрөгтэй тэнцэх), эсхүл 240-720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл 1-5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 1-5 жил хүртэл хугацаагаар хорих ял
15.3 дугаар зүйл. Хүний цус, эс, эд, эрхтэнийг хууль бусаар авах	1. Хууран мэхэлж, эсхүл хүч хэрэглэж, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлж хүний цусыг, эсийг авсан бол	1-5 жил хүртэл хугацаагаар хорих ял
	2. Хууран мэхэлж, эсхүл хүч хэрэглэж, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлж хүний эд, эрхтэнийг авсан бол	2-8 жил хүртэл хугацаагаар хорих ял
	3. Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг хохирогчийн хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдал, биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулж эрхшээлдээ байгаа хүний эсрэг үйлдсэн, эсхүл энэ гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.	5-12 жил хүртэл хугацаагаар хорих ял
16.6 дугаар зүйл. Хүүхэд худалдах	1. Төрүүлсэн, үрчлэн авсан, асран хамгаалж харгалзан дэмжиж байгаа хүүхдээ бусдад худалдсан нь энэ хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн шинжгүй бол	Арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Дээрх хүснэгтээс үзвэл Эрүүгийн хуулийн холбогдох заалтууд нь дараах байдлаар хэл найруулгын хувьд зөрчил үүсгэж байна:

- Эрүүгийн хуулийн 13.2 дугаар зүйлд бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийг **ашиг олох зорилгоор** бага насны болон 14-18 насанд хүрээгүй хүнийг албадан оруулж үйлдсэн тохиолдолд зүйлчлэлийг хүндрүүлэн ял оногдуулахаар заасан. Гэтэл тус хуулийн 13.1-д хүүхдийн эсрэг ХХГХ-ийг үйлдсэн тохиолдолд ямар арга хэлбэрээр үйлдэгдсэн байгааг үл харгалзан шийдвэрлэхээр заасан байна. Өөрөөр хэлбэл ямар нэг ашиг олох зорилгоор хүүхдийг бэлгийн мөлжлөгт өртүүлсэн тохиолдолд тус хоёр заалтын алингээр нь шийдвэрлэх эсэх нь тодорхойгүй байна.
- Эрүүгийн хуулийн 13.13 дугаар зүйлд албадан хөдөлмөрлүүлэх явдлыг гэмт хэрэгт тооцохоор заасан. Гэвч тус заалтын зүйлчлэлийн агуулга нь Эрүүгийн хуулийн 13.1-р зүйлд заасан ХХГХ-ийн

албадан хөдөлмөрлүүлж мөлжих үйлдлийн шинжтэй давхцаж байгаа хэдий ч оноох ялын хэмжээ 13.1-р зүйл заалтаас бага байна.

- Мөн Эрүүгийн хуулийн 16 дугаар бүлэгт Хүүхдийн эсрэг гэмт хэргийг хуульчилсан нь нэг талаасаа хүүхдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн сайшаалтай хэдий ч тус заалт нь мөн л тус хуулийн 13.1-р зүйл ХХГХ-ийн шинжүүдтэй давхардаж байгаа юм. 13.1-р зүйлийн тайлбарт хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэн бол ямар аргаар хэрхэн үйлдсэн эсэхийг үл харгалзаж хүн худалдаалах гэмт хэрэг гэж үзэх заалттай зөрчилдөж байна.
- Эрүүгийн хуулийн 15.3 дугаар зүйлд Хүний цус, эс, эд, эрхтэнийг хууль бусаар авах гэмт хэргийг заахдаа “хууран мэхэлж, эсхүл хүч хэрэглэж, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлж, хохирогчийн хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдал, биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулж хүний цусыг, эсийг, эд, эрхтэнийг авсан” бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан. Гэвч Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйл буюу Хүн худалдаалах хэргийн агуулгад “...эд, эрхтэнийг авах...” тухай дурдсан байна.

Эдгээр гэмт хэргүүдэд (Эрүүгийн хуулийн 12.3 Бэлгийн мөлжлөг, 13.13 Албадан хөдөлмөрлүүлэх, 15.3 Хүний цус, эс, эд, эрхтэнийг хууль бусаар авах, 16.6 Хүүхэд худалдах) оноох ял шийтгэлийн хэмжээг харьцуулж үзвэл 13.1-р зүйл буюу Хүн худалдаалах хэрэгт оноох ялын хэмжээнээс бага байна (**Хүснэгт 3**). Гэвч гэмт хэргийн үндсэн шинж нь ХХГХ-ийн нөхцөлтэй ижил, нэг гэмт хэрэгт Эрүүгийн хуулийн хоёр болон түүнээс дээш зүйл заалт хамаарч байгаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хуулийн зүйл заалтыг нэг мөр хэрэглэхэд тодорхойгүй нөхцөл байдал үүсгэхээр байна. Мөн уг зүйл заалтын давхардал нь ХХГХ-ийн статистик мэдээллийг тодорхой гаргахад хүндрэл учруулж байна.

Эндээс үзэхэд 2015 онд батлагдсан шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан Хүн худалдах гэмт хэргийн шинж нь Монгол Улсын нэгдэн орсон Палермо протоколын тодорхойлолттой нийцсэн хэдий ч хуулийн хэрэгжүүлэгчдийг хуулийг нэг мөр зөв хэрэглэх боломжоор хангахын тулд Эрүүгийн хууль дахь ижил төстэй гэмт хэргийн зүйлчлэлийн давхардлыг шийдвэрлэх шаардлагатай.

Судалгааны арга зүй

Судалгааны зорилтуудад хүрэхийн тулд судалгааны баг (1) баримт бичгийн судалгаа, (2) тоон судалгаа, (3) чанарын судалгааны аргуудыг ашиглан мэдээлэл цуглуулж шинжилгээ хийв.

Баримт бичгийн судалгаа. Баримт бичгийн судалгааны хүрээнд дараах үндсэн дөрвөн төрлийн бичиг баримтад шинжилгээ хийсэн. Доор дурдсан баримт бичгүүдийн жагсаалттай “Ашигласан материалын жагсаалт” бүлгээс танилцах боломжтой.

- **Хууль эрх зүйн баримт бичиг** - ХХГХ-тэй холбоотой олон улсын болон үндэсний хууль тогтоомж, холбогдох журам зэрэг нийт 30 орчим эрх зүйн баримт бичигтэй танилцсан.
- **Судалгаа, эрдэм шинжилгээний бүтээл** - ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдсэн ижил төстэй дотоодын 33 болон олон улсын 22 судалгааны тайлантай танилцсан.
- **Тоон мэдээлэл** - Мэдээлэл цуглуулалтын явцад судалгаанд хамрагдсан төрийн болон төрийн бус байгууллага (ТББ)-ын таван³⁹ эх сурвалжаас албан хүсэлтийн дагуу тоон мэдээллийг цуглуулж, судалгааны тайланд тусгасан.
- **Хавтаст хэргийн материал** - Эрүүгийн хэргийн архивд хадгалагдаж буй, Эрүүгийн хууль /2002/-ийн тусгай ангийн 113-р зүйлд заасан Хүн худалдаалах, 124-р зүйлд заасан Биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах, Эрүүгийн хууль /2015/-ийн 13.1 дүгээр зүйлд заасан Хүн худалдаалах гэмт хэргээр 2014-2018 онд шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн 14 хохирогчтой долоон хэргийн материалтай танилцаж, хэргийн шалтгаан, нөхцөлд дүн шинжилгээ хийв.

³⁹ Эрүүл мэндийн хөгжлийн төв, ГХЯ, ЦЕГ, ГИХГ, УЕПГ

Тоон судалгаа. Иргэдийг ХХГХ-т өртөхөд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодруулахын тулд сонгогдсон орон нутгийн 467 иргэнийг хамруулсан тоон судалгааг зохион байгуулсан. Судалгааг (1) эрсдэлт бүлгийн иргэдийг илрүүлэх, (2) эрсдэлтэй болох нь илэрсэн иргэдийн эмзэг байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг судлах зорилготой хоёр үе шаттай гүйцэтгэсэн.

Нэгдүгээр шатанд, эрсдэлт бүлгийн иргэдийг анхан шатны түвшинд илрүүлэхдээ “ХХГХ-ийн хохирогчийг таних жишиг маяг”⁴⁰-д үндэслэн боловсруулсан асуултыг ашигласан бол **хоёрдугаар шатанд,** иргэдийн эмзэг байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг судлахдаа ОУШХБ-ын “Эмзэг байдлыг тодорхойлох загвар” (цаашид DoMV загвар гэх)-ыг ашиглалаа. Уг загвар нь хувь хүн, гэр бүл/өрх, олон нийт, бүтцийн дөрвөн түвшинд хувь хүнийг эрсдэлд оруулахад нөлөөлж буй болон хамгаалж буй хүчин зүйлсийг тодруулж, иргэдийн эмзэг байдлыг бууруулах интервенц хэрэгжүүлэхэд ашиглагддаг аргачлал юм.

Тус загвараар хүн аливаа гэмт хэргийн хохирогч болох нь зөвхөн хувь хүн эсвэл гэр бүлээс хамаарсан нэгээс хоёр тодорхой хүчин зүйлээс шалтгаалдаггүй гэж үздэг. Хувь хүн, гэр бүл, амьдарч буй орон нутаг нь хүнийг ямар нэгэн эрсдэлд ороход шууд болон шууд бусаар нөлөөлж байдаг. Эрсдэлд хүргэж буй түвшин тус бүрийн гэмт хэргийн гаралтад үзүүлэх нөлөө харилцан адилгүй боловч хоорондоо шууд хамааралтай. Иймд DoMV загварын дагуу хувь хүнийг ХХГХ-ийн хохирогч болоход нөлөөлөх хүчин зүйлсийг хувь хүн, гэр бүл, олон нийтийн түвшинд тоон аргаар судлав.

Чанарын судалгаа. ХХГХ-ийн эрсдэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг олон нийтийн болон бүтцийн түвшинд тодруулах, Монгол дахь ХХГХ-ийн нөхцөл байдал, урсгал чиглэл, хохирогч хамгааллын үйлчилгээтэй холбоотой одоогийн нөхцөл байдлыг тодруулах зорилгоор иргэд, үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд, тогтолцооны холбогдох оролцогч талуудаас хагас бүтэцлэгдсэн ярилцлага, ганцаарчилсан ярилцлага, болон фокус бүлгийн ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулсан.

Судалгааны түүвэр

Судалгааны зорилгод хамаарах мэдээллийг ХХГХ-тэй тэмцэх тогтолцооны гол оролцогч талууд, үйлчилгээ үзүүлэгч байгууллага⁴¹ болон эрсдэлт бүлгийн иргэд, хохирогчдын төлөөлөлтэй уулзаж, цуглуулсан. Судалгаанд оролцогчдын түүврийн дэлгэрэнгүй мэдээллийг **Хүснэгт 4**-д харуулав.

Хүснэгт 4. Түүврийн хэмжээ, оролцогч талуудаар

#	Оролцогч талууд	Судалгаанд хамруулсан төлөөлөл	Арга	Түүврийн хэмжээ
1	Төрийн албан хаагчид	ХЗДХЯ-ГХУСАЗЗАА, Шүүх, Прокурор, Цагдаа, ГИХГ, Хилийн шалган нэвтрүүлэх алба	Хагас бүтэцлэгдсэн ярилцлага, асуумж	20
2	Үйлчилгээ үзүүлэгч талууд, ТББ	ТББ, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээ	Хагас бүтэцлэгдсэн ярилцлага	9
3	Шүүхээр шийдэгдсэн ХХГХ-ийн хэргүүд	Эрүүгийн хэргийн төв архивт хадгалагдаж буй 2014-2018 ⁴² оны хооронд шийдвэрлэгдсэн хэргүүд	Хавтаст хэргийн судалгаа	7
4	Орон нутгийн иргэд, албан хаагчдын төлөөлөл	Төслийн зорилтот байршил тус бүрээс	Фокус бүлгийн ярилцлага	6
5	ХХГХ-т өртөх эрсдэл бүхий иргэд	Илрүүлэх үнэлгээгээр эрсдэлтэй болох нь илэрсэн иргэд	Асуумж	423

⁴⁰ Стандарт, хэмжил зүйн газраас батлан гаргасан ХХГХ-ийн хохирогчид нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6418:2013 стандартын 1 дүгээр Хавсралт, Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг тодорхойлох жишиг маяг

⁴¹ ХХГХ-ийн хохирогчид нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6418:2013 стандартын нэр томъёог ашигласан.

⁴² Мэдээлэл цуглуулалт явагдаж байх хугацаанд Эрүүгийн хэргийн төв архивт 2019 онд шийдвэрлэгдсэн хэргүүдийн мэдээлэл ирээгүй байв.

6	Биеэ үнэлэгч иргэд	Төслийн зорилтот байршил тус бүрээс	Ганцаарчилсан ярилцлага	10
7	Гадаадын иргэд	ХХГХ-ийн хохирогч болсон гадаад иргэд (Мьянмар)	Ганцаарчилсан ярилцлага	3

Судалгааны хамрах хүрээ, хязгаарлагдмал тал

ХХГХ нь зохион байгуулалттай үйлдэгддэг нуугдмал гэмт хэрэг тул тус судалгаа нь арга зүй, хэрэглэгдэхүүний хувьд тодорхой хүрээнд хязгаарлагдах нь зайлшгүй. Иймд эхлэлтийн тайланд тусгасан судалгааны арга зүйн дагуу судалгаа дараах хүрээнд хязгаарлагдана:

- **Нэр томьёо, ойлголтын хүрээ:** ХХГХ-ийн ойлголт нь өргөн хүрээтэй. Монгол Улсад болон олон улсад хамгийн түгээмэл үйлдэгддэг, бүртгэгддэг төрөл нь бэлгийн мөлжлөг болон албадан хөдөлмөр эрхлүүлэх зорилгоор хүнийг худалдах хэлбэрүүд байна. Дээрхээс бусад ХХГХ-ийн хэлбэрүүд болох эс, эд эрхтэний наймаа, зуучлалын захиалгат гэрлэлт Монгол Улсын хуулийн байгууллагад бүртгэгдээгүй нь баримт бичгийн судалгаанаас харагдсан. Иймд энэхүү тайланд авч үзсэн ХХГХ-ийн төрөл хэлбэр, тус бүрийн нөхцөл байдал нь мэдээллийн олдоцтой байдалд үндэслэн тайланд тусгагдсан болно.
- **Мэдээлэл цуглуулалтын хүрээ:** Тус судалгааг гүйцэтгэхдээ Монгол Улс дотоодод болон гадаад улсад ХХГХ-ийн хохирогч болсон Монгол иргэд болон Монгол Улс дотоод ХХГХ-ийн хохирогч болсон гадаад иргэдийн асуудлыг хамруулан авч үзсэн болно.
- **Судалгаанд оролцогчдын насны хязгаар:** Үндэсний болон олон улсад хийгдсэн олон судалгааны үр дүн хүүхдүүд уг гэмт хэрэгт эмзэг, өртөмтгий, эрсдэлт бүлэг болохыг нотлон харуулдаг. Гэвч хүүхэд хамгааллын асуудалтай холбоотойгоор уг судалгаанд насанд хүрээгүй иргэдийг хамруулаагүй бөгөөд хүүхдүүдийн нөхцөл байдлыг баримт бичгийн судалгааны хүрээнд тодруулахыг зорив. Иймд судалгааны анхдагч өгөгдлийг зөвхөн насанд хүрсэн иргэдийн дунд цуглуулсан.
- **Тоон шинжилгээний хүрээ:** ХХГХ-т өртөмтгий байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг шинжлэхдээ “Хүн худалдаалахтай тэмцэх тухай” хуульд заасан гэмт хэргийн тодорхойлолтод заасан элементүүд (хорьж цагдах, хүч хэрэглэх, хуурч мэхлэх...) болон ХХГХ-ийн хохирогчийг тодорхойлох жишиг маягт (MNS 6418: 2013 стандартын Хавсралт 1)-уудыг үндэслэл болгосон. Иймд нөлөөлж буй хүчин зүйлсийн шинжилгээ нь ХХГХ гэх ерөнхий тодорхойлолтын хүрээнд тайлбарлагдах бөгөөд түүний төрөл, хэлбэр тус бүрээрх нарийн ялгааг хэлэх боломжгүй юм.

НЭГ: ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДЭГДЭХЭД НӨЛӨӨЛЖ БУЙ ЭРСДЭЛТ БОЛОН ХАМГААЛАГЧ ЗҮЙЛС

Судалгааны гол зорилтуудын нэг нь иргэдийг ХХГХ-т өртөхөд нөлөөлж буй болон хамгаалж буй хүчин зүйлсийг тодорхойлох байв. Уг зорилтод хүрэхийн тулд ХХГХ-ийн эрсдэл өндөр гэж үзсэн орон нутгууд⁴³-д 467 иргэнийг хамруулсан хоёр үе шаттай тоон судалгааг зохион байгуулсан. Нэгдүгээр шатанд, зорилтот бүлгийн 467 иргэний дунд ХХГХ-т өртөх эрсдэлийг илрүүлэх судалгааг гүйцэтгэсэн бол хоёрдугаар шатанд эрсдэлтэй болох нь тодорхойлогдсон 423 иргэний эмзэг байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодруулах зорилготой мэдээлэл цуглуулалтыг зохион байгуулсан.

1-р шат	Эрсдэлт бүлгийн иргэдийг илрүүлэх судалгаа (n=467)
2-р шат	ХХГХ-т өртөх эмзэг байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг тодорхойлох судалгаа (n=423)

Аргачлалын хувьд нэгдүгээр шатны илрүүлэх судалгааг зохион байгуулахдаа, ХХГХ-ийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” (MNS 6418:2013) стандартын Хавсралт 1-ээр батлагдсан ХХГХ-ийн хохирогчийг тодорхойлох жишиг маягт болон ХЗДХЯ-аас олон нийтэд санал болгодог ХХГХ-ийн эрсдэлийг таних 9 асуултад үндэслэж боловсруулсан 25 асуулт бүхий асуумжийг ашигласан⁴⁴.

Хоёрдугаар шатанд, иргэдийн эмзэг байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг шинжлэхдээ **Хүснэгт 5**-д үзүүлсэн шалгуур үзүүлэлт, түүнийг хэмжих хувьсагч, хувьсагчийн босго утгыг харгалзан **“ХХГХ-т өртөмтгий байдлын индекс” (Human Trafficking Index, цаашид НТИ гэх)** тооцсон. Эдгээр шалгуур үзүүлэлтийг тодорхойлохдоо Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд заасан ХХГХ-ийн тодорхойлолтод туссан гэмт хэрэг үйлдэх аргуудад суурилсан болно. Ийнхүү НТИ индексийг тооцоноор иргэдийн эмзэг байдлыг нэмэгдүүлэх болон бууруулахад нөлөөлж буй хүчин зүйлсийг ОУШХБ-ын DoMV загварын дагуу хувь хүн, гэр бүл, олон нийтийн түвшинд тодруулах нөхцөлийг бүрдүүлж өгсөн.

Хүснэгт 5. ХХГХ-т өртөмтгий байдлын индекс (НТИ) тооцсон шалгуур үзүүлэлт

#	ХХГХ-ийг тодорхойлох элемент ⁴⁵	Хэмжих хувьсагч	Хувьсагчийн босго утга
1	Хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах	Хүч хэрэглэхээр заналхийлсэн, эсвэл хүч хэрэглэсэн байдал	...-тай тулгарч байсан.
2		Дарамталж, айлган сүрдүүлсэн байдал	...-тай тулгарч байсан.
3	Залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах	Хуурч, мэхэлсэн байдал байдал	...-тай тулгарч байсан.
4	Өөр хүнийг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, хахуульдах аргаар хүнийг элсүүлэх, тээвэрлэх, нуун далдлах, дамжуулах, хүлээн авах	Хорьж, цагдаж, хянасан байдал	...-тай тулгарч байсан.

Шалгуур үзүүлэлтэд харгалзах элемент бүрд тэнцүү жин өгч, индексийг тооцсон. НТИ нь 0-ээс 1-ийн хооронд утгаар хэмжигдэх ба 0-рүү дөхөх тусам ХХГХ-ийн эрсдэлүүдэд өртөж байгаагүй, 1 рүү дөхөх тусам ХХГХ-ийн шинжтэй үйлдлүүдэд өртөж байсныг илэрхийлнэ.

⁴³ Мэдээлэл цуглуулалт явагдсан орон нутгууд: Улаанбаатар хот (n=234), Дархан (n=63), Өмнөговь (n=63) болон Дорнод (n=63).

⁴⁴ Илрүүлэх судалгааны асуумжтай Хавсралт 2-оос танилцана уу.

⁴⁵ ХХГХ-ийг үйлдэх аргууд

Нэгдүгээр шат. Эрсдэлт бүлгийн иргэдийг илрүүлэх судалгаа

Илрүүлэх судалгаанд ХХГХ-ийн шинжтэй үйлдлүүдэд өртсөн болон өртөх эрсдэлтэй иргэдийг танихад чиглэсэн 25 асуулт бүхий асуумж ашигласан⁴⁶. Асуумжийг “ХХГХ-ийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” (MNS 6418:2013) стандартын Хавсралт 1-ээр батлагдсан ХХГХ-ийн хохирогчийг тодорхойлох жишиг маягт болон ХЗДХЯ-аас олон нийтэд санал болгосон ХХГХ-ийн эрсдэлийг таних 9 асуултад үндэслэж боловсруулсан. Илрүүлэх судалгааны хэрэглэгдэхүүн, эрсдэлтэй иргэнийг таних шалгуур үзүүлэлттэй Хавсралт 2. Тоон судалгааны хэрэглэгдэхүүн хэсгээс танилцах боломжтой.

Эрсдэлт бүлгийн иргэдийг илрүүлэх судалгаанд нийт 467 иргэн хамрагдсаны 90.6 хувь (n=423) нь ХХГХ-т өртөх эрсдэлтэй иргэд байв. Илрүүлэлтийн хувь өндөр байгаа нь судалгаанд зорилтот түүврийн арга буюу ХХГХ-ийн төрөл хэлбэрүүдэд өртөх эрсдэл өндөр биеэ үнэлэгч, шилжин ирэгч, хөдөлмөр эрхэлдэггүй, бичиг баримтгүй, өрх толгойлсон, хүчирхийлэлд өртөж байсан, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхийн иргэдийг түлхүү хамруулсантай холбоотой байж болно. Энэ нь баримт бичгийн судалгаанд үндэслэн тодорхойлсон эдгээр зорилтот бүлгийн иргэдийн дунд эрсдэл өндөр байгааг давхар нотолж байв. Нэгдүгээр шатны судалгаагаар илэрсэн 423 оролцогчийн 58 хувь (n=245) нь эмэгтэйчүүд, 42 хувь (n=178) нь эрэгтэйчүүд, 35 хувь нь 19-30 насны оролцогчид, 31-40, 50 ба түүнээс дээш насны бүлгийн иргэд тус бүр 30 гаруй хувийг эзэлж байна.

Судалгааны үр дүнгээр, нийт оролцогчдын 86.5 хувь (n=365) нь ажил олгогч бичиг баримтыг нь хурааж авах тохиолдолтой тулгарч байсан, 60 хувь (n=252) нь өмнө нь ямар нэгэн гэрээ байгуулалгүйгээр хөдөлмөр эрхэлж байсан, тэдгээрийн ойролцоогоор 43 хувь (n=184) нь нэмэгдэл хөлсгүйгээр илүү цагаар ажилладаг байсан, 36 хувь (n=151) нь тохирсон цалин хөлсөө авч чадахгүй байх, ажил олгогчийн зүгээс үндэслэлгүй цалин бууруулах тохиолдолтой тулгарч байжээ (Зураг 2).

Зураг 2. ХХГХ-т өртөх эрсдэлийг таних асуултаудын үр дүн (n=423)



Эндээс үзэхэд судалгаанд хамрагдсан **хоёр хүн тутмын нэг нь ажил олгогчийн зүгээс анх тохирсноосоо өөр ажил хийхийг шаардах, шахах, ямар нэг байдлаар хуурч мэхлэх тохиолдлуудтай тулгарч байсан нь ХХГХ-ийн эрсдэл, ялангуяа хөдөлмөрийн мөлжлөгт өртсөн байх магадлалтайг харуулж** байв. Ялангуяа, эдгээр иргэдийн 5-8 хувь нь ажил олгогчийн зүгээс дарамталж айлган сүрдүүлэх, хүч хэрэглэх, хэрэглэхээр заналхийлэх, хорьж цагдаж хянах зэрэг

⁴⁶ Эрсдэлт түвшний иргэнийг тодорхойлох шалгуурыг тогтооходоо (1) өртсөн иргэдийг тодорхойлох 7 асуултын нэгд нь “тийм” гэж хариулсан бол, (2) өртөх эрсдэлтэй иргэдийг таних 18 асуултын гурваас дээш асуултад “тийм” гэж хариулсан бол тухайн оролцогчийг эрсдэлтэйд тооцсон.

хүчирхийллийн хэлбэрүүдийг мэдэрч байсан, 6 хувь нь ажил олгогчдоо өр төлбөртэй байсан гэж хариулжээ (Зураг 3).

Зураг 3. ХХГХ-ийн хэлбэрүүдэд өртсөн байдлыг таних асуултуудын үр дүн (n=423)



Цаашлаад, тухайн оролцогчийг ХХГХ-ийн эрсдэлт оруулах зан үйл бий эсэхийг тодруулах зорилгоор тодорхой болзолт нөхцөлүүдийг санал болгоход, нийт оролцогчдын 72 хувь (n=305) нь Монгол Улсад өндөр цалинтай ажил зуучлах санал тавбал зуучилж буй хүнийг танихгүй байсан ч зөвшөөрнө, 43 хувь (n=182) нь гадаад оронд очиж хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх санал тавьбал зөвшөөрнө гэж хариулснаас үзэхэд эдгээр нөхцөлийн төлөө оролцогчид өөрсдийгөө эрсдэлд оруулах магадлал өндөр байна. Ялангуяа, дээрх хариултыг эрэгтэйчүүд илүү өгч байв. Тодруулбал, өндөр цалин хөлстэй ажлын байрны нөхцөлийг санал болгосон дараах 2 асуултад хүйсийн зөрүү хамгийн өндөр байна. Үүнд: Монголдоо өндөр цалин хөлстэй ажилд зуучлах саналыг зөвшөөрөх байдал эрэгтэйчүүдийн хувьд эмэгтэйчүүдээс 17 хувиар илүү, гадаад улсад очиж ажил эрхлэх саналыг зөвшөөрөх байдал хамгийн өндөр буюу 30 хувиар илүү байгаа нь хүйсээс хамаарсан мэдэгдэхүйц ялгаа бийг харуулж байна.

Зураг 4. ХХГХ-т өртөх эрсдэлийг танихад чиглэсэн болзолт нөхцөлийг зөвшөөрч буй оролцогчид, хүйсээр




Уг үр дүн нь ХХГХ-т өртөх эмзэг байдлыг хэмжсэн индексийн тооцооллоор мөн батлагдаж байв. Уг шинжилгээгээр **ХХГХ-т өртөх эмзэг байдалд хүйсийн ялгаатай байдал нь нөлөөгүй болох нь батлагдсан**. Өөрөөр хэлбэл, аль аль хүйсийн дунд энэ төрлийн гэмт хэрэгт өртөх эрсдэл байна гэж үзэж болно. ХХГХ-ийн шинжтэй үйлдэлд өртсөн 120 иргэдийг⁴⁷ хүйсээр нь авч үзэхэд, эмэгтэйчүүд илүү **дарамталж, айлган сүрдүүлэх, хорьж, цагдах үйлдэлд өртөж байсан бол эрчүүд ажил олгогч талдаа хуурч, мэхлэгдэх тохиолдлуудад илүү өртсөн байна. Энэ нь эрэгтэйчүүд илүү хөдөлмөр мөлжлөгт өртөх эрсдэлтэйг харуулж байсан ба уг үр дүнг үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын өгсөн мэдээлэл мөн баталж байв. Тухайлбал, ХХГХ-ийн хохирогчид үйлчилгээ үзүүлдэг Хүйсийн тэгш эрхийн төв (ХТЭТ)**-өөр 2003-2018 оны хооронд үйлчлүүлсэн нийт үйлчлүүлэгчдийн 13 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Эдгээр бүх үр дүн нь ХХГХ-ийн хохирогчдын дунд хүйсийн ялгаа багасч байгааг харуулж байна.

Хоёрдугаар шат: ХХГХ-т өртөмтгий байдлыг тодорхойлох судалгаа


Нэгдүгээр шатны судалгаагаар илэрсэн эрсдэлт бүлгийн 423 иргэний мэдээлэлд тулгуурлан НТИ индексийг тооцсон. Нийт оролцогчдын үзүүлэлтээр **ХХГХ-т өртөмтгий байдлын индекс 0.10 дундаж утгатай, 0.19 стандарт хазайлттай гарсан** ба **Зураг 5-д үзүүлсэн хистограммаар зурагдаж байна. Тодруулбал, судалгаанд хамрагдсан 423 иргэнээс ХХГХ-т өртөмтгий байдлын индексийн шалгуур үзүүлэлтээс дор хаяж нэг үйлдэлд 28.4 хувь нь буюу 120 иргэн өртсөн байна. Энэ нь эдгээр иргэд ХХГХ-т өртөмтгий шинжтэй байгааг илтгэнэ.** ХХГХ-т өртөмтгий байдлыг хэмжих дөрвөн шалгуур үзүүлэлтийн дагуу:

- Гурван хүн дөрвөн үзүүлэлтэд бүгдэд нь өртсөн
- 9.2 хувь (n=11) нь дөрвөн үзүүлэлтийн гуравт нь өртсөн
- 20 хувь (n=24) дөрвөн үзүүлэлтийн хоёрт нь өртсөн
- 68.3 хувь (n=82) нь дөрвөн үзүүлэлтийн нэгд нь өртсөн байна (**Зураг 6**).

Зураг 5. ХХГХ-т өртөмтгий байдлын индексийн хистограмм, (n=423)



Зураг 6. ХХГХ-т өртөмтгий байдлын хистограмм, хувиар, (n=120)




ХХГХ-ийн шинжтэй үйлдэлд өртсөн иргэдийн эзлэх хувийг хүйсээр ялган харуулсан

Зураг 7-оос харахад эрэгтэйчүүд илүү хуурч, мэхлэгдэх байдалд өртсөн бол, эмэгтэйчүүдийн хувьд дарамталж, айлган сүрдүүлэх, хорьж, цагдах үйлдэлд хамгийн их өртөж байжээ.

⁴⁷ Хоёрдугаар шат: ХХГХ-т өртөмтгий байдлыг тодорхойлох судалгааны хэсэгт дэлгэрэнгүй үр дүнг тусгав.


Зураг 7. ХХГХ-ийн шинжтэй үйлдлүүдэд өртүүлсэн аргууд, хүйсээр, (n=120)



Өгөгдлийн эх сурвалж: ХХГХ-т өртөмтгий байдлыг тодорхойлох түүвэрлэлт

Насны хувьд, ахмад настай иргэдтэй харьцуулахад **залуучууд ХХГХ-т илүү өртөмтгий** байна (Зураг 8). Ялангуяа **20-24 насны иргэд** хамгийн их өртөмтгий байгаа бол удаад нь 30-34, 35-39 насны иргэд орж байна.

Зураг 8. ХХГХ-т эмзэг өртөмтгий байдал, насны бүлгээр (n=120)



Өгөгдлийн эх сурвалж: ХХГХ-т өртөмтгий байдлыг тодорхойлох түүвэрлэлт

ОУШХБ-ын DoMV загварын дагуу ХХГХ-т өртөмтгий байдлын индекст хувь хүн, гэр бүл, олон нийтийн хүчин зүйлс хэрхэн нөлөөлж буйг авч үзсэн шинжилгээний үр дүнг дараагийн бүлгүүдэд дэлгэрэнгүй авч үзлээ.

Хэсэг 1: Хувь хүний түвшний эрсдэлт болон хамгаалагч хүчин зүйлс

Энэ хэсэгт хувь хүний ямар онцлог, шинж чанар тухайн хүнийг ХХГХ-т өртөмтгий болгодог, эсвэл ХХГХ-т өртөхөөс хамгаалах нөлөө үзүүлж буйг шинжиллээ. Ингэхдээ ОУШХБ-ын DoMV загварын хувь хүний түвшний хүчин зүйлүүд (factors)-д үндэслэн ХХГХ-т өртөх байдалд нөлөөлөх хүчин зүйлсийн талаар дараах таамаглал (hypothesis)-ыг дэвшүүлж, тухайн таамаглал биелж байгаа эсэхийг олон хүчин зүйлсийн регрессийн загвар (multivariate regression model) ашиглан шинжиллээ.

- **Таамаглал 1.** Нас, биологийн хүйс, үндэс, угсаа, шашин шүтлэг, жендэр, бэлгийн чиг баримжаа, боловсролын түвшин зэрэг хүн ам зүйн хүчин зүйлсээс хамаарч хүн тус бүрийн ХХГХ-т өртөмтгий байдал ялгаатай байна.
- **Таамаглал 2.** ХХГХ-т өртөмтгий байдалд тухайн хүний нийгэмд эзлэх байр суурь, харилцааны чадвар, бие махбодын болон сэтгэлзүйн байдал, эрүүл мэндийн болон санхүүгийн мэдлэг, ХХГХ-ийн талаарх мэдлэг зэрэг үзүүлэлтүүд нөлөөлнө.

- **Таамаглал 3.** Тухайн хүний хөдөлмөр эрхлэлт, санхүүгийн байдал, шилжин суурьшсан шалтгаан, амьдарч буй байрны төрөл, оршин суугаа газартаа албан ёсны бүртгэлтэй эсэх нь хөдөлмөр мөлжлөгт өртөх магадлалыг нэмэгдүүлж, ХХГХ-т өртөмтгий байдалд нөлөөлнө.
- **Таамаглал 4.** Тухайн хүний шилжилт хөдөлгөөний түүх буюу шилжин суурьшсан эсэх, аяллын логистик (хэнтэй хамт аялж байсан зэрэг), шилжилт хөдөлгөөний тодорхой төлөвлөгөөтэй байсан эсэх зэрэг мэдээлэлд тулгуурлан ХХГХ-т өртөмтгий байдалд нөлөөлөгч, эсвэл хамгаалагч хүчин зүйлсийг тодорхойлж болно.

ХХГХ-т өртөмтгий байдлыг тодорхойлох олон хүчин зүйлсийн регрессийн шинжилгээнд түүвэр судалгаанд хамрагдсан 423 хүний мэдээллийг ашиглав. Регрессийн хамааран хувьсагчаар ХХГХ-т өртөмтгий байдлын индексийг авч, DoMV загварын дагуу үл хамаарах хувьсагчдыг сонгосон болно.

Регрессийн загваруудын үр дүнд үндэслэн ХХГХ-т өртөмтгий байдалд нөлөөлөгч хүчин зүйлсийг доорх хэсэгт тайлбарлалаа. Регрессийн загваруудтай Хавсралт 4. ХХГХ-т өртөмтгий байдалд нөлөөлөгч хүчин зүйлсийн шинжилгээ хэсгээс танилцах боломжтой.

1.1 Хувь хүний түвшний эрсдэлт хүчин зүйлс:

Залуучууд илүү ХХГХ-т өртөмтгий буюу нас залуужих хэрээр ХХГХ-т өртөх эрсдэл нэмэгдэж байна. Хавсралт 4-т харуулсан **Хүснэгт 16**-д харуулсан регрессийн (3)-р загварт **Age** хувьсагчийн үнэлэгдсэн коэффициент -0.002 байгаа нь судалгаанд оролцогчдын нас нэгээр залуужихад тэдний НТИ индекс 0.002 -оор өсөх магадлалтай байгааг 95 хувийн итгэх завсарт харуулж байв. DoMV загварын гарын авлагад 18-30 насны хооронд, болон 50-аас дээш насны иргэд ХХГХ-т илүү өртөмтгий талаар дурдсан бол тус судалгааны үр дүнгээр Монгол Улсад ахмад настай иргэдтэй харьцуулахад залуучууд (18-24 насны) ХХГХ-т өртөх магадлал өндөр байна. Чанарын судалгааны үр дүнд мөн дээрх нөхцөл байдал батлагдаж байсан ба ХХГХ-ийн хохирогчдын дунд ахмад настай (50 ба түүнээс дээш насны) хүний төлөөлөл байсан талаар мэдээлэл дурдагдаагүй байна.

Оюутан, улирлын чанартай ажил эрхлэх болон цагийн ажил эрхэлдэг байх нь ХХГХ-т өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Тогтсон ажилтай бол ХХГХ-т өртөх эрсдэл буурч, улирлын шинжтэй эсвэл цагийн ажил эрхэлдэг бол ХХГХ-т өртөх эрсдэл өсөх хандлагатай байгааг **Хүснэгт 16**-д харуулсан (2), (3), (5)-р загварын үр дүнгүүд харуулна. Уг үр дүнг НТИ индекс болон хөдөлмөр эрхлэлтийн байдал хооронд энгийн статистик шинжилгээ хийж шалгахад мөн ижил оюутан⁴⁸ болон улирлын чанартай⁴⁹, эсвэл цагийн⁵⁰ ажил эрхэлдэг иргэд ХХГХ-т өртөх эрсдэл өндөр байгаа нь батлагдсан.

Бие махбодын болон сэтгэл зүйн хувьд хүнд, хэцүү нөхцөлд орж байсан бол ХХГХ-т өртөх эмзэг байдал нэмэгдэж байна. *Physical_Psychosocial_Bad_Condition* хувьсагч нь бие махбодын болон сэтгэл зүйн ямар нэгэн таагүй, хүнд нөхцөлд орж байсныг төлөөлөх чанарын хувьсагч юм (**Хүснэгт 16**). Сүүлийн 3 жилийн хугацаанд гэр бүл салсан, ойр дотны хэн нэгэн нь хүндээр өвдсөн, ойр дотно хүнээ алдсан, өөрөө хүндээр өвдсөн, эсвэл бэртсэн, өр зээлтэй болсон, ажилгүй, орлогогүй болсон, албан бус шилжилт хөдөлгөөнд орсон бол 1, үгүй бол 0 утга оноож үнэлгээг хийсэн. Хувьсагчийн үнэлэгдсэн утга эерэг гарсан нь бие махбодын болон сэтгэл зүйн ямар нэгэн таагүй, хүнд нөхцөлд орж байсан иргэд ХХГХ-т өртөх магадлал өсөж байгааг статистикийн ач холбогдолтойгоор харуулж байна. Тодруулбал, ХХГХ-т өртөмтгий байдлын шалгуурыг ханган хоёр дахь шатны судалгаанд хамрагдсан нийт 423 оролцогчийн 87 хувь ($n=368$) нь судалгаанд хамрагдахаас өмнөх 3 сарын хугацаанд стресс, бухимдал, санаа зовнил, сэтгэл гутрал, айдас түгшүүртэй байгаа гэсэн хариултуудыг өгсөн байв.

Шүүхээр шийдвэрлэгдсэн хавтаст хэргийн материалуудад дүн шинжилгээ хийх явцад хохирогчийн сэтгэл зүйн тогтворгүй, таагүй төлөв байдал нь бусдад амархан хууртагдах, ятгалгад орох, эрсдэлтэй шийдвэр гаргахад нөлөөлсөн болох нь харагдаж байв (**Шигтгээ 1**). Мөн ижил төстэй хийгдсэн

⁴⁸ *coef* = 0.071; *robust s.e* = 0.040; *p - value* = 0.078

⁴⁹ *coef* = 0.064; *robust s.e* = 0.034; *p - value* = 0.063

⁵⁰ *coef* = 0.081; *robust s.e* = 0.032; *p - value* = 0.013

судалгааны тайлангуудад хохирогчийн сэтгэл зүйн тогтворгүй төлөв байдал нь эрсдэлтэй шийдвэр гаргахад нөлөөтэй байгаа талаар тэмдэглэжээ⁵¹. Эдгээр үр дүнгээс үзэхэд, хувь хүний нийгэм эдийн засгийн нөхцөл байдлаас гадна сэтгэл зүйн тогтворгүй байдал, ялангуяа тус нөхцөл байдалд гэр бүлийн харилцаа таарамжгүй байх нь иргэдийг гэмт хэрэгт өртөхөд нөлөөтэй байгааг харуулж байна.

Шигтгээ 1. Гэр бүлийн таарамжгүй харилцаанаас үүдсэн сэтгэл зүйн тогтворгүй байдал нь эрсдэлтэй шийдвэр гаргахад нөлөөлсөн талаар

Бэлгийн мөлжлөгийн хохирогч Ч.М нь 9 хүүхэдтэй айлын отгон хүүхэд бөгөөд эцэг эх нь нас барж, ах, эгч нартайгаа таарамжгүй харьцаатай байсны улмаас Улаанбаатарт ганцаараа ирсэн. Ирээд амьдрах тогтсон хаяггүй, эрхэлсэн тодорхой ажилгүй байсан тул яаж хурдан мөнгөтэй болох талаар л боддог байсан талаар мэдүүлэгтээ дурдсан байна. Түүнчлэн холбоо тогтоон тусламж гуйх хүнгүй байсан нь удаан хугацаагаар гэмт хэргийн хохирогч болох эрсдэлийг нэмэгдүүлсэн байв...

Хавтаст хэргийн материалаас

Ганц бие, эсвэл гэрлэлтээ цуцлуулсан бол ХХГХ-т өртөх эрсдэл нэмэгдэж байна. Гэрлэлтийн статусыг харуулсан *Marriage_Single* хувьсагч гэрлээгүй, ганц бие иргэнийг, *Marriage_Cohabitant* хувьсагч хамтран амьдрагч иргэнийг, *Marriage_Divorced* хувьсагч гэрлэсэн хэдий ч гэрлэлтээ цуцлуулсан хүнийг тус тус төлөөлөх чанарын хувьсагч (dummy) юм. *Marriage_Single* болон *Marriage_Divorced* хувьсагчдын үнэлэгдсэн утга эерэг бөгөөд статистикийн ач холбогдолтой байгаа нь гэрлэсэн хүмүүстэй харьцуулахад ганц бие болон гэрлэлтээ цуцлуулсан иргэдийн ХХГХ-т өртөх эрсдэл илүү байгааг илтгэнэ.

Орлогын эх үүсвэр тасалддаг, тогтвортой орлогогүй, санхүүгийн тааруу нөхцөлд байдаг бол ХХГХ-т өртөх эрсдэл нэмэгдэж байна. *Financial_Situation_Bad* хувьсагч орлогын эх үүсвэр тасалддаг, тогтмол орлогогүй иргэдийг төлөөлөх чанарын хувьсагч (dummy) юм. Уг хувьсагчийн үнэлэгдсэн утга 0.117 буюу бусад үнэлэгдсэн хувьсагчдаас өндөр бөгөөд статистикийн ач холбогдолтой байгаа нь уг хувьсагч нь ХХГХ-т өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байгааг илтгэнэ.

Тус үр дүн хавтаст хэргийн судалгаагаар бүрэн нотлогдож байсан. Дийлэнх гэмт хэрэгтнүүд хохирогчдын санхүүгийн нөхцөл байдлаа сайжруулах гэсэн санаа зорилгыг далимдуулан хохирогчдыг элсүүлсэн байв. Уг нөхцөл байдал нь ялангуяа нь биеэ үнэлэгч эмэгтэйчүүдийг энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болох эрсдэлийг нэмэгдүүлдэг байна (**Шигтгээ 2**). Хавтаст хэргийн судалгаагаар ХХГХ-ийн 14 хохирогчийн найм нь өмнө нь биеэ үнэлж байсан өгүүлэмжтэй байна.

Шигтгээ 2. Биеэ үнэлэгч эмэгтэйчүүд ХХГХ-ийн хохирогч болж буй талаар

Мөнгөний шаардлага гарсан гэх шалтгаанаар тогтсон ажилгүй охид санхүү өгнө авна гэх цахим хуудсуудад ханддаг. Гэвч тэдгээр эмэгтэйчүүдийг клиент /үйлчлүүлэгч/ нэрээр гэмт этгээдүүд олзлон авч, гар утас, мөнгө, эд зүйлийг нь дээрэмдэж, хохирогчийг нүцгэлж дүрс бичлэг хийн тохуурхан даажигнаж олон нийтийн сүлжээнд байршуулна, ойр дотно, гэр бүлийн хүмүүст нь тухайн хийсэн дүрс бичлэгийг үзүүлж биеэ үнэлэгч гэдгийг нь хэлнэ гэх зэргээр амь нас, эрүүл мэнд, нэр, хүнд, хувь хүний нууцтай холбоотой эмзэг асуудлаар нь далимдуулан өөрсдийнхөө эрхшээлд оруулж бусдад хүчээр биеийг нь үнэлүүлж хүн худалдаалах гэмт хэргийн золиос болгож байна.

Цагдаагийн албан хаагчтай хийсэн ярилцлагаас

Бүртгэлтэй иргэдтэй харьцуулахад харьяа орон нутагтаа бүртгэлгүй оршин сууж буй иргэдийн ХХГХ-т өртөх эрсдэл өндөр байна. Орлогчдын нийгмийн суурь үйлчилгээ авах боломжийг тодруулах зорилгоор одоогийн амьдарч буй орон нутагтаа албан ёсны бүртгэлтэй эсэхийг тодруулахад судалгаанд оролцогчдын 20.8 хувь (n=88) нь албан ёсны бүртгэлгүй байв. Тэдгээр иргэдийн 57 хувь нь эмэгтэй, дийлэнх нь буюу 42 хувь нь 18-25 настай, хоёр хүн тутмын нэг нь (50 хувь) орон нутгаас хот уруу шилжин орж ирээд бүртгэлээ хийлгээгүй байна. Байршлаар авч үзвэл, судалгаа явагдсан орон нутгуудаас Улаанбаатар хот (30 хувь, n=71) болон Өмнөговь аймгаас (17.5 хувь n=11) хамрагдсан иргэдийн дунд бүртгэлгүй иргэд хамгийн олон байна. Иргэд албан ёсны бүртгэлгүй байх нь нийгмийн

⁵¹ Хууль зүйн үндэсний хүрээлэн (2007) Хүн худалдаалах гэмт хэргийн шийдвэрлэлт: Хавтаст хэргийн судалгаа

олон талт үйлчилгээг авах боломжийг хязгаарлаж, улмаар иргэдийн эмзэг байдлыг нэмэгдүүлэхэд нөлөө үзүүлдэг. Регрессийн загварын дагуу оршин сууж буй нутагтаа албан ёсны бүртгэлгүй бол бүртгэлтэй иргэдтэй харьцуулахад ХХГХ-т өртөх эрсдэл илүү өндөр байгаа нь батлагдаж байв (coef=0.044; robust s.e=0.023; p-value=0.060). Мөн ХХГХ-т өртөх эрсдэлийг тодруулах асуултуудад гадаад улс уруу зорчих, өндөр цалинтай ажлын саналыг зөвшөөрөх сонголтуудыг бүртгэлтэй иргэдтэй харьцуулахад бүртгэлгүй иргэд илүү сонгосон байна (Зураг 9).

Зураг 9. ХХГХ-т өртөх эрсдэлийг танихад чиглэсэн болзолт нөхцөлийг зөвшөөрч буй оролцогчид, харьяа орон нутагтаа бүртгэлтэй эсэхээр




Бүртгэлээ хийлгээгүй дээрх шилжин ирэгсдийн 3 хүн тутмын нэг нь хөдөлмөр эрхлэх зорилгоор шилжиж ирсэн, тэдгээрийн 60.2 хувь нь ямар нэг гэрээ байгуулалгүй хөдөлмөр эрхэлж байсан, 43 хувь нь өмнөх ажил олгогч нь тохирсон цалин хөлсөө олгохгүй байх, үндэслэлгүй бууруулах тохиолдлуудтай тулгарч байсан нь бүртгэлтэй иргэдтэй харьцуулахад 6 хувиар өндөр байна.

Ажилд орох, суралцах зорилгоор урт хугацааны шилжилт хөдөлгөөнд орсон бол ХХГХ-т өртөх эрсдэл нэмэгдэж байна. Судалгаанд оролцогч сүүлийн 3 жилийн хугацаанд амьдарч буй байршлаа 30 хоногоос дээш хугацаагаар өөрчилсөн бол шилжилт хөдөлгөөний туршлагатай холбоотой дараах асуудлуудыг тодруулсан. Үүнд: (1) шилжилт хөдөлгөөн хийсэн шалтгаан, (2) шилжилт хөдөлгөөний логистик буюу хэнтэй хамт шилжилт хөдөлгөөнд орсон, (3) шилжилт хөдөлгөөний дараах төлөвлөгөө тодорхой байсан эсэх. Эдгээр гурван хүчин зүйл тухайн хүний эмзэг байдлыг нэмэгдүүлэхэд нөлөө үзүүлж буй эсэхийг шинжлэхэд бусад хоёр хүчин зүйлээс илүү шилжилт хөдөлгөөнд ямар зорилгоор орж буй нь чухал нөлөөтэй байв. Ялангуяа, ажилд орох, эсвэл сурах зорилгоор шилжилт хөдөлгөөнд орсон иргэд бусад зорилгоор шилжилт хөдөлгөөнд орсон иргэдтэй харьцуулахад ХХГХ-т өртөх эрсдэл илүү өндөр гарсан байна (coef=0.052; robust s.e=0.031; p-value=0.099).

Шилжилт хөдөлгөөнд орсон иргэдийн дийлэнх нь буюу 50 хувь нь орон нутгаас хот руу шилжсэн, тэдгээр иргэдийн 38 хувь нь хөдөлмөр эрхлэх зорилгоор, 18.5 хувь нь суралцах зорилгоор шилжилт хөдөлгөөнд орсон байгаа нь нийт шилжилт хөдөлгөөнд орсон хоёр хүн тутмын нэгийг эзэлж байна.

Зураг 10. Шилжилт хөдөлгөөний чиглэл (n=92) **Зураг 11.** Шилжилт хөдөлгөөнд орсон зорилго, (n=92)



1.2 Хувь хүний түвшний хамгаалагч хүчин зүйлс:

Өмнөх бүлэгт дурдсан эрсдэлт хүчин зүйлсийн эсрэг хувьсагчууд нь ихэнх тохиолдолд хамгаалалтын нөлөө үзүүлж байв. Тухайлбал, нас ахих хэрээр ХХГХ-т өртөх эрсдэл буурч, тогтмол орлоготой, тогтсон ажилтай, тогтвортой гэр бүлтэй байх нь ХХГХ-т өртөхөөс сэргийлж буй хүчин зүйлс байв. Эдгээрээс гадна хувь хүний түвшинд хамгаалалт болж буй бусад онцлох үр дүнг авч үзвэл:

Соёлын зарим бүлгийн хувьд (Казах, Буриад болон Ислам шашинтай иргэд)⁵² ХХГХ-т өртөх эмзэг байдал бага байх шинжтэй байна. Угсаатны хувьд судалгаанд оролцогчдын 88 хувь (n=374) нь халх, үлдсэн хувийг угсаатны цөөнх бүлгийн иргэд (казах, буриад, дөрвөд гэх мэт) бүрдүүлсэн. Бусад үндэс угсааны иргэдтэй харьцуулахад казах, буриад иргэдийн ХХГХ-т өртөх эмзэг байдал бага байгаа нь статистикийн хувьд ач холбогдолтой байв (p-value=0.000; p-value=0.001). Мөн, шашны итгэл үнэмшил нь ХХГХ-т өртөх эмзэг байдалд нөлөөтэй эсэхийг шинжлэхэд бусад шашинтай иргэдтэй харьцуулахад исламын шашинтай иргэдийн эмзэг байдал бага байгаа нь статистикийн хувьд нотлогдож байв (coef=-0.103; robust s.e.=0.009; p-value=0.000). Чанарын мэдээллээс үзэхэд, уг үр дүн нь бүлгийн соёлын онцлогтой холбоотой байж болохоор байна. Тухайлбал, исламын шашинд гэр бүлийн харилцаанд уламжлалт ёс заншлыг баримталдаг ба өөр бусад үндэстний хүнтэй гэр бүл болохыг хориглох, зөвхөн ижил шашин, угсаатны хүнтэй гэр бүл болохыг дэмждэг уламжлалтай. Уг ёс нь нэг талаар казах эмэгтэйчүүдийг ХХГХ-ийн хохирогч болохоос хамгаалах нөлөө үзүүлдэг байж болно. Бүлгийн соёлын онцлогоос хамаарсан уг нөлөөг цааш нарийвчлан судлах шаардлагатай.

2. Хувь хүний түвшинд ХХГХ-ийн эмзэг байдалд нөлөөгүй хүчин зүйлс:

ХХГХ-т өртөх эмзэг байдалд хүйсийн ялгаа нөлөөгүй байна. ХХГХ-т өртөмтгий байдлын индекс тооцооллоор ХХГХ-ийн шинжтэй дор хаяж нэг үйлдэлд өртсөн 120 иргэний хүйсийн харьцааг авч үзэхэд эмэгтэйчүүдийн хувь (47 хувь) эрэгтэйчүүдийнхээс (53 хувь) бага гарсан. Гэвч **Хавсралт 4**-т харуулсан регрессийн (2) болон (3)-р загварын дагуу хүйсийг илэрхийлэх чанарын хувьсагч нь статистикийн хувьд ач холбогдолгүй байв. Өөрөөр хэлбэл, аль нэг хүйсээс хамаараад ХХГХ-т илүү эмзэг өртөмтгий байх шинж ажиглагдаагүй буюу аль аль хүйсийн иргэдийн дунд эрсдэл бий гэж үзэж болохоор байна. Чанарын судалгааны үр дүн мөн дээрх нөхцөл байдлыг баталж байсан ба сүүлийн жилүүдэд эрэгтэй хохирогчдын тоо нэмэгдэх хандлагатай, ялангуяа хөдөлмөр мөлжлөгийн хохирогч болох, цөөн тохиолдолд хөвгүүд бэлгийн мөлжлөгийн хохирогч болсон тохиолдлууд бүртгэгдсэн байгаа нь ХХГХ-т зөвхөн эмэгтэйчүүд өртдөг гэх нийтлэг ойлголтыг няцааж байв.

Тайлангийн өмнөх бүлэгт дурдаж байсанчлан, илрүүлэх судалгаанд ХХГХ-ийн өртөх эрсдэлийг таних асуулуудад мөн цаашид өөрийгөө эрсдэлд оруулж болзошгүй сонголтыг эрэгтэйчүүд илүүтэй хийж

⁵² Угсаатны хувьд судалгаанд оролцогчдын 88% нь халх, үлдсэн хувийг угсаатны цөөнх бүлгийн иргэд (казах, буриад, дөрвөд гэх мэт) бүрдүүлсэн. Шашны хувьд судалгаанд хамрагдсан иргэдийн 36% нь будда, 14% нь бусад шашны урсгалд итгэдэг хүмүүс байсан бол 50% нь ямар нэгэн шүтлэггүй байгаа нь улсын хэмжээний ерөнхий дүр зургаас (нийт хүн амын 38.6% нь шүтлэггүй) өндөр хувьтай байв.

байгаа нь харагдсан. Эдгээр үр дүнгээс үзэхэд аль аль хүйсийн иргэд ХХГХ-т өртөх эрсдэлтэй байгаа нь харагдаж байна. Гэвч ХХГХ-ийн төрөл хэлбэрээс (бэлгийн мөлжлөг, хөдөлмөр мөлжлөг, зуучлалын гэрлэлт...) хамааран аль нэг хүйсийн төлөөлөл илүү эмзэг өртөмтгий байхыг үгүйсгэхгүй.

Боловсролын түвшин нь ХХГХ-т өртөх эмзэг байдалд нөлөөгүй байна. Хүснэгт 16-д харуулсан *Education_Low* хувьсагч бүрэн дундаас доош боловсролтой иргэдийг төлөөлөх чанарын хувьсагч юм. Уг хувьсагч сөрөг утгатай бөгөөд статистикийн ач холбогдолтой үнэлэгдсэн байгаа нь эдгээр иргэд ХХГХ-т өртөх эрсдэл бусад боловсролын түвшинтэй иргэдээс бага байгааг илтгэнэ. DoMV загварын гарын авлага болон бусад судалгааны тайлангуудад боловсролын түвшин нэмэгдэх хэрээр (ялангуяа дээд боловсролтой байх) ХХГХ-т өртөх эрсдэлийг бууруулах зүй тогтолтойг тэмдэглэсэн байгаа боловч уг судалгааны үр дүн өөр нөхцөл байдлыг харуулж байв.

Ерөнхий төлөв байдлаараа боловсролын түвшин нь эмзэг байдлын үзүүлэлт (хөдөлмөр эрхлэлт, ядуурлын үзүүлэлттэй)-д шууд холбоотой гэж үздэг боловч Монгол Улс дахь боловсролын чанарын асуудал уг үр дүнд нөлөөлж байх боломжтой. Тодруулбал, ҮСХ-ны Ядуурлын дүр төрх судалгааны 2019 оны тайланд дурдсанаар хөвгүүд, тэр дундаа хөдөөгийн хөвгүүд гэр бүлдээ туслахын тулд сургуулиас эрт завсардах хандлагатай байхад охид илүү удаан суралцаж, өндөр боловсрол эзэмших хандлагатай байна. Гэвч залуу эмэгтэйчүүдийн (25-29 насны) 70 хувь нь дээд боловсрол эзэмшсэн ч энэ нь тэднийг хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцоход нөлөөлөхгүй байгаа үр дүн гарсан байна⁵³. Өөрөөр хэлбэл бага боловсролтой байх нь эдийн засгийн хувьд эмзэг байх нөхцөлийг бүрдүүлж байгаа хэдий ч дээд боловсролтой байх нь эдийн засгийн хувьд баталгаатай байх нөхцөлийг бүрдүүлэхгүй байна.

Өөрөөр хэлбэл, Монгол Улсад хөдөлмөрийн зах зээлийн хязгаарлагдмал нөхцөл байдлуудаас шалтгаалан хувь хүний боловсролын түвшин, ялангуяа залуу эмэгтэйчүүдийн хувьд ХХГХ-т өртөх эмзэг байдлыг бууруулахад шууд нөлөө үзүүлж чадахгүй байна. Уг үр дүн нь олон нийтийн түвшний үр дүнгээр мөн батлагдаж байсан ба амьдарч буй орон нутагт нь хөдөлмөр эрхлэх боломж хязгаарлагдмал байх нь иргэдийг ажил хөдөлмөр эрхлэх зорилгоор шилжилт хөдөлгөөнд орох, улмаар уг нөхцөл байдал нь ХХГХ-т өртөх эмзэг байдлыг нэмэгдүүлэхэд нөлөөтэй байгаа нь харагдсан.

Зураг 12-д ХХГХ-т өртөх эрсдэлтэй 423 хүнээс авсан түүвэр судалгааны мэдээллийг ашиглан хувь хүний түвшинд ХХГХ-т өртөмтгий байдалд нөлөөлөгч болон хамгаалагч хүчин зүйлсийг тодорхойлсон үр дүнг нэгтгэн харууллаа.

Зураг 12. Хувь хүний түвшинд ХХГХ-т өртөх эрсдэлд нөлөөлж буй хүчин зүйлс



ХХГХ-т өртөмтгий байдалд нөлөөлөгч хүчин зүйлс

- Насны хувьд залуу байх: Залуучууд (18-25 насны иргэд)
- Ганц бие, эсвэл гэрлэлтээ цуцалсан байх
- Санхүүгийн муу нөхцөлд байх
- Оюутан, улирлын чанартай ажил эрхэлдэг, цагийн ажил эрхэлдэг байх
- Бие махбодын болон сэтгэл зүйн хүнд, хэцүү нөхцөлд орж байсан, сэтгэл зүйн тогтворгүй байдалд байх
- Оршин суух албан ёсны бүртгэлгүй
- Ажил хийж, эсвэл сурах зорилгоор 30 хоногоос дээш хугацаанд шилжилт хөдөлгөөнд орж буй иргэд



ХХГХ-ийн эрсдлээс хамгаалагч хүчин зүйлс

- Бүтэн цагийн ажилтай байх
- Тодорхой угсаатны болон шашны бүлэгт багтдаг байх (Казах...)
- Оршин суух албан ёсны бүртгэлтэй байх нь ХХГХ-т өртөмтгий байдлыг бууруулж байна.

⁵³ Ядуурлын дүр төрх, ҮСХ, Дэлхийн банк, 2019

Хэсэг 2: Өрхийн түвшний эрсдэлт болон хамгаалагч хүчин зүйлс

DoMV загварын дагуу ХХГХ-т өртөмтгий байдалд нөлөөлөгч хүчин зүйлсийг хэмжсэн дараагийн түвшин нь өрх, гэр бүлийн түвшин юм. Аливаа хүн эрсдэлтэй нөхцөл байдалд орсон тохиолдолд, ялангуяа насанд хүрээгүй иргэд, хүүхэд залуучуудын хувьд хамгийн эхэнд дэмжлэг туслалцаа хүсэх тал нь гэр бүл байдаг тул уг түвшин нь хувь хүний эмзэг болон тэсвэртэй байдлыг тодорхойлоход маш чухал нөлөөтэй. Гэр бүлийн бүх гишүүд нь эрх эзэмшигч буюу хүний эрхийн субъект бөгөөд тэдний эрх гэр бүлийн орчинд хэр хүндэтгэгдэж авч үзэгдэж байгаагаас өрхийн түвшний хүчин зүйл нь хувь хүнд хамгаалалт эсвэл эрсдэлт хүчин зүйлийн аль хэлбэрээр нөлөөлөх нь хамаардаг⁵⁴. Тухайлбал, өрхийн түвшний хүчин зүйлсд гэр бүлийн хэмжээ буюу өрхийн гишүүдийн тоо, өрхийн бүтэц, нийгэм-эдийн засгийн статус, шилжилт хөдөлгөөний түүх, хөдөлмөр эрхлэлт, амьжиргаа, боловсролын түвшин, нийгмийн харилцаа болон бусад нийгмийн сүлжээн дэх идэвх оролцоо (нийгмийн капитал) зэрэг хүчин зүйлсийг авч үзсэн.

Хувьсагч бүрийн нөлөө, статистик ач холбогдлыг харуулах зорилгоор Хавсралт 4 дэх **Хүснэгт 17**-д харуулсан регрессийн таван загварын үр дүнг нэгтгэн өрхийн түвшинд ХХГХ-т өртөмтгий байдалд нөлөөлөгч хүчин зүйлсийг дор тайлбарлая.

2.1 Өрхийн түвшний эрсдэлт хүчин зүйлс:

Гэр бүлийн уур амьсгал таагүй байх нь өрхийн гишүүдийн ХХГХ-т өртөх эмзэг байдлыг нэмэгдүүлж байна. *Physical_Psychosocial_Bad_Condition* хувьсагч гэр бүлийн уур амьсгал тайван бус өрхийг төлөөлөх чанарын хувьсагч юм. Судалгаанд оролцогч сүүлийн гурван сарын хугацаанд гэр бүлийн орчинд тайван бус уур амьсгалтай нөхцөлд байсан бол 1, үгүй бол 0 утга оноож, үнэлгээг хийсэн. Хувьсагчийн үнэлэгдсэн утга эерэг гарсан нь гэр бүлийн уур амьсгал тайван өрхийн гишүүнтэй харьцуулахад стресс, бухимдал, санаа зовнилт ихтэй, сэтгэл зүйн таагүй, хүнд нөхцөлд орж байсан өрхийн гишүүдийн ХХГХ-т өртөх эрсдэл нэмэгдэж байгааг статистикийн ач холбогдлын түвшин харуулж байв.

Чанарын мэдээллээс үзэхэд ялангуяа өсвөр насны хүүхдүүдийг эрсдэлтэй алхам хийхэд гэр бүлийн уур амьсгал, харилцаа илүү нөлөө үзүүлж буй байдал ажиглагдсан (**Шигтгээ 3**). Тухайлбал, хавтаст хэргийн судалгаагаар авч үзсэн 14 хохирогчийн дунд ХХГХ-ийн хохирогч болсон насанд хүрээгүй дөрвөн охин (16-17 насны) байсан ба бүгд гэр бүлийн харилцаа муу, хойд эцэгтэйгээ муудалцдаг, таарамжгүй харилцаатай гэсэн өгүүлэмжтэй байна.

Шигтгээ 3. Гэр бүлийн таагүй харилцаа нь эрсдэлтэй алхам хийхэд нөлөөлсөн талаар

Дүү бид хоёр хойд аавтайгаа таардаггүй, ялангуяа би байнга хэрэлддэг байсан. Хичээлдээ ч явах дургүй байсан болохоор 10-р ангидаа хичээлдээ явахад болиод ажил хийж энэ гэрээс явж өөрөө бие дааж амьдрахыг хүссэн. 2014 онд 10 жилийн сургуульд нэг ангид сурч байсан А-тай гэрийнхээ ойролцоо уулзаад ойр зуурын юм ярилцаж байгаад түүнд "хичээлдээ явахгүй байгаа ажил олж хиймээр байна" гэж хэлсэн. Тэгтэл тэр надад "Д.Х гэж эгч байдаг тэр чамд ажил олж өгөх байх" гэж хэлсэн. Ямар ажил хийхийг надад хэлээгүй.

...Хичээлдээ ч явахгүй, гэрт байнга хойд аавтай хэрэлдээд салахгүй болохоор ээж ч ажил хийе гэхэд татгалзаагүй, ээж А.Ц (шүүгдэгч)-тэй өөрөө уулзаад, гадаад руу дагуулж явахыг зөвшөөрөөд миний гадаад паспортыг хөөцөлдөж өгөөд явуулсан.

(Шүүгдэгч нь хохирогчийн гэр бүлтэйгээ таарамжгүй харьцаатай байгаа, ажил хайж байгаа, эдийн засгийн эмзэг байдлыг нь далимдуулан Монголоос БНХАУ-ын Өвөр Монголын өөртөө засах мужийн Эрээн хотод аваачиж биеийг үнэлүүлж, бэлгийн мөлжлөгт оруулж ашиг олсон)

Хавтас хэргийн материалаас

Гэр бүлийн хүчирхийлэл (ГБХ) болон бусад хэлбэрийн дарамт, шахалттай өрхийн гишүүдийн ХХГХ-т өртөх эрсдэл нэмэгдэж байна. Судалгаанд оролцогчдоос гэр бүлд нь хүчирхийлэл

⁵⁴ DoMV загварын гарын авлага, ОУШХБ, хуу 118

Үйлдэгдэх эрсдэлийг хэд хэдэн асуултаар тодруулж, *Family_Risky_Behaviour* болон *Family_Violence* хувьсагч үүсгэн, хэрвээ хүчирхийллийн эрсдэл байдаггүй бол 0, ямар нэгэн байдлаар хүчирхийлэл, дарамт, шахалт байдаг бол 1 утга оноож, үнэлгээг хийсэн. Хоёр хувьсагчийн үнэлэгдсэн утга хоёул эерэг бөгөөд статистикийн ач холбогдолтой гарснаас гадна *Family_Violence* хувьсагчийн үнэлэгдсэн утга 0.12 буюу бусад хувьсагчидтай харьцуулахад хамгийн өндөр байна. Энэ нь ХХГХ-т өртөмтгий байдлын индексэд *Family_Violence* хувьсагч хүчтэй нөлөөтэйг илтгэнэ. Өөрөөр хэлбэл, хүчирхийлэлгүй нөхцөлд амьдардаг өрхийн гишүүнтэй харьцуулахад ГБХ-тэй (шууд болон дам байдлаар) өрхийн гишүүний ХХГХ-т өртөх эмзэг байдал өндөр байна.

Уг үр дүн нь ГБХ болон ХХГХ хоорондын холбоо хамаарлыг харуулсан олон улсад хийгдсэн бусад судалгааны үр дүнгүүдтэй нийцэж байгаа юм. ГБХ нь ХХГХ-т өртөхөд нөлөөлөгч буюу түлхэгч хүчин зүйл болдог. Английн Лондон хотод хийгдсэн АНУ-ын Төрийн департаментын Хүн худалдаалах асуудлын төлөв байдлын 2009 оны тайланд ХХГХ-ийн хохирогч эмэгтэйчүүдийн 70 орчим хувь нь өмнө нь ГБХ-тэй орчинд байсныг дурдсан байна⁵⁵. НҮБХС-ийн тайлангуудад ч ГБХ-д өртдөг хүүхдүүд хүчирхийллээс зугтахын тулд гэрээсээ дайжих магадлал өндөр бөгөөд гэрээсээ зугтсан, дайжсан орон гэргүй хүүхдүүдийн ХХГХ-т өртөх эрсдэл хамгийн өндөр байдгийг тэмдэглэжээ. Мөн АНУ-ын Сураггүй алга болсон хүүхдүүдийн үндэсний төвөөс хийсэн судалгаагаар гэрээсээ дайжсан зургаан хүүхэд тутмын нэгд нь бэлгийн мөлжлөгт өртсөн шинж тэмдэг илэрч байгааг тэмдэглэсэн байна⁵⁶. Эдгээр хоёрдогч эх сурвалжийн үр дүнгүүд нь ГБХ нь хохирогчийн ХХГХ-т өртөх эмзэг байдлыг хүчтэй нэмэгдүүлдэг болохыг харуулж байна. Түүнчлэн гэмт хэрэгтнүүдийн хувьд ГБХ нь бэлгийн мөлжлөгт өртүүлж буй хохирогчдыг хяналтандаа байлгах нэг давуу тал, хяналтандаа байлгах нэг арга болж байдаг байна.

ЦЕГ-ын бүртгэл мэдээгээр сүүлийн дөрвөн жилийн хугацаанд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн ГБХ-ийн тоо буурсан үзүүлэлттэй боловч үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад хандсан зөрчлийн тоо⁵⁷ эсрэгээр нэмэгдсэн байна. Холбогдох байгууллагуудын зүгээс ГБХ-ийн тоо нэмэгдснийг COVID-19 цар тахлын дэгдэлттэй холбоотойгоор урт хугацааны хөл хорио тавигдсантай холбон тайлбарлаж байна. Тодруулбал, жил бүр ГБХ-ийн улмаас амь насаа алдсан иргэдийн тоо нэмэгдэж байна⁵⁸. 2020 оны статистик мэдээллээр ГБХ-ийн улмаас амь насаа алдсан иргэдийн тоо өмнөх онтой харьцуулахад 75 хувиар өссөн нь цар тахлын үеийн хөл хорионы үед ГБХ-ийн гаралт, түүний аюулын түвшин эрс нэмэгдсэнийг харуулж байсан. Мөн хөл хорионы дэглэмийн үед нийт бүртгэгдсэн гэмт хэргийн тоо буурсан байхад, ГБХ-ийн дуудлага, хамгаалах байр болон нэг цэгийн үйлчилгээний төвөөс тусламж хүссэн хохирогчдын тоо нэмэгдсэн байна⁵⁹.

Зураг 13. ЦЕГ-т бүртгэгдсэн ГБХ-ийн гэмт хэрэг болон зөрчлийн тоо, 2017-2020



⁵⁵ Хүн худалдаалах асуудлын төлөв байдлын тайлан, АНУ-ын төрийн департамент, 2009, <https://2009-2017.state.gov/documents/organization/123357.pdf>.

⁵⁶ Гэр бүлийн хүчирхийлэл болон ХХГХ, Ханна Коды, НҮБХС, АНУ, 2017 оны 11-р сарын 15.

⁵⁷ Эрүүгийн хуулиар зохицуулах боломжгүй гэмт хэргийг Зөрчлийн тухай хуулиар зохицуулдаг. Хохирлын хэмжээг баталгаажуулсан баримт нь зөрчил эсвэл гэмт хэрэг мөн эсэхийг тогтооход ашигладаг. Санхүүгийн хувьд 300,000 төгрөгөөс доош дүнтэй тохиолдолд зөрчилд тооцож, харин 300,000 төгрөгөөс дээш тохиолдолд гэмт хэрэгт тооцдог.

⁵⁸ Гэр бүлийн хүчирхийлэл, статистикийн тойм, ҮСХ, ЦЕГ, 2020.

⁵⁹ COVID 19 цар тахлын улмаас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ (хөл хорио тогтоох, онцгой нөхцөл байдал зарлах) нь ЖСХ ялангуяа гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эрх хамгаалалд үзүүлж буй нөлөө, түргэвчилсэн үнэлгээний тайлан, ХНХЯ, НҮБХАС, ШХА, 2020

2020 онд бүртгэгдсэн ГБХ-ийн хохирогчдын 86.6 хувь нь эмэгтэй, 11 хувь нь 11-18 насны хүүхдүүд, 28 хувь нь 18-29 насны залуучууд, 49 хувь нь дунд боловсролтой иргэд байна. Улсын хэмжээнд бүртгэгдсэн ГБХ-ийн гэмт хэргийн 58.6 хувь нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн. Эдгээр бүх тоон болон чанарын судалгааны үр дүн нь ГБХ-ийн улмаас үүссэн нөхцөл нь иргэдийг амьдралын нөхцөлөө сайжруулах, өндөр цалинтай ажлын төлөө эрсдэлтэй алхам хийхэд түлхэц болж байгааг батлан харуулж байна.

Өрхийн санхүүгийн чадавх сайн байх нь өрхийн гишүүдийг ХХГХ-т өртөх эрсдэлээс хамгаалж чадахгүй байна. Хувь хүний түвшинд санхүүгийн чадавх тааруу байх нь ХХГХ-т өртөх эмзэг байдлыг нэмэгдүүлж буй үр дүн гарсан. Гэвч өрхийн түвшинд уг хүчин зүйлийг авч үзэхэд өрхийн санхүүгийн чадавх сайн байх нь өрхийн гишүүдийг ХХГХ-т өртөхөөс хамгаалж чадахгүй байх нөхцөл байдлыг харуулав. Судалгаанд хамрагдсан 423 өрхийн 47.8 хувь нь л дунджаас дээш буюу өдөр тутмын хэрэглээнээс гадна бусад шаардлагатай нийгмийн үйлчилгээнд мөнгө зарцуулж чаддаг. Тэдгээрээс ХХГХ-ийн аль нэг элементэд өртсөн гэх 120 оролцогчийн мэдээллийг авч үзэхэд тэдний 51.7 хувь нь дээрхтэй ижил өрхийн хэрэгцээгээ хангаж чаддаг гэж хариулсан байна.

Өрхийн санхүүгийн байдал өрхийн гишүүдийн ХХГХ-т өртөх эрсдэлд нөлөөлдөг эсэхийг шинжлэх зорилгоор өрхийн орлогоороо өдөр тутмын хоол хүнсээ авч чаддаггүй өрхүүдийг *Family_Financial_Situation* хувьсагчаар төлөөлүүлэн шинжлэхэд үнэлэгдсэн утга эерэг хэдий ч энэ нь статистикийн ач холбогдолгүй гарч байв. Өөрөөр хэлбэл, өрхийн санхүүгийн чадавх сайн байх нь өрхийн гишүүдийг ХХГХ-т өртөхөөс хамгаалж чадахгүй байна. Энэ нь өрхийн санхүүгийн нөхцөл байдал нь тэргүүлэх хамгаалалтын хүчин зүйл биш болохыг харуулах ба бусад өрхийн болон нийгмийн хүчин зүйлүүд (ГБХ, бүлгийн нягтаршил, эв нэгдэл...) орлогоос илүү хүчтэй нөлөө үзүүлдэг байх боломжтой.

2.2 Өрхийн түвшний хамгаалагч хүчин зүйлс:

Өмнөх бүлэгт дурдсан эрсдэлт хүчин зүйлсийн эсрэг хувьсагчууд нь ихэнх тохиолдолд хамгаалалтын нөлөө үзүүлж байв. Тухайлбал, гэр бүлийн уур амьсгал тайван, таатай байх, хүчирхийлэлгүй эрүүл харилцаатай байх нь өрхийн гишүүдийг ХХГХ-т өртөхөөс сэргийлж байв. Эдгээрээс гадна гэр бүлийн түвшинд хамгаалалт болж буй онцлох үр дүнг авч үзвэл:

Өрх оршин суугаа хороо, сумынхаа засаг захиргааны нэгжтэй харилцаатай, нийгмийн идэвхтэй байх нь өрхийн гишүүдийг ХХГХ-т өртөхөөс хамгаалах нөлөөтэй байна. Судалгаанд оролцогчдоос тухайн өрх оршин суугаа орон нутгийнхаа анхан шатны засаг захиргааны нэгж байгууллагууд, өрхийн эмнэлэг, сургууль, цагдаа, хөршийн холбоо, ТББ-тай харилцаа, холбоотой эсэх, орон нутгийн иргэдийн социал нэгдэл (фейсбүүк групп), хөгжлийн төв, дугуйланд хамрагддаг эсэхийг тодруулж, эдгээр байгууллагуудтай холбоотой байх нь ХХГХ-т өртөх эрсдэлд нөлөөтэй эсэхийг шинжилсэн. Судалгааны үр дүнгээр дээрх байгууллагуудаас зөвхөн хороо, сумын захиргаа буюу анхан шатны захиргааны нэгжээс бусад байгууллагатай харилцаатай байх нь ХХГХ-т өртөх эмзэг байдалд тодорхой нөлөөгүй байв. Харин өрхийн оршин суугаа газрын засаг захиргааны анхан шатны нэгж болох хороо, сумынхаа захиргаагаар үйлчлүүлдэг, харилцаа холбоотой иргэдтэй харьцуулахад тогтмол үйлчлүүлдэггүй, үйлчилгээ авдаггүй өрхийн гишүүдийн ХХГХ-т өртөх эмзэг байдал нь нэмэгдэж байгаа нь *Family_No_Network* хувьсагч статистикийн ач холбогдолтой, эерэг утгатай үнэлэгдсэн байдлаас харагдаж байна.

Гэр бүлээрээ урьдчилан төлөвлөж шилжилт хөдөлгөөнд орсон байх нь өрхийн гишүүдийг ХХГХ-т өртөхөөс хамгаалж байна. Судалгаанд оролцогчдын 21.5 хувь (n=91) нь сүүлийн гурван жилийн хугацаанд 30 хоногоос дээш хугацаагаар гэр бүлээрээ шилжилт хөдөлгөөнд орсон байв. Тэдгээр өрхийг *Family_Migration* хувьсагчаар төлөөлсөн ба хувьсагчийн үнэлэгдсэн утга сөрөг байгаа нь өрхийн аль нэг гишүүн нь шилжилт хөдөлгөөнд орсон өрхтэй харьцуулахад ХХГХ-т өртөх магадлал бага байгааг харуулж байсан. Өөрөөр хэлбэл, өрхийн аль нэг гишүүн суралцах эсвэл хөдөлмөр эрхлэх зорилгоор урт хугацаанд шилжилт хөдөлгөөнд орсон бол тухайн өрхийн эмзэг байдал нэмэгдэж, гэр

бүлээрээ урьдчилан төлөвлөгөөтэй шилжилт хөдөлгөөн орсон бол ХХГХ-т өртөх эмзэг байдал буурч байна.

ХХГХ-т өртөмтгий байдалд нөлөөлөгч хүчин зүйлсийг өрхийн түвшинд шинжилсэн тоон шинжилгээний үр дүнг доорх зурагт нэгтгэн харууллаа.

Зураг 14. Өрхийн онцлог, шинжээс хамаарч ХХГХ-т өртөх байдлыг тайлбарлах хүчин зүйлс



**ХХГХ-т
өртөмтгий
байдалд
нөлөөлөгч
хүчин зүйлс**

- Гэр бүл харилцаа, уур амьсгал таарамжгүй байх
- Гэр бүлийн орчинд хүчирхийлэл, дарамт, шахалт, зөрчил их байх
- Өрхийн санхүүгийн байдал ХХГХ-т өртөх эрсдэлд нөлөөгүй буюу санхүүгийн чадавх сайн байх нь хамгаалах нөлөө үзүүлэхгүй
- Өрхийн нэг гишүүн ажил хийх, сурах зорилгоор урт хугацааны шилжилт хөдөлгөөнд орсон бол тухайн өрхийн гишүүдийн эмзэг байдал нэмэгдэж байна.



**ХХГХ-т
өртөхөөс
хамгаалагч
хүчин зүйлс**

- Гэр бүлийн уур амьсгал тайван, таатай байх
- Гэр бүл ямар нэг хүчирхийлэлгүй, дарамт, шахалтгүй байх
- Өрх, гэр бүлээрээ урьдчилан төлөвлөж шилжилт хөдөлгөөнд орох
- Оршин суугаа газрын засаг захиргааны анхан шатны нэгж байгууллагаар үйлчлүүлдэг, харилцаа холбоотой байх нь

Хэсэг 3: Олон нийтийн түвшний эрсдэлт болон хамгаалагч хүчин зүйлс

DoMV загварын дагуу олон нийтийн түвшний хүчин зүйлд иргэдийн итгэл үнэмшил, амьжиргаа, хөдөлмөр эрхлэх боломж, байгаль цаг уурын хүчин зүйл, нийгмийн үйлчилгээний хүртээмж (эрүүл мэнд, нийгмийн халамж, санхүү, боловсрол), нийгмийн сүлжээ ба иргэний оролцоо, нийгмийн хэм хэмжээ, иргэдийн зан үйлтэй холбоотой асуудлуудыг хамруулсан.

Энэ хэсэгт 423 оролцогчоос авсан асуулга болон баримт бичгийн шинжилгээ, ганцаарчилсан ярилцлагын үр дүнд тулгуурлан ХХГХ-ийн эмзэг байдалд олон нийтийн түвшинд эрсдэлт болон хамгаалалт болж буй хүчин зүйлүүдийг тодорхойлсон. Мөн нэмэлтээр олон нийтийн түвшинд нийт 30 хүнийг хамруулсан таван удаагийн бүлгийн хэлэлцүүлгийг Улаанбаатар хот болон орон нутагт зохион байгуулж олон нийтийн түвшинд нөлөөлж буй хүчин зүйлсийг баталгаажуулав.

3.1 Олон нийтийн түвшний эрсдэлт хүчин зүйлс:

Хувь хүн болон өрх, гэр бүлийн нөхцөл байдал нь өргөн утгаараа тухайн амьдарч буй орон нутгаас хамаарсан хүчин зүйлийн дунд нөхцөлдөж байдаг. Тухайлбал, тухайн орон нутгийн эдийн засгийн байдал, соёлын болон нийгмийн онцлог болон иргэдийн олон нийтийн дунд хүлээн зөвшөөрөгдөх байдал, эзлэх байр суурь зэрэг нь тухайн нутгийн иргэдийн амьжиргаа, амьдралын чанарт ихээхэн нөлөөтэй байдаг. Олон нийтийн харилцаа холбоо сайн, аливаа нөөцийг иргэддээ тэгш хуваарилж чаддаг орон нутагт амьдрах нь тухайн орон нутгийн иргэдийг аливаа гэмт хэрэгт өртөхөөс сэргийлж чаддаг бол эсрэгээр олон нийтийн харилцаа, холбоо тааруу хөгжсөн, нөөцийг оновчтой, үр ашигтай хуваарилж чаддаггүй орон нутагт амьдрах нь тухайн орон нутгийн иргэдийн эмзэг байдлыг нэмэгдүүлж байдаг.

Олон нийтийн түвшний зарим хүчин зүйлс нь иргэдийн дундах бүлэг бүрийн онцлогоос хамаараад ялгаатай нөлөө үзүүлж байж болдог. Тухайлбал, зарим хүчин зүйл нь тодорхой нэг бүлгийн эмзэг байдлыг ихээр нэмэгдүүлж байхад бусад бүлэгт өөр байдлаар нөлөө үзүүлэх боломжтой. Иймд олон нийтийн түвшний хүчин зүйлийг шинжлэхдээ өмнөх хоёр түвшний (хувь хүн, гэр бүл) боловсруулалтаас ялгаатай арга зүйг ашиглах шаардлага үүссэн. Учир нь олон нийтийн түвшний хүчин зүйлийг хэмжсэн шалгуур нь тухайн орон нутгийн иргэдийн амьжиргаа, амьдралын чанарт нөлөөлөх хүчин зүйлсийн талаар иргэдийн өөрсдийн байр суурь, хандлагад (субъектив үнэлгээ) суурилж буйгаараа онцлог юм.

Иймд олон нийтийн түвшний хүчин зүйлийг чанарын болон тоон мэдээлэл аль алинд нь тулгуурлан тодорхойлсон. Үүнд: олон талт төлөөллийг оролцуулсан бүлгийн (орон нутгийн-иргэд, төр болон иргэний нийгэм, хувийн хэвшлийн байгууллагын албан хаагчид г.м) ярилцлагын үр дүнд тулгуурлан иргэдийн эмзэг байдалд нөлөөтэй олон нийтийн түвшний эрсдэлт болон хамгаалах хүчин зүйлсийг тодруулж, тэдгээрийг түүвэр судалгаанд хамрагдсан 423 оролцогчийн өгсөн тоон мэдээллээр баталгаажуулсан.

Тоон судалгааны өгөгдөлд шинжилгээ хийхдээ вариацийн шинжилгээний (ANOVA)⁶⁰-ний аргыг ашигласан. Уг статистик аргачлалын хувьд сонгосон хувьсагч нь (хүчин зүйл нь) хамаарах хувьсагчид (ХХГХ-т өртөмтгий байдлын индекст) нөлөөтэй эсэхийг статистик шинжилгээний аргаар тодруулдаг аргачлал юм. Уг аргачлалын дагуу судалгааны баг DoMV загварын дагуу судалгаанд хамрагдсан 423 оролцогчоос амьдарч буй орон нутгийнх нь нөхцөл байдал, нийгмийн үйлчилгээний хүртээмж, гэмт хэргийн гаралт зэрэг ХХГХ үйлдэгдэх нөхцөлийг бүрдүүлж болох нөхцөл байдлуудын талаарх ойлголт, байр суурь болон хандлагыг тодруулах асуултуудыг асуусан.

Олон нийтийн нэгдэл, нягтралд нөлөөлж буй иргэдийн сөрөг итгэл үнэмшилтэй холбоотой хүчин зүйлс нь иргэдийн ХХГХ-т өртөх эмзэг байдлыг нэмэгдүүлж байна⁶¹. Тухайн орон нутгийн нийгэм, соёлын онцлогоос шалтгаалан иргэдийн нас, хүйс, үндэс угсаа, шашин шүтлэг, хэл соёл, бэлгийн чиг баримжаа, гэрлэлтийн байдал, нийгмийн анги давхраа, эрхэлж буй ажил, боловсролын түвшин, гэр бүл, хамаатан садан ураг төрлийн холбоо, олон нийтийн дундахь байр суурь, эрүүл мэндийн нөхцөл байдалтай холбоотой хүний эмзэг байдлыг нэмэгдүүлэхүйц ямар нэг тогтсон итгэл үнэмшил бий эсэх, байдаг бол энэ нь тухайн орон нутгийн иргэдийн эмзэг байдлыг нэмэгдүүлэхэд нөлөө үзүүлж буй эсэхийг шинжилсэн. Гэтэл судалгааны оролцсон гурван хүн тутмын нэг нь нэг дор амьдарч буй орон нутгийнхаа иргэдийн талаар ойлголт багатайгаас уг асуултад хариулт өгч чадахгүй байсан нь эдгээр орон нутгуудад олон нийтийн нэгдэл, нягтрал, бүлийн (community) төлөвшил сул байгааг харуулж байв.

Хариулт өгсөн оролцогчдын мэдээллийн хувьд энгийн статистик болон вариацийн шинжилгээ (ANOVA)-ний аргаар шинжилгээ хийхэд нийгмийн давхрага, үндэс угсаа, боловсрол, эрүүл мэнд зэрэг хүчин зүйлс ХХГХ-т өртөх эмзэг байдалд хамгийн ихээр нөлөөлдөг болох нь статистикийн ач холбогдолтой байна (**Хүснэгт 6**). Өөрөөр хэлбэл, боловсролын түвшин доогуур байх, суурь өвчтэй/хөгжлийн бэрхшээлтэй байх, нийгмийн анги, давхраа доогуур, угсаатны цөөнхийн төлөөлөл байх нь хүмүүсийг ялгаварлан гадуурхалт болон хүчирхийлэлд өртөх эрсдэлийг нэмэгдүүлдэг байна.

Хүснэгт 6. Олон нийтийн түвшин дэх ХХГХ-т өртөх эмзэг байдлыг нэмэгдүүлж буй хүчин зүйлс, вариацийн шинжилгээний үр дүн, ач холбогдлын түвшингээр

	Хүчин зүйлс	Давтамж	F критик утга	P утга	Статистик ач холбогдол
1.	Нийгмийн анги давхрага доогуур байр суурь эзэлдэг	30.7%	3.659	0.006	***
2.	Бусад хүмүүстэй харьцуулахад янз бүрийн угсаатны бүлэгт хамаарагддаг	12.3%	2.544	0.039	***
3.	Хүмүүс боловсролын түвшин доогуур байх	32.2%	3.671	0.006	***
4.	Эрүүл мэндийн байдал (өвчтэй эсвэл хөдөлмөрийн чадваргүй)	32.4%	3.689	0.006	***
5.	Залуучууд	25.1%	2.556	0.038	***

⁶⁰ Олон нийтийн түвшинд хэмжиж буй хүчин зүйлийн талаарх иргэдийн ойлголт, хандлагыг тодруулахын тулд 1-5 хүртэлх Лайкертын шкалыг ашигласан. Тодруулбал, судалгаанд оролцогчийн үнэлгээнд вариацийн шинжилгээ (ANOVA)-г сонгосон хувьсагч (хүчин зүйл) нь ХХГХ-ийн эмзэг байдлыг тодорхойлох үл хамааран хувьсагч (НТИ)-д хэрхэн нөлөөлдөг болохыг тодруулах зорилгоор хийсэн.

⁶¹ Хүснэгт 6-д харуулсан 13 хүчин зүйлээс шалтгаалан тухайн хүн амьдарч буй орон нутагтаа ялгаварлан гадуурхалт, дарамт, хүчирхийлэлд өртдөг эсэхийг тодруулсан.

6.	Бэлгийн чиг баримжаа өөр хүмүүс	16.8%	3.276	0.012	**
7.	Жендэрийн илэрхийлэл өөр хүмүүс (эрэгтэй, эмэгтэй болон интерсекс)	14.7%	3.214	0.013	**
8.	Бусадтай харьцуулахад янз бүрийн ажил эрхэлдэг хүмүүс	22.7%	2.120	0.038	**
9.	Шашин шүтлэгийн ялгаатай байдал	9%	2.341	0.054	*
10.	Гэрлэлтийн байдал (салсан, бэлэвсэн)	21%	1.072	0.370	*
11.	Угсаа, хэл яриагаар ялгаатай хүмүүс	12.1%	0.931	0.446	*
12.	Гэр бүл болон ураг төрлийн холбоо өөр хүмүүс	14.9%	0.594	0.667	*
13.	Ахмад настан	16.3%	0.559	0.692	*

Чанарын судалгааны үр дүнгээр **Хүснэгт 6**-д харуулсан бүх хүчин зүйл нь ХХГХ-ийн эмзэг байдалд тодорхой хэмжээнд нөлөөтэй ба үүнээс ялангуяа хөдөлмөр эрхлэх, олон нийтийн дунд хүлээн зөвшөөрөгдөхтэй холбоотой асуудлууд нь хувь хүний байр суурь, эмзэг байдалд нөлөөлдөг байна. Өөрөөр хэлбэл, эдгээр хүчин зүйл нь доогуур буюу тааруу нөхцөлд байх нь иргэдийг ХХГХ-т өртөхөд олон нийтийн түвшиндээ нөлөөлж байна.

Шигтгээ 4. Олон нийтийн түвшинд иргэдийн ХХГХ-т өртөх эрсдэлийг нэмэгдүүлж буй хүчин зүйлсийн талаар

"Боловсролтой, боловсролгүй хүмүүсийн хооронд асар том ялгаа бий. Боловсрол нь хүмүүсийн хоорондын ур чадвар бусдыг уруу татах магадлалтай, хүнийг шийдвэр гарахад нөлөөлдөг. Боловсролтой хүмүүсийн тоо нэмэгдэх тусам боловсролгүй хүмүүсийн гэмт хэрэгт өртөх магадлал ихэсдэг".

"Нийгмийн анги давхаргын байр суурь маш чухал. Үүнийг би хөгжиж буй улс орнуудын тулгамдсан асуудал гэж харж байна. Учир нь малчны хүүхэд малчин болох ёстой гэсэн уламжлалт хандлага байдаг. Төрийн албанд ажиллахад аав ээж нь хэн болох, ямар ажил эрхэлдгийг асуудаг тохиолдол гардаг. Миний ажигласнаар хүмүүс тухайн хүний онцлог гэхээс илүү удам угсаа, нийгмийн байдал, гэр бүлийн нөхцөл байдалд илүүтэй анхаарал хандуулдаг. Таныг хөдөлмөрч хүн гэж хэлсэн хэлээгүй амьдрал дээр даргын хүүхэд орж ирэхэд үйлчилгээ нь өөр байдаг. Жишээлбэл, нэг ангид сурч байгаа 2 хүүхдийн нэгнийхэн эцэг эх баян, нөлөөтэй бол багш нар илүү сайн хандах, дэмжлэг авах магадлал өндөр. Тиймээс манай нийгэмд ялгаварлан гадуурхах явдал их гардаг".

"Бодит байдал дээр Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс нийгмээс тусгаарлагдсан, эдийн засгийн хувьд эмзэг, амьдрал ахуйн тааруу, бусдаас хараат, цөхөрсөн хүмүүс байдаг. Хөгжлийн бэрхшээлийн улмаас сургуульд суралцаж чадахгүй, ялгаварлан гадуурхагддаг бөгөөд хаана хэнд уг асуудлаа тавихаа мэддэггүй. Хөгжлийн бэрхшээлтэй эмэгтэйчүүдийг сул дорой, чадваргүй гэж үздэг тул дарамт шахалт болон бэлгийн мөлжлөгт өртөх магадлалтай. Өөрөөр хэлбэл, Хөгжлийн бэрхшээлтэй хүнийн хувьд эрсдэл өндөртэй".

Иргэдтэй хийсэн фокус бүлгийн хэлэлцүүлэгээс

Мөн иргэдтэй хийсэн бүлгийн ярилцлагын үеэр, олон нийтийн дунд залуучуудыг ажил хийх мэдлэг, туршлага, ур чадвар дутмаг гэсэн нийтлэг хандлага байдаг тул насны хувьд залуу байх нь мөн эмзэг байдлыг нэмэгдүүлдэг талаар оролцогчид дурдаж байв.

Орон нутагт нь хөдөлмөр эрхлэх боломж бага байх нь иргэдийг ажил хийх зорилгоор шилжилт хөдөлгөөнд орох, улмаар хөдөлмөрийн эрсдэлтэй сонголт хийхэд хүргэж байна. Амьдарч буй орон нутагт нь амьжиргааны түвшин доогуур орлоготой, эмзэг бүлгийн иргэд болон удаан хугацаанд ажил хийгээгүй хүмүүс хөдөлмөр эрхлэх боломжтой эсэхийг оролцогчдоос тодруулсан. Тоон болон чанарын аль аль үр дүнгээр орон нутагт хөдөлмөр эрхлэх боломж хомс байх нь иргэдийг ХХГХ-т өртөх эрсдэлийг нэмэгдүүлдэг болох нь харагдаж байна.

Зураг 15. Орон нутагт зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэх боломж (n=423)



Тоон судалгааны үр дүнгээр оролцогчдын 61.2 хувь (n=259) нь амьжиргааны түвшин доогуур орлоготой, эмзэг бүлгийн иргэд, харин 60.5 хувь (n=256) нь урт хугацаанд ажил эрхлээгүй хүмүүс ажилд орох боломж бага гэж үзсэн. Фокус бүлгийн хэлэлцүүлгийн үр дүнгээр орон нутагт, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өрх толгойлсон эх, эцэг, боловсролын түвшин бага иргэд болон насны хувьд залуу эсвэл 40-өөс дээш насны иргэд хөдөлмөр эрхлэхэд хамгийн их бэрхшээлтэй тулгарч байгааг оролцогчид дурджээ (**Шигтгээ 5**).

Шигтгээ 5. Амьдарч буй орон нутагт нь хөдөлмөр эрхлэх боломж хязгаарлагдмал байх нь иргэдийн хөдөлмөрийн эрсдэлтэй сонголт хийхэд нөлөөлж буй талаар

Аймаг, сумдад үйлдвэрлэл явуулдаг ААНБ цөөн, гол төлөв төрийн болон банк санхүүгийн байгууллагууд, худалдааны төвүүд үйл ажиллагаа явуулдаг. Зарим орон нутаг газар зүйн онцлогоос хамаарч улирлын шинж чанартай (барилга, газар тариалан, ашигт малтмлын олборлолт, тээвэрлэлт гэх мэт) ажлын байрууд нээлттэй байдаг ч танил талараа ажилд орох байдал нийтлэг байна. Ядуу, эмзэг бүлэг болон урт хугацаанд ажил эрхлээгүй хүмүүст тогтсон ажил олдоно гэдэг их хүндрэлтэй. Иймд иргэд ажил хийн амьжиргаагаа залгуулах, ар гэрээ тэжээх зорилгоор хот суурин газар уруу нүүхэд хүрдэг. Ажил идэвхтэй хайж байгааг далимдуулан биеийн үнэлүүлэх, цаашлаад хүний наймааны хохирогч болдог нийтлэг дүр зураг байна.

Тухайлбал, Иргэн Б амьдран сугаа орон нутагт ажлын байр олдохгүй, ар гэрээ тэжээхийн тулд Улаанбаатар хотыг зорьсон. Ажилд орох уулзалтад хэд хэдэн удаа орсон боловч эзэмшсэн мэргэжилгүй, боловсрол багатай байгаа нь ажилд авахгүй байх шалтгаан болж байв. Улмаар сонингоос "санхүү авна" гэсэн зарын дагуу зуучлагчтай холбогдон уулзсан байна. Зуучлагч нар мэргэжил, боловсрол шаардахгүй ажил байгааг хэлж, цалин боломжийн гэж итгүүлсэн. Энэ цаг мөчөөс биеэ үнэлэх болсон бөгөөд зуучлагч хэд хэдэн удаа хүсээгүй байхад нь хүчиндэх, хэл амаар доромжлох, зодох, сүрдүүлэх үйлдлийг гаргаж байсан. Түүнчлэн охид, эмэгтэйчүүдийн биеийг үнэлүүлж мөнгө олдог зуучлагч нар "ажил идэвхтэй хайж байна" гэсэн зар тавьсан охид руу утасдаж, уулзалт зохион байгуулахдаа дайлах нэрээр согтууруулах ундаа уулган хүчиндэж, гарцаагүй байдалд оруулан биеийн үнэлүүлсэн тохиолдол гарсан байна.

Хавтаст хэргийн материалаас


Чанарын судалгааны үр дүнгээр орон нутагт ажил эрхлэх боломж хомс байгаа нь иргэдийг хот суурин газар уруу зориход хүргэж, улмаар иргэдийн ХХГХ-т өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байна. Тухайлбал, хувь хүний түвшинд сүүлийн 3 жилийн хугацаанд урт хугацааны шилжилт хөдөлгөөнд орсон 92 хүний ихэнх нь буюу 50 хувь нь орон нутгаас хот уруу нүүсэн байх ба тэдний 38 хувь нь хөдөлмөр эрхлэх зорилгоор шилжилт хөдөлгөөнд орсон байна.

Баримт бичгийн судалгаа мөн дээрх нөхцөл байдлыг нотлох үр дүнг харуулж байсан ба хөдөлмөр эрхлэх боломж хязгаарлагдмал байх, ажилгүйдлийн асуудал нь ялангуяа Улаанбаатар хотод төвлөрч байна. ҮСХ-ны мэдээллээр 2020 оны байдлаарх Монгол Улсын нийт ажилгүйчүүдийн 49 хувийг 30-44 насныхан эзлэх ба хүйсийн хувьд эрэгтэйчүүд давамгайлж байна. Эмэгтэйчүүдийн ажилгүйдлийн хувьд 15-24 насны ажилгүй эмэгтэйчүүдийн тоо жил ирэх тусам буурч байгаа хэдий ч нийт хүн амын дундах 30-аас доош насны эмэгтэйчүүдийн ажилгүйдэл өндөр хэвээр байна⁶².

Амьдарч буй орон нутагт нь эрүүл мэнд, боловсрол, санхүүгийн үйлчилгээний хүртээмж хангалтгүй байх нь иргэдийн ХХГХ-т өртөх эмзэг байдлыг нэмэгдүүлж байна. Тухайн орон нутаг дахь боловсрол, эрүүл мэнд, санхүү, нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээний хүртээмж нь оршин суугчдынхаа эмзэг байдалд нөлөө үзүүлж буй эсэхийг энэ хэсэгт авч үзсэн.

⁶² Хүн ам, орон сууцны 2020 оны тооллогын нэгдсэн дүн, ҮСХ, 2020

Зураг 16. Хувь хүний эмзэг байдалд нөлөөлж буй нийгмийн үйлчилгээ (n=423)



Судалгаанд оролцогчдын 34.7 хувь (n=147) нь эдгээр нийгмийн суурь үйлчилгээ одоогийн амьдарч буй орон нутагт нь хүртээмжтэй байж чаддаггүй гэж хариулсан. Хүртээмжгүй байгаа нь орон нутгийн иргэдийн эмзэг байдалд нөлөө үзүүлж буй эсэхийг шинжлэхэд олон нийтийн түвшинд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ (F critical value=4.762, p value=0.001, статистик ач холбогдолтой) болон банк, санхүүгийн үйлчилгээ⁶³ (F critical value=3.624 p value=0.006, статистик ач холбогдолтой) хамааралтай байна. Тодруулбал, иргэд эрүүл мэндийн шинжилгээ, эмчилгээ хийлгэхийн тулд аймаг/нийслэлийн эрүүл мэндийн төвийг зорих, орон нутаг дахь өөрийн эзэмшлийн хөрөнгө, авч буй цалин нь банкны зээлийн батлан даалт болж чадахгүй байх зэрэг олон асуудалтай тулгардаг байна (**Шигтгээ 6**).

Шигтгээ 6. Орон нутаг дахь эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийн талаар

Эрүүл мэндийн үйлчилгээ маш муу, бас их төвөгтэй, чирэгдэл ихтэй санагддаг. Хороодын өрхийн эмнэлэгийн хувьд эмч нар нь наад захын үзлэг оношилгоог чанартай хийдэггүй учраас 13А маягтыг бөглүүлэн хоёрдогч шатлал, цаашлаад гуравдагч шатлалын эрүүл мэндийн байгууллагад ханддаг. Хоёрдогч, гуравдагч эрүүл мэндийн шатлалын байгууллагын цаг авахад хугацаа нь сарын дараа байх жишээтэй. Эрүүл мэндийн даатгал төлөөгүй, дэвтэргүй иргэнээс мөнгөө төлөхийг шаарддаг.

Иргэдийн төлөөлөлтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас

Гэмт хэрэг, зөрчил багатай, тайван орчинд амьдардаг иргэдтэй харьцуулахад гэмт хэргийн гаралт ихтэй орон нутгийн иргэдийн ХХГХ-т өртөх эмзэг байдал илүү байна. Судалгаанд оролцогчид ажиллаж, амьдран суугаа орон нутгийнхаа гэмт хэргийн гаралтын талаар мэдээлэл маш багатай байсан. Ялангуяа бэлгийн мөлжлөг болон ХХГХ-ийн талаар хоёр хүн тутмын нэг нь огт мэдээлэлгүй байв. Энэ нь нэг талаас, олон нийтийн ХХГХ-ийн талаарх ойлголт мэдлэг бага байгааг нөгөө талаас энэ чиглэлийн мэдээлэл иргэдэд хүрэхгүй байгааг, орон нутагт энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа хангалтгүй явагдаж байгааг харуулж байна.

Зураг 17. Орон нутаг дахь хүчирхийлэл, гэмт хэргийн тархалт (n=423), иргэдийн хариултаар



Орон нутгуудад хамгийн түгээмэл үйлдэгддэг гэмт хэрэгт судалгаанд оролцогчдын 30 хувь (n=127) нь ГБХ-ийн асуудлыг нэрлэсэн байсан. Гэр бүлийн түвшинд хийсэн DoMV загварын шинжилгээгээр ГБХ нь өрхийн гишүүдийг хөдөлмөр эрхлэлтийн аюултай сонголт хийхэд хүргэж, улмаар ХХГХ-т өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байгаа үр дүн гарсан. Иймд ГБХ-ийн гаралт өндөр орон нутагт амьдрах нь иргэдийн ХХГХ-т өртөх эмзэг байдлыг нэмэгдүүлэхэд нөлөөтэй байна.

⁶³ Банкны үйлчилгээ: хадгаламж, зээл, карт, цахим банкны үйлчилгээ, гадаад төлбөр тооцоо, даатгал, батлан даалт, үнэт зүйл хадгалах; Банкнаас бусад санхүүгийн байгууллагын үйлчилгээ: хувьцаа, бонд, хөрөнгө оруулалт, валют арилжаа, барьцаа хөрөнгө.

Шигтгээ 7. ГБХ нь ХХГХ-ийн эрсдэлийг нэмэгдүүлж буй талаар

Яг хүчирхийлэл, гэмт хэргийн гаралтаас үүдэн өөр орон нутаг руу дайжих, шилжих асуудал иргэдийн дунд гараагүй хэдий ч иргэдийн дунд бие биенээ сэтгэл санаагаар дарамтлах (хэл амаар доромжлох, дарамтлах), гэр бүл дотроо бие мажбодын хүчирхийлэл (зодох, цохих) болон зарим тохиолдолд бэлгийн хүчирхийлэл (насанд хүрээгүй охид) үйлдэгдэх явдлууд байдаг.

Иргэдийн төлөөлөлтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас

3.2 Олон нийтийн түвшний хамгаалагч хүчин зүйлс:

Олон нийтийн түвшинд ХХГХ-ийн эмзэг байдлыг нэмэгдүүлэхээс сэргийлж буй хүчин зүйлсийн шинжилгээг тоон болон чанарын судалгааны үр дүнд суурилан дараах хэсэгт дэлгэрэнгүй танилцуулав.

Амьдарч буй орон нутагт нь хөдөлмөр эрхлэх боломж нээлттэй байх нь иргэдийг ХХГХ-ийн эрсдлээс сэргийлж байна. Судалгаанд оролцогчдын 52 хувь (n=220) нь амьдарч буй орон нутагтаа ажиллах боломж нээлттэй байдаг гэж хариулсан. Судалгааны талбаруудаар (байршлаар) авч үзвэл Өмнөговь аймаг Улаанбаатар хотоос 4.7 пунктаар илүү байна. Тус аймагт Тавантолгой, Оюу толгой, Нарийнсухайт зэрэг стратегийн ач холбогдолтой гурван томоохон орд газар тогтоогдож, одоогийн байдлаар 14 компаниуд ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулдаг⁶⁴ бөгөөд үүнтэй холбоотой хөдөлмөрийн зах зээлд ажлын байрны эрэлт өсөх, орон нутгийн иргэдийг нээлттэй ажлын байранд зуучлах үйлчилгээ идэвхтэй явагдаж байгаагийн илрэл юм. ҮСХ-ны 2021 оны мэдээллээр уул уурхай, олборлолтын салбарт ажиллагчдын дундаж цалин улсын дунджаас 2.3 дахин их буюу 2,934,000 төгрөг байгаа нь иргэдийг энэ салбарт ажиллахад нөлөөлөх хүчин зүйл болно. Гэхдээ уул уурхай хөгжиж буй бүс нутаг нь иргэдийн шилжилт хөдөлгөөн их, бэлгийн болон хөдөлмөр мөлжлөг (биеэ үнэлэх, бэлгийн мөлжлөгт хүүхэд өртөх, хүнд тээврийн жолооч нар хөдөлмөрийн мөлжлөгт өртөх зэрэг) эрсдэл өндөр тул аль болох бусад бүс нутгуудад ажлын байрыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах нь чухал байна.

ХНХЯ-аас 2021 онд Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, Цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр, Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, Хөдөлмөр эрхлэлт, ажлыг байрыг дэмжих хөтөлбөрийг тус тус баталсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд нь иргэдийг ХХГХ-т өртөхөөс шууд хамгаалж байна хэмээн үзэх боломжгүй ч эдгээр хөтөлбөрүүд нь иргэдийн ХХГХ-т өртөх эрсдэлийг бууруулахад чухал нөлөөтэй юм. Тухайлбал, 2018 онд ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 24,233 иргэн хамрагдаж 18,972 иргэн ажлын байраар хангагдсан байна⁶⁵.

3.3 COVID-19 цар тахлын олон нийтийн түвшинд үзүүлэх нөлөө болон хувь хүн, гэр бүлийн түвшний хүчин зүйлстэй холбогдох нь:

Олон нийтийн түвшинд авч үзсэн өөр нэг хүчин зүйл нь байгалийн болон бусад давагдашгүй хүчин зүйлс байв. **Байгалийн болон давагдашгүй хүчин зүйлс нь гэнэтийн байдлаар иргэдийг орон гэргүй, ажилгүй болох, хөдөлмөрийн чадвараа алдахад нөлөөлдөг эмзэг байдлын хүчин зүйлсд тооцогддог.** Энэ хүрээнд (1) зуд, түймэр, үер зэрэг байгалийн эрсдэлүүд болон (2) ХХГХ-ийн эрсдэлийг нэмэгдүүлэхэд COVID-19 цар тахлын хувь хүн, гэр бүл, олон нийтийн түвшинд үзүүлэх нөлөөг авч үзсэн.

2021 оны 8-р сарын байдлаар Монгол Улсад COVID-19-ийн 195,245 тохиолдол бүртгэгдсэн нь нийт хүн амын 5.8 хувийг эзэлж байна⁶⁶. Эрүүл мэндийн яамны мэдээлснээр, COVID-19 цар тахлын дельта хувилбар 2021 оны 7-р сараас эхлэн Монгол Улсад тархаж, энэ оны 8-р сард өдөрт 1000 гаруй

⁶⁴ Өмнөговь аймгийн хэмжээнд Оюутолгой, Тавантолгой, Эрдэнэс таван толгой, Энержи ресурс, Мөнх ноён суварга, Дун юань, Олон овоот гоулд, Зөв зүг, МАК, Чинхуа-Мак-Нарийн сухайт, Саус гоби сэндс, Өсөх зоос, Терра энерги, Жавхлант орд зэрэг 14 компаниуд ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулж байна.

⁶⁵ ХХҮЕГ, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих газар (2018) Хөдөлмөр зах зээлийн мэдээллийн танилцуулга.

⁶⁶ COVID-19 цар тахлын нөхцөл байдал <https://covid19.mohs.mn/p/cat/post/57/>

батлагдсан тохиолдол бүртгэгдэж байгаа нь хүн амын дунд өндөр үзүүлэлт болж байна. Байршлын хувьд Дархан-Уул аймаг, Төв аймаг нь бусад аймгуудтай харьцуулахад халдвар авсан хүний тоо хамгийн өндөр байна. Вакцинжуулалтын түвшинг авч үзвэл нийт хүн амын 68.3 хувь нь (n=2,222,451) эхний тунгаа, 62.7 хувь нь (n= 2,038,558)⁶⁷ хоёр дахь тун дархлаажуулалтад хамрагдсан байдлаараа вакцинжуулалтын хамрагдалтаар Монгол Улс дэлхийд 19-рт жагсааж байна⁶⁸.


2020-2021 онд Монгол Улсын Засгийн газар нийт дөрвөн удаагийн хатуу хөл хорих арга хэмжээ авч, улсын хилийг хааж, үйлчилгээний компаниудад цагийн хязгаарлалтыг тогтоох зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн. Цаашдаа вакцинжуулалтыг эрчимжүүлэхтэй зэрэгцэн эдийн засгийг дэмжих бодлого баримталж тодорхой хязгаарлалтуудыг аажмаар бууруулах чиглэл барьж байгаа талаар Засгийн Газраас мэдэгдэж байгаа. Гэвч COVID-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн үйлчлэх хугацааг 2021 оны 12-р сарыг дуустал хүртэл хугацаанд сунгасан байна.

Зураг 18. Байгалийн гамшиг болон COVID-19 нөхцөл байдал нь иргэдийн амьжиргааг дордуулахад нөлөөлж буй байдал, (n=423), иргэдийн хариултаар



Байгаль, цаг уур, орчны хүчин зүйлсээс COVID-19 цар тахлын нөхцөл байдал иргэдийн амьжиргааг дордуулахад хүчтэй нөлөөтэй байна. Тухайлбал, COVID-19 цар тахлын дэгдэлт нь иргэдийн эмзэг байдлыг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн гэж оролцогчдын 71 хувь (n=300), тэдний 37 хувь (n=156) нь орлого буурч, ажил багассан, 19.3 хувь (n=82) нь сэтгэл зүйн тулгамдсан асуудалтай болсон, 12.4 хувь (n=52) нь гэр бүлийн гишүүдийн социал медиан хэрэглээ огцом нэмэгдсэн зэрэг хариултаар өгсөн байна.

Зураг 19. COVID-19 цар тахалтай холбоотой гэр бүлийн амьдралд тулгамдаж буй хүндрэл бэрхшээл, (n=423)



Судалгааны эдгээр үр дүн нь цар тахлаас өмнөх үеийн хувь хүн, өрх/гэр бүлийн болон олон нийтийн түвшин дэх эмзэг байдлын хүчин зүйлүүд нь COVID-19 цар тахлын цаг үед улам муудсанаар иргэдийн ХХГХ-т өртөх эмзэг байдал нэмэгдэхэд нөлөөлж байгааг харуулж байна.

⁶⁷ Мэдээллийг дараах эх сурвалжаас ашиглав: [WHO Coronavirus \(COVID-19\) Dashboard | WHO Coronavirus \(COVID-19\) Dashboard With Vaccination Data](#)

⁶⁸ Мэдээллийг дараах эх сурвалжаас ашиглав: [Covid World Vaccination Tracker - The New York Times \(nytimes.com\)](#)

Чанарын судалгааны үр дүн мөн ижил цар тахал нь хүмүүсийн амьдралд өргөн хүрээнд нөлөөлж байгааг харуулж байна. Тухайлбал, цар тахлын үед цагдаагийн байгууллагад бүртгэгдэх ГБХ-ийн зөрчил, гэмт хэргийн тоо нэмэгдсэн (**Зураг 13**). Тайлангийн өмнөх бүлгүүдэд дурдсанчлан ГБХ нь ХХГХ-ийн эрсдэлийг нэмэгдүүлэх суурь шалтгааны шинжтэй нөлөө үзүүлдэг. Уг нөхцөл байдал нь бусад улс орнуудад ч мөн ажиглагдаж буй үзэгдэл юм. НҮБ-ын Хүн амын сангийн тооцооллоор COVID-19 цар тахлын үе дэх 3 сарын хөл хорио тутамд дэлхий даяар жендэрт суурилсан хүчирхийллийн 15 сая тохиолдлыг бий болгож байгаа талаар НҮБ-ын Ази, Номхон далайн эдийн засгийн комиссын тайланд дурдсан байна. Уг тооцоолол нь хөл хорионы үеэр ГБХ-ийн гэмт хэрэг 20 хувиар өссөнд үндэслэсэн тооцоолол юм⁶⁹.

Шигтгээ 8. Хил хаагдсан нь дотоодод бэлгийн мөлжлөгийн хэргийг нэмэгдүүлж буй талаар

COVID-19 гарснаас хойш дотоодод бэлгийн мөлжлөгийн хохирогчид ихэссэн. Урьд нь магадгүй гадагшаа чиглэсэн их анхаардаг байсан байх. Хятад руу яваад байна, Малайз руу зарагдаад байна гэдэг байсан бол дотооддоо охидын биеийг хүчээр үнэлүүлж байгаа кейсүүд дээр анхаарлаа тэр хэмжээнд хандуулаагүй байсан. Хөл хориотой холбоотой хил хаагдсанаас хойш дотоод дахь бэлгийн мөлжлөгийн хохирогчдын илрүүлэлт, тоо өссөн.

Цагдаагийн албан хаагчтай хийсэн ганцаарчилсан ярилцлагаас

Хүснэгт 7. ХХГХ-ийн гаралт дахь COVID-19 цар тахлын нөлөө, оролцогч талуудын хариултаар

Эерэг нөлөө	Сөрөг нөлөө
<ul style="list-style-type: none"> Хил хаагдсантай холбоотой гадаад улс орнууд руу худалдагдах эрсдэл багассан. Гадаадад байгаа иргэдийг эргүүлэн татах үйл ажиллагаатай холбоотойгоор хохирогч болох эрсдэлтэй охид эх орондоо ирсэн. Дотооддоо үйлчилгээний газруудын ажиллах цагийг хязгаарлах, хаах шийдвэрүүд гарсан нь баар цэнгээн, массажны газрыг хаасан нь ХХГХ-ийн хохирогч болох эрсдэлүүдийг бууруулсан. 	<ul style="list-style-type: none"> Хилийн боомт хаагдсантай холбоотой дотоодод бэлгийн мөлжлөгт өртөх байдал нэмэгдэж, ХХГХ илүү зохион байгуулалтад орж байна. Цар тахлаас үүдэлтэй хорио цээрийн дэглэм, хязгаарлалт нь цалин хөлсөө өгөхгүй байх, ААНБ-уудын үйл ажиллагаа доголдоход хүргэсэн. Биеэ үнэлэх тохиолдлууд хот суурин газарт илүү түгээмэл болсон. Хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх ажил хорио цээр, хязгаарлалтаас болж суларсан. Хилийн чанадад хөдөлмөр эрхэлж буй иргэд болон ХХГХ-ийн хохирогчид хил хаасантай холбоотой ирж чадахгүй болж, хүнд байдалд орсон.

Дээрх нөлөө гарч буй боловч хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй цаг үеийн нөхцөл байдалд нийцүүлэн COVID-19 цар тахал ХХГХ-ийн төрөл хэлбэр тус бүрийн гаралтад хэрхэн нөлөөлж буйг цаашид гүнзгийрүүлэн судлах шаардлагатай.

Зураг 20-д тоон судалгаа, баримт бичгийн шинжилгээ, оролцогч талуудтай хийсэн ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагын үр дүнд тулгуурлан олон нийтийн түвшинд иргэдийн ХХГХ-т өртөх эрсдэлийг нэмэгдүүлэх болон бууруулах нөлөө үзүүлж буй хүчин зүйлсийг нэгтгэн харууллаа.

⁶⁹ United Nations ESCAP, 2020b: 8

Зураг 20. ХХГХ-ийн эрсдэлд нөлөөлж буй олон нийтийн түвшний хүчин зүйлс



ХХГХ-т өртөмтгий байдалд нөлөөлөгч хүчин зүйлс

- Боловсрол, анги давхарга, эрүүл мэндийн байдал, нас зэрэг хүчин зүйлсээс нь хамаарч ялгаварлан гадуурхалт явагддаг байх
- Амьдарч буй орон нутагт нь хөдөлмөр эрхлэх боломж бага байх
- Амьдарч буй орон нутагт нь гэмт хэргийн гаралт өндөр байх
- Амьдарч буй орон нутагт нь эрүүл мэнд болон санхүүгийн үйлчилгээ хүртээмжгүй байх



ХХГХ-т өртөхөөс хамгаалагч хүчин зүйлс

- Орон нутагт ажил, хөдөлмөр эрхлэх боломж нээлттэй байх
- Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмж сайн байх
- Зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээ нь иргэдийн эмзэг байдлыг бууруулахаас сэргийлж байгаа нь ХХГХ-т өртөхөөс хамгаалах нөлөө үзүүлж байна.

Хэсэг 4: Бүтцийн түвшний эрсдэлт болон хамгаалагч хүчин зүйлс

DoMV загварын дагуу ХХГХ-т өртөмтгий байдалд нөлөөлөгч хүчин зүйлсийг хэмжих дөрөв дэх түвшин нь бүтцийн түвшин юм. Бүтцийн түвшний хүчин зүйл нь ХХГХ-ийн гаралтад суурь шалтгааны нөлөө үзүүлж буй улсын хэмжээний, тогтолцооны шинжтэй, макро хүчин зүйлсийг авч үздэг. Үүнд тухайн орны улс төрийн систем, засаглал, хууль эрх зүйн орчин, шилжилт хөдөлгөөнийг зохицуулж буй бодлого, хэвлэлийн эрх чөлөө зэрэг нийгэм, эдийн засаг, улс төрийн хүчин зүйлсийг авч үзэхээс гадна ХХГХ-тэй тэмцэх тогтолцооны чадавх, түүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг авч үздэг. Иймд уг бүлэгт DoMV загварын дагуу бүтцийн түвшний хүчин зүйлсийг:

- ХХГХ-тэй тэмцэх тогтолцооны чадавх, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлж буй эрсдэлт болон хамгаалагч хүчин зүйлс
- Нийгэм, эдийн засаг, улс төрийн болон бусад контекст бүтцийн эрсдэлт болон хамгаалагч хүчин зүйлс гэсэн агуулгын хүрээнд авч үзлээ.

Дээр дурдсан хүчин зүйлсийг судалгааны баг баримт бичгийн судалгаа, төрийн албан хаагч, ТББ-ын төлөөлөлтэй хийсэн ганцаарчилсан ярилцлагын чанарын мэдээлэлд тулгуурлан шинжлэв.

4.1 ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх, тэмцэх тогтолцооны түвшний эрсдэлт болон хамгаалагч хүчин зүйлс

Монгол Улс ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр бие даасан хуулийг 2012 онд баталж⁷⁰ улмаар хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг (цаашид Үндэсний хөтөлбөр гэх) хэрэгжүүлж байна. Тус хууль болон хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд ХХГХ-ийн илрүүлэлт нэмэгдэж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа сайжирч, хохирогчид үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэж, оролцогч талуудын хамтын ажиллагаа сайжрах учиртай.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээ⁷¹ болон бусад хэд хэдэн ижил төстэй судалгааны үр дүнд бие даасан хууль батлагдсан нь сайшаалтай хэдий ч хуулийн хэрэгжилт хангалттай түвшинд явагдаж чадахгүй байгааг тал талаас нотолсон байна. Тухайлбал, 2016 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, ШХА-ын дэмжлэгтэйгээр хийсэн үнэлгээний тайланд⁷² Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль батлагдсан хэдий ч хэрэгжилт хангалтгүй, хүн худалдаалахтай

⁷⁰ Төрийн мэдээлэл, 2012 он, дугаар 7

⁷¹ Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Швейцарийн хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр хийсэн Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн үнэлгээний тайлан, УБ, 2016


⁷² Монгол Улсын хүчин төгөлдөр хууль, холбогдох захиргааны хэм хэмжээний актад тусгасан төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллагаас шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хангах аливаа зохицуулалтын өнөөгийн хэрэгжилтийн байдалд хийсэн үнэлгээний тайлан, 2016

тэмцэх төрийн үйл ажиллагаа нь “зөвхөн хурал, цуглаан хийх байдлаар хязгаарлагдаж” байна гэж, 2017 онд Иргэдэд туслах хүний эрхийн төвөөс гүйцэтгэсэн судалгааны тайланд “хуулийн хэрэгжилт хангалтгүй, хүн худалдаалах гэмт хэрэг нь ялангуяа хөдөлмөрийн мөлжлөг, охид, эмэгтэйчүүдийн биеийг үнэлүүлэх хэлбэрээр түгээмэл үйлдэгдэж, энэхүү хэрэг нь нууц далд, зохион байгуулалттай, үндэстэн дамнан үйлдэгдэж буйгаас хохирогчийг илрүүлэх, зөв таних ажил хангалттай түвшинд явагдаж чадахгүй байна” гэжээ.

Уг судалгааны хүрээнд төрийн болон ТББ-ын холбогдох оролцогч талуудтай хийсэн ярилцлагын үр дүнгээр мөн ижил **Монгол Улсад ХХГХ-тэй тэмцэх хууль эрх зүйн орчин бүрдэж, түүнийг дагасан тогтолцоо ажиллаж байгаа хэдий ч түүний үр нөлөөтэй байдал хангалтгүй байгаа талаар дийлэнх оролцогч талууд ижил байр суурьтай байв. Үүнд ХХГХ-тэй тэмцэх тогтолцоо бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн чадавх, хамтын ажиллагааны сул байдал нөлөөлж байна гэж талууд үзэж байна.**

Монгол Улсад ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр ажиллаж буй өнөөгийн бүтэц тогтолцооны ерөнхий дүр зургийг авч үзвэл:

Зураг 21. Монгол Улс дахь ХХГХ-тэй тэмцэх үндэсний тогтолцооны бүдүүвч



Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн⁷³ 15.3 дахь хэсэгт улсын хэмжээнд тодорхой төрлийн гэмт хэргүүдээс урьдчилан сэргийлэх ажлыг дагнан зохицуулах үүрэг бүхий дэд зөвлөлийг зохицуулах зөвлөлийн дэргэд ажиллуулах тухай заасан. Энэ хүрээнд Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Дэд зөвлөлийг Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэд байгуулсан нь ХХГХ-тэй тэмцэх тогтолцооны гол удирдах нэгж болж байна.

Дэд зөвлөлийн бүрэлдэхүүн байгууллагуудаас ХХГХ-тэй тэмцэх хамгийн том бүтэц цагдаагийн байгууллагад ажиллаж байна.⁷⁴ Тодруулбал, ЦЕГ-ын даргын 2017 оны А/33 дугаар тушаалаар Эрүүгийн цагдаагийн албанд Зохион байгуулалттай гэмт бүлэг, ХХГХ-тэй тэмцэх хэлтсийг байгуулсан ч энэ нь зөвхөн нийслэлд төвлөрөн ажиллаж байна. Харин ХХГХ-тэй тэмцэх үүрэг бүхий бусад байгууллагуудад бие даасан бүтэц бий болоогүй, тухайн асуудлыг дагнан хариуцдаг мэргэжилтэн байхгүй тул бусад албан хаагчид өөр асуудлуудтай хавсран хариуцдаг байна.

Ажлын даалгаварт өгөгдсөн судалгааны зорилтын дагуу Хохирогч хамгааллын асуудлыг илүү нарийвчлан судалсан бөгөөд тус хэсгийн үр дүнг Бүлэг 3-т дэлгэрэнгүй танилцууллаа. Иймд тайлангийн уг хэсэгт урьдчилан сэргийлэх (prevention), хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа (prosecution) болон

⁷³ Төрийн мэдээлэл, 2019 он, дугаар 42

⁷⁴ Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний тайлан, SICА, 2019

хамтын ажиллагаа (partnership) гэсэн гурван дэд сэдвийн хүрээнд ХХГХ-тэй тэмцэх тогтолцооны чадавх, хуулийн хэрэгжилтэд нөлөөлж хүчин зүйлсийг авч үзлээ:

4.1.1 ХХГХ-тэй тэмцэх үндэсний тогтолцоон дахь хязгаарлагдмал асуудлуудаас үүдэн бүтцийн түвшинд ХХГХ үйлдэгдэх эрсдэлийг нэмэгдүүлж буй хүчин зүйлс:

ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх ажлууд дахь талуудын оролцоо, хамтын ажиллагаа сул, ихэнх тохиолдолд богино хугацааны төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд нэгдсэн бодлого, хяналтгүй явагдаж байгаа нь урьдчилан сэргийлэх ажлуудын уялдаа холбоо, түүний үр дүнг сулруулахад нөлөөлж байна. Монгол Улсад гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 20 гаруй хууль⁷⁵ мөрдөгдөж байгаагаас “Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль” нь ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх гол хууль юм. Энэ хууль болон түүний хэрэгжилтийг хангах зорилгоор батлагдсан Үндэсний хөтөлбөрт урьдчилан сэргийлэх чиглэлээр холбогдох байгууллагуудын чиг үүргийг тодорхой дурдсан.

2019 онд SICA судалгааны институт Үндэсний хөтөлбөрт тусгагдсан дараах үндсэн дөрвөн зорилтын хэрэгжилтийг үнэлэх хөтөлбөрийн дунд хугацааны үнэлгээг⁷⁶ гүйцэтгэсэн. Үүнд:

1. ХХГХ-ээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үе шаттай арга хэмжээг авч хэрэгжүүлэх
2. ХХГХ-т өртсөн болон хохирсон иргэдийг хамгаалах, эрүүл мэндийг нөхөн сэргээх, нийгэмшүүлэх цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх
3. ХХГХ-ийг илрүүлэх, шийдвэрлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх
4. Хүн худалдаалахтай тэмцэх ажлыг хэрэгжүүлэгч байгууллагууд болон гадаад улс, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх

Эдгээр зорилтуудад хүрэхийн тулд 2017-2019 оны хооронд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнг үнэлэхийн тулд дараах аргуудад тулгуурлан мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийсэн. Үүнд: (1) 2018, 2019 оны хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлангуудад дүн шинжилгээ хийх, (2) ХХГХ-тэй тэмцэх дэд зөвлөлийн гишүүн байгууллагуудтай ганцаарчилсан ярилцлагууд хийх (n=7), (3) Оролцогч байгууллагуудын олон нийтэд ХХГХ-ээс сэргийлэх, сэрэмжлүүлэх зорилготой цахим хуудсандаа байршуулсан мэдээ, нийтлэлд ажиглалт хийж үнэлгээг гүйцэтгэсэн байна. Үнэлгээний үр дүнгээр “ХХГХ-ээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн үе шаттай арга хэмжээг авч хэрэгжүүлэх” тухай 1-р зорилтын биелэлт 84.5 хувьтай буюу тодорхой үр дүнд хүрсэн гэж дүгнэсэн. Гэвч уг үнэлгээ нь хөтөлбөрийн зорилтын үр дүнд хүрснийг тодорхойлох, хэмжих шалгуур үзүүлэлтгүйгээс уг үнэлгээ нь тодорхой төлөвлөгөөнд суурилж гүйцэтгэгдээгүй байна. Иймд цаашдын урьдчилан сэргийлэх бодлого, стратегийг мэдээллээр хангахад үнэлгээг чиглүүлэхийн тулд хяналт, үнэлгээ хийх арга зүй, түүний чанарыг сайжруулах шаардлагатай.

Мөн уг тайлангийн дүгнэлтээс үзэхэд төрийн байгууллагуудын ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хүлээсэн үүргээ биелүүлэх, хамтарч оролцох байдал харилцан адилгүй, зарим байгууллагын оролцоо бага байгаа нь ажиглагдаж байна⁷⁷.

Үүрэг хүлээсэн төрийн байгууллагуудаас гадна, ИНБ-уудын үйл ажиллагааны ихээхэн хэсэг нь ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх ажил уруу чиглэгддэг. Уг судалгааны хүрээнд ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогч хамгааллын үйлчилгээ үзүүлдэг зургаан ТББ-тай ярилцлага хийсэн ба ихэнх нь олон улсын байгууллагуудын дэмжлэгтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг. Эдгээр байгууллагууд нь бүгд

⁷⁵ Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Авлигын эсрэг, Садар самуун явдалтай тэмцэх тухай, Мансууруулах эм, сэтгэгдэл нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай, Хүн худалдаалахтай тэмцэх тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай, Гэрч хохирогчийг хамгаалах тухай, Гамшгаас хамгаалах тухай, Соёлын өвийг хамгаалах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн тухай, Төрийн хяналт шалгалтын тухай, Цагдаагийн албаны тухай, Хүүхэд хамгааллын тухай хуулиуд

⁷⁶ Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний тайлан, SICA, 2019

⁷⁷ Өмнөхтэй ижил.

тодорхой хэмжээнд урьдчилан сэргийлэх чиглэлийн сургалт, сурталчилгаа, мэдээлэл түгээх ажлуудыг хэрэгжүүлж байгаа хэдий ч үйл ажиллагаа нь байгууллага бүрийн чадавхаас хамааран тодорхой нэг төсөл, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжиж байна. Тухайлбал:

- **UNBOUND ТББ** ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх чиглэлд сургалт, сурталчилгаа, олон нийтийн нөлөөллийн ажлуудыг идэвхтэй зохион байгуулдаг. Тус байгууллага нь 2018 оноос ХХГХ-т өртөж болзошгүй охид, эмэгтэйчүүдийг хилээр дамжин өнгөрөхөөс өмнө олж тогтоон, урьдчилан сэргийлж, таслан зогсоох зорилготой “Дамжин өнгөрөх ажиглалт” төслийг Дорноговь аймгийн Замын-Үүд сумын хилийн боомтод хэрэгжүүлж байна. Төслийн хүрээнд 16-40 насны нийт 3,601 охид, эмэгтэйчүүдээс асуулга судалгаа авч, ХХГХ-т өртөх эрсдэлтэй 205 эмэгтэйг тогтоон, 38 охид, эмэгтэйчүүдэд ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх, болзошгүй эрсдэлээс өөрсдийгөө хамгаалах талаар зөвлөгөө өгснөөс 24 эмэгтэй гадаад улс руу гарахаас татгалзсан тул гэр бүлд нь аюулгүй буцаасан байна.⁷⁸
- **ЭКПАТ Үндэсний сүлжээ ТББ** Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн захын хороод болон МСҮТ-ийн дотуур байранд амьдардаг, шилжин суурьшсан, эмзэг бүлгийн, бэлгийн мөлжлөг, ХХГХ, ГБХ-ээс хамгаалагдах шаардлагатай өсвөр насны 25 охидыг хамруулж нийгэм-сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлж байна.
- Мөн ХХГХ, түүний нийгэмд үзүүлж учруулж буй хор нөлөөллийн талаарх олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, төр засгийн болон олон нийтийн оролцоог дэмжих, бодит арга хэмжээ авахыг уриалах зорилготой ХХГХ-ийн эсрэг кампанит ажил болох НҮБ-аас жил бүрийн 7-р сарын 30-нд зарладаг “Хөх зүрхний аян”-г ХЗДХЯ болон бусад ТББ-тай хамтран үндэсний хэмжээнд зохион байгуулсан байна.

Эдгээр жишээнээс үзэхэд урьдчилан сэргийлэх ажлууд нь ОУБ-ын дэмжлэгтэйгээр тодорхой нэг төсөл, хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдаж байгаа хэдий ч тогтолцооны хүрээнд **байгууллагуудын урьдчилан сэргийлэх ажлууд хоорондоо уялдаатай байх, нэг бодлогын хүрээнд зангидагддаг байх, амжилттай хэрэгжиж, сайн туршлага болж буй ажлуудын хүрээг нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх хэрэгцээ байна.**

Мөн Үндэсний хөтөлбөрт холбогдох төрийн байгууллагуудын чиг үүргийг тодорхойлсон хэдий ч тэдгээрийн хэрэгжилтийг хангахад асуудал хариуцсан байгууллагаас бусад төрийн байгууллагуудын оролцоо, анхаарлыг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Үүний тулд урьдчилан сэргийлэх ажлуудыг уялдуулах чиглэлээр баталсан хуулийн хэрэгжилтийг хангах, урьдчилан сэргийлэх ажлыг нэгдсэн нэг бодлого, чиглэл, төлөвлөгөөний хүрээнд зохион байгуулах, хяналт үнэлгээг тогтмолжуулж, үр ашигтай хамтран ажиллах байдлыг сайжруулах нь чухал байна.

ХХГХ-ийг хянан шийдвэрлэхэд Эрүүгийн хууль дах гэмт хэргийн зүйлчлэлийн давхардал, шүүхийн албан хаагчдын мэдлэг, ойлголт, тогтворгүй байдал зэрэг хүчин зүйлс сөргөөр нөлөөлж байна. Монгол Улсад 2014-2020 оны эхний хагас жилийн байдлаар цагдаагийн байгууллагад ХХГХ-ийн 86 хэрэг шалгагдсан боловч үүний зөвхөн 10 хувь нь буюу есөн хэрэг л шүүхээр шийдвэрлэгдсэн. 2017 онд бүр ХХГХ-ийн ганц ч хэрэг шүүхээр шийдвэрлээгүй байгаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хангалтгүй явагдаж байгааг харуулах ба үүнд дараах шалтгаанууд нөлөөлж байна. Үүнд:

- **Хуулийн заалт дахь давхардал:** 2015 онд шинэчлэн баталсан Эрүүгийн хуульд ХХГХ-ийг тодорхойлохдоо Палермо протоколын агуулгад тулгуурлан оруулсан байдаг. Гэвч тус хуульд ХХГХ-ийн хэлбэрүүдийг бие даасан гэмт хэрэг болгон давхар хуульчилсан байна. Эдгээр гэмт хэргүүд нь зөвхөн мөлжлөгийн зорилготой үйлдсэн байхыг зааснаас гадна ХХГХ-ий үйлдэх арга, үйлдэл зэргийг илэрхийлэх шинжийг агуулсан байгаа нь гэмт хэргийн зүйлчлэлүүдийн ялгааг

⁷⁸ Дамжин өнгөрөх ажиглалт төслийн тайлан, Unbound, 2019

гаргахад үг хэллэг, найруулгын талаас төөрөгдөл үүсгэх эргэлзээтэй байдлыг үүсгэж байна. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нийтлэг тохиолдолд хэрэг үйлдэгчийн субъектив сэдэл, санааг тодорхойлох боломжгүй нөхцөлд хэрэгтний эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийн заалтаар зохицуулах зарчим үйлчилдэг. Энэ тохиолдолд давхардуулан зүйлчилсэн гэх эдгээр заалтууд нь ХХГХ-ээс бага ял шийтгэлтэй байгаа нь 13.1-р зүйл заалтыг хэрэглэхгүй байх цоорхойг үүсгэж байна. Энэ нь ХХГХ шүүхээр шийдвэрлэхгүй байхад нөлөөлж буй зарчмын гол шалтгаануудын нэг болж байна.

- **Боловсон хүчний мэдлэг, чадавх:** Шүүх байгууллагын ажилтнуудын Эрүүгийн хуулийн ХХГХ-тэй холбоотой заалтуудын талаарх ерөнхий мэдлэг, ойлголт дутмаг байдгаас зарим хэргүүдэд хөнгөн ял шийтгэл оногдуулах, гэмт хэрэгтэнд ял завших боломж олгосон тохиолдол гарсан байна.⁷⁹ Тухайлбал, Цагдаагийн байгууллагад ХХГХ байж болзошгүй 12 гомдлыг шалгаж, 7 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэсэн. Гэвч шинэчилсэн Эрүүгийн хуультай бүрэн танилцаж амжаагүй гэх шалтгаанаар Прокурорууд ял шийтгэл оногдуулахад оновчтой бус, 26 эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон ноцтой асуудал гарсан⁸⁰. Мөн шүүх, цагдаа, прокурорын албан хаагчдын ХХГХ-ийн талаар мэдлэг, ойлголт сул байгаагаас ХХГХ, ялангуяа бэлгийн мөлжлөгийн хохирогчийг биеэ үнэлэгч гэж харьцах хандлага байсаар байна⁸¹.
- 2017-2019 оны хооронд АНУ-ын төрийн департаментийн санхүүжилттэйгээр Азийн сангаас хэрэгжүүлсэн “Хохирогч төвтэй мөрдөн шалгах ажиллагааг сайжруулах нь” төслийн хэрэгжүүлсэн. Уг төслийн хүрээнд үндэсний хэмжээнд 19 төрлийн чадавх бэхжүүлэх сургалтын хүрээнд 720 гаруй хууль сахиулах ажилтнуудыг сургаж, чадавхжуулсан байна. Үүнд, анхан шатны шүүхийн 51 шүүгч, 96 прокурор, 232 цагдаагийн ажилтан, 212 хил хамгаалахын ажилтан, 118 гадаадын иргэн харьяатын ажилтнууд хамрагджээ. Өргөн хүрээнд зохион байгуулсан уг сургалтын хүрээнд хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа сайжирч, 2017 онд нэг ч хэрэг шийдэгдээгүй байсан бол 2018 онд гурав, 2019 онд хоёр, 2020 онд найман хэрэг 13.1 заалтын дагуу тус тус шүүхээр шийдвэрлэгдсэн байна. Иймд цаашдаа тогтолцооны оролцогч талуудыг тогтмол чадавхжуулах сургалтууд зохион байгуулах шаардлагатайг судалгаанд хамрагдсан бүх талууд онцолж байна.

Шигтгээ 9. Төрийн албан хаагчдад чиглэсэн чадавх бэхжүүлэх сургалтын хэрэгцээний талаар

“Хүн худалдаалах гэмт хэргийн бэлгийн мөлжлөгийг хангалттай илрүүлэн, таньж мэддэг болсон. Харин хүн худалдаалах гэмт хэргийн бусад төрлүүд болох хөдөлмөр мөлжлөг, хүүхэд худалдаалах гэмт хэргийг илрүүлэх, таньж мэдэх дээр суралцах хэрэгцээ байгаа. Энэ нь манай улсын хувьд шинэ хэлбэр, төрлүүд, нэгдсэн ч ойлголтгүй байна.”

Цагдаагийн албан хаагчтай хийсэн ганцаарчилсан ярилцлагаас

- **Боловсон хүчний тогтворгүй байдал:** Хохирогчид үйлчилгээ үзүүлдэг ТББ-ын төлөөлөлтэй хийсэн ярилцлагаар хууль сахиулах байгууллагын алба хаагчдын тогтворгүй байдал нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах нэг хүчин зүйл болдог байна. Хариуцсан албан хаагч нь солигдсоноор хохирогчийг мөрдөн шалгах ажиллагаанд удаа дараа оролцуулах зэргээр хохирогчийг залхаах нөхцөлийг бүрдүүлдэг нь хохирогчид хуулийн байгууллагад хандахаас зайлсхийх нөхцөл болж байна.
- **Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үе дэх хохирогч хамгааллын асуудал:** Хуулийн байгууллагын үе шат бүрд хохирогч хамгааллын үйлчилгээ сул байгаагаас Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирогч унааны зардал, зарим мөрдөн шалгах ажиллагаа /шинжилгээ хийлгэх гэх мэт/-ны зардлыг өөрөөсөө гаргах шаардлагатай болдог. Уг нөхцөл байдал нь хохирогчид санхүүгийн хувьд дарамт болдог нь хохирогч хэргээ шийдүүлэхээс цааргалах, татгалзахад нөлөөлж байна.


⁷⁹ АНУ-ын төрийн департаментын 2018 оны Хүн худалдаалах төлөв байдлын тайлан

⁸⁰ Өмнөхтэй ижил.

⁸¹ Өмнөхтэй ижил.

Монгол Улсад ХХГХ-ээр үүсгэсэн хэргийг шийдвэрлэхэд хэдий хугацааг зарцуулж байгааг хуулийн заалт болон шийдвэрлэгдсэн долоон хавтаст хэргийн материалд үндэслэн харьцуулалт хийв. ЭХХШТХ-д зааснаар ХХГХ-ийг нэг жилийн дотор хянан шийдвэрлэх боломжтой боловч бусад хүчин зүйлийн шалтгаанаар энэ хугацаа цааш сунгагдах боломжтой байна (**Зураг 21**).

Зураг 22. Судалгааны зорилгоор танилцсан 7 хэргийн шийдвэрлэгдсэн хугацаа



Судалгааны багийн танилцсан шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн эрүүгийн хэргүүдийн шийдвэрлэгдсэн хугацааг харьцуулан үзвэл нэг хэргийг хянан шийдвэрлэхэд дунджаар 13.4 сар зарцуулж байгаа ба үүнээс мөрдөн байцаалт, прокурорын хяналтын ажиллагаанд 8.2 сар, шүүхийн ажиллагаанд 4.7 сарыг зарцуулсан байна. Гэхдээ энэ нь тухайн хэргийн ээдрээ, төвөгтэй байдал, гэмт хэрэг үйлдсэн этгээд олдсон эсэх зэрэг бусад нөхцөл байдлаас шалтгаалан өөр өөр байхыг анхаарах хэрэгтэй.

Дээрх нөхцөл байдлуудаас харвал мөрдөн шалгах ажиллагаа, хэргийг шүүхээр хэлэлцэх явцад гэмт хэргийн зүйлчлэл өөрчлөгдөх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цар хүрээнээс хамаарч бүртгэгдсэн гэмт хэрэг болон шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тооны харьцаанд хол зөрүүтэй байдал үүсэх нөхцөл бүрдэж байна.

ХХГХ-ийг мөрдөн шалгах, шүүхээр хянан шийдвэрлэх явцад гадаад бусад улс орнуудаас нотлох баримт цуглуулж хохирогчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд олон улсын бусад орнуудтай хамтран ажиллах, холбогдох олон улсын гэрээ, хэлэлцээр, конвенцыг ашиглах байдал бага байна. ЭХХШТХ-ийн 42.1 дүгээр зүйлд зааснаар гадаад улсын нутаг дэвсгэрт мэдүүлэг авах, үзлэг, нэгжлэг, туршилт хийх, эд хөрөнгө хураан авах болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах шаардлагатай бол эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай болон олон улсын бусад гэрээ, хэлэлцээрийн дагуу хүсэлт илгээдэг. Өөрөөр хэлбэл, Монгол Улсаас эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр гэрээ байгуулсан 18 улсад⁸² ХХГХ үйлдэгдсэн тохиолдолд холбогдох нотлох баримтыг цуглуулж бэхжүүлэх талаар хүсэлтээ илгээн шийдвэрлүүлэх боломжтой.

⁸² Беларусь, Болгар, Чехословак (одоогийн Чех, Словак), БНАСАУ, Франц, Хонконг, Унгар, Казахстан, Киргизстан, Энэтхэг, Бүгд Найрамдах Солонгос, БНХАУ, Польш, Румын, ОХУ, Турк, Украин, Вьетнам.

УЕПГ-аас авсан мэдээллээр 2017 онд 13, 2018 онд 17, 2019 онд 25, 2020 онд 29 хэрэгт гадаад улсад нотлох баримт цуглуулах хүсэлт илгээжээ. Гэвч уг мэдээллээс Эрүүгийн хуулийн аль зүйл хэсэгт заасан хэрэгт, ямар улс руу хүсэлт илгээснийг харах боломжгүй байна.⁸³

Судалгааны хүрээнд 2014-2018 онд шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн 14 хохирогчтой долоон хэргийн материалтай танилцахад тэдгээр хэргийн тав нь БНХАУ руу хохирогчдыг гаргаж, бэлгийн мөлжлөгт өртүүлж, биеийг нь үнэлүүлсэн байна. Гэтэл эдгээр хэргүүдээс зөвхөн нэг л хэрэгт БНХАУ, Монгол Улсын хооронд байгуулсан эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний дагуу гэрчийг байцаах ажиллагаа явуулсан байна.

Үүнээс үзвэл мөрдөгч, прокуророос ХХГХ, ялангуяа хил давуулан хүнийг худалдаалсан аливаа гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, хохирогчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд онцгой анхаарч, гадаад улсад нотлох баримт цуглуулах ажиллагааг эрх зүйн хүрээнд хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Уг судалгааны хүрээнд ХХГХ-ийн гадаад болон дотоод урсгал чиглэлийг тодруулахыг зорьсон⁸⁴. Судалгааны үр дүнгээр ХХГХ-ийн гадаад урсгал чиглэлд Монгол Улсаас Зүүн болон Зүүн өмнөд Азийн улс орнууд руу охид, эмэгтэйчүүдийг худалдаалах чиглэл хэдий нь бий болсон нь албаны болон бусад эх сурвалжийн мэдээллээр баталгаажсан. Иймд ХХГХ үйлдэгдэж буй урсгал чиглэлтэй холбоотойгоор эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулаагүй улс, тухайлбал Норвеги, Швед, Бельги, Камбож, Герман, Япон, Малайз, Филиппин, АНУ зэрэг улс оронтой Монгол Улс харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулах зайлшгүй шаардлагатай байна.

Мөн Монгол Улсын нэгдсэн орсон олон улсын баримт бичиг, гэрээ конвенцыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиглаж буй байдлыг авч үзсэн. Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн (2017 оны 7 сарын 1) нэг ололттой тал нь Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний заалтыг хэрэглэх боломжийг бүрдүүлсэн явдал юм. Гэвч ХХГХ-ийг шүүхээр хянан шийдвэрлэхдээ олон улсын гэрээний заалтыг дурдаж, шийдвэрлэсэн “ганцхан” тохиолдол байна. Тодруулбал, Баянзүрх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 234 дугаартай шийтгэх тогтоолын (2020 оны 2 дугаар сарын 7-ны өдрийн) тодорхойлох хэсэгт “Боолчлол, боолын худалдааг хориглох тухай конвенц”, “Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенц, түүний нэмэлт болох хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол”, Хүүхдийн эрхийн конвенцын холбогдох заалтуудыг тус тус тухайлан заасан нь шүүхийн практикт анхны тохиолдол болжээ.

Хэдийгээр олон улсын конвенцыг шүүхийн практикт хэрэглэсэн тохиолдол цөөн байгаа ч ашигласан туршлага байгаа нь сайшаалтай юм. Учир нь цаашид үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийг шүүхээр хэлэлцэхдээ нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын заалтыг баримтлах нөхцөл бүрдсэн гэж харж байгаа бөгөөд уг туршлагыг түгээн дэлгэрүүлэхэд шүүхийн байгууллага анхаарал хандуулж, идэвх, санаачилгатай ажиллах шаардлагатай.

Хэрэг мөрдөн шалгах ажиллагааны явцад хохирогчид өмгөөллийн туслалцаа үзүүлэх байдал хангалтгүй байна. ЭХХШТХ-ийн 8.2 дугаар зүйлд хохирогч нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй хэмээн заасан. Гэвч уг заалтын хэрэгжилт хангалтгүй байна. Уг судалгааны хүрээнд нийт 14 хохирогчтой долоон хэргийн хавтаст материалтай танилцахад насанд хүрээгүй нэг хохирогчоос бусад нь төлбөрийн чадваргүйн улмаас өмгөөлөгчгүй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон байв.

Монгол Улсын Их Хурлаас 2013 онд төлбөрийн чадваргүй ялагдагчийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах, төрөөс хууль зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоо, зохион байгуулалт, эрх зүйн байдлыг

⁸³ УЕПГ-ын 2020 оны 9/5472 дугаартай албан бичиг

⁸⁴ ХХГХ-ийн урсгал чиглэлтэй холбоотой судалгааны үр дүнг тайлангийн 2-р бүлэгт танилцуулав.

тогтоох зорилгоор “Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай” хуулийг батлан гаргасан. Гэвч төлбөрийн чадваргүй хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх журам өнөөг хүртэл батлагдаагүй учир хуулийн байгууллагад хандсан хохирогчид өмгөөллийн туслалцаа авч чадахгүй нөхцөл байдлууд нэмэгдэж байна.

Төр ийнхүү төлбөрийн чадваргүй хохирогчийн өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхийг орхигдуулсныг үйлчилгээ үзүүлэгч ТББ-ууд нөхөж, хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийнхөө хүрээнд мэргэшсэн өмгөөлөгч хөлсөлж байгаа нь ажиглагдлаа. Эдгээр байгууллагуудаас жишээ дурдахад Хүйсийн тэгш эрх төв ТББ нь ХХГХ-ийн хохирогч болсон охид, эмэгтэйчүүдэд хүний эрх, ХХГХ-тэй холбоотой хууль тогтоомжийн талаарх мэдээлэл өгөх, эрх зүйн анхан шатны туслалцаа үзүүлэх, хуулийн байгууллагад хандсан хохирогч нарын хууль ёсны эрх ашгийг хамгаалан ажиллах өмгөөлөгчдийг ажиллуулдаг. Эдгээр үйл ажиллагаатай холбоотой зардлыг хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрөөсөө санхүүжүүлдэг талаар ярилцлагадаа дурджээ.

ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагааны түвшинд талуудын хамтран ажиллах байдал сайн хэдий ч бодлогын түвшинд алсын хараа, үйл ажиллагааны чиглэлээ уялдуулах байдал орхигдсон байна. ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр талуудын оролцоог Хүн худалдаалдахтай тэмцэх тухай хууль болон Үндэсний хөтөлбөрт тодорхой заасан бөгөөд олон талын үйл ажиллагааг уялдуулах, нэгдсэн бодлого, удирдлагаар хангах чиг үүргийг Дэд зөвлөл гүйцэтгэж байгаа талаар өмнө дурдсан.⁸⁵ Тэдгээр оролцогч талуудын хамтын ажиллагааг хангах, сайжруулах, бэхжүүлэх чиглэлээр Үндэсний хөтөлбөрт мөн бие даасан зорилт тусгагдсан байдаг.

Үндэсний хөтөлбөрийн 4-р зорилтод “Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр гадаад улс, олон улсын болон төрийн бус байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх” зорилтыг тавин, хэрэгжилтийг хангахад чиглэсэн долоон дэд үзүүлэлт, 27 нэгж үйл ажиллагааг төлөвлөсөн. Энэхүү зорилтын биелэлтийг хөтөлбөрийн дунд хугацааны хэрэгжилтийн үнэлгээний тайланд 83.3 хувь буюу “тодорхой үр дүнд хүрсэн” хэдий ч шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа тул хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай гэж дүгнэжээ⁸⁶.

Хөтөлбөрийн үнэлгээний тайланд дурдсанаар хамтын ажиллагааг хангах чиглэлд холбогдох байгууллагын зүгээс тодорхой хүчин чармайлт гарган ажиллаж байна. Тухайлбал, төрийн болон бусад хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах байдлын хувьд ХЗДХЯ, ГХЯ, ХНХЯ, УБЕГ, ЦЕГ, ГБХЗХГ зэрэг төрийн байгууллагууд Монголын хуульчдын холбоо, ХТЭТ, Unbound Mongolia, ЭКПАТ Үндэсний сүлжээ зэрэг ХХГХ-ийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай хамтран тодорхой ажлууд хэрэгжүүлсэн байна. Харин энэ чиглэлээр талуудтай идэвхтэй хамтын ажиллагаатай олон улсын байгууллагад ОУШХБ болон Азийн сан зэрэг байгууллагууд дурдагджээ.

Гэвч талуудтай хийсэн ярилцлагаар нийт оролцогчдын 60 хувь орчим нь ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр салбар болон байгууллага хоорондын хамтын ажиллагааны өнөөгийн байдлыг сайжруулах шаардлагатай гэж үнэлсэн байна. Ялангуяа, ингэж үнэлэхэд талууд хоорондын мэдээллийн урсгал хангалтгүй байх буюу хаана ямар байгууллага ямар ажил хэрэгжүүлсэн, төрөөс ямар бодлого барьж ажиллаж байгаа талаар тогтмол, ил тод мэдээллийн урсгал сул (**Шигтгээ 10**) байгааг онцолж байлаа.

Шигтгээ 10. Салбар хоорондын байгууллагууд дунд мэдээллийн урсгал дутмаг байгаа талаар

Сүүлийн үед бусад салбаруудын оролцоо илт багасаж байна. Хоорондоо мэдээллээ хуваалцдаг нь багассан. Гол нь ил тод нээлттэй байдал нь байхгүй болчихсон учраас ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр хэн, хаана, яаж тэмцээд байгаа гэдэг талаар нэгдсэн мэдээлэлгүй болчихоод байна.

Төрийн албан хаагчтай хийсэн ганцаарчилсан ярилцлагын тэмдэглэлээс

⁸⁵ ХЗДХЯ, АНУ-ын Төрийн департамент, ХСИС, Азийн сан, ХХГХ-ийн хохирогч төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гарын авлага, УБ., 2018.

⁸⁶ ХЗДХЯ, SICA “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт” тайлан, 2019

Хамтын ажиллагааны үр дүнтэй байдлыг тодруулбал, байгууллагууд өөрсдийн хэрэгжүүлж буй ажлынхаа хүрээнд албан ёсоор хандсан тохиолдолд хамтран ажиллах саналыг хүлээж авах байдал нээлттэй байдгийг үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд дурдсан. Гэвч олон талын өгч буй мэдээллийг нэгтгэн үзвэл ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр байгууллагууд бодлогын түвшиндээ үйл ажиллагаагаа уялдуулах байдал хангалтгүй байна гэж судалгааны баг дүгнэсэн.

Энэ хүрээнд бодлогын түвшинд гарч буй шийдвэрүүдийн талаар үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд хангалттай мэдээлэлгүй байгаагаа ярилцлагын явцад илэрхийлж байв. Хэдийгээр Дэд зөвлөлд ТББ-ын төлөөлөл байдаг боловч ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр баримталж буй бодлого, гарсан шийдвэр, хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээллийг бусад байгууллагуудтай солилцох нэгдсэн сүлжээ, зохион байгуулалт дутмаг байна (**Шигтгээ 11**).

Шигтгээ 11. Мэдээллийн ил тод байдал, мэдээллээ түгээх, хуваалцах зохион байгуулалт дутмаг байгаа талаар

Хүн худалдаалахтай тэмцэх дэд зөвлөлийн хийгдэж байгаа ажлууд, гарсан шийдвэрүүд бусад байгууллагуудад нээлттэй биш санагддаг. Уг нь бол дэд зөвлөлд ТББ-ыг төлөөлсөн байгууллагуудын багтдаг хэдий ч бид хангалттай мэдээлэлгүй л ажиллаж байна. Улсын хэмжээнд хийгдэж байгаа ажлууд тэнд л нэгтгэгдэж, базагдаж байгаа тул эндээс л мэдээлэл сайн түгдэг байх ёстой гэж боддог.

Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын төлөөлөлтэй хийсэн ярилцлагын тэмдэглэлээс

Иймд ХХГХ-тэй тэмцэхэд оролцож буй бүх талуудад хүртээмжтэйгээр мэдээлэл түгээх, мэдээлэлтэй байлгах, мэдээллийн урсгалыг сайжруулахад анхаарах шаардлагатай.

ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр бүс нутгийн хамтын ажиллагаа нь хүний нөөцийг чадавхжуулах сургалт, туршлага солилцох чиглэлээр хязгаарлагдаж байна. ХХГХ нь үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг болохын хувьд түүнтэй тэмцэх ажилд бусад улс орнуудаас харилцан суралцах, туршлага, мэдээлэл солилцох, мөрдөн шалгах ажиллагаанд дэмжлэг үзүүлэх байдлаар хамтын ажиллагаагаа хадгалах нь чухал. Дээрх хэрэгцээ шаардлагад үндэслэн улс орнууд эрүүгийн хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээг хоёр улс орны хооронд байгуулдаг. Өмнөх бүлэгт дурдсанчлан Монгол Улс 18 улстай дээрх гэрээг байгуулсан байдаг боловч өнөөдрийг хүртэл ХХГХ-ийг шийдвэрлэх чиглэлээр ашигласан туршлага цөөн байна. Энэ нь нэгдүгээрт, илэрч, мөрдөгдөж, шийдвэрлэж байгаа хэргийн тоо цөөн, хоёрдугаарт, хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэгч албан хаагчдын чадавх, ойлголт мэдлэг сул байгаатай холбоотой байна.

ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр бусад улс орнуудын төрийн байгууллагатай хамтран ажилласан байдлыг авч үзвэл илүү хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулах, туршлага солилцох зорилгоор хамтран ажиллаж иржээ. Тухайлбал:

- 2018 онд Прокурорын байгууллагын Сургалтын төвийн чадавхыг сайжруулах чиглэлээр 8 прокурорыг ХБНГУ-ын шүүх, прокурорын сургалтын тогтолцоотой танилцуулж, сургагч багш нар сургалтын арга зүйн талаар санал солилцсоноос гадна Европын зөвлөл, Европын Хүний эрхийн шүүхийн үйл ажиллагаатай танилцсан.
- ОУШХБ-аас гадаад улс дахь Дипломат төлөөлөгчийн газарт ажиллаж байгаа 30 консулын ажилтнуудыг ХХГХ-ийн хохирогчид туслалцаа үзүүлэх чиглэлээр цахим сургалтад хамруулсан.
- 2019 онд ХЗДХЯ нь Азийн сантай хамтран хэрэгжүүлсэн төслийн хүрээнд 12 хүнийг мэргэшүүлэх сургалтад хамруулан сургасан.
- 2019 онд ЦЕГ-ын Зохион байгуулалттай гэмт хэрэг, ХХГХ-тэй тэмцэх тасаг болон Хууль сахиулах сургуулийн төлөөлөл 10 ажилтан БНХАУ-ын Бээжин хотноо зохион байгуулсан ОУШХБ-ын хуралд оролцон ХХГХ-тэй тэмцэхэд хоёр улсын хамтын ажиллагааг үйл ажиллагааны түвшинд сайжруулах зорилтын хүрээнд ижил чиг үүргийн цагдаагийн албан хаагч нартай туршлага солилцсон.

Үндэсний хөтөлбөрийн дунд хугацааны үнэлгээний тайланд ХХГХ-тэй тэмцэх ажлыг хэрэгжүүлэгч байгууллагууд болон гадаад улс, олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх тухай Зорилт 4-ийн хүрээнд гадаад улсын ХХГХ-тэй тэмцэх чиг үүрэг бүхий болон холбогдох бусад байгууллагаас туршлага судлах, харилцаа холбоо тогтоох асуудалд анхаарч байна гэжээ. Тухайлбал, ГХЯ-аас ХХГХ-ийн шинэ хэлбэрүүд болох цус, эс, эд эрхтэн худалдахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох асуудлаар олон улсын туршлагыг судлах үүднээс хилийн чанад дахь Дипломат төлөөлөгчийн газруудаас судалгаа авсан байна. Судалгаанд үндэслэн ХХГХ-тэй тэмцэх үндэсний бодлого, тогтолцоо нь тогтсон, мэргэжилтэн бэлтгэх, сургах чиглэлээр бусад улс оронтой хамтран ажиллах боломжийг эрэлхийлж байгааг дурдсан байна.

Түүнчлэн судалгааны явцад төрийн байгууллагын алба хаагчид илүү олон улсын шинэ хандлагад алба хаагчдыг ялангуяа хууль сахиулах салбарын алба хаагчдыг мэргэшүүлэн сургахын ач холбогдлыг онцолж байв. **Одоогийн түвшинд холбогдох алба хаагчид бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийг илрүүлэхийн тулд хэрхэн, ямар арга тактикаар ажиллах талаар тодорхой хэмжээнд мэдлэг, туршлагатай болсон. Харин ХХГХ-ийн бусад төрөл хэлбэр ялангуяа, хөдөлмөрийн мөлжлөг, эд, эрхтэний наймаатай холбоотой гэмт хэргийг илрүүлэх, хянан шалгах, нотлох баримт цуглуулах чиглэлд чадавхжих шаардлагатай байна.**

2021 оны байдлаар улсын хэмжээнд ердөө 87 хөдөлмөрийн байцаагч байгаа бөгөөд Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт зургаа, нийслэлд 35, үлдсэн нь аймаг орон нутагт ажиллаж байна. Бодит байдалд цогц хяналт шалгалт хийхэд хүний нөөцийн хувьд энэ нь хангалтгүй тоо юм. Мөн албадан хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэргийг хянаж шалгах чиглэлээр байцаагчдад зориулсан сургалт дутмаг байна. Тухайлбал, 2018-2021 оны хугацаанд хөдөлмөрийн байцаагч нарт чиглэсэн ХХГХ-тэй тэмцэх арга хэмжээний талаар ганцхан удаа сургалт зохион байгуулсан байна⁸⁷. Мөн хилийн хяналтын улсын байцаагчдыг чадавхжуулах сургалтууд зохион байгуулагддаг хэдий ч эдгээр сургалтуудын ОУБ-аас хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн хүрээнд цөөн, тогтмол бусаар зохион байгуулагддаг байна⁸⁸.

Одоогийн байдлаар хөдөлмөрийн байцаагчид Төрийн хяналт шалгалтын тухай хуульд заасны дагуу гэнэтийн хяналт шалгалт хийх эрхгүй байна. Хуулийн дагуу аливаа байгууллагад хөдөлмөрийн хяналт шалгалт хийхээс тав хоногийн өмнө зайлшгүй бичгээр урьдчилан мэдэгдэх ёстой байдаг нь байгууллагуудад аливаа зөрчлөө нуун дарагдуулах боломжийг олгож байж болзошгүй юм⁸⁹. Судалгааг гүйцэтгэж байх хугацаанд Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга⁹⁰-ын 162 дугаар зүйлийн 162.2.1 дэх хэсэгт хяналт шалгалт явуулах аж ахуйн нэгж, байгууллага, ажлын байранд урьдчилан мэдэгдэхгүйгээр чөлөөтэй нэвтрэх эрхийг хөдөлмөрийн хяналтын байцаагчийн эрх үүрэгт тусгасан. Иймд уг хуулийн өөрчлөлттэй холбоотойгоор Төрийн хяналт шалгалтын тухай хуульд хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчдын гэнэтийн хяналт шалгалт хийх эрхтэй холбоотой зохицуулалтыг тусгах шаардлага үүсэж байна.

4.1.2 ХХГХ-тэй тэмцэхэд бүтцийн түвшинд эмзэг байдлыг бууруулж буй хамгаалагч хүчин зүйлс:

ХХГХ-тэй тэмцэх олон улсын гэрээ конвенцид нэгдэж, үндэсний хууль эрх зүйн орчныг бүрдүүлсэн нь бүтцийн түвшинд иргэдийг хамгаалах суурь нөхцлийг бүрдүүлж байна. Олон улсад ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр 16 олон улсын хэмжээний баримт бичиг батлагдан мөрдөгдөж байгаагийн 14-д нь Монгол Улс нэгдэн орж, улс орныхоо хэмжээнд хэрэгжүүлэх үүрэг хүлээжээ.

⁸⁷ 2021 онд Улаанбаатар хот болон аймгуудын 112 хөдөлмөрийн байцаагч, хөдөлмөрийн эрүүл ахуйн байцаагчдыг “ХХГХ, албадан хөдөлмөр, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэртэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай сургалт”-д хамруулсан байна.

⁸⁸ 2020 оны 9 сард Өмнөговь аймгийн МХГ-ын Шивээ хүрэн боомт, 10 дугаар сард Сэлэнгэ аймгийн Алтанбулаг боомтын хил хамгаалах байгууллагын ажилтнуудад “ХХГХ-ийн хохирогчийг илрүүлэх, хамгаалах, хохирогчдод туслалцаа үзүүлэх” сэдэвт 2 өдрийн сургалтад нийт 12 хилийн мэргэжлийн хяналтын улсын байцаагчдыг хамруулсан.

⁸⁹ АНУ-ын Төрийн департаментын 2020 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тайлан

⁹⁰ Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2022 оны 01-р сарын 01-ээс мөрдөж эхэлнэ.

Тэдгээрээс олон улсад мөрдөгдөж буй гол баримт бичиг нь НҮБ-ын Ерөнхий Ассамблейгаас 2000 онд баталсан Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол (Палермогийн протокол) байна.

Монгол Улс 2008 онд уг протоколыг соёрхон баталж, ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, хохирогчдыг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр анхааран ажилласны дүнд Монгол Улсын хууль тогтоомж сайжирч, олон улсын тодорхойлолт, зарчимтай нийцүүлсэн талаар холбогдох судалгааны тайланд⁹¹ дурдсан байна.

Үндэсний эрх зүйн баримт бичгүүдийг авч үзвэл Монгол Улс 2012 онд ХХГХ-тэй тэмцэх бие даасан хууль, тус хуулийн хэрэгжилтийг хангах “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр”-ийг батлан 2017-2021 оны хугацаанд хэрэгжүүлж байна. Бусад хөгжиж буй улс орны туршлагатай харьцуулахад Монгол Улс ХХГХ-тэй тэмцэх дотоодын эрх зүйн орчныг бүрдүүлж, олон улсын жишигт нийцүүлж, хуулийг хэрэгжүүлэх зорилгоор бие даасан үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж буй нь энэ чиглэлээрх бүтцийн түвшний нэг чухал хамгаалах хүчин зүйл болж байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас дараах олон улсын баримт бичгүүдэд⁹² нэгдэн орохоор Монгол хэл рүү орчуулж, батлуулах ажлыг зохион байгуулж байна:

1. 1980 оны 10 сарын 25-нд батлагдсан “Олон Улсын хэмжээнд хүүхэд хулгайлахтай холбогдон үүсэх иргэний асуудлын тухай конвенц”
2. 1996 оны 10 сарын 19-нд батлагдсан “Эцэг, эхийн эрх, үүрэг, хүүхэд хамгааллын арга хэмжээнд холбогдох хэргийн харьяалал, хэрэглэгдэх хууль, шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, хэрэгжүүлэх болох хамтран ажиллах тухай конвенц”
3. 2007 оны 11 сарын 23-нд батлагдсан “Тэжээн тэтгэх үүрэгт хэрэглэгдэх хуулийн тухай протокол”

Эдгээр олон улсын баримт бичгийг соёрхон баталснаар үндэсний хууль тогтоомжийг уялдуулах, хэрэгжилтийг хангахад тогтолцооны оролцогч талуудын хамтын ажиллагаа, хүчин чармайлт чухал ач холбогдолтой байхаар байна.

ХХГХ-тэй тэмцэх, урьдчилсан сэргийлэх чиглэлд ажиллаж буй дотоодын ТББ, олон улсын байгууллагуудын чадавх, үйл ажиллагаа, төсөл хөтөлбөрийн тоо нэмэгдэж буй нь ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх, хамгаалах тогтолцоог сайжруулахад хувь нэмэр оруулж байна. Сүүлийн жилүүдэд ХХГХ, түүний төрөл хэлбэрүүдийг таних, судлах, иргэд олон нийт, албан хаагчдын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах давтамж, цар хүрээ, хөрөнгө санхүүжилтийн хэмжээ нэмэгдэж буй нь уг асуудалд анхаарал хандуулж, үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудын тоо өсөн нэмэгдэж байгааг харуулж байна. Тэр хэрээр ХХГХ-тэй тэмцэх иргэний нийгмийн чадавх бэхжиж байгаа ба энэ хэрээр ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх, тэмцэх үйл ажиллагааг тогтвортой үргэлжлүүлэх боломжийг бүрдүүлж байна.

Тухайлбал, ОУШХБ, Азийн сан, ДЗМОУБ зэрэг олон улсын байгууллагууд, АНУ-ын төрийн департамент зэрэг гадаад орны засгийн газрууд ХХГХ-ийн нөхцөл байдлыг тодруулах, чадавх бэхжүүлэх ажлуудыг үйл ажиллагааныхаа стратегид тусган сүүлийн жилүүдэд тасралтгүй хэрэгжүүлж буй нь Монголчуудыг ХХГХ-т өртөх эрсдэлийг бууруулах, иргэдийг хамгаалахад хувь нэмэр оруулж буй бүтцийн түвшний нэг чухал хүчин зүйл болж байна.

⁹¹ Бодлогын судалгаа 1: Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол болон Монгол Улсын зарим хууль тогтоомжийн харьцуулалт, Азийн сан, 2017

⁹² ХНХЯ-ын Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газраас ирүүлсэн 2021 оны 11-р сарын 25-ны 11/3154 дугаартай албан тоот болон 2021/12/20-ны өдөр авсан тодруулга мэдээллийн дагуу

4.2 Нийгэм, эдийн засаг, соёл болон бусад салбарын түвшинд нөлөөлж буй бүтцийн эрсдэлт болон хамгаалагч хүчин зүйлс

4.2.1 Эмзэг байдлыг нэмэгдүүлж буй бүтцийн түвшний бусад хүчин зүйлс:

Ядуурал өндөр түвшинд байгаа нь ХХГХ-т өртөх иргэдийн эмзэг байдлыг нэмэгдүүлж байна.

Оролцогч талуудтай хийсэн ярилцлага, эрсдэлт бүлгийн иргэдийн эмзэг байдлын судалгаа, хавтаст хэргийн судалгаа болон бусад ижил төстэй судалгааны мэдээлэлд үндэслэвэл ХХГХ-ийн эрсдэл нэмэгдэхэд нөлөөлж буй суурь шалтгаануудын нэг нь иргэдийн санхүүгийн эмзэг байдал буюу ядуурлын асуудал зайлшгүй хөндөгдөж байна.

Хавтаст хэргийн судалгаагаар шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн долоон эрүүгийн хэрэгт хохирогчоор тогтоогдсон 14 хүний хөдөлмөр эрхлэлтийн байдалд дүн шинжилгээ хийхэд гурван хүнээс бусад нь эрхэлсэн тодорхой ажилгүй, эдийн засгийн хүндрэлтэй байсан нь гэмт хэрэгтнүүдтэй холбогдох нөлөөлжээ⁹³. DoMV загварын иргэдийн эмзэг байдлыг тодорхойлох тоон судалгааны дүнгээр мөн адил өндөр цалин хөлстэй ажлын төлөө эрсдэлтэй алхам хийх иргэдийн хувь маш өндөр (72 хувь) байв. Өөрөөр хэлбэл, санхүүгийн эмзэг байдал, түүнээс үүдсэн ядуурал нь иргэдийг гэмт этгээдүүдийн гарт орох эмзэг байдлыг нэмэгдүүлж буй гол хүчин зүйлсийн нэг болж байна.

Ядуурлын төлөв байдлыг илтгэх улсын хэмжээний тоо баримтуудыг авч үзвэл ҮСХ, Дэлхийн Банк хамтран гүйцэтгэсэн Өрхийн нийгэм, эдийн засгийн 2018 оны судалгааны дүнгээр Монгол Улсын хүн амын ядуурлын түвшин 2016 онд 29.6 хувь байсан бол 2018 онд 28.4 хувь болж, 1.2 пунктээр буурсан. Гэвч энэ нь өндөр үзүүлэлт бөгөөд Монгол Улсын нийт хүн амын 28.4 хувь нь өдөрт 1.9 ам.доллараас бага орлогоор амьдарч байна гэсэн үг. Үүнээс гадна ямар нэг эдийн засгийн цочрол үүсэхэд ядууралд өртөхөд ойрхон, эмзэг байдалтай хүн ам нийт хүн амын 15 хувийг эзэлж байгаа нь өндөр үзүүлэлт юм.

Байршлаар харвал орон нутагт 2016-2018 оны хооронд ядуурал 4.1 пунктээр буурсан бол эсрэгээр Улаанбаатар хотод ядуурлын түвшин өөрчлөгдөөгүй байна. Өөрөөр хэлбэл, Улаанбаатар хотод хүн амын төвлөрөл, тэр дундаа ядуу хүн амын эзлэх хувь өндөр байгаа нь нөлөөлөх ба нийт ядуу хүмүүсийн 63.5 хувь нь хот суурин газарт, түүний 41.8 хувь (378.2 мянган хүн) нь Улаанбаатар хотод амьдарч байна⁹⁴.

ҮСХ-ны тайланд дурдсанаар ядуурал бага насны хүүхдийн дунд зонхилж байна. Монголд ядуу таван хүн тутмын хоёр нь 15-аас доош насны хүүхэд байна. Ядуурал тухайн өрх дэх хүүхдийн тоо, тэжээгчдийн хувьтай нягт хамааралтай байгаа нь үр хүүхдүүдээ тэтгэх хангалттай тооны хөдөлмөрийн насны хүмүүс дутагдалтай байгааг илтгэж байна. Тэгвэл ядууралд өссөн хүүхдүүдийн хувьд боловсрол эзэмших боломж бага⁹⁵, үүнийг дагаад хүрэлцээтэй цалин хөлстэй хөдөлмөр эрхлэх боломж буурах, улмаар эдийн засгийн аливаа боломжийн төлөө иргэд өөрсдийгөө эрсдэлд оруулах магадлалыг нэмэгдүүлдэг. Энэ нь хүүхдүүд хөдөлмөрийн идэвхтэй насанд хүрэх үедээ ядуурлаас гарч чадахгүй байх, гэмт хэрэгт өртөх, холбогдох бүтцийн шинжтэй шалтгааныг бий болгож байна.

Өөрөөр хэлбэл, нэгэнт ажиглагдаж эхэлсэн ядуурлын соёл, түүнийг дэмжсэн нийгмийн тэгш бус байдлын дунд ядууралд байгаа иргэдэд амьдралаа дээшлүүлэх боломж хязгаарлагдмал болж байгаа нь тэдгээр иргэдийг ямар нэг хэлбэрийн гэмт хэрэгт өртөх, холбогдох хүргэж байна.

Орон нутгаас нийслэлийг зорих шилжилт хөдөлгөөний хориг нь албан бус шилжин ирэгчдийн ХХГХ-т өртөх эмзэг байдлыг нэмэгдүүлж байна. Монгол Улс дахь дотоод шилжилт хөдөлгөөн нь 1990 оноос хойш эрчимтэй явагдаж эхэлсэн. Шилжилт хөдөлгөөний урсгалыг харвал хот суурин газар уруу, ялангуяа, нийслэл Улаанбаатар хот руу шилжин суурьшиж буй өрхийн эзлэх хувь өндөр бөгөөд

⁹³ Эрүүгийн хэргийн төв архивт хадгалагдаж буй эрүүгийн хэргийн материалаас


⁹⁴ <https://www.worldbank.org/mn/news/press-release/2019/06/21/mongolias-2018-poverty-rate-estimated-at-284-percent>

⁹⁵ "Монгол Улсын боловсролын тогтолцоонд тэгш бус байдал газар авч байгааг олон судалгаа дурддаг ба хүүхдүүд хаана, ямар гэр бүлд өсч байгаагаас хамаарч боловсролын үлэмж ялгаатай орчинд суралцаж байна". Боловсролын тэгш бус байдал ардчиллын өөрийнх нь хувь заяатай холбоотой асуудал, МУИС-ийн багш, Социологийн ухааны доктор Г. Түмэннаст, 2020

энэ нь хотжилтын түвшинг нэмэгдүүлж, хөдөө орон нутгийн зарим хэсэгт хүн амын хэт цөөрөлтийг бий болгож байна.

Хөдөө орон нутгаас хот руу шилжих хөдөлгөөн 2010 онд дээд цэгтээ хүрч байсан бөгөөд түүнээс хойш ч гэсэн урсгал өндөр хэвээр буюу 2017 он хүртэл жилд дунджаар 30,000 хүн Улаанбаатар хотод шилжин суурьшсан байна. Хүн амын хэт төвлөрлийг барих зорилгоор 2017 оны 1 сард Нийслэлийн засаг дарга Улаанбаатар хот уруу чиглэсэн дотоодын шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах захирамжийг гаргасантай холбоотойгоор тус оноос хойш албан ёсоор шилжин ирэгсдийн тоо огцом буурсан (Зураг 23).

Зураг 23. Шилжин ирэгсдийн урсгал, бүс нутгаар



Эх сурвалж, Үндэсний статистикийн хороо www.1212.mn

Захиргааны бүртгэл мэдээллийг харвал уг шийдвэр нь нийслэл хот руу зорих шилжилт хөдөлгөөнийг бууруулсан мэт харагдах боловч дээрх хоригоос шалтгаалан шилжин ирэгсдийн хувьд олон асуудал бэрхшээлтэй тулгарах болсныг ОУШХБ-ын судалгааны тайлан⁹⁶-д дурджээ. Улаанбаатар хотод шилжин суурьшихыг хориглосон 2017 оны шийдвэртэй холбоотойгоор Нийслэлийн иргэнээр бүртгүүлэх, амьдрах газрын зөвшөөрөл авах, орон сууц, ажлын байр олоход бэрхшээлтэй болж, нийгмийн суурь үйлчилгээнд хамрагдах боломж хязгаарлагдан, улмаар нийгэм, эдийн засгийн амьдралаас тусгаарлагдах, гадуурхагдах зэрэг хүндрэлүүд нийтлэг тулгамдсан байна. Шилжилт хөдөлгөөнтэй холбоотойгоор үүсэж буй дээрх асуудлууд иргэдийн эмзэг байдалд хэрхэн нөлөөлж буйг авч үзвэл:

- Шилжигчдийн дийлэнх нь 25–39 насны залуучууд ба хөдөлмөрийн нөхцөлөө сайжруулах боломжийг эрэлхийлэн уугуул нутгаа орхиж явж байна. Гэвч хөдөлмөрийн зах зээлийн албан секторт ажлын байр харьцангуй хомс байгаа учраас тэдний ихэнх нь албан бус секторын тодорхой бус нөхцөлтэй үйл ажиллагаанд оролцож байна.
- Шилжихээсээ өмнө шилжин суурьших нутгийнхаа талаар мэдээлэл олж авах байдал хязгаарлагдмал. Шилжигч өрхүүдийн дийлэнх нь шилжин суурьших гэж байгаа газар нутгийнхаа талаар ямар нэг мэдээлэлгүйгээр шилжин суурьшиж байна.
- Шилжин ирэгсэд нь тухайн газарт ирснийхээ дараа амьжиргаа/ахуйн нөхцөлтэй холбоотой асуудалтай тулгардгаас гадна шилжин суурьшихаар ирсэн нутагт орон байр болон газрын зөвшөөрөлтэй холбоотой бэрхшээлүүд илүүтэй тохиолддог байна.
- Шилжигч өрхүүдийн дунд шилжих хөдөлгөөний бүртгэлийн түвшин харьцангуй доогуур, энэ нь нэн ялангуяа, Улаанбаатарт хамгийн бага байна. Шилжих хөдөлгөөний бүртгэлгүй шилжигч өрхийн тоо нийслэлд хамгийн өндөр байна.

⁹⁶ Улаанбаатар хотод шилжин ирэгсдийн эмзэг байдлын судалгаа, ОУШХБ, 2018


Илүү дээр амьдралын боломж нөхцөлийг эрэлхийлэн шилжилт хөдөлгөөнд орсон хэдий ч албан ёсоор орон нутгийн захиргаанд бүртгүүлж төрийн үйлчилгээ авч чадахгүй байх, албан секторт ажил хөдөлмөр эрхэлж чадахгүй байх, орон байр, газрын эзэмшил, ахуйн нөхцөлтэй холбоотой хүндрэлтэй тулгарч байгаа нь иргэдийн эмзэг байдлыг нэмэгдүүлж байна. Тодруулбал, шилжих хөдөлгөөний хориг нь иргэдийн эмзэг байдалд нөлөөлж буй эсэхийг авч үзсэн судалгааны дүнгээр бусад жилүүдэд хот уруу шилжсэн өрхөөс 2017 оноос хойш буюу шилжих хөдөлгөөний хоригтой жилүүдэд хот уруу орж ирсэн өрхийн олон талт эмзэг байдлын индекс 1.3 хувиар бага гарсан байна⁹⁷.

Шилжилт хөдөлгөөн болон Улаанбаатар хотын ядуурлын үзүүлэлтийг харьцуулж үзвэл жил тутам шилжин ирэгсдийн урсгал нэмэгдэх хэрээр нийслэлийн ядуурлын түвшинд эерэг өөрчлөлт гарахгүй байгаа дүр зураг харагдана. Ядууралтай холбоотой шалтгааныг авч үзсэн өмнөх хэсэгт дурдсанчлан Улаанбаатар хотод Монгол Улсын нийт ядуу таван хүн тутмын гурав нь байрлаж байгаа, тэдгээр иргэдийн дийлэнх хувийг шилжин ирэгсэд бүрдүүлж байгааг харгалзан үзвэл дотоод шилжилт хөдөлгөөний идэвхтэй урсгал нь иргэдийн эмзэг байдлыг нэмэгдүүлэх шалтгааны нэг болж байна.

Уг судалгааны анхдагч шинжилгээний хүрээнд мөн бүртгэлгүй шилжин ирэгчдийн ХХГХ-т өртөх эмзэг байдал бусад бүлгээс өндөр байгаа нь DoMV загварын шинжилгээгээр батлагдсан (*Хэсэг 1: Хувь хүний түвшний эрсдэл ба хамгаалалтын хүчин зүйлс бүлэгтэй танилцана уу*).

Боловсролын чанар хангалтгүй, хүртээмж сул байгаа нь иргэдийн эмзэг байдлыг нэмэгдүүлж байна. 2020 оны байдлаар Монгол Улсын бичиг үсэг тайлагдалтын түвшин 98.7 хувь⁹⁸, хүн ам боловсролын түвшингээр гурван хүн тутмын хоёр нь бүрэн дундаас дээш боловсролтой (**Зураг 24**), нэг хүний дунджаар суралцах хугацаа 15 жил⁹⁹ зэрэг үзүүлэлт нь боловсролын түвшний индекс болон ерөнхий үзүүлэлтээрээ бусад ижил төстэй оронтой харьцуулахад эерэг үр дүнг харуулж байна.

Зураг 24. Хүн амын боловсролын түвшин, хүйсээр, 2020, хувиар



Эх сурвалж: 2020 оны Хүн ам, орон сууцны тооллогын үр дүн

*Хүн ам орон сууцны тооллого судалгаа нь 10 ба түүнээс дээш насныхны дунд зохион байгуулагддаг.

Ерөнхий төлөв байдлаараа боловсролын түвшин нь ядуурлын үзүүлэлттэй харилцан уялдаатай хэвээр байна. Хөвгүүд, тэр дундаа хөдөөгийн хөвгүүд гэр бүлийнхэндээ туслахын тулд сургуулиасаа эрт завсардах хандлагатай, харин охид илүү удаан суралцаж, өндөр боловсрол эзэмших хандлагатай байна. Гэвч нас болон хүйсийн зарим бүлэгт онцлог ялгаатай үр дүн ажиглагдсан. Тухайлбал, залуу эмэгтэйчүүдийн (25-29 нас) 70 хувь нь дээд боловсрол эзэмшсэн ч энэ нь тэднийг хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцоход нөлөөлөхгүй байгаа үр дүн гарсан байна.¹⁰⁰ Өөрөөр хэлбэл бага боловсролтой байх нь эдийн засгийн хувьд ядуу байх нөхцөлийг бүрдүүлж байгаа хэдий ч дээд боловсрол эзэмшсэн байх нь эдийн засгийн хувьд сайн байх нөхцөлийг бүрдүүлэхгүй байна.

⁹⁷ Улаанбаатар хотын шилжилт хөдөлгөөний хязгаарлалтын үр нөлөө болон шилжин суурьшигчдын эмзэг байдлыг үнэлэх судалгаа, ОУШХБ, 2020

⁹⁸ http://1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_0400_068V1

⁹⁹ Монгол Улсын боловсролын статистикийн өнөөгийн байдал, YCX

¹⁰⁰ Ядуурлын дүр төрх, YCX, Дэлхийн банк, 2019

Мөн хувь хүний түвшинд хөдөлмөрийн зах зээлийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалан боловсрол эзэмшсэн байдлаас үл хамааран хөдөлмөрийн эрсдэлтэй сонголт хийх зан үйлтэй байгаа нь боловсролын түвшин нь ХХГХ-т өртөх эрсдэлийг бууруулахад хамгаалалтын нөлөө үзүүлж чадахгүй байгааг харуулж байсан. Иймд боловсрол, ядуурал, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөмтгий байдлын хоорондын хамаарлыг зайлшгүй үйл ажиллагааны төлөвлөлтөд анхаарч авч үзэх шаардлагатай бөгөөд тоохгүй үлдээж болохгүй юм.

Тус судалгааны хүрээнд хийсэн хавтаст хэргийн судалгааны дүнгээр хохирогчид бүгд бага болон бүрэн дунд боловсролтой, ХХГХ-т өртөх эрсдэлтэй 423 иргэний 72 хувь нь бүрэн дундаас доош боловсролтой байсан. Эндээс харахад ХХГХ-т дийлэнх нь боловсрол бага хүмүүс хохирох нөхцөл байдал ажиглагдана. Хоёрдугаарт, ХХГХ-т өртөмтгий иргэдийн 21 хувийг дээд боловсролтой хэрнээ сарын орлого нь 500,000 төгрөгөөс бага орлоготой хүмүүс бүрдүүлж байснаас үзэхэд дээд боловсролтой хэдий ч орлого багатай байх нь тэдгээр иргэдийг өндөр цалин хөлсний төлөө эрсдэлтэй алхам хийхэд хүргэж байна. Үүнд харилцан хамаарал бүхий олон асуудал нөлөөтэй байж болох хэдий ч бага боловсролтой иргэд олон байгаа нь ерөнхий боловсролын үйлчилгээний хүртээмжтэй холбоотой, дээд боловсрол хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцоход нөлөөлөхгүй байгаа нь дээд боловсролын чанар, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн асуудлыг хөндөхөд хүрч байна.

4.2.2 Эмзэг байдлыг бууруулж буй бүтцийн түвшний бусад хүчин зүйл:

Нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлгийн иргэдэд чиглүүлж буй нь тэдгээр иргэдийн эмзэг байдлыг нэмэгдүүлэхээс сэргийлж байна. Өнөөдрийн байдлаар Монгол Улсад нийгмийн халамжийн чиглэлийн таван хууль хэрэгжиж, эдгээр хуулийн хүрээнд ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, алдар цолтой ахмад настан, хүүхэд, эхчүүд болон нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа зайлшгүй шаардлагатай иргэдэд төрөөс тэтгэвэр, тэтгэмж олгож, тусламж, үйлчилгээ үзүүлж байна.

2021 оны эхний улирлын байдлаар Нийгмийн халамжийн сангаас 2.2 (давхардсан тоогоор) сая хүнд 512.6 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж үйлчилгээ, хөнгөлөлт олгосон нь өмнөх оны мөн үеэс нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид 134.4 (6.5 хувь) мянгаар, үйлчилгээнд олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлтийн хэмжээ 310.7 (2.5 дахин) тэрбум төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлт юм (**Хүснэгт 8**). Энэ нь COVID-19 цар тахлын нөлөөгөөр Монгол Улсын Засгийн газраас иргэдийн амьжиргааг дэмжих чиглэлээр мөнгөн тэтгэмжийн хэмжээг нэмэх, хүнд нөхцөл байдалд байгаа иргэдээ хамруулах шийдвэрийг гаргасантай холбоотой.¹⁰¹

Хүснэгт 8. Монгол Улсын Нийгмийн халамжийн үзүүлэлтүүд, оноор

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2019/03	2020/03	2021/03
Нийгмийн халамжийн сангийн санхүүжилт	Тэрбум төгрөг	170.9	230.3	538.5
Нийгмийн халамжийн санхүүгийн зарцуулалт	Тэрбум төгрөг	171.4	202.9	513.2
Нийгмийн халамжийн үйлчилгээнд олгосон тэтгэвэр, тэтгэмж, тусламж, үйлчилгээ, хөнгөлөлтийн хэмжээ	Тэрбум төгрөг	170.8	202.0	512.6
Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдагчид	Мянган хүн	1 868.0	2 079.4	2 213.8

Эх сурвалж: Монгол Улсын нийгэм эдийн засгийн байдал, ҮСХ, 2021/03

Халамжийн төрлөөр авч үзвэл, нийт зарцуулалтын 54 хувь нь Хүүхдийн мөнгөн тэтгэмжид зарцуулагдсан. 2021 оны эхний улирлын байдлаар 18 хүртэлх насны 1.2 сая хүүхдэд 360.7 тэрбум төгрөгийн тэтгэмж олгосон байна¹⁰². Хүүхдийн мөнгөн тэтгэмж нь Монгол Улсын ядуурлыг бууруулах, ялангуяа хөдөө орон нутгийн ядуурлыг бууруулахад өндөр ач холбогдолтой хөтөлбөрт тооцогддог¹⁰³ ба уг тэтгэмжийг нэмэгдүүлэх замаар аливаа цочролын үед хүүхэд болон гэр бүлд тусламж хүргэх нь

¹⁰¹ ҮСХ (2021) Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал 3/2021

¹⁰² Өмнөхтэй ижил.

¹⁰³ Хүүхдийн мөнгө хөтөлбөр, Хураангуй, ОУХБ, 2016

хамгийн үр дүнтэй болох нь ОУБ-ын судалгааны тайланд дурдагдсан байна.¹⁰⁴

Халамжийн үйлчилгээнд хэт их төсөв зарцуулж буй нь иргэдэд бэлэнчлэх сэтгэлгээ суулгах сөрөг талтай гэх шүүмжлэл дагуулдаг хэдий ч зорилтот бүлгийн хүн амын амьжиргааны суурь баталгааг хангахад үзүүлж буй хувь нэмэр нь эдгээр зорилтот бүлгийн иргэдийг гэмт хэрэгт өртөх эмзэг байдлыг бууруулах нөлөө үзүүлдэг нь одоогийн хэрэгжиж буй нийгмийн халамжийн бодлого, үйл ажиллагааны нэг чухал үр нөлөөтэй тал юм.

Улмаар нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдахын тулд харьяа баг/хороонд бүртгүүлэх, засаг захиргааны байгууллагуудтай харилцаатай байхад түлхэц үзүүлдэг нь зөвхөн орлогын дэмжлэг үзүүлэхээс гадна иргэдийг амьдарч буй орон нутаг, олон нийттэй харилцаатай байхад нөлөөлж байгаа нь иргэдийн эмзэг байдлыг бууруулахад давхар нөлөө үзүүлнэ.

ХОЁР: ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, УРСГАЛ ЧИГЛЭЛ, ЧИГ ХАНДЛАГА

Энэ бүлэгт Монгол Улсад болон Монгол Улсаас гадагшаа чиглэсэн ХХГХ-ийн хэлбэрүүд, арга зам, нийтлэг байршил болон ХХГХ үйлдэгдэж буй урсгал чиглэлийг боломжит мэдээллийн эх сурвалжуудад үндэслэн нэгтгэн харуулахыг зорилгоо.

Хэсэг 1. Монгол Улс дахь ХХГХ-ийн төлөв байдал

Монгол Улсын Эрүүгийн тухай хуулиар хүн худалдаалах гэмт хэрэг, бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөрлүүлэх, хүний цус, эс, эрхтэнийг хууль бусаар авах үйлдлүүдийг тусад нь гэмт хэрэгт тооцохоор заасан. Эдгээр зүйл заалт дахь зөрчилтэй тодорхойлолтууд нь хэрэгтэнд хөнгөн ял оногдуулах буюу ял завших боломжийг олгох эрсдэлийг дагуулж байгаа талаар өмнөх бүлэгт дурьдсан¹⁰⁵. Уг нөхцөл байдал нь мөн ХХГХ-ийн бүртгэл, тоон мэдээллийг нэгтгэн гаргахад төвөгтэй байдлыг үүсгэж байна. Тухайлбал, 13.1-р зүйл хүн худалдаалах гэмт хэргээр шүүхээр шийдэгдсэн бүх хэргүүд нь бэлгийн мөлжлөгийн зорилгоор худалдаалагдсан байх ба 12.3-р зүйлд мөн ижил бэлгийн мөлжлөгийн хохирогчид хамаарч байна. Уг хоёр зүйлчлэл нь зөвхөн хохирогчийн зорчих эрхийг хязгаарласан эсэх шинжээр ялгагдаж байна.

Дээрх хуулийн зүйл заалтын давхардмал байдлыг харгалзан тайлангийн уг бүлэгт Эрүүгийн хуулийн холбогдох зүйл заалт тус бүрээрх мэдээллүүдийг нэгтгэн авч үзлээ.

Зураг 25. Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэргийн тоо (жилээр)



Эх сурвалж: ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн албанаас авсан мэдээллээр, 2014-2020¹⁰⁶

¹⁰⁴ Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нэмэгдүүлэх замаар цочролын үед хүүхэд, гэр бүлд тусламж хүргэх нь хамгийн үр дүнтэй (mnb.mn)


¹⁰⁵ Хүн худалдаалах гэмт хэргийн тодорхойлолт, тайлангийн хуудас 27

¹⁰⁶ ЦЕГ-т бүртгэгдсэн гэмт хэргийн тоо: <http://police.gov.mn/as/static?page=1>

Цагдаагийн байгууллагад 2014–2020 оны хооронд бүртгэгдсэн хүн худалдаалах, бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийг авч үзвэл энэ төрлийн гэмт хэргийн тоо жил тутам тогтвортойгоор өсөх хандлагатай байна (**Зураг 25**). Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өсөж буй нь нэг талаас гэмт хэргийн илрүүлэлт нэмэгдэж буйг илтгэх эерэг үзүүлэлт юм. Гэвч эдгээр жилүүдэд Эрүүгийн хуулийн 15.3-р зүйл буюу хүний цус, эд эрхтэнийг хууль бусаар авахтай холбоотой хэрэг огт бүртгэгдээгүй байна.

Нөгөө талаас, Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн дээрх тоон мэдээлэл нь үйлчилгээ үзүүлэгч ТББ-ын бүртгэл мэдээллээс **хол зөрүүтэй** байгаа нь ХХГХ-ийн хохирогч болсон ч хуулийн байгууллагад мэдэгдэхгүй тохиолдлууд тэр хэмжээгээр олон байгааг илтгэж байна. ХХГХ-ийн хохирогчид туслалцаа үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Хүйсийн тэгш эрхийн төв (ХТЭТ) ТББ-ын мэдээлснээр тус байгууллага 2003 онд ХХГХ-ийн гурван хохирогчид л туслалцаа үзүүлж байсан бол энэ тоо сүүлийн жилүүдэд 30–40 (нэг жилд) болж нэмэгджээ (**Зураг 26**).

Зураг 26. ХТЭТ-д хандаж тусламж дэмжлэг авсан үйлчлүүлэгчдийн тоо



Эх сурвалж: ХТЭТ-өөс авсан мэдээлэл, 2021 оны 06 сарын 07-ны өдрийн байдлаар

ХХГХ-ийн төрөл, хэлбэр тус бүрээрх Монгол Улс дахь нөхцөл байдлыг тоймлон авч үзвэл:

1. Бэлгийн мөлжлөг/Бэлгийн мөлжлөгийн зорилгоор худалдаалах: Монгол Улсын Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга)-ийн 12.3 дугаар зүйлд “Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорчих эрхийг хязгаарлахгүйгээр бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан” үйлдлийг бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг гэж хуульчилсан. Уг хуулийн 13.1-р зүйл буюу Хүн худалдаалах гэмт хэргээс 12.3-р заалтын агуулгыг ялгаж буй гол заалт нь “зорчих эрхийг хязгаарласан эсэх” үзүүлэлт болдог. **Гэвч 12.3-р зүйл нь бэлгийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэргийн зарим хэлбэрүүдийг хамарч байна.**¹⁰⁷

ЦЕГ-ын ЭЦА-ны мэдээлснээр сүүлийн гурван жилийн байдлаар (2018–2020) **13.1-р зүйл Хүн худалдаалах гэмт хэргээр 131 хохирогч, 12.3-р зүйл бэлгийн мөлжлөгийн гэмт хэргээр 30 хохирогч тогтоогдсон байна (Зураг 27)**. ХХГХ-ийн бүх хохирогчид нь бэлгийн мөлжлөгийн хохирогч байгааг харгалзвал ойролцоогоор **жилд дунджаар 40–50 гаруй** охид, эмэгтэйчүүд бэлгийн мөлжлөгийн зорилгоор бусдад худалдагдаж байна.¹⁰⁸

Зураг 27. ХХГХ болон бэлгийн мөлжлөгийн гэмт хэргийн хохирогч, холбогдогчийн тоо, 2018–2020/06



Эх сурвалж: ЦЕГ-ын ЭЦА-ны мэдээлэл, 2020/12/10-ны байдлаар

¹⁰⁷ Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан, АНУ-ын Департамент, 2020

¹⁰⁸ ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн албанаас авсан мэдээллээр, 2021.03.02

Дотоодод үйлдэгдэж буй хэргүүд нь ихэнх тохиолдолд хохирогчийг караоке, саун, массажны газруудад дотоод болон гадаадын иргэдэд биеийг нь үнэлүүлэх замаар бэлгийн мөлжлөгт оруулдаг. Ашиглаж буй нийтлэг аргын хувьд өрийн барьцаанд оруулах, хуурч мэхлэх, архи тамхи хэрэглүүлж, эмзэг байдлыг нь далимдуулан эрхшээлдээ оруулж байна. Ялангуяа сүүлийн жилүүдэд эл байдал нь гудамж талбай, олон нийтийн газар биеийг үнэлүүлэхээс гадна интернэтээр дамжуулан зар тавих эс бөгөөс тодорхой үйлчилгээний байгууллагын ажилтнуудаар дамжуулан үйлчлүүлэгч (клиент) олж, хохирогчдыг зуучлах, дуудлагаар биеийг нь үнэлэх далд хэлбэр рүү шилжиж байна¹⁰⁹.

Хилийн чанадад үйлдэгдэж буй ХХГХ-ийн нөхцөл байдлыг эрүүгийн хавтаст хэрэгт хийсэн дүн шинжилгээ болон мэргэжлийн бүлгийн хүмүүстэй хийсэн ярилцлагаар тодруулахад ихэвчлэн найз нөхдөөр нь дамжуулан өндөр зэрэглэлийн үйлчилгээний газарт цалин сайтай ажил санал болгох замаар эмзэг байдлыг нь далимдуулан найз нөхдөөр нь дамжуулан элсүүлэлт хийж энэ төрлийн гэмт хэрэгт өртүүлэх нийтлэг байдал ажиглагдаж байна (Шигтгээ 12).

Шигтгээ 12. Өндөр цалин хөлс амлах замаар хохирогчийг хууран мэхэлж элсүүлсэн талаар

... 2020 оны 01-р сарын 30-д Чингис хаан нисэх буудлаас Малайз улсаар дамжин Сингапур хотод очиж зочид буудалд 4 сая төгрөгний цалинтай ажил хийнэ гээд явсан. Очих газраа очтол Сингапур биш Малайз улс байсан. Биднийг хоёр хоёроор нь өөр өөр буудалд тарааж байрлуулсан. Биднийг угтаж авсан хүнийг Роналд гэж дуудаж байсан. Тэр хүн нь бидний паспортыг штамп даруулна гээд хурааж авсан. Надаас мөнгө зээлээд гэр бүл рүүгээ илгээж болно гэхэд бид 2000 ренгит зээлсэн. Тэгээд буудал дамжуулан байрлуулахад байрны зардал, хоол хүнсний зардлыг цаанаас дааж байгаа гээд байсан худлаа болж бидэнд дээр өр үүссэн талаарх сүүлд мэдсэн.

ЦЕГ-ын ЭЦА-аас авсан мэдээллээс

... Б-д БНХАУ-ын Эрээн хотод бараа зарах ажил байгаа, 2-3 сар ажиллаад 1000 юаниас дээш орлого олох боломжтой гэж хэлсэн. Олсон мөнгөөрөө сурах боломжтой гэсэн санал тавьсан. Эрээн хотод очтол бичиг баримтыг хураан авч массажны газарт гурван сар биеэ үнэлж, бэлгийн мөлжлөгт орсон.

Хохирогчтой хийсэн ярилцлагын тэмдэглэлээс

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн бэлгийн мөлжлөгийн 131 хохирогчийн мэдээлэлд¹¹⁰ үндэслэн уг гэмт хэрэгт өртөж буй хохирогчдын нийтлэг ерөнхий мэдээллийг дор харуулав.

Зураг 28. Бэлгийн мөлжлөгийн хохирогчдын ерөнхий профайл (n=131)



¹⁰⁹ ЭЦА-аас 2021 оны 3 сарын 2-ны өдөр авсан мэдээллээр,

¹¹⁰ Хохирогчдын мэдээллийг ЭЦГ, Талита Ази ТББ, ОУШХБ-аас ирүүлсэн мэдээллүүдэд үндэслэв.



Хохирогчийг
элсүүлсэн
арга

- Эмзэг байдлыг далимдуулах
- Өрийн барьцаа
- Залилах хуурах
- Архи, хар тамхи хэрэглүүлэх
- Итгэлийг олж авах
- Заналхийлэх
- Хүч хэрэглэх

- Залилах хуурах
- Өрийн барьцаа
- Эмзэг байдлыг далимдуулах
- Заналхийлэх
- Итгэлийг олж авах
- Архи, хар тамхи хэрэглүүлэх

Бэлгийн
мөлжлөгт
өртүүлж
буй чиг
хандлага

- Цахим орчинд санхүү өгнө авна гэсэн албан бус зараар хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэх болсон.
- Фейсбүүкийн чат, видео дуудлага хэлбэр түлхүү ашиглагдан ХХГХ-т өртүүлэх, хохирогчийг элсүүлэх ажил хийгдэж байна.
- Цар тахалтай холбоотойгоор гудамж талбай, караоке, саун зэрэг газрууд хаагдаж далд хэлбэр лүү шилжсэн.

- Эхний хохирогч нь суллагдахын тулд дараагийн хохирогчийг өөрийн таньдаг хүрээлээсээ олж, хуурч мэхлэн авчрах байдлаар элсүүлдэг.
- Ихэвчлэн өрийн дарамтад орсон найз, нөхөд рүүгээ холбогдон цалин сайтай ажил хийж байгаа байдлаар видео хэлбэрээр тогтмол илгээдэг. Мөн тогтмол видео ярилцлага хийдэг. Хурдан шийдвэр гаргахыг ятгадаг. Өөрөө богино хугацаанд их мөнгө олсон одоо буцахаасаа өмнө чамайг ажилд оруулаад өгөө гэх зэргээр сайн сэтгэл гаргаж буй мэт өөртөө дасган, найзынхаа итгэлийг нь олж авдаг. Бүх зардлыг нь даана. Ирээд төлөх боломжтой гэдэг. Билетыг хүртэл цахимаар захиалан ирүүлдэг байна. Эцсийн зогсоол хүртэл тухай хүнээс ямар нэгэн төлбөр мөнгө гаргадаггүй.

Хохирогчдын профайлаас үзвэл энэ төрлийн гэмт хэрэгт **дотооддоо өртөж буй охид, эмэгтэйчүүд насны хувьд 14-22 настай байхад гадаадад энэ төрлийн гэмт хэрэгт өртөж байгаа эмэгтэйчүүдийн насны хувьд 19-24 нас** байна. Эндээс үзэхэд Монгол Улс дотооддоо насанд хүрээгүй хүүхдүүд хохирогч болох хандлага илүү давамгайл байна. Ганцаарчилсан ярилцлага болон хавтаст хэргийн судалгаанаас үзэхэд ХХГХ-ийн хохирогч болсон охид, эмэгтэйчүүдийг сонгохдоо ганц бие, хараа хяналт муутай, гэр бүлийн таагүй харилцаатай байдал, хүчирхийлэл дарамтад байдаг, санхүүгийн боломжгүй байдал (сургалтын төлбөрөө төлөх, гэр бүлийн хэн нэгний эмчилгээний зардал) зэрэг эмзэг байдлыг далимдуулан хохирогч болгодог байна.

Хүйсийн хувьд мэдээлэлтэй нь танилцсан бүх хэргийн хохирогчид эмэгтэй байсан боловч судалгаанд хамрагдсан ТББ-ын өгсөн мэдээллээр 2020 онд **насанд хүрээгүй эрэгтэй хүүхэд** бэлгийн мөлжлөгийн хохирогч болсон нэг тохиолдол бүртгэгдсэн байна¹¹¹ (**Шигтгээ 13**).

Шигтгээ 13. Бэлгийн мөлжлөгийн хэрэгт эрэгтэй хүүхэд өртсөн талаар

17 настай хүү бэлгийн болон хөдөлмөр мөлжлөгийн хохирогч болсон байсан. Уг хүүхэд нь ээж, эгчийн хамт амьдардаг байсан боловч ээж нь архины хамааралтай байгаад багад нь нас барсан. Эгч нь байдаг хэдий ч биеэ үнэлэх зам уруу орчихсон. 1-р ангид байхад нь ээж нь нас барж "Хүүхэд хамгаалах төв"-д очсон. Уг төвд байх хугацаандаа бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон байсан (Одоо уг төв нь татан буугдсан). Эцэстээ уг хүүхэд нь бэлгийн мөлжлөгийн хохирогч болсон байсан боловч өөрийгөө хохирогч болсноо мэдэхгүй байсан.

Манай байгууллагын зүгээс хүүд нийгэм сэтгэл зүйн нөхөн сэргээх туслалцаа үзүүлсэн. Бага насандаа бэлгийн хүчирхийллийн хохирогч болсон хүүхдүүд нь бэлгийн мөлжлөг болон өөр бусад олон гэмт хэргийн хохирогч болох байдал нийтлэг ажиглагддаг.

Энэ бол маш олон бэлгийн хүчирхийллийн, мөлжлөгийн хохирогч болсон эрэгтэй хүүхдүүдийн нэг жишээ. Ийм хэрэг нуугдмал байдлаар, маш их үйлдэгдэж байгааг манайхаар үйлчлүүлсэн хүүхдүүдийн ярианаас мэдэж авч байна.

Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

¹¹¹ Үйлчилгээ үзүүлэгч байгууллагын төлөөлөлтэй хийсэн ярилцлагаар нэг насанд хүрээгүй эрэгтэй хүүхэд ХХГХ-ийн хохирогчоор бүртгэгдэж, хамгаалах байранд байрлан үйлчилгээ авч байсан талаар мэдэгдсэн.

Энэ нь уг гэмт хэрэгт зөвхөн эмэгтэйчүүд өртдөг гэх нийтлэг ойлголтыг үгүйсгэх ба DoMV загварын эмзэг байдалд нөлөөлж буй хүчин зүйлийн шинжилгээгээр ХХГХ-т өртөх эрсдэлд хүйсийн ялгаа нөлөөгүй гарсан нь дээрх үр дүнг нотолж байв. Иймд бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэгт нийтлэг эмэгтэйчүүд өртөж байгаа хэдий ч эрэгтэй, ялангуяа насанд хүрээгүй хүүхдүүд өртөх эрсдэл байгааг анхан шатны түвшний илрүүлэлтэд анхаарах нь зүйтэй байна. Мөн ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг энэ бүлэг рүү чиглүүлэх, зохион байгуулах хэрэгцээ байгааг харуулж байна.

Хохирогчдын бэлгийн мөлжлөгт өртсөн хугацааг харгалзвал 1-13 сар хүртэлх хугацаанд, дунджаар 9 сар орчим хугацаанд мөлжлөгт өртсөн байна. ЭЦА-аас ирүүлсэн мэдээллээр бэлгийн мөлжлөгийн зорилгоор худалдагдсан эмэгтэйчүүдийг өдөрт дунджаар 40 хүртэл хүнд “үйлчлүүлдэг” бөгөөд энэ нь олон хохирогчид маш хүнд хэлбэрийн мөлжлөгт өртөж байгааг харуулж байна.

2019-2020 онд ЭЦА-д бүртгэгдэн шалгагдсан хэргүүд дэх гэмт этгээд, холбогдогчдийн мэдээллийг авч үзэхэд урьд нь **1-5 удаагийн ял шийтгэл эдэлж байсан, өршөөлийн тухай хуулиар суллагдсан гэмт этгээдүүд** дийлэнх нь байсан бөгөөд олзолж авсан охид, эмэгтэйчүүдийг хээр зэлүүд газар аваачин зодох, хүчиндэх зэргээр хүчирхийлэлд өртүүлэн айлган сүрдүүлж, дарамтлан өөрсдийн эрхшээлдээ оруулдаг байсан нь тогтоогдсон байна (**Шигтгээ 14.**)

Шигтгээ 14. ХХГХ үйлдсэн бүлэг этгээдүүдийн талаар

Цагдаагийн байгууллагаас 2019-2020 оны хооронд цахим орчныг ашиглан охид, эмэгтэйчүүдийг олзлон авч, эрхшээлдээ оруулан зорчих эрхийг нь хязгаарлаж бусдад хүчээр биеийг нь үнэлүүлж ашиг олдог найман бүлгийн 18 этгээд, мөн гадаад улсад өндөр цалинтай ажилд зуучлах нэрээр хуурч мэхлэн хил давуулан худалдаалсан нэг бүлгийн дөрвөн этгээдийн үйлдсэн гэмт хэргүүдийг илрүүлэн холбогдох мөрдөн шалгах ажиллагааг явуулж 2020 онд шүүхээр шийдвэрлэсэн. Нэг бүлэг нь охидыг биеийг үнэлүүлж шөнийн дотор 500,000-2,000,000 төгрөгийн орлого олж байсныг олж тогтоосон.

ХХГХ-ийн өнөөгийн нөхцөл байдал, ЭЦА-ны танилцуулгаас, 2020

2. Албадан хөдөлмөрлүүлэх/Хөдөлмөр мөлжлөг: Эрүүгийн хуулийн 13.1-р зүйл ангиар Цагдаагийн байгууллагад 2018-2020 оны хооронд 131 хохирогч бүртгэгдсэн хэдий ч эдгээр дунд хөдөлмөр мөлжлөгийн хохирогч бүртгэгдээгүй байна. Монгол Улсын Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга)-д албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийг тусад нь гэмт хэрэг болгон зүйлчилсэн ба хуулийн 13.13 дугаар зүйлд **“Бусдад хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, илт хохиролтой болзол, нөхцөл тулгаж, эсхүл хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулан эрхшээлдээ оруулж цалин хөлсгүй хөдөлмөр эрхлүүлсэн”** үйлдлийг албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан.

Уг зүйл ангиар Цагдаагийн байгууллагад **2018 онд нэг, 2019 онд хоёр, 2020 онд нэг хэрэг бүртгэгдсэн** ч шүүхээр шийдвэрлэгдсэн хэрэг өнөөдрийг хүртэл байхгүй байна. Гэвч ХТЭТ ТББ-ын мэдээгээр тус байгууллагаас 2003-2018 оны хооронд туслалцаа авсан нийт хохирогчдын **22 хувь нь хөдөлмөр мөлжлөгийн хохирогч** байгаагаас үзвэл Монгол Улсад хөдөлмөр мөлжлөгийн хэргийн илрүүлэлт хангалтгүй явагдаж байна. Тус үр дүнг цаашдаа илүү нарийвчлан судлах шаардлагатай.

2015 онд шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд анх удаа албадан хөдөлмөрлүүлэх /хөдөлмөр мөлжлөгийн гэмт хэргийг хуульчилсан нь уг гэмт хэрэгтэй тэмцэх чухал алхам болсон хэдий ч хуулийн зохицуулалт нь тодорхой бус, сайжруулах шаардлага байгааг мэргэжлийн байгууллагууд дүгнэсэн байна. Тухайлбал, албадан хөдөлмөрлүүлэх хэргийн илрүүлэлт хангалтгүй байгаад уг гэмт хэргийн бүрэлдэхүүнд зөвхөн **цалин хөлсгүйгээр** хөдөлмөрлүүлсэн л бол албадан хөдөлмөрлүүлэх гэж тооцохоор, харин цалин хөлс олгосон бол албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэрэг гэж үзэхгүй байхаар хуульд тусгасан нь нөлөөтэй байх талтайг Монголын Хуульчдын Холбооноос хийсэн судалгааны тайлан¹¹²-д дурджээ. Түүнээс гадна **албадан хөдөлмөрлүүлэх, хөдөлмөрийн мөлжлөгийн**

¹¹² ОУХБ-ын Албадан Хөдөлмөрийн тухай 1930 оны 29 дүгээр Конвенцын 2014 оны протоколд нэгдэн орох боломжийг тодорхойлох зорилгоор Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, тэдгээрийн хэрэгжилтийн байдалд хийсэн үнэлгээ, Монголын Хуульчдын холбоо, Хөдөлмөрийн эрх зүйн дэд хороо, 2019 он, Улаанбаатар хот

талаарх хууль, хяналт, мэргэжлийн хяналтын байгууллага, олон нийтийн ойлголт, мэдлэг тааруу байгаа нь хохирогчийг илрүүлэх ажиллагаа сул явагдахад нөлөөлж буй нэг хүчин зүйл болж байна¹¹³.

Хууль эрх зүйн тодорхойгүй байдлаас гадна DoMV загварын бүтцийн түвшинд нөлөөлж буй хүчин зүйлсийн хэсэгт дурдсанчлан хууль сахиулах байгууллагууд болох хөдөлмөрийн байцаагч, гадаадын иргэн харьяатын албаны албан хаагчдын уг гэмт хэргийг хянан шалгах боломж хязгаарлагдмал байгаа нь энэ төрлийн гэмт хэрэг илрэхгүй байх нэг нөхцөл болж байна. Иймд хөдөлмөр мөлжлөгийн хэргийн илрүүлэлтийг нэмэгдүүлэхийн тулд дээр дурдсан асуудлуудыг хамарсан цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Баримт бичгийн судалгаа болон ЭЦА, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудаас авсан мэдээллүүдэд үндэслэн¹¹⁴ хөдөлмөр мөлжлөгийн хохирогч болсон иргэдийн ерөнхий профайл мэдээллийг дор нэгтгэн харууллаа.

Зураг 29. Хөдөлмөр мөлжлөгийн хохирогчдын ерөнхий профайл

	ДОТООД	ГАДААД
Хохирогчийн ерөнхий мэдээлэл	<ul style="list-style-type: none"> Хүйс: Эрэгтэй, эмэгтэй Дундаж нас: 14-40 нас Боловсрол: Бага болон бүрэн дунд Мөлжлөгийн үргэлжилсэн хугацаа: 6 сараас 2 жил хүртэл 	<ul style="list-style-type: none"> Хүйс: Эрэгтэй, эмэгтэй Дундаж нас: 18-40 нас Боловсрол: Бага болон бүрэн дунд Мөлжлөгийн үргэлжилсэн хугацаа: 6 сараас 2 жил хүртэл
Хөдөлмөр мөлжлөгт өртүүлсэн байршил	<ul style="list-style-type: none"> Монгол Улс, Улаанбаатар хот 	<ul style="list-style-type: none"> БНХАУ, Манжуур хот Бүгд Найрамдах Турк Улс, Анкара хот Бүгд Найрамдах Солонгос Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улс, Сингапур Улс, Тайкашима гудамж Египет Улс, Александра хот Казахстан, Норвеги, Швед, Сингапур
Хохирогчийг элсүүлсэн арга	<ul style="list-style-type: none"> Эмзэг байдлыг далимдуулах, Заналхийлэх, Хүч хэрэглэх 	<ul style="list-style-type: none"> Залилах хуурах Эмзэг байдлыг далимдуулах Өрийн барьцаа Заналхийлэх Хүч хэрэглэх
Эрхлүүлж буй хөдөлмөр	<ul style="list-style-type: none"> Массажист 	<ul style="list-style-type: none"> Мал маллах Гуйлга гуйлгах Гэрийн үйлчлэгчээр ажиллуулах Оёдлын үйлдвэрт ажиллуулах Циркийн болон урлагийн тоглолт хийлгэх

Хохирогч иргэдийн ерөнхий мэдээллийг үзвэл уг гэмт хэрэгт эрэгтэй, эмэгтэй аль аль хүйсийн хүмүүс өртсөн байна. Хохирогчдын ажиллаж буй нийтлэг салбарын хувьд Монгол Улсын иргэд гадаад улс оронд хөдөө аж ахуй, үйлдвэр, урлагийн салбаруудад хөдөлмөр мөлжлөгт өртөх эрсдэл өндөр байна. Үүнээс гадна Монгол Улсад барилга, үйлдвэрлэл, газар тариалан, ой мод, загас, ан агнуур, бөөний болон жижиглэнгийн худалдаа, автомашины засвар, уул уурхайн салбарт гэрээгээр ажиллаж буй гадаад улсын иргэд ХХГХ-т өртөх эрсдэл өндөр байна¹¹⁵. Тухайлбал, өнгөрсөн 2020 онд хөдөлмөр

¹¹³ Өмнөхтэй ижил.

¹¹⁴ Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан 2020, ЦЕГ-ын ЭЦА-аас авсан мэдээлэлд үндэслэв.

¹¹⁵ 2020 ОНЫ ХҮН НАЙМААЛАХ АСУУДЛЫН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТУХАЙ ТАЙЛАН | Монгол Улс дахь Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яам (usembassy.gov)



зуучлалын байгууллагаар зуучлуулан Монгол Улсад хөдөлмөр эрхлэхээр ирсэн гурван Мьянмар эмэгтэй хөдөлмөр мөлжлөгийн хохирогч болсон тохиолдол бүртгэгджээ (**Шигтгээ 15**).

ХХГХ-т өртсөн эрэгтэй хохирогчдын тоо улам нэмэгдэж буй нь зөвхөн эмэгтэйчүүд ХХГХ-т өртдөг гэх ойлголтыг няцааж байна. ХТЭТ-өөр 2003-2018 оны хооронд үйлчлүүлсэн нийт хохирогчдын 13 хувь нь эрэгтэйчүүд байсан. Уг судалгааны үр дүнгээр мөн хүйсийн ялгаатай байдал нь ХХГХ-т өртөх эмзэг байдалд нөлөөгүйг харуулсан дээрх олон эх сурвалжийн үр дүнгүүд нь нэг ижил дүгнэлтэд хүргэж байна. Хэдийгээр ХХГХ-ийн хохирогчид нь нийтлэг охид эмэгтэйчүүд байгаа хэвээр боловч эрэгтэйчүүдийн энэ төрлийн гэмт хэрэгт өртөх эрсдэл өндөр байгаа нь эрэгтэй хохирогчдыг илрүүлэх, эрэгтэйчүүд рүү урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг чиглүүлэх шаардлагатай байна.

Шигтгээ 15. Гадаад улсын иргэд Монголд ХХГХ-ийн хохирогч болж буй талаар

Гурван Мьянмар улсын иргэн Монгол Улсад 2020 оны 01-р сард хөдөлмөр эрхлэх зорилготой ирсэн. Монголд ажилд зуучилсан нэгэн компанийн захиалгаар тус компанийн 200 сайхны газарт массажистаар ажиллаж байсан. Анх сарын цалин нь 800 ам доллар гэж тохиролцсон хэдий ч Монгол Улсад ирээд 600 ам доллар болсон. Ажлын цаг нь 8 цаг байна гэсэн хэдий ч өглөөний 11 цагаас оройн 24 цаг хүртэл ажилладаг ба амралтын өдөр гэж байгаагүй. Харин цар тахал гарсан үеэс үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааг хаасан хэдий ч зарим тохиолдолд ажилладаг байсан. Зуучилсан газрын эздийн гэрийг цэвэрлэх гээд гэрээгээр хүлээгээгүй үүргийн давхар хийж гүйцэтгэсэн. Хамгийн сүүлд эрх чөлөөнд нь халдаж гар хүрсэн байсан.

ЦЕГ-ийн ЭЦА-аас авсан мэдээллээс

3. Зуучлалын гэрлэлтээр дамжуулан ХХГХ-т өртөх нь: Монгол Улсад иргэдийг гэр бүл болоход зуучлах асуудлыг зохицуулсан хуулийн заалт одоогоор байхгүй. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд ч гэр бүл зуучлалын үйлчилгээ явуулах эрхийг ямар нэгэн байгууллагад олгохоор заагаагүй буюу **хуулиар энэ төрлийн үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрөөгүй**.

Гэвч 2003-2020 оны хооронд өндөр хөгжилтэй улс орнуудад, ялангуяа БНСУ уруу Монгол охид, эмэгтэйчүүдийг тодорхой төлбөртэйгөөр гэрлүүлэх, гэр бүл зуучлалын үйл ажиллагааг хувь хүн, компани зохион байгуулдаг байсан талаар мэдээлэл байна.¹¹⁶ Тодруулбал, 2005-2012 оны хооронд ХТЭТ-д **(45 хүн), Хүний эрх, хөгжил төвд (2 хүн) гадаад хүнтэй гэр бүл болохоор зуучлуулаад ХХГХ-ийн хохирогч болсон иргэд хандаж, туслалцаа авч** байжээ.¹¹⁷ Тэдний олонх нь харийн нутагт очиж, хүчирхийлэл дарамтад өртөж, байнгын боолчлолын нөхцөлд ажил хөдөлмөр эрхлэх, зарцлагдах, ажлын хязгааргүй цагаар, цалин хөлсгүй ажиллах, биеийг нь үнэлүүлэх зэрэг хүнд нөхцөлд орсон хохирогчид байсан байна. Гэвч эдгээр хэргүүдийн аль нь ч ХХГХ-ээр хуулийн байгууллагаар шийдвэрлэгдээгүй байна. Гэвч эдгээр хохирогчтой холбоотой ХХГХ-ээр эрүүгийн хэрэг үүсгэгдэн шалгагдсан талаар мэдээлэл байсангүй. Мөн цагдаагийн байгууллагад **2018-2020 онд ХХГХ-т зуучлалын захиалгат гэрлэлттэй холбоотойгоор бүртгэгдсэн хэрэг байхгүй** байна.¹¹⁸

Зуучлалаар гэрлэх, гэрлээд хууртагдсан тохиолдолд хариуцлага хүлээлгэх тухай тусгайлсан заалт Эрүүгийн хуульд байхгүй хэдий ч хэрвээ энэ төрлийн хэрэг хууль хяналтын байгууллагад бүртгэгдсэн тохиолдолд Эрүүгийн хуулийн 13.1-р зүйл заалтын агуулга нь тус гэмт хэргийн шинжийг бүрэн агуулсан байна. Тодруулбал, 13.1-р зүйлд хүч хэрэглэх, хэрэглэхээр заналхийлэх, хууран мэхлэх, итгэлийг нь эвдэх аргаар мөлжих, боолчлох болон түүнтэй адилтгах зорилгоор бусдыг элсүүлэх, тээвэрлэх, шилжүүлэх зэрэг үйлдлүүдийг хийсэн бол ХХГХ-т тооцохоор заасан. Иймд мөлжих, эсвэл худалдаалах санаа зорилгоор охид, эмэгтэйчүүдийг гэрлүүлсэн, гэрлэхэд нь зуучилсан бол Эрүүгийн хуулийн 13.1-д заасны дагуу хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндэслэлтэй байна.

4. Хүүхэд худалдаалах: Эрүүгийн хуулийн 13.1-р зүйлд ХХГХ-ийг насанд хүрсэн хүний эсрэг үйлдсэн бол 2-8 жилийн хорих ял, хүүхдийн эсрэг үйлдсэн бол 5-12 жил хүртэлх хугацаагаар хорих

¹¹⁶ Улсын бүртгэлийн ерөнхий газраас гадаад иргэдтэй гэр бүл болсон гэрлэлтийн тоон мэдээллийг авах хүсэлт гаргасан боловч мэдээлэл өгөхөөс татгалзсан тул бид жилд дунджаар хэдэн хүн гадаад иргэдтэй гэр бүл болдог талаарх мэдээллийг оруулах боломжгүй байв.

¹¹⁷ Жендэрийн үндэсний хороо болон бусад "МУ-ын жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ 2005 оноос өнөөг хүртэлх ололт амжилт ба сорилт, сургамж" судалгаа, 2019 он, хуудас 63

¹¹⁸ 2021.03.02-ны өдөр ЦЕГ-ын ЭЦА-аас авсан мэдээлэл.

ял оноохоор заасан. Өөрөөр хэлбэл, хүүхдийн эсрэг уг гэмт хэргийг үйлдсэн бол хүндрүүлсэн зүйл заалтаар шийтгэхээр хуульчилсан.

Харин Эрүүгийн хуулийн 13.1-д заасан “хүн худалдаалах” гэмт хэргээр сүүлийн гурван жилийн хугацаанд цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэрэгт **131 хохирогч тогтоогдсоны 35 хувь нь насанд хүрээгүй хүн буюу 14-18 хүртэлх насны хохирогч** байна.¹¹⁹ Эндээс үзэхэд ХХГХ-т өртсөн насанд хүрээгүй хохирогчдын асуудлыг Эрүүгийн хуулийн 13.1-р зүйл ангиар нийтлэг шийдвэрлэж байна.-

5. Хууль бусаар хүний цус, эс, эд эрхтэнийг авах: Монгол Улс 2008 онд эс, эд эрхтэний наймааны эсрэг Истанбулын тунхаглалд нэгдэн орж, 2018 онд Донорын тухай хуулийг шинэчлэн баталсан. Уг шинэчилсэн найруулгаар Эс, эд эрхтэнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дэргэд 2018 оны 1-р сард байгуулснаар өмнө нь хяналтгүй байсан цус, эс, эд эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээний асуудалд хяналт тавих эрх бүхий бүтэц бүрджээ. Уг зохицуулах зөвлөл нь одоогийн байдлаар Монгол Улсад эс, эд, эрхтэний наймаанаас урьдчилан сэргийлэх, тэмцэх гол үүргийг хүлээж буй төрийн байгууллага юм.

Тус албаны мэдээлснээр сүүлийн гурван жилийн хугацаанд Монгол Улсад эмнэлгийн нөхцөлд нийт 104 донороос эд эрхтэн шилжүүлэн суулгах 150 мэс ажилбар хийгдсэний 82 хувийг нь амьд донороос шилжүүлэн суулгасан ба одоогоор хуулийн байгууллагад хүний цус, эд, эрхтэнийг хууль бусаар авсан тохиолдол бүртгэгдээгүй.¹²⁰

Өнөөгийн байдлаар Монгол Улс дотоод болон гадаад улс орноос БНСУ, Энэтхэг улс руу эрхтэн шилжүүлэн суулгах мэс засалд орохоор зорчих гэж буй иргэдэд уг Зохицуулах албанаас донорын хамаарал үнэн зөв эсэхийг баталгаажуулсан баримт бичиг гаргуулах шаардлага тавигдаж буй нь эд эрхтэний наймаанаас урьдчилан сэргийлэх чиглэлээр тавигдаж буй гол хяналт, шаардлага болж байна (**Шигтгээ 16**).

Шигтгээ 16. Эс эд эрхтэний наймаанаас урьдчилан сэргийлэх зорилгоор Донорын тухай хуульд тусгагдсан заалтын талаар

Донорын тухай хуульд амьд донорын хувьд гэр бүлийн гишүүн нь байна гээд заасан байдаг. Уг заалтын дагуу бид БНСУ, Энэтхэг улсын элчин сайдтай уулзаад, эдгээр улс руу эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал хийлгэхээр явах гэж буй хүмүүст манай албанаас өгсөн энэ хүмүүсийн донорын хамаарал нь үнэн зөв байна гэдэг тодорхойлох бичиг шаарддаг болгосон. Үүнээс хойш гадаад явж байгаа хүмүүс бидэнд тийм бичиг авч ирж өгөөд бид түүнийг нь иргэний бүртгэл мэдээллийн төвийн мэдээлэлд үндэслэн шалгаж хардаг. Мөн бид Монгол Улсад элэг, бөөр шилжүүлэн суулгаж байгаа хүмүүст мөн адил иргэний бүртгэл мэдээллийн төвөөс донорын хамаарлын бичгийг шаарддаг болсон. Тухайлбал, Доржийн донор Дондог гэдэг хүн байлаа гэхэд энэ хоёр хүн ямар хамааралтай гэдэг албан бичгийг авч ирүүлдэг болсон.

Эс, эд эрхтэнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

Тус зохицуулах алба байгуулагдахаас өмнө эд, эрхтэнээ худалдах зар олон нийтэд нээлттэй байрших, гадаад улс орон руу эд эрхтэн шилжүүлэх мэс ажилбарт явж буй иргэдэд тавих хяналт сул байсан бол сүүлийн гурван жилийн хугацаанд энэ чиглэлээр мэдэгдэхүйц ахиц гарч буй нь холбогдох албаны өгч буй мэдээллээс харагдаж байв (**Шигтгээ 17**).

Шигтгээ 17. Эд эрхтэний наймааны нөхцөл байдлын талаар

Намайг улсын ... эмнэлэгт ажиллаж байхад 2017 онд элэг шилжүүлэн суулгах мэс засалд орох гээд сошиалаас олсон хүүхэд дагуулж ирээд, энэ нь баригдаад, донор болох гэж байгаа хүүхдийн аав ээж, ах эгч нь ирээд болиулж бөөн юм болж байсан тохиолдол бий. Тэгэхээр алба байгуулагдахаас өмнө бол энэ бүхэн нэгдсэн хяналтгүй байсан бөгөөд Зохицуулах алба байгуулагдсанаас хойш бол энэ бүхэн тодорхой хэмжээнд хяналтад орсон.

Эс, эд эрхтэнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны төлөөлөлтэй хийсэн ярилцлагаас

¹¹⁹ О.Нямдаваа, Бэлгийн мөлжлөг, Хүн худалдаалах гэмт хэргийн шийдвэрлэлтийн өнөөгийн нөхцөл байдал. 2020 он, УБ

¹²⁰ 2018-2020 оны 8 дугаар сарын 18-ны байдлаар

Иймд судалгааны үр дүнгээс үзэхэд 2017 оноос хойш эс, эд, эрхтэний наймаанаас урьдчилан сэргийлэх чиглэлээр хяналт тавих эрх бүхий бүтэц байгуулагдаж, эрх зүйн орчин тодорхой хэмжээнд бүрдэж, эд эрхтэн шилжүүлэн суулгах эмчилгээ дотоодод хөгжиж буйтай холбоотойгоор энэ төрлийн гэмт хэргээс сэргийлэх орчин бүрдэж байна. Цаашид энэ чиглэлээр, бусад улс орны Элчин сайдын яамд, ГХУСАЗЗ болон Эс, эд эрхтэнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах алба харилцан тогтмол мэдээллээ солилцох, төлөвлөлтөө уялдуулах замаар хамтын ажиллагаагаа нэмэгдүүлэх нь зүйтэй.

Хэсэг 2. ХХГХ-ийн эмзэг байршил, урсгал чиглэл

Монгол Улсад ХХГХ үйлдэгдэх гадаад, дотоод урсгал чиглэл хэдийнээ бий болсон. Түүнчлэн ХХГХ-ийн хүлээн авагч, илгээгч улс орон болсон талаар АНУ-ын төрийн департаментын Хүн худалдаалах гэмт хэргийн төлөв байдлын тухай тайланд дурдсан байна. Тус судалгааны хүрээнд ЦЕГ-ийн ЭЦА, Гадаад харилцааны яам (ГХЯ), ТББ-уудаас авсан хохирогчдын мэдээлэл болон бусад ижил төстэй судалгааны материалуудад дурдагдсан мэдээллийг нэгтгэвэл Монгол Улсад дараах улс орнуудаас ХХГХ-ийн хохирогч орж ирэх болон илгээгдэж байна.

Хүснэгт 9. ХХГХ-ийн илгээгч болон хүлээн авагч улс орнууд

Хүлээн авагч	Илгээгч
<ul style="list-style-type: none"> • Хойд Солонгос (Оёдлын үйлдвэр, барилгын салбарт) • БНХАУ (Барилгын болон замын ажил) • Филиппин улс (гэрийн үйлчлэгч) • Вьетнам улс (машин засвар) • Мьянмар улс (Массажист) 	<ul style="list-style-type: none"> • Ази (Камбож, БНХАУ, Мьянмар, Хонконг, Япон, Макао, Малайз, БНСУ, БНКиру, Филиппин, Сингапур, Казакстан) • Европ (Бельги, Герман, Турк, Швед, Израил, Швейцар, Унгар, Чех) • АНУ

2.1 ХХГХ-ийн дотоод урсгал

UNODC 2020 оны ХХГХ-ийн дэлхийн тайланд дурдсанаар, ХХГХ-ийн хохирогчдын ихэнх нь эх орондоо эсвэл ойролцоо бүс нутгийн улс орнууддаа ХХГХ-т өртдөг байна. Сүүлийн жилүүдэд улс дотооддоо ХХГХ-т өртсөн хохирогчдын эзлэх хувь нэмэгдэж байна¹²¹. Тухайлбал, Ази, Номхон далайн орнуудын эх орондоо худалдаалагдсан хохирогчдын эзлэх хувь 2014 онд 22 хувь байсан бол 2016 онд 39 хувь, 2018 онд 47 хувь болж өссөн байна.

Монгол Улсын хувьд 2018-2020 оны хооронд бүртгэгдсэн ХХГХ-ийн хохирогчдын 71 хувийг дотоодод үйлдэгдсэн хэргийн хохирогчид эзэлж байна. Тэдний дийлэнх нь **Улаанбаатар хотод (66 хувь)**¹²² бүртгэгдсэн ба хот дотроо нэг дүүргээс нөгөө дүүрэгт тээвэрлэн биеийг нь үнэлүүлэх, эсвэл нэг байршилд хоригдож бэлгийн мөлжлөгт өртөж байжээ (**Шигтгээ 18.**).

Шигтгээ 18. Дотооддоо бэлгийн мөлжлөгийн хохирогч болсон эмэгтэйн кейс

РС тоглоомын газарт ажилд орсон, эхэндээ бүх зүйл хэвийн байсан. Нэг өдөр гэр лүү маань харуулахгүй, гадагшаа гарч болохгүй гээд сүрдүүлж харанхуй сүлжээ барихгүй өрөөнд хорьсон. Энэ хугацаанд биеийг хүчээр үнэлүүлдэг байсан. Цагийн 100,000 төгрөг авдаг. Надад мөнгө өгдөггүй. Харин хоол сайн өгдөг байсан. Ажлын цагт баригдахгүй. Өдөр, шөнө хамаагүй ажиллуулна. Тэд нар хар тамхи хэрэглэдэг. Намайг архи их уулгадаг байсан. Болимоор байна гэхээр айлгаж, сүрдүүлдэг байсан.

Нэг хүн танай доод өрөөнөөс хүн уйлаад байна гээд цагдаад дуудлага өгсөн байсан. Дуудлага өгсөн даруйд намайг өөр газар луу шилжүүлсэн. Тэд утас болон цахим хуурамч хаяг ашиглан охидыг олдог.

Хохирогчтой хийсэн ярилцлагын тэмдэглэлээс

ХХГХ-ийн дотоод урсгал чиглэл нь дотоодын шилжилт хөдөлгөөний урсгалтай уялдаатай байдаг¹²³.

¹²¹ GLOTiP_2020_15jan_web.pdf (unodc.org)

¹²² 2018-2020 оны хооронд ЦЕГ-т бүртгэгдсэн 131 хохирогчийн 66 хувь (n=87) нь Улаанбаатар хотод, 6 хэрэг Өмнөговь аймагт, 38 нь хилийн чанадад бүртгэгдсэн байна.

¹²³ *GLOTiP_2020_15jan_web.pdf (unodc.org)

Монгол Улсын хувьд шилжилт хөдөлгөөний гол түлхэгч болон татагч хүчин зүйл нь иргэдийн эдийн засгийн чадавх, амьжиргааны түвшингээ дээшлүүлэх хүсэл сонирхолтой холбоотой байдаг¹²⁴. Сүүлийн 20 жилийн хугацаанд Монгол Улсад орон нутгаас хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөний урсгал тогтмолжиж, уул уурхайн бүтээн байгуулалтыг дагасан, хил орчмын бүс нутгууд дахь шилжин суурьших хөдөлгөөн нэмэгдсэн.

Монгол Улсын өмнөд хэсэгт өрнөж буй уул уурхайн салбарын хөгжил дотоодын болон олон улсын шилжилт хөдөлгөөнийг эрчимжүүлсэн нь ялангуяа Монгол-Хятадын хилийн эргэн тойронд хүний ХХГХ-ийн эрсдэлийг нэмэгдүүлж, үүнд ялангуяа Өмнөговь, Дорноговь, Дорнод зэрэг хил орчмын бүс нутаг нь эрсдэл өндөр байршилд тооцогдож байна. Тодруулбал, хотоос аймгийн төв, зарим тохиолдолд хилийн ойролцоох сумд уруу зорчиж эмэгтэйчүүд биеэ үнэлдэг талаарх мэдээллүүд чанарын ярилцлагын явцад илэрсэн. Энэ мэт тээврийн жолооч, уурхайн ажилчдыг дагасан явуулын биеэ үнэлэлт нэмэгдэх нь хилийн орчимд ХХГХ-ийн эрсдэлийг нэмэгдүүлж байна. Эдгээр баримт нь зуучлагч этгээд болон зохион байгуулалттай бүлэг этгээдүүд хохирогч нарыг хотоос хөдөө рүү тээвэрлэн бэлгийн мөлжлөгт өртүүлдэг байх эрсдэл бийг харуулж байв.

ЦЕГ-т бүртгэгдсэн мэдээллээр 2018-2020 оны хооронд бүртгэгдсэн ХХГХ-ийн 5 хувь (6 хэрэг) нь Өмнөговь аймагт бүртгэгдсэн. Азийн сан, Хүн ам зүйн сургалт, судалгааны төвтэй хамтарсан “Монголын уурхайн газар дах биеэ үнэлэлт ба хүний наймаа” судалгааны үр дүнгээс үзэхэд Өмнөговь аймагт биеэ үнэлэгч эмэгтэйчүүдтэй хийсэн ярилцлагаар хэд хэдэн эмэгтэй худалдаалагдах эрсдэлтэй буюу заримдаа тэдний нөхцөл байдал хэдийнээ худалдаалагдсан мэт байсан талаар дурдсан байна.¹²⁵ Тухайлбал: Ярилцлага хийсэн 16 биеэ үнэлэгчийн дөрөв нь зуучлагчтай байсан ба хувийн эрх чөлөөг хязгаарлах талтай, цалинг нь саатуулж байжээ. Хоёр нь иргэний үнэмлэхгүй, нэгийг нь зуучлагч нь зодож байсан байна.¹²⁶ Эдгээр үр дүн нь уул уурхайн бүсэд эрсдэл өндөр байгааг харуулж байна.

Түүнчлэн БНХАУ-ын хилээр нүүрс тээвэрлэж буй тээврийн хэрэгслийн жолооч нар хөдөлмөрийн мөлжлөгт өртөх эрсдэл өндөр байна. Ачааны машины жолооч нар хөдөлмөрийн бүтээмжээ нэмэгдүүлж, нэг сарын хугацаанд тээвэрлэх давтамжаа нэмэгдүүлэхийн тулд сэтгэцэд нөлөөлөх бодис¹²⁷ хэрэглэдэг талаарх мэдээллүүд бүртгэгдсэн. Эдгээр жолооч нар Хятадад тээвэрлэлт хийх зөвшөөрөл авах хүртлээ хэдэн долоо хоног, хэдэн сараар нойргүй ачааны машинтайгаа оочирт зогсоход хүрдэг. Хүргэлт хоцроход цалин хөлсийг нь бууруулдаг, цалингийн суутгал ногдуулах зэрэг нь тээврийн жолооч нарыг хөдөлмөрийн мөлжлөгт өртөх эмзэг байдлыг нэмэгдүүлдэг байна¹²⁸. Иймд хилийн боомтоор нэвтэрч буй монгол тээврийн жолооч нарын хөдөлмөрийн нөхцөлд тогтмол хяналт тавих нь нэн чухал байна.

Монгол Улсад үйлдэгдэж буй ХХГХ-ийн урсгал чиглэлд ажиглагдаж буй өөр нийтлэг хэв маяг нь ихэнх хохирогчид нь Улаанбаатар хотод албан ёсоор бүртгэлгүй, эдийн засгийн хөгжил буурай, ядуурал, ажилгүйдэл өндөр аймаг, орон нутгаас шилжин ирсэн байна. Тухайлбал, шүүхээр шийдвэрлэгдсэн долоон хавтаст хэргийн материалын 14 хохирогчийн мэдээллийг авч үзэхэд, тэд Өвөрхангай, Дорнод, Хөвсгөл, Архангай зэрэг орон нутгаас хот уруу шилжин ирсэн албан ёсны бүртгэлгүй иргэд байна. Дотооддоо үйлдэгдсэн ХХГХ-ийн нийтлэг шинжийг харгалзвал¹²⁹ ихэнх нь Улаанбаатар хот болон хилийн ойролцоох эсвэл уул уурхай, аялал жуулчлал хөгжсөн хүн амын хөдөлгөөний урсгал ихтэй аймаг орон нутгуудаас элсүүлэлт хийгдсэн байна (**Зураг 30**). Эдгээр хохирогчдын дийлэнх нь

¹²⁴ mongolia_internal_migration_study_mon.pdf (iom.int)

¹²⁵ Азийн сан, Хүн ам зүйн сургалт судалгааны төв “Монголын уурхайн газар дах биеэ үнэлэлт ба хүний наймаа” судалгаа, 2008 он

¹²⁶ Азийн сан, Хүн ам зүйн сургалт судалгааны төв “Монголын уурхайн газар дах биеэ үнэлэлт ба хүний наймаа” судалгаа, 2008 он, хуудас 4-5


¹²⁷ Мими гэх нэршилтэй нунтаг цагаан өнгөтэй /шахах шоо хатуу хэлбэрт оруулсан байдаг/ бодис нь БНХАУ-ын зүүн өмнөд хэсгээс гаралтай. 1950-1960 онд ӨМӨЗО-ны Баяннуур аймагт илэрч нутгийн ард ихээр хэрэглэх болсон. Тухайн бодис нь нутгийн хүмүүсийн ам яриагаар бол нойр хүргэхгүй сэргээшнээр төрлийн бодис гэж ярьдаг.

¹²⁸ 2020 оны АНУ-ын төрийн департаментийн Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тайлан

¹²⁹ Хавтаст хэргийн дүн шинжилгээ болон ЭЦА, ТББ-аас авсан мэдээллийн дагуу

Улаанбаатар хотод худалдагдсан байгаагаас үзэхэд элсүүлэлт хийгдсэн болон мөлжлөг явагдаж буй байршлууд нь тийм хол зайтай биш байна.

Зураг 30. Дотоодод бүртгэгдсэн ХХГХ-ийн хохирогчдын харьяа орон нутаг, байршлууд



Эдийн засгийн хямрал, ажилгүйдэл, COVID-19-тэй холбоотой нөхцөл байдлууд зэрэг бүтцийн түвшний хүчин зүйлс эрчимжиж байгаатай холбоотойгоор ХХГХ-ийн тоо жил ирэх тусам нэмэгдэх төлөвтэй байна.


Иймд эрсдэл ихтэй бүс нутгууд болох Улаанбаатар хот, Өмнөговь, Дорноговь, Дорнод аймгуудад ХХГХ-ийг илрүүлэх чадавхыг сайжруулахад анхаарахын зэрэгцээ хөдөө орон нутгийн нийгэм, эдийн засгийн нөхцөл байдлыг сайжруулахад анхаарч, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх нь нэн чухал юм. Ялангуяа Монгол Улсын төвлөрлийг сааруулах хөгжлийн бодлоготой уялдуулан эдийн засгийн идэвхтэй бүс нутаг болон хил орчмын бүс нутгуудад хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх чадавхыг бэхжүүлэх нь чухал юм.

2.2. ХХГХ-ийн гадаад урсгал

Монгол Улсаас гадагш чиглэлтэй үйлдэгдэж буй ХХГХ-ийн урсгал чиглэлийн хүрээг авч үзэхэд зөвхөн газар зүйн хувьд ойр байршлын орон гэлтгүй дэлхийн маш олон оронд Монгол Улсын иргэд худалдаалагдсан, ХХГХ-ийн хохирогч болсон тохиолдлууд бүртгэгдсэн байна. Эдгээрээс хуулийн байгууллагад болон үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хандсан хохирогчдын мэдээллийг харвал бэлгийн мөлжлөгийн хэлбэрээр Малайз, Макао, БНХАУ, Мьянмар, Хонконг, Япон, Камбож, БНСУ, Киргизстан, Филиппин, Сингапур улс руу, хөдөлмөр мөлжлөгийн хэлбэрээр Хятад, Казакстан, Өмнөд Солонгос, Япон, Турк улс руу худалдагдах урсгал илүү давамгайлж байна.

Худалдагдсан улсуудын хохирогчдын тоо хэмжээгээр улс орнуудыг авч үзвэл **Зүүн болон Зүүн Өмнөд Азийн орнууд уруу чиглэсэн урсгал давамгайлж байна (Зураг 31)**. Тодруулбал, сүүлийн 3 жилд бүртгэгдсэн хохирогчдын дийлэнх нь БНХАУ, Малайз, Макао, Камбож, Турк, Мьянмар улсуудаас бүртгэгдсэн байна (**Хүснэгт 10**).

Зураг 31. Монгол Улсын иргэд ХХГХ-т өртсөн улс орнууд, ХХГХ-ийн төрлөөр



Эх сурвалж: ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн алба, ГХЯ, Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан, 2020 болон бусад судалгааны тайлангуудын үр дүнг нэгтгэв.

Энэ чиглэлийн урсгал бүрдэх шалтгааны нэг нь эдгээр орнуудад сексийн үйлчилгээ үзүүлдэг бизнесийн дэд бүтэц хэт хөгжсөнтэй холбоотой байж болно.¹³⁰

Хүснэгт 10. Монгол Улсын иргэд худалдаалагдсан улс орнууд¹³¹

ХХГХ-ийн төрөл	Ази тив	Европ тив	Америк
Бэлгийн мөлжлөгийн зорилгоор худалдах	Камбож, БНХАУ, Мьянмар, Хонконг, Япон, Макао, Малайз, БНСУ, БНКиру, Филиппин, Сингапур	Бельги, Герман Турк, Швед, Израил, Швейцар, Унгар	АНУ
Хөдөлмөр мөлжлөгийн зорилгоор худалдах	БНХАУ, Казакстан, Өмнөд Солонгос, Япон	Швед, Норвеги, Турк, Чех	
Зуучлалын захиалгат гэрлэлтээр дамжуулж худалдах	БНСУ, Япон, БНХАУ,	ОХУ, ХБНГУ, Их Британи	АНУ

Хүснэгт 11. 2018-2020/09 хооронд эгүүлэн татсан ХХГХ-ийн хохирогчдын тоо

Он	Эрүүгийн цагдаагийн албаны мэдээлэл (2020/08/26-ны байдлаар) ¹³²	ГХЯ-ны Консулын газраас ирүүлсэн мэдээлэл (2020/09/01-ны байдлаар) ¹³³
2018	БНХАУ (14 хохирогч), Малайз (2 хохирогч) Мьянмар (3 хохирогч), Камбож (4 хохирогч)	-
2019	Бүгд Найрамдах Турк Улс (1 хохирогч)	Камбож улс (4 хохирогч) Бүгд найрамдах Киргизстан Улс (1 хохирогч) Филиппин (1 хохирогч)
2020	Малайз Улс (14 хохирогч) ¹³⁴	-

¹³⁰ ЭЦА-ны төлөөлөөс авсан мэдээллээр


¹³¹ Эрүүгийн хавтаст хэрэгт хийсэн дүн шинжилгээ болон мэргэжлийн байгууллагууд, хохирогчид болон ХХГХ-тэй холбоотой тайлан мэдээлэлд үндэслэн Хүснэгт 10-д тусгагдсан мэдээллийг гаргав.

¹³² ЦЕГ-ын ЭЦА-аас албан тоотын дагуу авсан мэдээлэл. 2020 оны 8-р сарын 26-ны байдлаар

¹³³ ГХЯ-ны Консулын газрын захирал Л.Мөнхтүшигийн 2020 оны 3893 тоот албан бичиг

¹³⁴ 2020 онд ЦЕГ-аас Малайз улсад хохирсон 14 иргэнийг ГХЯ-ны Консулын газартай хамтран эх оронд нь авчирсан. ЭЦА-аас 2021/06/15-ны байдлаар авсан мэдээллээр.

Зураг 32. 2018-2020 онд ХХГХ-ийн хохирогч эгүүлэн татсан улс орнууд



Эх сурвалж: ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн алба, ГХЯ-аас авсан мэдээлэлд тулгуурлав

Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн “3.2.4 гадаад улсад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч байж болзошгүй Монгол Улсын иргэнд туслалцаа үзүүлэх, эгүүлэн авчрах, Монгол Улсад хохирогч болсон гадаад иргэнийг эх оронд нь буцахад туслалцаа үзүүлэх чиглэлээр олон улсын болон ТББ-тай хамтран ажиллах” заалтын дагуу гадаад улсад хохирогч болсон иргэдийг эгүүлэн авчрах ажиллагаанд ХЗДХЯ-ны ГХУСАЗАА, ГХЯ-ны Консулын газар, ЭЦА, ОУШХБ, ГИХГ болон ХТЭТ ТББ-ууд хамтран ажиллаж байна. Хамгийн сүүлд 2020 онд Монгол Улсын Засгийн газраас Малайз Улсад ХХГХ-т өртсөн 14 хохирогчийг тусгай үүргийн онгоцоор эх нутагт авчрах ажиллагааг хамтран зохион байгуулсан байна.

2.3. Монгол Улсад гадаадын иргэд ХХГХ-т өртөж буй байдал

Монгол Улс нь гадаад улс орноос ажиллах хүчин хүлээн авагч орнуудын нэг. 2020 оны хагас жилийн байдлаар Монгол Улсад 3,380 гадаад улсын иргэн хөдөлмөрийн гэрээтэй ажил эрхэлж байна. Гэвч COVID-19 цар тахлын дэгдэлттэй холбоотойгоор хил хаах, гадаадын иргэдийг нутаг буцаах үйл ажиллагаатай холбоотой гадаадын иргэдийн тоо огцом буурсан бөгөөд 2020 оны дүн нь өмнөх оноос 15 хувиар буурсан дүнтэй байна.

Монгол Улсад хөдөлмөр эрхэлж буй гадаад иргэдийг улс орноор нь харвал БНХАУ, ОХУ, БНСУ, Австрали улсын иргэд давамгайлж байна. Хөдөлмөр эрхэлж буй салбараар нь харвал уул уурхай, олборлолт, боловсрол, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарууд орж байна. Гадаадын иргэдийн ажиллаж буй салбарыг улсаар нь авч үзвэл нэг улсын иргэд тодорхой нэг салбарт олноор ажиллаж буй нийтлэг шинж ажиглагдаж байна (**Хүснэгт 12**).

Хүснэгт 12. Гадаад иргэд Монгол улсад эрхэлж буй ажил

	Улс	Монгол Улсад эрхэлж буй ажил
1	Вьетнам	Авто засвар
2	Филиппин	Хүүхэд асрагч, гэрийн үйлчлэгч
3	Мьянмар	Массажист, гэрийн үйлчлэгч
4	Тайланд	Массажист, гэрийн үйлчлэгч
5	Балба/Непал	Массажист, гэрийн үйлчлэгч
6	Өмнөд Солонгос	Зоогийн газар, гоо сайхан, үйлчилгээний салбарт

7	Хойд Солонгос	Барилга, оёдлын үйлдвэр
8	Канад,	Уул уурхай, хүнд үйлдвэр
9	Австрали	Уул уурхай, хүнд үйлдвэр
10	Америк	Уул уурхай, хүнд үйлдвэр
11	Герман	Уул уурхай, хүнд үйлдвэр
12	Хятад	Барилга, зам гүүр
13	Орос	Сургууль, цэцэрлэг зэрэг боловсролын салбарт
14	Өмнөд Африк	Спорт

Дээрх улс орны иргэд, ялангуяа бүртгэлгүй эсвэл тогтмол бус статустай хүмүүс хөдөлмөрийн мөлжлөгийн зорилгоор ХХГХ-т өртөх эмзэг байдал өндөр байна. Тухайлбал Филиппин, Вьетнам, Мьянмар Улсын иргэд гэрийн үйлчлэгч, авто засвар, саун массаж зэрэг газарт хөдөлмөр эрхлэх зорилгоор ирдэг хэдий ч ажил олгогч нь тэднийг ажиллуулах явцдаа зодож дарамтлах, айлган сүрдүүлэх, цалин хөлс өгөхгүй байх зэргээр бие махбодын болон сэтгэл санааны хүчирхийлэлд оруулсан тохиолдлууд ГИХГ-т бүртгэгдсэн.

Гадаад улсын иргэд Монгол Улсад ХХГХ-ийн хохирогч байж болзошгүй тохиолдлууд бүртгэгдэж байгаа хэдий ч энэ тохиолдолд гадаадын иргэдийн эрх ашгийг хамгаалах, тусламж үзүүлэх, эрхийг нь хамгаалахад хууль эрх зүйн орчны тодорхойгүй байдлууд байгаа нь цаашид гадны иргэдийг хохироох асуудалд бүрэн хяналт тавихад сөргөөр нөлөөлж байна (**Шигтгээ 19**). Иймд Монгол Улсад ХХГХ-ийг илрүүлэх, тэмцэх тогтолцоонд гадаадын иргэдийг илрүүлж, хамгааллын үйлчилгээ үзүүлэх асуудлыг анхааралдаа авах шаардлагатай байна.

Шигтгээ 19. Гадаад улсын иргэд бичиг баримтын зөрчлийн асуудал нь ХХГХ-т өртүүлэх эмзэг байдлыг нэмэгдүүлж буй талаар

...гадаад улсын иргэдийг авчирч ажиллуулж байгаа Монгол дахь ажил олгогчид санаатайгаар цалин урамшууллыг нь өгөхгүй байх, баримт бичгийг нь хураан авах, зөвшөөрөлгүй хөдөлмөр эрхлүүлэх зэрэг байдлаар гадаадын иргэдийг хохироодог. Ажил олгогч нь гадаад ажилтнаа хууль бус оршин суугч болгосноор гадаадын иргэдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хандан албадан гаргуулах хүсэлтийг гаргаснаар тухайн иргэний хөдөлмөрийн харилцааг дуусгавар болгодог нийтлэг зөрчил гардаг байна.

ГИХГ-ын албан хаагчтай хийсэн ганцаарчилсан ярилцлагаас


Судалгааны баг мэдээллийн боломжит эх сурвалжуудаас цуглуулсан мэдээлэлд тулгуурлан ХХГХ-ийн дотоод, гадаад урсгал чиглэлийн 2020 оны байдлаарх суурь нөхцөл байдлыг нэгтгэн харуулахыг зорьлоо. Судалгааны үр дүнг нэгтгэн үзэхэд Монгол Улсад ХХГХ-ийн давамгайлсан урсгал чиглэл нэгэнтээ ажиглагдаж байна. Дотооддоо хүн амын төвлөрөл, зах зээл, уул уурхайн эдийн засагт тулгуурласан орон нутгуудад анхаарлаа хандуулах шаардлагатай байгаа бол, гадагшаа Зүүн болон Зүүн өмнөд Азийн улс орнууд уруу худалдаалагдах урсгал давамгайл байна. Иймд эдгээр улс орнуудтай хэргийн илрүүлэлт, хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд хамтын ажиллагааг нэмэгдүүлэхэд нэн тэргүүний ээлжинд анхаарах шаардлагатай байна.

Хэсэг 3. ХХГХ-ийн чиг хандлага, өөрчлөлт

Судалгаанд хамрагдсан оролцогч талуудын санал болон олон улсын байгууллагуудын тайлан мэдээнд үндэслэвэл ХХГХ-ийн чиг хандлагад дараах өөрчлөлт ажиглагдаж байна. Үүнд:

ХХГХ-т хүүхэд өртөх нь нэмэгдэж байна. Цагдаагийн байгууллагад сүүлийн гурван жилийн хугацаанд ХХГХ-ийн 131 хохирогч хүн бүртгэгдсэний 47 нь насанд хүрээгүй хүн байна. **Зураг 33**-т харуулсанчлан жил тутамд насанд хүрээгүй хохирогчийн тоо нэмэгдэж байгаа ба, 2020 онд энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болсон хүүхдийн тоо огцом нэмэгджээ.

Зураг 33. ХХГХ-т насанд хүрээгүй хүүхэд өртсөн байдал, 2018-2020



Эх сурвалж: ЭЦА-аас авсан мэдээлэл, 2020 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар

Цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн ХХГХ-ийг хүүхдийн эсрэг үйлдсэн аргыг авч үзвэл гадаад хэлний бэлтгэлд зуучлах, сургуульд тэтгэлгээр суралцуулах, өндөр цалинтай ажилд зуучлах зэргээр зар гаргаж, хуурч мэхлэн гадаад улсад гарган биеийг үнэлүүлж, хилийн чанадад гэмт хэргийн хохирогч болгосон тохиолдлууд гарсан байна. Мөн хүүхдээр гуйлга гуйлгах, хулгай хийх болон хурдан морь унуулах, мал маллуулах, эсвэл хогийн цэг дээр хог түүлгэх, барилга зэрэг салбарт албадан байдлаар хөдөлмөр эрхлүүлэх явдал нэмэгдэж байна.

Хохирогчдын дунд хүйсийн ялгаа багасаж, эрэгтэй хохирогчдын тоо нэмэгдэх хандлагатай байна. Тус судалгааны DoMV загварын дагуу гүйцэтгэсэн иргэдийн эмзэг байдалд нөлөөлж буй хүчин зүйлийн шинжилгээгээр хүйсийн ялгаатай байдал нь ХХГХ-т өртөх эмзэг байдалд нөлөөгүй болох нь батлагдсан. Хэдийгээр цагдаагийн байгууллагад 2018-2020 оны хооронд бүртгэгдсэн ХХГХ-ийн 131 хохирогчийн дунд эрэгтэй хохирогч бүртгэгдээгүй хэдий ч 2003-2018 оны хооронд ХТЭТ-д хандаж туслалцаа авсан үйлчлүүлэгчдийн 13 хувь нь эрэгтэйчүүд байна. Хэдийгээр охид эмэгтэйчүүд энэ төрлийн гэмт хэргийн хохирогч болох нь нийтлэг хэвээр байгаа боловч эрэгтэйчүүд мөн ХХГХ-т өртөх байдал нэмэгдэж байна. Мөн Монгол эрэгтэйчүүд хилийн чанадад хөдөлмөр мөлжлөгийн хохирогч болох эрсдэл өндөр байна. Тухайлбал, 2020 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тайланд "... Хятад компаниуд Монгол хөвгүүд, эрчүүдийг хөдөө аж ахуйн чиглэлээр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс хэт доогуур цалин өгч ажиллуулж байгаа нь хөдөлмөрийн мөлжлөгт өртөх эрсдэлийг бий болгож байгаа тухай дурджээ. Түүнчлэн Монгол Улсад Хойд Солонгосын ажилчид хүнд, хэцүү нөхцөлд ажиллаж амьдардаг ба чөлөөтэй зорчих, ажлын байраа сонгох эрхгүйн дээр цалингаа бүтэн авдаггүй талаар дурдсан байна.

Интернэтэд суурилсан ХХГХ-ийн элсүүлэлт нэмэгдэж байна. Бүх нийтийн дижитал технологийн хэрэглээ өсөн нэмэгдэж буйн давуу талыг гэмт хэрэгтнүүд мөн ашиглаж байна. Ялангуяа, хувийн социал хуудаснуудад иргэдийн зураг, хувийн мэдээлэл нь нээлттэй байрладаг, өөрийн хэрэгцээ, сэтгэл санааны төлөв байдлыг илэрхийлэх боломжууд нь гэмт хэрэгтнүүд хохирогчийг олзлоход давуу талыг үүсгэдэг байна. Цахим орчинд хохирогчийг олж авах харилцаа нь агнах (hunting-тодорхой нэг хүнийг онилж итгэлийг нь олж авахыг зорих) болон загасчлах (fishing-ажлын санал болон бусад агуулгын зар тавьж хариу өгөх хүнийг хүлээх) гэсэн үндсэн хоёр хэлбэрээр үйлдэгддэг.¹³⁵

Монгол Улсад Фейсбүүк сүлжээний хэрэглээ маш өндөр бөгөөд 2020 оны 1-р сарын байдлаар Монгол Улсад фейсбүүк идэвхтэй хэрэглэгчдийн тоо 2.2 сая байгаа нь хүн амын тоотой харьцуулахад хэрэглээгээрээ дэлхийд эхний аравт багтаж байна.¹³⁶ COVID-19 цар тахлын үед бүх нийтийн хөл хорио тогтоосонтой холбоотойгоор насанд хүрэгчдийн төдийгүй хүүхдүүдийн социал медиан хэрэглээ огцом нэмэгдсэн ба тогтоосон насны хязгаараас бага 14 хүрээгүй хүүхдүүд ч социал орчинд хэд хэдэн хаяг ашиглаж байна.

Эдгээрээс гадна цахим орчинд биеэ үнэлэлтийн зохион байгуулалттай цахим хуудсууд олноор

¹³⁵ Global Report on Trafficking in Persons, Chapter 5, Traffickers use of the Internet, UNODC, 2020

¹³⁶ Digital 2020: Mongolia

нээгдсэн байна (**Шигтгээ 20**). Эдгээр цахим хуудаснуудад тавьсан заруудын дагуу санхүү авна гэх охид, эмэгтэйчүүдийг клиент (үйлчлүүлэгч) нэрээр гэмт этгээдүүд олзлон авч, гар утас, мөнгө, эд зүйлийг нь дээрэмдэх, хохирогчийг нүцгэлж дүрс бичлэг хийн тохуурхан даажигнаж олон нийтийн сүлжээнд байршуулах, ойр дотны, гэр бүлийн хүмүүст нь тухайн хийсэн дүрс бичлэгийг үзүүлж биеэ үнэлэгч гэдгийг нь илчлэх зэргээр амь нас, эрүүл мэнд, нэр хүнд, хувь хүний нууцтай холбоотой эмзэг асуудлаар нь далимдуулан өөрсдийнхөө эрхшээлд оруулж бусдад хүчээр биеийг нь үнэлүүлж хүн худалдаалах гэмт хэргийн золиос болгож байна.¹³⁷

Шигтгээ 20. Цахим хуудсуудыг ХХГХ-ийн хохирогчийг элсүүлэхэд ашиглаж буй талаар

"Sodonzar.com", "MGLchat.com", "Msjli.com", "Msgzar.com" гэх зарын вэб сайтууд мөн "Санхүүгийн туслалцаа, өгөө аваа +18", "Sanhuu vip group", "Hi guys" гэх зэрэг 30 гаран хаалттай фэйсбүүк группүүд нээгдэж урьдчилгаа мөнгө авч оруулдаг секс бичлэгтэй, видео калл хийж дуудлагаар биеэ үнэлдэг, эмэгтэйчүүдийн дугаар зэргийг өгч цахим орчин дахь биеэ үнэлэлт зохион байгуулалттай дижитал хэлбэрт шилжсэн.

Цагдаагийн албан хаагчдтай хийсэн ярилцлагын тэмдэглэлээс

Мөн тус судалгааны хүрээнд ХХГХ-ийн 14 хохирогчийн хавтаст хэрэгт шинжилгээ хийхэд тэдний долоо нь цахимаар холбогдож, харилцааар эцэстээ ХХГХ-ийн хохирогч болсон байх ба тэдгээр хэргийг үйлдсэн гэмт хэрэгтнүүдийн зургаа нь агнах, нэг нь загасчлах стратегиар цахим орчинг ашиглан ХХГХ үйлдсэн байна.

Секс аялал жуулчлал. АНУ-ын төрийн департаментийн 2020 оны тайланд Япон, Өмнөд Солонгос Улсын жуулчид хүүхэдтэй бэлгийн харьцаанд орох сонирхлоор Монголд ирдэг талаар дурдсан байна¹³⁸. Уг нөхцөл байдал үндэслэлтэйг ЭЦА-ны төлөөллөөс авсан мэдээлэл баталж байв. Тодруулбал, БНХАУ, БНСУ, Япон зэрэг улсын иргэд Монгол Улсад секс жуулчлал хийхээр зорьж ирэн хотоос хол байрлалтай амралтын газар, нууц далд аргаар үйл ажиллагаа явуулж буй караоке баар, цэнгээний газруудаар үйлчлүүлэн тэндээ Монгол охидыг худалдан авч секс үйлчилгээ авдаг байна. Эдгээр үйлчилгээг үзүүлэхэд зочид буудлууд, жуулчны баазууд багадаа 4-5, ихдээ 30-40 охидыг "нууц" караокед цуглуулан наргиж цэнгэн дараа нь секс үйлчилгээг үзүүлдэг. Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй зочид буудал, жуулчны баазууд зочид буудалд орж байгаа насанд хүрээгүй хүүхдийн бүртгэл, харгалзагч, хяналтын асуудлыг нарийвчлан зохицуулсан журам байхгүй байна.¹³⁹

COVID-19 цар тахлын үе дэх ХХГХ: Цар тахлын дэгдэлттэй холбоотойгоор хил хаагдаж, дотоод хөдөлгөөний урсгал хязгаарлагдсантай холбоотойгоор гадаад болон дотоодод үйлдэгдэх ХХГХ тодорхой хэмжээнд хязгаарлагдсан хэдий ч гэмт хэрэгтнүүд цаг үеийн нөхцөл байдалтай зохицон гэмт хэргийг илүү далд хэлбэрээр, тэр дундаа цахимаар үйлдэх нь нэмэгдсэн.¹⁴⁰ Цар тахлаас үүдэлтэй нийгэм эдийн засгийн олон хорио, хязгаарлалтууд, сургууль цэцэрлэгийн үйл ажиллагааг зогсоосны үр дагавар нь цар тахлын дараах нийгэмд эдийн засгийн, боловсролын хувьд завсардсан бүлэг үеийг гаргаж ирэх төлөвтэй байна.

Олон улсад хийгдсэн судалгааны тайлангуудад дурдсанаар нийгэмд үүссэн хямралын дараа сургууль завсардсан, орлогогүй, ажилгүй болсон иргэдийн гэмт хэрэг үйлдэх, гэмт хэрэгт өртөх эмзэг байдал улам нэмэгддэг. Иргэдийн эмзэг байдал нэмэгдэх нь гэмт хэрэгтнүүдэд хохирогчдыг олзлох боломжийг улам олгох ба COVID-19-ийн үед болон түүнээс цаашир цаг үед уг үүссэн нөхцөл байдал нь ХХГХ-ийн гаралтыг улам нэмэгдүүлэх нөхцөл байдал бүх улс орнуудад ижил ажиглагдаж байна.¹⁴¹

Дээрх үр дүнгээс үзэхэд ХХГХ үйлдэгдэх аргууд нийгэм цаг, үеийн хөгжлийг даган илүү далд, нуугдмал хэлбэрт шилжиж, зохион байгуулалтад орж, хохирогчийг олзлох арга хэлбэр нь өөрчлөгдөж буй

¹³⁷ ЦЕГ-ийн ЭЦА-ны Зохион байгуулалттай гэмт бүлэг, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтээс 2021 оны 3 сарын 2-ны өдөр авсан мэдээлэл

¹³⁸ <https://mn.usembassy.gov/mn/2020-trafficking-persons-report-mn/>

¹³⁹ Лантуун дохио ТББ-ын 2013 онд хэрэгжүүлсэн Зочид буудал төслийн мэдээллээс

¹⁴⁰ ЦЕГ-ийн ЭЦА-ны Зохион байгуулалттай гэмт бүлэг, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хэлтээс 2021 оны 3 сарын 2-ны өдөр авсан мэдээлэл

¹⁴¹ ХХГХ-ийн шинэ чиг хандлага болон COVID-19 цар тахлын үр дагавар, НҮБ Эмэгтэйчүүд

байдал ажиглагдаж байна. Ялангуяа, цар тахал дэгдсэн нь ХХГХ үйлдэгдэх арга, чиг хандлагын өөрчлөлтөд тодорхой нөлөөллүүд оруулж буй тул цаашид энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааг төлөвлөхдөө сүүлийн үед гарч буй өөрчлөлт чиг хандлагыг харгалзан үзэх нь чухал байна.

ГУРАВ: ХОХИРОГЧ ХАМГААЛАЛ, ХОХИРОГЧИД ШААРДЛАГАТАЙ ДЭМЖЛЭГ ТУСЛАЛЦАА

Монгол Улс ХХГХ-ийн хохирогчийг хэрхэн хамгаалдаг, ямар тусламж үйлчилгээ үзүүлж буйг судлахын тулд холбогдох хууль эрх зүйн баримт бичигт “хохирогч” гэх ойлголтыг хэрхэн тодорхойлсон, хохирогч хамгааллын үйлчилгээг зохицуулсан эрх зүйн зохицуулалтууд, тэдгээрийн хэрэгжилтийг авч үзлээ.

Хүснэгт 13. Хохирогчийг тодорхойлсон тодорхойлолтууд

Холбогдох хуулиуд	Тодорхойлолтууд
Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль (2012)	3.1.2. Хохирогч гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэсэн, хохирогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаалан хүн худалдаалахын улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол зөрчигдсөн хүнийг хэлнэ.
Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль (2013)	4.1.1. “Гэрч, хохирогч” гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэрч, хохирогчийг ойлгоно.
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2015)	8.1. Хохирогч гэж гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг хохирогч гэнэ.
Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль (2017)	5.1.2. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч гэж гэр бүлийн хүчирхийллийн улмаас сэтгэл санаа, эдийн засаг, бие махбод, бэлгийн халдашгүй байдлаараа хохирсон хүнийг хэлнэ.
Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль (2017)	3.2. “Хохирогч” гэж зөрчлийн улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсэн хүн, хуулийн этгээдийг хэлнэ.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд хохирогчийг өргөн хүрээнд тодорхойлсон байх бөгөөд хохирогч нь заавал хохирогчоор тогтоогдсон эсэхээс үл шалтгаалан үйлчилгээ үзүүлэгч байгууллагад шууд хандан хохирогчоор бүртгэгдэж болохоор заасан нь хохирогчдод ээлтэй зохицуулалт болжээ. Гэтэл Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн үйлчлэлд зөвхөн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар **хохирогчоор тогтоогдсон** (шүүх, прокурор, мөрдөн байцаагчийн шийдвэрт үндэслэн) хүн хамаарагдахаар заасан байна. Энэ нь хохирогч хууль хяналтын байгууллагад хандаагүй тохиолдолд эрүүгийн байцаан шийтгэх болон гэрчийг хамгаалах тухай хуульд заасан хамгааллын үйлчилгээг авах боломжгүйг харуулж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “хохирогч” гэдэгт гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг ойлгоно гэж заасан. Одоогийн нөхцөлд хохирогчид учирсан сэтгэл санааны хохирол, сэтгэл зүйн гэмтэлд өртсөн эсэх үзүүлэлтийг хохирогчийг авч үзсэн тодорхойлолтуудад тусгагдаагүй байна (**Хүснэгт 13**).

Энэ нь **хохирогчийг тодорхойлсон хуулийн заалт хооронд агуулгын зөрүү буюу хийдэл байгааг** харуулах ба түүний нөлөөгөөр ХХГХ-ийн хохирогч болсон олон хүн хуулийн дагуу шаардлагатай хамгааллын туслалцаа авч чадахгүйд хүрдэг тухай үйлчилгээ үзүүлэгч ТББ-ын төлөөллүүд ярилцлагадаа дурдаж байлаа. Тухайлбал, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хүрээнд хамгаалалтын арга хэмжээг авахын тулд зайлшгүй Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэрч, хохирогчоор тогтоогдсон байхаар заасан нь хохирогч хуулийн байгууллагад хандаж тусламж, дэмжлэг авч чадахгүйд хүргэдэг байна.

Мөн өмнө дурдсанчлан аль ч тодорхойлолтод хохирогчийн сэтгэл санааны хохиролыг харгалзах талаар нарийвчлан тусгаагүй. Зөвхөн Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлд хохирогч нь сэтгэл санааны хохирлоо нөхөн төлүүлэхийг гэм буруутай этгээдээс шаардах эрхтэй ба сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлөх асуудлыг нэхэмжлэх шаардлагын хүрээнд хохирогчид учирсан гэм хорын хэм хэмжээг харгалзан шүүх тогтооно гэж заасан. Гэвч **сэтгэл санааны**

хохирлыг мөнгөн хэлбэрээр тооцох аргачлал өнөөдрийг хүртэл батлагдаагүй нь хохирогч сэтгэл санааны хохирлоо нэхэмжилдэг ч түүнийг шүүх хангах боломжийг хязгаарлаж байна. Тухайлбал, тус судалгааны хүрээнд танилцсан долоон хавтаст хэрэгт хохирогчоор тогтоогдсон 14 хүнээс нэг л хүн сэтгэл санааны хохирлоо мөнгөн хэлбэрээр нэхэмжилсэн байгаа ч шүүх нэхэмжлэлийг хангаагүйгээс үзэхэд Монгол Улсад хохирогчийн сэтгэл санааны хохирлыг үндэслэлтэй тооцох аргачлал байхгүй байна.

Өнөөдрийн байдлаар Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль дахь хохирогчид үзүүлэх тусламж үйлчилгээний заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд гарсан эрх зүйн баримт бичгүүдийг авч үзвэл:

- Гэрч, хохирогчид эрүүл мэндийн туслалцаа үзүүлэх журам¹⁴²,
- Гэрч, хохирогчийг аюулгүй газарт түр байрлуулах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам¹⁴³,
- Гэрч, хохирогчийн мэдээллийн нууцлалыг хангах аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хэрэглэх журам¹⁴⁴,
- Гэрч, хохирогчийг тусгай техник хэрэгслийн жагсаалт, хэрэгслээр хангах, хэрэглэх журам,
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх журам¹⁴⁵
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод сэтгэцийн нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ үзүүлэх журам¹⁴⁶
- ХНХЯ-аас гаргасан Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах, үйлчилгээ үзүүлэх журам¹⁴⁷
- Гадаад улсад ХХГХ-т өртсөн хохирогчийг эх нутагт нь буцаан авчрах үйлчилгээний журам¹⁴⁸-ууд батлагдан хэрэгжиж байна.

Эдгээр журмуудын хүрээнд хохирогч хамгааллын үйлчилгээний хэрэгжилтийн үр дүнг дүгнэсэн мэдээ, тайлан байхгүй одоогоор байна.

ХЗДХЯ-аас батлах **“Хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх журам”** батлагдаагүй учир хуулийн байгууллагад хандсан хохирогчдод өмгөөллийн туслалцаа авч чадахгүй байна. Тухайлбал, судалгааны хүрээнд шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн хавтаст хэргүүдэд шинжилгээ хийхэд нийт 14 хохирогчдоос зөвхөн нэг л хохирогч өмгөөлөгч авсан бол үлдсэн 13 хохирогч нь төлбөрийн чадваргүйн улмаас өмгөөллийн үйлчилгээ авч чадаагүй байв. Иймд аливаа гэмт хэргийн улмаас хохирсон, төлбөрийн чадваргүй хохирогчдод өмгөөлөл, хууль зүйн туслалцаа авах эрхийг баталгаатай эдлүүлэх үүднээс эрх зүйн орчныг бий болгох буюу хууль зүйн туслалцаа үзүүлэх журмыг нэн даруй боловсруулан батлах шаардлага байна.

Мөн ХХГХ-ийн хохирогчид үзүүлэх үйлчилгээнд тавих наад захын шаардлагыг тогтоох зорилго бүхий баримт бичгийг 2013 онд Монгол Улсын Стандартчиллын Үндэсний зөвлөлийн 58-р тогтоолоор “ХХГХ-ийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” (MNS 6418:2013) баталсан. Стандартаар хохирогчийг хүлээн авах, тодорхойлох, яаралтай анхан шатны үйлчилгээ үзүүлэх, нөхцөл байдлын үнэлгээ хийх, эргэн нийгэмшүүлэх төлөвлөгөө боловсруулах, хохирогчийн

¹⁴² Эрүүл мэндийн сайд, Хууль зүйн сайдын хамтарсан 2014 оны А/356, А/182 дугаар тушаал

¹⁴³ Хууль зүйн сайдын 2014 оны А/114 дүгээр тушаал

¹⁴⁴ Хууль зүйн сайдын 2014 оны А/112 дугаар тушаал

¹⁴⁵ Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/135 тоот тушаал Эрүүл мэндийн сайд, Хууль зүйн сайдын хамтарсан 2014 оны А/356, А/182 дугаар тушаал Хууль зүйн сайдын 2014 оны А/112, А/113, А/114 дүгээр тушаал, Гадаад харилцааны сайдын 2013 оны А/91 дүгээр тушаал

¹⁴⁶ Эрүүл мэндийн сайдын 2013 оны 462-р тушаал “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод сэтгэцийн нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ үзүүлэх” журмыг баталсан байна.

¹⁴⁷ Хөдөлмөрийн сайдын 2013 оны А/142 тоот тушаал “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэх” журмыг баталсан байна.

¹⁴⁸ Гадаад харилцааны сайдын 2013 оны А/91-р тушаал “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх” журмыг баталсан байна.

түүхийг хаах, хохирогчоос утсаар мэдээлэл авах, зөвлөгөө өгөхөд анхаарах асуудал зэрэг суурь шаардлагуудыг тодорхойлсон.

Гэвч уг стандартын хэрэгжилтэд хяналт тавих механизм бүрдээгүйгээс **уг стандарт хохирогч хамгааллын үйлчилгээнд бүрэн мөрдөгдөж буй эсэх, үзүүлж буй үйлчилгээний чанарыг үнэлж дүгнэх боломж хязгаарлагдмал байна.** Иймд цаашид уг стандартын хэрэгжилтэд хяналт тавих ажлыг хэрэгжүүлэх хэрэгцээ байгаа нь ажиглагдав.

Дараагийн хэсгүүдэд хохирогчид үзүүлж буй үйлчилгээний нөхцөл байдлыг баримт бичиг болон үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай хийсэн ярилцлагын мэдээлэлд үндэслэн тодруулж, цаашид ХХГХ-ийн хохирогчид нэн шаардлагатай дэмжлэг туслалцаа, хохирогч хамгааллын үйлчилгээнд нэвтрүүлэх шаардлагатай үйл ажиллагаа, санал зөвлөмжийг тодорхойллоо.

Хэсэг 1. Хохирогчид үзүүлж буй үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдал

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 12-р зүйлд тусгаснаар Монгол Улсад хохирогчид дараах таван төрлийн нөхөн сэргээх үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэхээр хуульчилсан. Үүнд:

12.1.1	12.1.2	12.1.3	12.1.4	12.1.5
Эрүүл мэндийн нөхөн сэргээх эмчилгээ	Сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээ	Ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах	Хууль зүйн туслалцаа	Гадаад улсад Монгол Улсын консулын газраас хохирогчийг түр хугацаагаар орон байр, хоол хүнсээр хангах, гадаад паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг олгох, эх оронд нь буцаан авчрах

Үйлчилгээ үзүүлэгч ТББ-ын төлөөлөлтэй ярилцах явцад ХХГХ-ийн хохирогч нарт анхан шатны туслалцаа нэн тэргүүнд шаардлагатай байдаг бөгөөд тус туслалцаанд сэтгэл зүйн зөвлөгөө, хууль эрх зүйн туслалцаа, эрүүл мэндийн үзлэг, хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээнүүд багтдаг. Гэвч Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд зөвхөн хохирогчид нөхөн сэргээх үйлчилгээг үзүүлэхээр тусгасан ба **анхан шатны үйлчилгээг хэн үзүүлэх, хаана хандах талаар зохицуулалт орхигдсон байна.** Уг орон зайг ТББ-ууд нөхөж ОУБ-ын дэмжлэгтэйгээр өнөөг хүртэл хохирогчдод нэн шаардлагатай анхан шатны үйлчилгээг үзүүлж байна.

Тус судалгааны хүрээнд хохирогчид үзүүлж буй үйлчилгээний нөхцөл байдлыг судлах зорилгоор Иргэдэд туслах хүний эрх төв, ХТЭТ, Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Талита Ази, ЭКПАТ Үндэсний сүлжээ, Unbound ТББ-уудын төлөөлөлтэй ганцаарчилсан ярилцлага зохион байгуулсан. Эдгээр ТББ-ууд нь хохирогчдод туслалцаа үзүүлэх чиглэлээр таваас дээш жил ажилласан туршлагатай байгууллагууд ба үзүүлж буй үйлчилгээ бүгд өөр өөрийн онцлогтой байна. Тухайлбал:

- Талита-Ази ТББ нь удаан хугацаагаар хамгаалах байр ажиллуулахын зэрэгцээ сэтгэл заслын цогц үйлчилгээ,
- Хүйсийн тэгш эрхийн төв ТББ нь хохирогчдыг гадаад улс орноос эгүүлэн авчрах, түр хамгаалах байранд байрлуулах, нийгмийн ажлын цогц үйлчилгээ,
- Хүчирхийллийн эсрэг үндэсний төв, Иргэдэд туслах хүний эрхийн төв нь хууль зүйн туслалцаа, зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээ,
- ЭКПАТ Үндэсний сүлжээ нь насанд хүрээгүй иргэдэд чиглэсэн сургалт, сурталчилгаа, зөвлөгөө өгөх үйлчилгээ,
- Unbound ТББ нь сургалт, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны чиглэлээр түлхүү ажиллаж байна.

Эдгээр байгууллагууд ХХГХ-ийн хохирогчдод үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлдэг ба тэдгээрийг нэгтгэн авч үзвэл (1) анхан шатны дэмжлэг туслалцаа, (2) нөхөн сэргээх гэсэн үндсэн хоёр түвшинд үйлчилгээ үзүүлж байна:

Хүснэгт 14. ТББ-ын хохирогчид үзүүлж буй үйлчилгээнүүд

Хохирогчид үзүүлж буй үйлчилгээ	Үйлчилгээ үзүүлж буй ТББ	Хүйсийн тэгш эрхийн төв	Талита Ази	Иргэдэд туслах хүний эрхийн төв	Хүчирхийллийн эсрэг үндэсний төв
Эх нутагт нь эгүүлэн авчрах үйл ажиллагаа					
Хамгаалах байр (аноулгүй байдал)					
Сэтгэл зүйн дэмжлэг, засал					
Эрүүл мэндийн үйлчилгээ					
Хууль зүйн туслалцаа					
Сэтгэцийн нөхөн сэргээх үйлчилгээ					
Дэмжих бүлэг					

Гэвч өмнөх бүлэгт дурдсан хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбоотой журмын хэрэгжилт, тусламж үйлчилгээний хүртээмж, чанарыг үнэлэх, дүгнэх мэдээлэл дутмаг байна. Уг судалгааны хүрээнд 14 хохирогчтой долоон хэргийн материалтай танилцахад хохирогчдын ихэнх нь (n=11) ямар нэгэн үйлчилгээ, тусламж, дэмжлэг аваагүй байсан. Тусламж, үйлчилгээ авсан цөөн хохирогчийн тухайд хамгаалах байранд цөөн хоногоор байрласан, хууль зүйн туслалцаа авсан, сэтгэл зүйн зөвлөгөө, эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан хэдий ч **санхүүгийн асуудлаас шалтгаалан үргэлжлүүлэн авч чадаагүй байна.**

ХХГХ-ийн хохирогчдод нөхөн сэргээх, эргэн нийгэмшүүлэх цогц үйлчилгээг үзүүлэхэд урт хугацаа шаардагддаг тул хохирогчид **үйлчилгээ үзүүлэхэд тулгардаг гол бэрхшээл нь санхүүгийн асуудал болдгийг** үйлчилгээ үзүүлэгч байгууллагын төлөөллүүд мөн илэрхийлж байв. Тухайлбал, Талита-Ази ТББ нь ХХГХ-ийн хохирогчдыг урт хугацаанд хамгаалах байранд байрлуулдаг ба нэг дор эмэгтэй 4, эрэгтэй 2 үйлчлүүлэгч хүлээн авах хүчин чадалтай. Өнөөдрийг хүртэл нийт ХХГХ-ийн 30 хохирогчид (эмэгтэй 28, эрэгтэй 2) туслалцаа үзүүлсэн¹⁴⁹. Тус байгууллага нь **эрэгтэй хохирогчийг хүлээн авах боломжтой хамгаалах байртай ганц байгууллага** боловч хамгаалах байранд ажиллах хүний нөөц болон санхүүгийн асуудлаас шалтгаалан 2021 оны 7 сараас хамгаалах байраа ажиллуулах боломжгүй болж байгаа талаар мэдээлж байв. Хохирогч хамгааллын үйлчилгээг ТББ-ууд ОУБ-ын дэмжлэгтэй төсөл хөтөлбөрийн хүрээнд л санхүүжүүлэн үзүүлж байгаа нь хохирогч хамгааллын үйлчилгээ тогтвортой хүргэх нөхцөл бүрдээгүй, санхүүжилтээс шалтгаалан үйлчилгээ тасалдах эрсдэлтэйг харуулж байв.

Төрөөс хохирогч хамгааллын үйлчилгээг үзүүлж буй туршлага одоогоор байхгүйн зэрэгцээ энэ төрлийн үйлчилгээнд тусгайлсан төсөв тавигдсан, зарцуулагдсан туршлага өмнө байгаагүй. Харин 2019 онд Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах¹⁵⁰ зорилгоор ХЗДХЯ-наас ХТЭТ ТББ-д “Хохирогч хамгааллын үйлчилгээг тогтмолжуулах” зөвлөх ажил үйлчилгээний төслийн хүрээнд 20,000,000¹⁵¹ төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж, энэ нь ХХГХ-т өртсөн 15 хохирогчийн нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэхэд зарцуулагдсан туршлага байна.

ХХГХ-ийн хохирогчдод тусламж үйлчилгээг хүргэж болох өөр нэг хувилбар нь төрийн байгууллагуудын харьяа нэг цэгийн үйлчилгээний төв (НЦҮТ)-д юм. Эдгээр төвүүд нь гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн

¹⁴⁹ Талита Ази ТББ нь 2013 оноос хойш үйл ажиллагаагаа 8 дахь жилдээ явуулж байна. Энэ хугацаанд нийт 39 хохирогчид туслалцаа үзүүлсний 9 нь ГБХ-ийн хохирогч, 30 нь ХХГХ-ийн хохирогч байна. Талита Ази ТББ-аас 2021/06/07-ны байдлаар авсан мэдээлэл.

¹⁵⁰ ХЗДХЯ, SICA “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт” тайлан, 2019

¹⁵¹ АНУ-ын төрийн департаментын Хүн наймаалах асуудлын төлөв байдлын 2020 оны тайланд Монгол Улсын Засгийн газар Хүн худалдаалахтай тэмцэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 509 сая төгрөг зарцуулсан гэжээ.



хохирогчдод олон талт үйлчилгээ үзүүлдэг бөгөөд Монгол Улсын бараг бүх аймагт салбартай, хүний нөөцийн хувьд зорилтот бүлгийн иргэдтэй харилцах, ажиллах чиглэлээр сургалтуудад хамрагддаг, санхүүжилтийн хувьд тогтвортой байдаг тул ХХГХ-ийн хохирогчдод анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэх чиглэлээр үйл ажиллагааг нь өргөжүүлэх боломжтой. Үүний тулд НЦҮТ-ийн албан хаагчдыг ХХГХ-ийн хохирогчийг анхан шатны түвшинд хүлээн авах, тусламж үйлчилгээ үзүүлэх чиглэлээр чадавхжуулах, хохирогчийг дараагийн шатны байгууллага уруу нь дамжуулах үйл явцыг албажуулж, холбогдох зохион байгуулалтыг тодорхой журамлах шаардлага тулгарна.

Дээрх үр дүнгүүдэд үндэслэвэл ХХГХ-ийн хохирогчийг хамгаалах ээлтэй тогтолцоо Монгол Улсад бүрдсэн эсэхэд эргэлзээтэй нөхцөл байдлууд хууль эрх зүйн орчин болон практик түвшинд аль алинд нь ажиглагдаж байна. Хохирогч хамгааллын асуудлаар хууль эрх зүйн орчинд цөөнгүй хийдэл (gap), алдаа байхаас гадна зохицуулагдаагүй үлдсэн асуудлууд байна. Тодруулбал, төрийн институтын хохирогч хамгааллын үйлчилгээ үзүүлэх тогтолцоо бүрдээгүй, тус үүргийг ИНБ-ууд гүйцэтгэж байна. Тухайлбал, ХХГХ-ийн хохирогчийг хамгаалан байрлуулах анхан шатны үйлчилгээг зөвхөн ТББ-ууд үзүүлж, бусад шаардлагатай сэтгэл зүйн болон хууль зүйн туслалцааг тодорхой хугацаатай төсөл хөтөлбөрүүдийн хүрээнд зохицуулж байна. Үүнээс үзэхэд хохирогчид үйлчилгээ үзүүлэх механизмыг онцгойлон авч үзэх, ингэхдээ хохирогчдод туслалцаа үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжийг судлах, тэдгээрийн цаашдын тогтвортой байдлыг хангах, улмаар улсын төсвөөс хохирогч хамгааллын анхан болон нөхөн сэргээх үйлчилгээнд зориулж төсөв хуваарилдаг болох шаардлага тулгамдаж байна.

Хэсэг 2. ХХГХ-ийн хохирогчид шаардлагатай дэмжлэг, туслалцаа

Судалгааны баг ОУШХБ-ын ХХГХ-ийн хохирогчдод үзүүлэх шууд тусламжийн гарын авлагад¹⁵² тулгуурлан үйлчилгээний төрөл, хэлбэрийг тодорхойлов. Түүнчлэн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд болон хохирогчийн нөхцөл байдалд үндэслэн цаашид хохирогчид нэн шаардлагатай үйлчилгээ, арга хэмжээг DoMV загварын дагуу хувь хүн, гэр бүл, олон нийт болон бүтцийн түвшинд боловсруулан дараах хүснэгтэд харууллаа.

Хэрэгцээ шаардлагыг тодорхойлохдоо нийтлэг ХХГХ-ийн хохирогчдод шаардлагатай хэрэгцээ шаардлагыг тодорхойлсноос гадна насанд хүрээгүй иргэд, хөгжлийн бэрхшээлтэй хүн, бэлгийн чиг баримжаа өөр хүн (LGBT) зэрэг тусгай хэрэгцээ бүхий талуудын онцлог нөхцөл байдлыг хохирогч хамгааллын үйлчилгээнд хэрхэн харгалзах шаардлагатайг давхар авч үзэв.

Олон нийт болон бүтцийн түвшинд хэрэгжүүлэх шаардлагатай ажлууд нь хувь хүн болон өрхийн түвшинд хохирогчид шаардлагатай дэмжлэг туслалцааг үзүүлэх суурь нөхцөл болох тул төрийн байгууллагын зүгээс нэн тэргүүнд хохирогч хамгааллын үйлчилгээг сайжруулахтай холбоотой бүтцийн түвшний шийдвэрлэх шаардлагатай асуудлуудад анхаарлаа хандуулах нь зүйтэй.

¹⁵² ОУШХБ, НҮБ-ын Хүүхдийн сан, ХТЭТ нар “Хүн худалаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх шууд тусламжийн гарын авлага” Улаанбаатар хот, 2007

Хүснэгт 15. Хохирогчид шаардлагатай тусламж, үйлчилгээ

Түвшин	Нийтлэг хэрэгцээ шаардлага	Тусгай хэрэгцээ, шаардлага (Хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй, бэлгийн чиг баримжаа ялгаатай иргэд)
Хувь хүний түвшинд	<ul style="list-style-type: none"> - 24 цагийн турш нээлттэй хамгаалах байр ажиллуулах (шөнийн цагаар хохирогч хүлээн авах боломжтой байх) - Эрэгтэй болон эмэгтэй аль аль хүйсийн хохирогчийн онцлог хэрэгцээг харгалзсан үйлчилгээ үзүүлэх - Эрх зүйн зөвлөгөө, туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх - Сэтгэл зүйн зөвлөгөө, заслын үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх - Сэтгэл зүйн зөвлөгөө өгөх газар, сэтгэл зүйчид хүрэлцээтэй байх - Эрүүл мэндийн цогц тусламж үйлчилгээ авах боломжтой байх 	<ul style="list-style-type: none"> - Хамгаалах байранд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хүлээн авах орчныг бүрдүүлэх, тулгуур эрхтэний бэрхшээлтэй иргэдэд орох, гарах гарц, харааны бэрхшээлтэй иргэдэд хөтөч, сонсголын бэрхшээлтэй иргэдтэй харилцах зорилгоор дохионы хэлмэрчийг ажиллуулах, - Хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохируулан хамгаалах байрыг тохижуулах - Хамгаалах байрны албан хаагчдыг бэлгийн чиг баримжааны хувьд ялгаатай иргэдийг хүлээн авах, ажиллах чиглэлээр сургах
Өрх, гэр бүлийн түвшинд	<ul style="list-style-type: none"> - Хохирогчийг гэр бүлийн гишүүдийн хамтад нь урт болон богино хугацааны сэтгэл зүйн зөвлөгөөнд хамруулах - Гэр бүлийн гишүүдээр дамжуулж хохирогчийг нөхөн сэргээх чиглэлд гэр бүлийн гишүүдийг чадавхжуулах, дэмжих - Хохирогчийг гэр бүлд эргэн нэгтгэх ажлыг мэргэжлийн түвшинд зохион байгуулах - Хохирогчдийг мэргэжилтэй болоход нь туслах 	<ul style="list-style-type: none"> - Хөгжлийн бэрхшээл болон хохирогчийн бусад тусгай хэрэгцээтэй холбоотойгоор гэр бүлд санхүүгийн дэмжлэг үзүүлэх - Хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэний тусгай хэрэгцээ, онцлогийг мэддэг мэргэшсэн сэтгэл зүйч, мэргэжилтэнг хуваарилах
Олон нийтийн түвшинд	<ul style="list-style-type: none"> - Үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд хоорондоо мэдээлэл, туршлага солилцдог албан ёсны харилцааны сувагтай байх - Хохирогчдод ээлтэй орчин бүрдүүлэхийн төлөө үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд хамтран нөлөөллийн ажлууд зохион байгуулах 	<ul style="list-style-type: none"> - Хамгаалах байр болон төрийн холбогдох албан хаагчдыг хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд, бэлгийн чиг баримжаа өөр хүний онцлог, тусгай хэрэгцээг таниулах, чадавхжуулах - Төрийн өмчийн бүх хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн албан хаагчдыг ХХГХ-ийн хохирогчтой ажиллах чиглэлээр бэлтгэх, чадавхжуулах
Бүтцийн түвшинд	<ul style="list-style-type: none"> - Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн үйлчлэлд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар хохирогчоор тогтоогдсон эсэхээс үл хамааран хуулийн хамгаалалт авахаар хуулийн тодорхойлолтыг шинэчлэх - Хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх журмыг боловсруулах - Хохирогчдод учирсан сэтгэл санааны хохирлыг тооцох аргачлалыг боловсруулах - "ХХГХ-ийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага" (MNS 6418:2013)-ын дагуу үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавих, үйлчилгээний чанарыг баталгаажуулах - Хүн худалдаалахтэй тэмцэх тухай хуульд хохирогчид анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэх тухай нарийвчилж зааж оруулах - Хохирогч хамгааллын үйлчилгээний санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх 	<ul style="list-style-type: none"> - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хараат бус, бие даан амьдрах боломж, нөхцлийг бүрдүүлэх - ХХГХ-т өртсөн хохирогч хүүхдийг хамгаалах тусгай хамгаалах байрыг бий болгох - Хууль зүйн туслалцаа үзүүлэх үйлчилгээг хохирогчдод үнэ төлбөргүй үзүүлэх боломжийг бүрдүүлэх



ДҮГНЭЛТ

ОУШХБ-ын 2020-2022 оны хооронд хэрэгжүүлж буй “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх Монгол Улсын хүчин чармайлтыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд IRIM судалгааны хүрээлэн **Монгол Улс дахь ХХГХ-ийн нөхцөл байдал, нөлөөлж буй хүчин зүйлсийн суурь судалгааг** 2020 оны 4 сараас 2021 оны 10 сарын хугацаанд хийж гүйцэтгэлээ. Судалгааны ерөнхий 4 зорилтод хүрэхийн тулд судалгаанд тоон болон чанарын аргуудыг хослуулан мэдээлэл цуглуулж, олон оролцогч тал, мэдээллийн эх сурвалжид тулгуурлан гарч ирж буй гол асуудлуудыг дараах долоон гол үр дүнд нэгтгэн танилцууллаа.

- **Үр дүн 1:** Хөдөлмөрийн мөлжлөг нь Монгол Улсад улам нэмэгдэж буй чиг хандлага болж байгаа боловч хууль эрх зүйн хязгаарлагдмал байдал, тогтолцооны түвшинд энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэх, тэмцэх үйл ажиллагаа дутмаг байгаагаас хөдөлмөр мөлжлөгийн хэрэг нь илэрч, зохих ёсоор хуулийн дагуу шийдвэрлэгдэхгүй байна.
- **Үр дүн 2:** Монгол Улсад эрэгтэй, эмэгтэй аль аль хүйсийн иргэд ХХГХ-т өртөж байна.
- **Үр дүн 3:** Санхүүгийн хязгаарлагдмал байдал, хөдөлмөр эрхлэх боломж хомс байгаа нь мөлжлөгт өртөх нөхцөлийг бүрдүүлж, олон талт түвшинд иргэдийг ХХГХ-т өртөх эмзэг байдлыг нэмэгдүүлж байна.
- **Үр дүн 4:** Бүртгэлгүй шилжин ирэгсэд ХХГХ-т илүү өртөмтгий байна.
- **Үр дүн 5:** Улаанбаатар хот, орон нутгуудаас Өмнөговь, Дорноговь, Дорнод аймгуудад ХХГХ-ийн эрсдэл өндөр байгаа боловч ХХГХ-тэй тэмцэх Монгол Улсын хүчин чармайлт Улаанбаатар хотод голчлон төвлөрч байна.
- **Үр дүн 6:** Хуулийн заалтууд өөр хоорондоо зөрчилтэй, уялдаа холбоо хангалтгүй, санхүүжилт дутмаг зэргээс болж хохирогчдод үзүүлэх тусламж үйлчилгээ хязгаарлагдмал байна.
- **Үр дүн 7:** COVID-19 цар тахлын эсрэг авч хэрэгжүүлж буй шийдвэр, урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь иргэдийн ХХГХ-т өртөх эмзэг байдлыг нэмэгдүүлж, ХХГХ-ийн чиг хандлагад нөлөөлж байгаа нь тодорхой боловч уг асуудлыг тусгайлан авч үзсэн судалгаа хийгдээгүй байна.

Монголчуудын ХХГХ-т өртөмтгий байдалд нөлөөлж буй хүчин зүйлсийг ОУШХБ-ын DoMV загварын дагуу судалж, статистикийн гүнзгийрүүлсэн шинжилгээний аргуудыг ашиглан хүчин зүйл тус бүрийн үзүүлэх нөлөөллийг нарийн тооцож хэмжсэн нь уг салбар дахь оролцогч талуудын үйл ажиллагааг нотолгоонд суурилсан мэдээллээр хангахад чухал хувь нэмэр үзүүлнэ гэж найдаж байна.

Тайланд дурдагдсан гол үр дүнгүүдийг судалгааны ерөнхий дөрвөн зорилтын дагуу дүгнэн авч үзвэл:

Зорилт 1. Монгол Улсын иргэдийг ХХГХ-т өртөх эрсдэлд нөлөөлж буй эрсдэлт болон хамгаалагч хүчин зүйлс

Судалгаанд ашигласан ОУШХБ-ын DoMV загварын дагуу аливаа хувь хүн гэмт хэргийн хохирогч, холбогдогч болох нь зөвхөн нэгээс хоёр тодорхой хүчин зүйлээс шалтгаалдаггүй бөгөөд уг нөхцөл байдлыг үүсгэхэд түвшин тус бүрээс хамаарсан хүчин зүйлүүд шууд болон шууд бус байдлаар нөлөөлж байдаг гэж үздэг.

ХХГХ-т өртөх эрсдэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг уг дөрвөн түвшинд судалсан судалгааны үр дүнгээр түвшин тус бүрд нөлөөтэй хүчин зүйлсийн хооронд нягт хамаарал байгаа нь харагдаж байв. Тухайлбал, бүтцийн түвшиндээ нийгмийн хэмжээнд ажилгүйдэл, ядуурал өндөр байгаа нь хувь хүн, өрхийн түвшинд орлогын тогтвортой эх үүсвэргүй байхад нөлөөлж байна. Олон нийт, бүтцийн түвшиндээ нийгмийн суурь үйлчилгээний чанар хүртээмж сул байх нь хувь хүн, өрх гэр бүлийг шилжилт хөдөлгөөн хийхэд хүргэж, өрхийн эмзэг байдлыг улам нэмэгдүүлж байна. Энэ мэтчилэн

олон нийт, бүтцийн түвшний суурь асуудлууд нь хувь хүн, өрхийн амьжиргаа, амьдралын чанарт нь шууд нөлөөлж байгаа нь хувь хүний сэтгэл зүйн төлөв байдал, гэр бүлийн уур амьсгалд таагүй нөлөөг үзүүлж дарамт, хүчирхийлэл мөлжлөг үйлдэгдэх, улмаар иргэдийг илүү боломж, амьдралын таатай нөхцөлийн төлөө гэмт хэрэгт холбогдох, эрсдэлтэй сонголт хийх суурь нөхцөлийг бүрдүүлж өгч байна.

Иймд ХХГХ-тэй тэмцэх тогтолцооны чадавхыг дээшлүүлж, ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх чиглэлээр олон нийт, холбогдох төрийн албан хаагчдын мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх асуудалд шууд чиглэсэн ажлуудыг зохион байгуулахтай зэрэгцэн олон нийт, бүтцийн түвшинд нөлөөтэй нийгмийн суурь хүчин зүйлсийг шийдвэрлэхэд чиглэсэн урт хугацааны бодлого, төлөвлөлтийг хийх, хэрэгжүүлэхэд анхаарал хандуулах шаардлагатай байна.

Түвшин тус бүрээрх судалгааны гол үр дүнг дүгнэвээс:

1.1. Хувь хүний түвшинд нөлөөлж буй хүчин зүйлс

Хувь хүний нас, санхүүгийн чадавх, хөдөлмөр эрхлэлтийн байдал, сэтгэл зүйн тогтворгүй байдал зэрэг үзүүлэлтүүд нь тухайн хүнийг ХХГХ-т өртөмтгий байдалд хамгийн их нөлөөтэй байна. ХХГХ нь ашиг хонжоо олох сэдлээр үйлдэгддэг тул хөдөлмөрийн чадвартай, залуу байх, санхүүгийн хувьд эмзэг, сэтгэл зүйн хувьд тогтворгүй байх нь гэмт хэрэгтнүүдийн хохирогчийг ашиглах, элсүүлэх гол эмзэг, сул талууд болдог байна.

Олон нийтийн дунд боловсрол эзэмшээгүй эсвэл бага боловсролтой эмэгтэйчүүд л ХХГХ-ийн хохирогч болдог гэх хэвшмэл ойлголт байдаг. Гэвч судалгааны үр дүнгээр хувь хүний хүйс болон боловсролын түвшин нь ХХГХ-ийн эмзэг өртөмтгий байдалд эрсдэл болон хамгаалалтын аль ч хэлбэрээр нөлөө үзүүлэхгүй байгаа нь батлагдсан. Тус үр дүн нь бидэнд ХХГХ-ийн хохирогчдыг авч үзэх нийтлэг ойлголтод өөр байр сууринаас хандах шаардлагатай болсныг харуулах ба ялангуяа ХХГХ-т өртөмтгий бүлэгт тооцдоггүй эрэгтэйчүүдийн эмзэг байдлыг бууруулахад чиглэсэн санаачилгуудад анхаарлаа хандуулах хэрэгтэйг харуулж байна.

1.2. Гэр бүлийн түвшинд нөлөөлж буй хүчин зүйлс

Өрхийн түвшинд хамгийн их нөлөө үзүүлж буй хүчин зүйл нь гэр бүлийн гишүүдийн харилцааны зөрчил, таагүй уур амьсгал, тогтворгүй байдал, хүчирхийлэл үйлдэгдэж буй нөхцөлүүд байв. Эсрэг тохиолдолд буюу гэр бүлийн харилцаа таатай байх нь тухайн өрхийн гишүүдийг ХХГХ-т өртөхөөс хамгаалах нөлөө үзүүлж буйгаас үзэхэд өрхийн түвшинд тус хүчин зүйлс нь шийдвэрлэх нөлөөтэй байна.

Хувь хүний түвшинд тухайн хүний санхүүгийн чадавх нь эрсдэлт хүчин зүйлд тооцогдож байсан боловч өрхийн санхүүгийн чадавх нь тэр хэмжээнд нөлөө үзүүлэхгүй байгаа нь уг хэсэгт анхаарал татаж буй үр дүн байсан. Өөрөөр хэлбэл, гэр бүл санхүүгийн хувьд баталгаатай хэдий ч гэр бүлийн харилцаа муу, уур амьсгал таагүй, зөрчилтэй бол тухайн өрхийн гишүүдийн ХХГХ-т өртөх эмзэг байдал нэмэгдэж байна. Энэ нь гэр бүлийн түвшинд өрхийн санхүүгийн нөхцөл байдлаас илүү гэр бүлийн дотоод нягтаршил, харилцаа, уур амьсгал тухайн гэр бүлийн гишүүдийн эмзэг байдалд илүү хүчтэй нөлөөтэйг илтгэж байна.

1.3. Олон нийтийн түвшинд нөлөөлж буй хүчин зүйлс

Олон нийтийн түвшинд иргэдийн эмзэг байдлыг нэмэгдүүлж буй гол хүчин зүйлд тухайн орон нутаг дахь хөдөлмөр эрхлэх боломж, нийгмийн суурь үйлчилгээний хүртээмж тооцогдож байна. Ялангуяа хөдөлмөр эрхлэх боломж хязгаарлагдмал байх нь боловсрол, ажлын туршлага бага иргэдэд хамгийн хүчтэй нөлөөлдөг бөгөөд улмаар тухайн хүнд өөрийн сонирхол, хэрэгцээнд нийцсэн ажил хийх боломжийг бууруулж, энэ нь орлогын эх үүсвэрээ таслахгүй, гэр бүлийнхээ амьжиргааг залгуулахын тулд эрсдэлтэй сонголт, алхам хийхэд түлхэц үзүүлдэг байна. Тухайлбал, хавтас хэргийн материалаас

үзэхэд төрсөн орон нутагтаа ажил олдоогүйгээс хот уруу нүүн, хотод тохирсон ажлын байр олж чадалгүй удаан явсан тул баталгаагүй ажлын зараар зуучлагч нартай холбогдон биеэ үнэлэх болж, улмаар ХХГХ-ийн хохирогч болсон тохиолдлууд байна. Үүнээс үзэхэд амьдарч буй орон нутагт нь хөдөлмөр эрхлэх боломж хэр нээлттэй байдаг эсэх нь иргэдийг ХХГХ-т өртөх эмзэг байдалд нөлөөлж буй хувь хүний болон гэр бүлийн түвшний хүчин зүйлсийг бүрдүүлэгч суурь нөхцөл болж байна.

Хөдөлмөр эрхлэлт нь шилжилт хөдөлгөөнийг өдөөгч гол хүчин зүйл болж байдаг. Иргэдийн шилжилт хөдөлгөөний урсгал, ялангуяа хөдөө орон нутгаас хот уруу чиглэсэн залуучуудын урсгал нь Улаанбаатар хот дахь бүртгэлгүй шилжин ирэгчдийн тоог нэмэгдүүлэхэд нөлөөлж байна.

1.4. Бүтцийн түвшинд нөлөөлж буй хүчин зүйлс

DoMV загварын дагуу бүтцийн түвшний хүчин зүйлс нь ХХГХ үйлдэгдэх нөхцөл бүрдэхэд суурь шалтгааны шинжтэй нөлөө үзүүлдэг. Үүнд (1) ХХГХ-тэй тэмцэх тогтолцооны чадавх болон (2) нийгэм, эдийн засаг, улс төр зэрэг олон талт системийн хүрээнд энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгдэхэд шууд бус байдлаар нөлөөлж буй хүчин зүйлсийг авч үзсэн.

ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцооны нөхцөл байдлыг урьдчилан сэргийлэх, хэрэг хянан шийдвэрлэх, хамтын ажиллагаа гэсэн хүрээнд авч үзэхэд:

- **Урьдчилан сэргийлэх чиглэлээр (Prevention):** ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх ажил хэрэгжүүлж буй талуудын уялдаа холбоо сул, урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлэх чиглэлээр нэгдсэн бодлого, төлөвлөлтгүйн дээр ихэнх үйл ажиллагаанууд нь ТББ, ОУБ-ын санаачилга, дэмжлэгтэйгээр зохион байгуулагдаж байна.
- **Хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны чиглэлээр (Prosecution):** 2014-2020 оны хооронд ХХГХ-ээр цагдаагийн байгууллагад 86 хэрэг шалгагдсан байхад шүүхээр зөвхөн есөн хэрэг шийдэгдсэнээс үзэхэд уг чиглэлээрх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хангалтгүй явагдаж байна. Үүнд, Эрүүгийн хуульд ХХГХ-ийн төрлүүдийг бие даасан гэмт хэрэг болгон хуульчилсан; хууль сахиулах албан хаагчдын ХХГХ, ялангуяа хөдөлмөр мөлжлөгийн талаарх мэдлэг, ойлголт дутмаг мөн хууль хяналтын байгууллагын хүний нөөцийн тогтворгүй байдал зэрэг нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрах, хэргийн зүйлчлэл өөрчлөгдөх, хэрэг шийдвэрлэгдэхгүй байх нөхцөлийг бүрдүүлж байна.
- **Хамтын ажиллагааны чиглэлээр (Partnership):** ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр ажиллаж буй байгууллага хоорондын ил тод мэдээллийн урсгал хангалтгүй буюу хаана ямар байгууллага ямар үйл ажиллагаа хэрэгжүүлсэн, төрөөс тухайн чиглэлд ямар бодлого барьж ажиллаж байгаа талаар тогтолцооны оролцогч талуудын мэдлэг, мэдээлэл дутмаг, нэгдсэн ойлголт сул байна.

ХХГХ-тэй тэмцэх тогтолцооны дээрх нөхцөл байдлаас гадна суурь бүтцийн түвшиндээ дам байдлаар ХХГХ-ийг нэмэгдүүлэхэд нөлөө үзүүлж буй бусад салбарын нөлөөг авч үзвэл:

- Монгол Улсын нийт хүн амын хэмжээнд дундаж давхарга доторх ядуурлын шугамтай ойр хүн амын эзлэх хувь өндөр, эдийн засгийн хямрал болоход ядуурлын шугамаас доош орох магадлалтай өрхийн тоо их байна. Мөн нийгмийн суурь үйлчилгээ болох боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж сул, хөдөлмөр эрхлэх боломж хязгаарлагдмал байгаа нь иргэдийн эмзэг байдлыг нэмэгдүүлэх, улмаар амьдралын таатай боломж нөхцөлийн төлөө эрсдэлтэй алхам хийх, хохирогч болоход түлхэц үзүүлж байна. Мөн төрөөс авч хэрэгжүүлж буй зарим шийдвэр, тодруулбал шилжилт хөдөлгөөнийг хориглох шийдвэр нь албан бус шилжин ирэгсдийг нэмэгдүүлэх, тэдгээр иргэдийн эмзэг байдлыг нэмэгдүүлэхэд нөлөө үзүүлж байгаа нь шууд бус байдлаар иргэдийг ХХГХ-т өртөхөд нөлөөтэй байна.

Зорилт 2. Монгол Улс дотоодод болон Монгол Улсаас гадагшаа чиглэсэн ХХГХ-ийн урсгал чиглэл, чиг хандлага

Монгол Улсад ХХГХ-ийн бэлгийн болон хөдөлмөр мөлжлөгийн хэлбэрүүд зонхилон үйлдэгдэж байна. Эдгээр хэлбэрээр үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хандсан хохирогчдын тоо нь цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн гэмт хэрэг, хохирогчдын тооноос их байгаа хэдий ч жил бүр цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хэргийн тоо өсөж байгаа нь хэргийн илрүүлэлтэд ахиц гарч буйг харуулж байв. Гэвч өнөөдрийг хүртэл бүртгэгдсэн хэргүүд дунд эрэгтэй хохирогчтой болон хөдөлмөр мөлжлөгийн тохиолдлууд огт бүртгэгдээгүй байна. Мөн цус, эс, эд эрхтэн худалдаалах болон албадан гэрлэлтэй холбоотойгоор мөлжлөгт өртүүлсэн тохиолдлууд одоогийн байдлаар хууль хяналтын байгууллагад бүртгэгдээгүй байна.

Ядуурал, ажилгүйдэл их, шилжилт хөдөлгөөний урсгал, уул уурхай дагасан зах зээл зэрэг ХХГХ-ийн эрсдэлийг нэмэгдүүлж буй хүчин зүйлсийг харгалзвал дотооддоо Улаанбаатар хот болон Өмнөговь, Дорноговь, Дорнод аймгууд хамгийн эмзэг байршлуудад тооцогдож байна. Харин хилийн чанадад ХХГХ-ийн хохирогч болсон иргэдийн мэдээлэлд үндэслэвэл Зүүн болон Зүүн өмнөд Ази руу чиглэсэн урсгал илүү давамгайлж байна. Иймд ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх ажлыг дурдагдсан дотоод болон гадаад дахь эмзэг байршлууд уруу чиглүүлэхэд анхаарах нь зүйтэй байна.

Мэдээллийн технологийн хурдацтай хөгжил болон COVID-19 цар тахал зэрэг цаг үеийн нийгмийн асуудлуудаас үүдэн ХХГХ-т хохирогчийг элсүүлэх болон гэмт хэргийг үйлдэх арга тактик өөрчлөгдөн, шинэ чиг хандлагууд гарч ирж, цар тахлаас өмнөх үед нийгэмд байсан эмзэг байдлын хүчин зүйлсийг (ажлын байрны хомсдол, амьжиргааны асуудлууд...) улам нэмэгдүүлэхэд нөлөөлж байна. Сүүлийн жилүүдэд гарч буй өөрчлөлтийг харвал ХХГХ-т хохирогчдыг интернэт, цахим орчинд суурилсан байдлаар элсүүлэх болсонтой холбоотойгоор хохирогчдын дунд хүйсээс хамаарсан ялгаа багасаж, насны хувьд илүү залуужих хандлагатай болж байна. Цар тахлаас үүдэлтэй нийгэм эдийн засгийн хямралын дараа сургууль завсардсан хүүхдүүд, орлогогүй, ажилгүй болсон иргэдийн гэмт хэрэг үйлдэх, гэмт хэрэгт өртөх эмзэг байдал улам нэмэгдэх хандлагатай байгаагаас үзвэл COVID-19-ийн үед болон түүнээс хойших цаг үед ХХГХ-ийн гаралт улам нэмэгдэх төлөвтэй байна.

Зорилт 3. ХХГХ-ийн хохирогчдод шаардлагатай дэмжлэг тусалцаа, хэрэгцээ

ХХГХ-ийн “хохирогч” гэх тодорхойлолтыг 2012 онд Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулиар анх хуульчилсан. Уг тодорхойлолт нь бусад эрүүгийн холбогдох хуулиуд дахь хохирогчийн тодорхойлолтоос илүү өргөн хүрээнд хохирогчийг авч үзсэнээрээ хохирогчид илүү ээлтэй заалт болсон гэж үздэг. Тодруулбал, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд цагдаа, шүүхийн байгууллагаар хохирогчоор тогтоогдсон эсэхээс үл хамааран ХХГХ-ийн хохирогч нь үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хандан тусламж, үйлчилгээ авах боломжийг бүрдүүлсэн.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд зааснаар хохирогчид таван төрлийн нөхөн сэргээх үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэхээр заасан хэдий ч хохирогчдод нэн тэргүүнд шаардлагатай тусламж дэмжлэг болох хамгаалах байр, хоол, хүнс, эрүүл мэндийн яаралтай тусламж үйлчилгээ зэрэг анхан шатны үйлчилгээг хэн хэрхэн, ямар санхүүжилтээр үзүүлэх талаарх нарийвчилсан зохицуулалт тусгагдаагүй байна. Мөн эдгээр үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой төсвийн асуудлыг хуульд нарийвчлан заагаагүй.

Мөн хуулийг даган гарах журмуудаас ХХГХ-ийн хохирогчдод “Хууль зүйн тусалцаа үзүүлэх журам” батлагдаагүй. Өнөөдрийн байдлаар үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын дийлэнх нь ОУБ-ын дэмжлэгтэйгээр ХХГХ-ийн хохирогчдод хууль зүйн зөвлөгөө, өмгөөллийн тусалцаа үзүүлж байгаа хэдий ч энэ тогтвортой үргэлжлэх нөхцөл хангагдахгүй байгаагаас үзвэл дээрх журмыг яаралтай батлах хэрэгцээ шаардлага үүссэн байна.

Цаашид хохирогчид үзүүлэх үйлчилгээний тогтолцоог сайжруулах, ялангуяа одоогийн нөхцөлөөр тусламж үйлчилгээ авах боломж нөхцөл нь хангагдаагүй эрэгтэй хохирогчдын хэрэгцээг харгалзах,

хохилогч хамгааллын суурь үйлчилгээний стандартыг бий болгох, үйлчилгээний чанар, хүртээмжийг үнэлэх, улмаар хохирогч хамгааллын анхан болон нөхөн сэргээх үйлчилгээний санхүүжилтийг шийдвэрлэх замаар үйлчилгээний тогтвортой байдлыг хангах зохицуулалт нэн тэргүүнд шаардагдаж байна.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Судалгааны гол үр дүнд үндэслэн ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлд дараах зөвлөмжийг холбогдох талуудад санал болгож байна:

Хугацаа	Ерөнхий чиглэл	Зөвлөмжүүд	Хариуцах байгууллага
Хувь хүний түвшин дэх эрсдэлт болон хамгаалагч хүчин зүйлс:			
<ol style="list-style-type: none"> 1. Залуучууд (14-25 насны иргэд) ХХГХ-т илүү өртөмтгий байна 2. Эрэгтэйчүүд ХХГХ-т мөн өртөж байна, ялангуяа хөдөлмөр мөлжлөгт өртөх эрсдэл өндөр байна. 3. Оюутан, улирлын чанартай (газар тариалан, барилга, уул уурхайн олборлолт гэх мэт) ажил эрхлэгч, болон цагийн ажил эрхэлдэг иргэдийн ХХГХ-т өртөх эмзэг байдал өндөр байна (орлогын тогтворгүй байдлаас шалтгаалан). 4. Бие махбодын хувьд болон сэтгэл зүйн хувьд хүнд, хэцүү нөхцөлд орж байсан иргэд ХХГХ-т өртөх эрсдэл өндөр байна. 5. Хөдөлмөр эрхлэх болон суралцах зорилгоор 30 хоногоос дээш хугацаагаар шилжилт хөдөлгөөнд орсон иргэд, албан ёсны бүртгэлгүй иргэдийн ХХГХ-т өртөх эмзэг байдал өндөр байна. 6. Санхүүгийн чадавх сул, эдийн засгийн боломж тааруу иргэд ХХГХ-т илүү өртөж байна. 			
Богоно хугацаанд	<p>1. ХХГХ-т эрсдэл өндөр 14-25 насны иргэдийн хүний наймааны талаарх ойлголт мэдлэгийг дээшлүүлэх</p> <p>Ялангуяа эрэгтэйчүүдийн хувьд хөдөлмөр мөлжлөг, албадан хөдөлмөрийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх</p>	<p>1.1 Хороо/багийн түвшинд оршин суух албан ёсны бүртгэлгүй, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой, өрөөсгөл гэр бүлтэй (өрх толгойлсон, салсан, бэлэвсэн), оюутан, улирлын чанартай болон хагас цагаар ажилладаг залуучуудын судалгааг нарийвчлан гаргах, зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн кампанит ажил, аян, нэвтрүүлэг, подкаст, шторк бүтээх замаар ХХГХ-ийн талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх;</p> <p>1.2 Хөдөө аж ахуй, барилга, уул уурхай зэрэг хөдөлмөр мөлжлөгийн эрсдэл өндөр салбарт ажилладаг эрэгтэйчүүдэд чиглэсэн мэдээлэл олгох үйл ажиллагааг ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх урт хугацааны үйл ажиллагааны төлөвлөлттэй уялдуулан, үе шаттай зохион байгуулах;</p>	<p>Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх дэд зөвлөл (цаашид Дэд зөвлөл гэх)</p> <p>Үндэсний хэвлэл мэдээллийн байгууллагууд</p> <p>Цагдаагийн ерөнхий газар (ЦЕГ)</p> <p>Олон улсын байгууллагууд</p> <p>Дэд зөвлөл, ЦЕГ, ХНХЯ, ОУБ-ууд</p>
Дунд хугацаанд	<p>2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт¹⁵³ ХХГХ-т өртөх эрсдэлтэй залуучуудыг хамруулах</p> <p>Хот руу шилжин ирсэн иргэдэд орлого олох боломжуудыг нэмэгдүүлэх</p>	<p>2.1 2020 оны 6 сард батлагдсан Оюутны цагаар хөдөлмөр эрхлэх журмын хэрэгжилтийг хангах замаар оюутан, залуучуудыг цагийн ажилд зуучлах, орлого олох боломжийг нэмэгдүүлэх;</p> <p>2.2 Урт хугацаанд хөдөлмөр эрхлээгүй залуучуудыг ажлын дадал, туршлага эзэмшүүлэх туршилтын хөтөлбөрүүдэд хамруулах;</p> <p>2.3 Хот уруу хөдөлмөр эрхлэх зорилгоор шилжин ирсэн иргэдэд Улаанбаатар хотод бүртгэлтэй эсэхээс үл хамааран мэргэжлийн боловсролын сургалтад хамрагдах боломжийг бий болгох;</p>	<p>Сум, дүүрэг, аймаг, нийслэлийн Засаг дарга, нутгийн өөрөө удирдах байгууллага буюу Иргэдийн төлөөлөгчдийн хурал (ИТХ)¹⁵⁴ ХНХЯ</p> <p>Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар (ГБХЗХГ) Боловсрол, шинжлэх ухааны яам (БШУЯ)</p>

¹⁵³ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (2021 оны 2 сарын 9 өдрийн 1 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт) Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр.

¹⁵⁴ Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага Нэгдүгээр дэд бүлэг, Орон нутгийн чиг үүрэгт 19-26-р зүйл; Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8-р зүйл, Аймаг, нийслэл, сум дүүрэг, баг, хорооны Засаг даргын бүрэн эрх; Хөдөлмөрийн тухай хуулийн 137.4-д Бүх шатны Засаг дарга бүрэн эрхийнхээ хүрээнд хөдөлмөрийн удирдлагыг хэрэгжүүлнэ гэж заасан.



Урт хугацаанд	3. ЕБС-ийн хичээлийн хөтөлбөрийг ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх чиглэлийн мэдээлэл, агуулгаар баяжуулах	3.1 ЕБС-ийн Нийгмийн тухай мэдлэг хичээлийн агуулгад ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх сэдвийг тусгах (үндсэн ойлголт, жишээ гэх мэт); 3.2 Их дээд сургуулийн ерөнхий суурь хичээлүүдийн хөтөлбөрийг (Хүний эрх, Нийгмийн ажил, Социологи, Сэтгэл судлал зэрэг мэргэжлийн) ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх агуулгаар баяжуулах;	БШУЯ Аймаг/дүүргийн боловсролын хэлтэс ОУБ-ууд ТББ-ууд
	4. ХХГХ-ийн хохирогчдод туслалцаа үзүүлэх	4.1 Сэтгэл зүйчид, зөвлөгөө өгөх төвүүдийг ХХГХ-ийн хохирогчтой ажиллах чиглэлээр чадавхжуулах, мэргэжлийн сургалтуудыг зохион байгуулах, хохирогчид туслалцаа үзүүлэх чиглэлээр орон нутгийн сургуулиуд болон ТББ-тай хамтран ажиллах байдлыг дэмжих;	БШУЯ
Гэр бүлийн түвшин дэх эрсдэлт болон хамгаалагч хүчин зүйлс:			
<ol style="list-style-type: none"> 1. Гэр бүлийн уур амьсгал тайван бус, хүчирхийлэл, дарамт, шахалттай өрхийн гишүүд ХХГХ-т өртөх эрсдэл өндөр байна. 2. Гэр бүлийн аль нэг гишүүн суралцах эсвэл хөдөлмөр эрхлэх зорилгоор урт хугацаагаар шилжилт хөдөлгөөнд оролцсон бол ХХГХ-т өртөх өрхийн эмзэг байдал нэмэгдэж байгаа бол урьдчилан төлөвлөж, гэр бүлээрээ шилжилт хөдөлгөөн орох нь ХХГХ-ийн эрсдэлээс сэргийлэх хамгаалагч хүчин зүйл болж байна. 3. Өрхийн санхүүгийн чадавх муу байх нь тухайн өрхийн гишүүдийг ХХГХ-т өртөх эрсдэлийг нэмэгдүүлж байгаа хэдий ч санхүүгийн чадавх сайн байх нь хамгаалах нөлөө үзүүлэхгүй байна. 			
Богино хугацаанд	1. Өрхийн гишүүн нь урт хугацаагаар шилжилт хөдөлгөөнд орсон гэр бүлийн эмзэг байдлыг нь бууруулахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх	1.1 Гэртээ хараа хяналтгүй хүүхэд үлдээдэг гэр бүлд энэ талын эрсдэлийг таниулах мэдлэг, мэдээлэл олгох үйл ажиллагаа зохион байгуулах; 1.2 Гэртээ хараа хяналтгүй үлдэж буй хүүхдүүдэд чиглэсэн олон нийтийн дэмжлэг туслалцааг ашиглах, хөршүүдийн холбоо, хяналтыг сайжруулах төслүүд санаачилж, хэрэгжүүлэх;	Орон нутгийн засаг захиргааны нэгжүүд (Хороо, сум), ОУБ-ууд Орон нутгийн засаг захиргааны нэгжүүд (Хороо, сум), БШУЯ, ОУБ-ууд
Дунд хугацаанд	2. ХХГХ-ийн эрсдэлийг бууруулахын тулд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хүчин чармайлтаа нэмэгдүүлэх	2.1 ХХГХ болон гэр бүлийн хүчирхийлэл хоорондын холбоо хамаарлыг хүлээн зөвшөөрч, ГБХ-ээс (бие махбодын сэтгэл санааны, бэлгийн, эдийн засгийн) урьдчилан сэргийлэх, өртсөн тохиолдолд хаанаас, хэрхэн тусламж дэмжлэг авах талаар мэдээллийг хэвлэл мэдээлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан түгээх;	БШУЯ, Насан туршийн боловсролын үндэсний төв (НТБҮТ), ГБХЗХГ, Дэд зөвлөл, Аймаг, дүүргийн насан туршийн боловсролын төвүүд (21 аймаг, 9 дүүргийн салбар)
Урт хугацаанд	3. Зорилтот гэр бүл, хүүхдүүд, ялангуяа нийгмийн үйлчилгээг авах боломж хязгаарлагдмал бүртгэлгүй өрхүүдэд сэтгэл зүйн зөвлөгөө, дэмжлэг, туслалцаа үзүүлэх	3.1 Гэр бүлийн хүчирхийлэлтэй, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой, албан ёсны бүртгэлгүй, нийгмийн үйлчилгээ авахад хязгаарлагдмал нөхцөл байдалд байгаа гэр бүлд зөвлөн туслах, нийгэмшүүлэх сургалт зохион байгуулах, хөршийн холбоог сайжруулах, мэргэшсэн хүний нөөцөөр хангах, үйлчилгээнд шаардлагатай зардлыг жил бүрийн улсын төсөвт суулгах;	ХНХЯ ГБХЗХГ ТББ-ууд

Олон нийтийн түвшин дэх эрсдэлт болон хамгаалагч хүчин зүйлс:			
<ol style="list-style-type: none"> Амьдарч буй орон нутагт нь хөдөлмөр эрхлэх боломж бага байгаа нь иргэдийг хөдөлмөр эрхлэх зорилгоор шилжилт хөдөлгөөнд орох, улмаар ХХГХ-ийн хохирогч болох эрсдэлийг нэмэгдүүлж байна (COVID-19 цар тахлын улмаас аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаа доголдон иргэд ажлын байраа алдахад хүргэж байна) Гэмт хэрэг, зөрчил гардаггүй, тайван орчинд амьдран суудаг иргэдтэй харьцуулахад гэмт хэрэг, халдлага гардаг газарт оршин суудаг иргэд ХХГХ-т өртөх эмзэг байдал өндөр байна. Амьдарч буй орон нутагт нь эрүүл мэнд, боловсрол, санхүүгийн үйлчилгээний хүртээмж хангалтгүй байх нь иргэдийн ХХГХ-т өртөх эмзэг байдлыг нэмэгдүүлж байна. 			
Богино хугацаанд	1. Орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлэх	<p>1.1 Орон нутаг бүрд ямар төрлийн ажлын байрууд нээлттэй байгаа, эсвэл цаашдаа хөгжүүлэх боломжтойг тодорхойлж, тэдгээр ажлын байранд шаардагдах ур чадварыг тодорхойлж, орон нутгийн иргэдийн хэчнээн хувь нь эдгээр ажлын байруудад оролцох боломжтой зэргийг тодорхойлох орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн шинжилгээ хийх;</p> <p>1.2 Нутаг дэвсгэрт нь үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагад орон нутгийн иргэдийг түлхүү ажиллуулах, ажлын байранд шаардлагатай ур чадварыг олгох сургалтуудыг Мэргэжлийн боловсролын байгууллагатай хамтран зохион байгуулах;</p>	Сум, дүүрэг, аймаг, нийслэлийн Засаг дарга, ИТХ ХНХЯ Аж ахуйн нэгж байгууллагууд Техникийн болон мэргэжлийн боловсролын байгууллагууд
	2. Ковид-19 цар тахлын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх	2.1 Үйлдвэрлэл, үйлчилгээ, мал аж ахуй эрхлэгчдэд үйл ажиллагаагаа сэргээхэд чиглэсэн барьцаагүй, хүүгүй, эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг болон санхүүгийн бус дэмжлэг, ажлын байр бий болгох, хадгалах, хамгаалах санаачилгыг дэмжих, зорилтот бүлгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах;	Сум, дүүрэг, аймаг, нийслэлийн Засаг дарга, ИТХ ХНХЯ Аймаг/дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс
Дунд хугацаанд	3. Зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх	<p>3.1 Эмнэлгийн тусламж үйлчилгээ авч чадахгүй байгаа иргэдийн судалгааг гарган хэрэгцээг тодорхойлох, шаардлагатай тусламж үйлчилгээг хүргэх, мэргэжлийн ёс зүйн алдаа гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор эмч мэргэжилтнүүдийн ХХГХ-ийн талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, өвчтөн болон эмнэлгийн аюулгүй байдлыг хангах ажлуудыг зохион байгуулах;</p> <p>3.2 Зорилтот бүлгийн иргэдэд санхүүгийн бүтээгдэхүүний талаарх ойлголт мэдлэгийг дээшлүүлэх, иргэд өөрийн онцлог хэрэгцээнд тохирсон санхүүгийн зөв бүтээгдэхүүнийг сонгон авах, санхүүгийн залилан мэхлэлтээс урьдчилан сэргийлэх, хадгаламжийг бүрдүүлэх, өр багасгах, хөрөнгийн зах зээлд оролцоход дэмжлэг үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах;</p>	Эрүүл мэндийн яам Бүх шатлалын эмнэлэг, төв (төрөлжсөн мэргэжлийн эмнэлэг, төв, бүсийн оношилгоо, эмчилгээний төв, эрүүл мэндийн төв, сумдын эмнэлэг, баг/хорооны өрхийн эмнэлэг гэх мэт) Сангийн яам Санхүүгийн зохицуулах хороо Арилжааны банкнууд
Урт хугацаанд	4. Иргэдийн ажиллаж, амьдрах таатай, тайван орчныг бүрдүүлэх	<p>4.1 Орон нутаг дахь гэмт хэргийн гаралтын бүсийг тогтоон иргэдэд мэдээллийг олон талт эх сурвалжуудаар өгөх, хяналт шалгалт хийх, гэмт хэргийг гаралтад нөлөөлж буй хүчин зүйлсийг тогтоох, тэдгээрийг бууруулах арга хэмжээг хорооны түвшинд идэвхжүүлэх;</p> <p>4.2 Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжих хөрөнгө оруулалт, төсөлд иргэдийн оролцох боломжийг нэмэгдүүлэх, иргэдийн саналд тулгуурлан аюулгүй, таатай орчныг бий болгох (гэрэлтүүлэг, дэд бүтэц);</p> <p>4.3 Орон нутагт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн үр нөлөөг дээшлүүлэх;</p>	Дэд зөвлөл ЦЕГ Сангийн яам Орон нутгийн хөгжлийн сан Сангийн яам ОУБ-ууд, ТББ-ууд

Бүтцийн түвшний эрсдэлт болон хамгаалагч хүчин зүйлс:

1. Үйл ажиллагааны түвшинд талуудын хамтран ажиллах байдал сайн хэдий ч бодлогын түвшинд алсын хараа, үйл ажиллагааны чиглэлээ уялдуулах байдал орхигдсон байна.
2. ХХГХ-ээр цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн хэргийн тоо, шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн тоон мэдээлэл харьцангуй их зөрүүтэй байна.
3. Хөдөлмөр мөлжлөгийн гэмт хэрэг Монгол Улсад үйлдэгдэж байгааг илтгэх баримтууд байгаа хэдий ч тус гэмт хэргийг илрүүлэх, хэргийг хянан шийдвэрлэх үйл ажиллагаа хангалтгүй явагдаж байна.
4. Эрэгтэйчүүд мөн ХХГХ-ийн хохирогч болох эрсдэлтэй байгаа хэдий ч цагдаагийн байгууллагад эрэгтэй хохирогч албан ёсоор бүртгэгдсэн тохиолдол байхгүй байна.
5. Дотооддоо Улаанбаатар хот, Өмнөговь, Дорноговь, Дорнод аймгууд нь ХХГХ-ийн эрсдэл өндөрт тооцогдож байгаа хэдий ч ХХГХ-тэй тэмцэх ЗГ-ын хүчин чармайлт зөвхөн Улаанбаатар хотод л төвлөрч байна.
6. Хэрэг мөрдөн шалгах ажиллагааны явцад хохирогч өмгөөллийн туслалцаа авах байдал хангалтгүй байна.
7. ХХГХ-ийн хохирогчид "Хууль зүйн туслалцаа үзүүлэх журам"-ыг яаралтай батлах, хохирогчдод учирсан сэтгэл санааны хохирлыг тооцох аргачлалыг боловсруулж батлуулах шаардлагатай байна.
8. ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр бүс нутгийн хамтын ажиллагаа нь хүний нөөцийг чадавхжуулах сургалт, сурталчилгааны чиглэлээр хязгаарлагдаж байна.

Богино хугацаанд	1. Хөдөлмөр мөлжлөг, албадан хөдөлмөрийн одоогийн чиг хандлага, нөхцөл байдлыг судлах	<p>1.1 ХХГХ-ийн хөдөлмөрийн мөлжлөгийн хэлбэрүүд, салбарын онцлогтой холбогдон гарч байгаа асуудлаар тандалт судалгаа хийх;</p> <p>1.2 ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр кампанит ажил, нөлөөллийн ажил зохион байгуулах, ялангуяа Хууль сахиулах байгууллагын албан хаагчдад эрэгтэйчүүдийн энэ төрлийн гэмт хэрэгт өртөх эрсдэлийг таниулах агуулгыг тусгах;</p>	<p>Дэд зөвлөл Мэргэжлийн хяналтын ерөнхий газар (МХЕГ),</p> <p>Судалгааны байгууллагууд, ОУБ-ууд, ТББ-ууд</p>
	2. Хүн худалдаалахтай тэмцэх дэд зөвлөлд шинээр төлөөлөл оруулах, гишүүдийн хамтын ажиллагааг сайжруулах	<p>2.1 Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5.9-д Мэргэжлийн хяналтын байгууллага нь аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагсдыг албадан хөдөлмөр, боолчлол, боолчлолтой ижил төстэй нөхцөлд ажиллуулж, байлгаж байгаа эсэхэд өөрийн бүрэн эрхийнхээ хүрээнд тавих хяналтыг тасралтгүй сайжруулах, иргэдийг хөдөлмөр мөлжлөгт өртүүлсэн кейс, тохиолдлуудад дүн шинжилгээ хийн хяналт шалгалт хийх стандарт, хяналтын хуудсыг шаардлагатай тохиолдолд шинэчлэн боловсруулдаг байх;</p> <p>2.2 Гадаадын иргэн харьяатын газар, Цагдаагийн байгууллага, Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газар, МХЕГ зэрэг төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, дүн мэдээ, мэдээлэл судалгаа солилцох, цахим мэдээллийн системтэй болох, хамтран хяналт шалгалт хийх боломжийг бүрдүүлэх;</p> <p>2.3 Оролцогч талуудын хүлээх үүрэг, тооцох хариуцлагыг тодорхой болгох. Ялангуяа эрүүл мэнд, боловсролын салбарын ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр хүлээсэн үүргийн биелэлтийг сайжруулахад анхаарах;</p> <p>2.4 Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн Хүн худалдаалах, соёлын өвийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх тасгийн орон тоог нэмэгдүүлэх, орон нутаг ажиллах, ялангуяа Өмнөговь, Дорноговь, Дорнод аймгууд дахь мөрдөгчдийг нэмэгдүүлэх;</p> <p>2.5 ХХГХ-тэй тэмцэх Дэд зөвлөлийн бүх гишүүд байгууллагуудад ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх, тэмцэх үүрэг бүхий бие даасан бүтэц, нэгж бий болгоход анхаарах;</p>	<p>Дэд зөвлөл Мэргэжлийн хяналтын ерөнхий газар</p>

		<p>2.6 Хилийн чанадад ХХГХ-ийн хохирогч болсон иргэдийг түргэн шуурхай, аюулгүй буцаан татахтай холбоотой олон талын хамтын ажиллагааг сайжруулахын тулд хилийн чанад дахь хохирогчийг илрүүлэх, эгүүлэн татах үйл ажиллагааг зохион байгуулах журам боловсруулах;</p> <p>2.7 Албан бус харилцааны механизмыг бий болгох замаар төр, төрийн бус байгууллагуудын мэдээллийн урсгал, солилцоог сайжруулах, уялдаа холбоог нэмэгдүүлэх;</p> <p>2.8 ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн бүрэлдэхүүнд Эс, эд эрхтэнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны төлөөллийг оруулах;</p>	
	<p>3. Хуулиар үүрэг хүлээсэн хууль сахиулах, прокурор, шүүх, хуульч, өмгөөлөгч зэрэг төрийн алба хаагчдыг чадавхжуулах</p>	<p>3.1 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны практикт нэгэнт нэвтэрсэн "Хохирогч төвтэй мөрдөн шалгах ажиллагаа явуулах аргачлал"-ын дагуу болон олон улсын сайн туршлагыг таниулах чиглэлээр хууль сахиулах, прокурор, шүүх эрх мэдлийн алба хаагчдыг бэлтгэх, давтан сургах;</p> <p>3.2 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хангалтгүй явагдахад хүргэж буй Хөдөлмөр мөлжлөг, албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийг илрүүлэх, хянан шийдвэрлэх, ял шийтгэл онооход тулгарч буй хүндрэл бэрхшээлийг тодруулах хуулийн шинжилгээ хийх;</p> <p>3.3 Нотолгоонд суурилсан стратегиар хөдөлмөр мөлжлөгийн хэргийн илрүүлэлт, мөрдөн байцаалт, хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг явуулах чиглэлээр хууль сахиулах байгууллагууд, прокурор, шүүхийн алба хаагчдад сургалтын стандарт хөтөлбөрт суурилсан чадавх бэхжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, сургагч багш нар бэлтгэх;</p> <p>3.4 Ажлын орчин дахь ХХГХ-ийн эрсдэлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хөдөлмөрийн байцаагч нар болон цагаачлалын албаны мэргэжилтнүүдийг чадавхжуулах, сургагч багш нар бэлтгэх;</p> <p>3.5 Хохирогчдод төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлдэг про-боно өмгөөлөгчдийн жагсаалтыг гаргах, хөдөлмөр мөлжлөгийн хохирогчдод өмгөөллийн туслалцаа үзүүлэх чиглэлээр чадавхжуулах;</p> <p>3.6 Хуулийн чиглэлээр их, дээд сургуульд суралцаж буй оюутан нарт ХХГХ-ийн талаар ойлголт мэдлэг олгох хөтөлбөрийн агуулгыг сайжруулах, судлах боломжоор хангах;</p> <p>3.7 Хөдөлмөр мөлжлөг, эд эрхтэний наймаа, зуучлалын захиалгат гэрлэлт зэрэг ХХГХ-ийн бусад төрөл хэлбэрийг илрүүлэх, таних чиглэлээр төр болон төрийн бус байгууллагын алба хаагчдыг мэргэшүүлэн сургах, сургагч багш нар бэлтгэх;</p> <p>3.8 Хууль сахиулах, прокурор, шүүхийн албан хаагчид болон хөрш улс орнуудын ижил төстэй албан хаагчдын дунд үндэстэн дамнасан мөрдөн шалгах ажиллагааны чиглэлээр хамтарсан сургалт зохион байгуулах;</p>	<p>Дэд зөвлөл БШУЯ ГХЯ Шүүхийн ерөнхий зөвлөл УЕПГ Дотоод хэргийн дээд сургууль Бусад хууль зүйн их, дээд сургууль</p>

		<p>3.9 Сэтгэлзүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх, заслын үйлчилгээ үзүүлэх чиглэлээр үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудыг чадавхжуулах сургалтыг тогтмол зохион байгуулах, мэргэшсэн хүний нөөцийг нэмэгдүүлэхэд анхаарах, хамгаалах байр, НЦҮТ-ийн мэргэжилтнүүдийн ХХГХ-ийн хохирогчтой ажиллах чадавхыг дээшлүүлэх;</p> <p>3.10 Зүүн Өмнөд Азийн орнууд дахь Монголын дипломат, консулын алба хаагчид, өргөмжит консулуудад ХХГХ-ийн хохирогчийг таних, илрүүлэх, нутаг буцаах, дамжуулах чиглэлээр чадавхжуулах сургалт зохион байгуулах;</p>	
Дунд хугацаанд	<p>4. Үндэстэн дамнасан гэмт хэрэгтэй холбоотой ялангуяа ХХГХ-ийн урсгал чиглэл, шинэ чиг хандлагын талаарх мэдээллийг бүртгэх нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх, жил тутам шинэчлэх</p>	<p>4.1 Цагдаа, шүүх, тагнуул, хилийн шалган нэвтрүүлэх алба зэрэг талуудыг оролцуулан ХХГХ-ийн урсгал чиглэлийг гэмт хэргийн төрөл хэлбэрүүдээр нарийвчлах криминологийн судалгаа хийх;</p> <p>4.2 ХХГХ-ийн шалтгаан, нөхцөл, эмзэг байршил, урсгал чиглэлийн мэдээллийг жил бүр шинэчлэн боловсруулж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөж, Дэд зөвлөлд танилцуулан, тодорхой шийдвэр гаргуулж байх;</p> <p>4.3 Цагдаа, шүүх, хил хамгаалах байгууллага, болон үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын мэдээлэлд үндэслэсэн ХХГХ-ийн кейсүүдийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэх, тогтмол шинэчлэх, хохирогчдын хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангахад онцгой анхаарах;</p>	<p>ЦЕГ, ХХЕГ, ГИХГ</p> <p>ЦЕГ, Эрүүгийн Цагдаагийн алба</p> <p>Дэд зөвлөл Үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд УЕПГ, ЦЕГ</p>
	<p>5. ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангах</p>	<p>5.1 ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх, ХХГХ-ийн бусад төрлүүд болох хөдөлмөр мөлжлөг, эд эрхтэний наймаа, хуурамч гэрлэлт, хүүхдийг худалдаалах гэмт хэргүүдийг таниулах кампанит ажил, аян, хэлэлцүүлэг, сургалт сурталчилгаа зэрэг нөлөөллийн ажлыг нийгмийн бүх түвшинд бүлгийн онцлогт тохируулсан арга аргачлалаар үе шаттай зохион байгуулах (залуу охид, эрэгтэйчүүд болон хөдөлмөр мөлжлөгийн хохирогч болох эрсдэлтэй бүлгийг чиглэх);</p> <p>5.2 ХХГХ-ийн эмзэг байршил, урсгал чиглэлийн мэдээлэлд тулгуурлан урьдчилан сэргийлэх ажлыг нэгдсэн бодлоготойгоор хэрэгжүүлэх;</p> <p>5.3 Хоол, энтертайнмент, зочид буудал зэрэг үйлчилгээний салбаруудад тавих хяналтыг сайжруулах замаар ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх мэдээлэл түгээх ажлыг зохион байгуулах;</p> <p>5.4 Хилээр нэвтрэх, буцах цэгүүдэд ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх санамж, зөвлөмж хэвлүүлэн тараах;</p>	<p>Дэд зөвлөл ЦЕГ ХХЕГ Үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд Хэвлэл мэдээллийн байгууллагууд</p>

	<p>6. ХХГХ-ийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх төсвийг улсын төсөвт тогтмол тусгах</p>	<p>6.1 Үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын чадавхад тулгуурлан хохирогч хамгааллын үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудад төсөв хуваарилах боломжийг судлах;</p> <p>6.2 Үйлчилгээний стандартад нийцсэн төрөлжсөн хамгаалах байрнуудыг байгуулах. Тух: эрэгтэй хохирогчид, насанд хүрээгүй хүнийг тусад нь байрлуулах байрыг бий болгох. Үйлчилгээ үзүүлэх болон үйлчилгээний арга зүй, стандартыг тогтоохдоо олон улсын жишиг арга зүйд нийцүүлэн боловсруулах, боловсруулах;</p> <p>6.3 НЦҮТ-ийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах, шаардлагатай нөөцөөр хангах, санхүүжилт олгох замаар ХХГХ-ийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх хувилбарыг судлах;</p> <p>6.4 ХХГХ үйлдэгдэх эрсдэл өндөр бүс нутаг, ялангуяа хилийн орчмын бүс нутагт хохирогч хамгааллын үйлчилгээг хөгжүүлэх;</p>	<p>Дэд зөвлөл Сангийн яам ЦЕГ</p>
<p>Урт хугацаанд</p>	<p>7. ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр эрх зүйн орчныг сайжруулах</p>	<p>Эрүүгийн хуульд дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулах:</p> <p>7.1 Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах замаар ХХГХ-ийн төрөл, хэлбэрийг бие даасан гэмт хэрэг болгож хуульчилсан байдлыг залруулж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эргэлзээтэй байдлыг бий болгохгүй байхын тулд хуулийн зүйл заалтуудыг тодорхой болгох;</p> <p>7.2 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль дахь “хохирогч”-ийн тодорхойлолтыг хохирогч төвтэй хандлагад үндэслэн Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн тодорхойлолттой нийцүүлэх;</p> <p>7.3 Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд хохирогчид анхан шатны туслалцааг хэн, хэрхэн үзүүлэх асуудлыг тодорхой зааж оруулах, оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг тодорхой болгох;</p> <p>7.4 Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 17 дугаар зүйлд уг хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх тухай заасан хэдий ч Зөрчлийн тухай хуульд энэ талаар огт тусгаагүй байгаа тул Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар бүлэгт “Хүн худалдаалахтай тэмцэх хууль зөрчих” бие даасан зөрчлийг нэмж, хуулиар үүрэг хүлээсэн этгээдэд хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг бий болгох;</p> <p>7.5 Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлд заагдсан хохирогчийн сэтгэл санааны хохирлыг тооцох аргачлалыг боловсруулан батлуулах;</p> <p>7.6 Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч нарын ААНБ, ажлын байранд гэнэтийн хяналт шалгалт хийх эрхийг Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 162.2.1 дэх заалттай уялдуулан Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон холбогдох журамд тусгах;</p> <p>7.7 Албадан хөдөлмөрийг тодорхойлсон хуулийн тодорхойлолтыг эргэн харж зөрчилтэй, буруу ойлголт төрүүлэхүйц найруулга, агуулгыг сайжруулах;</p>	<p>Дэд зөвлөл Хүний Эрхийн Үндэсний Комисс Жендэрийн үндэсний хороо</p>

	<p>7.8 Донорын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2018 оны 01 дүгээр сарын 19-нд батлагдсантай холбоотойгоор Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд “эд, эрхтэнийг авах...” гэсний өмнө “эс” гэж нэмэх;</p> <p>7.9 Хохирогчид үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах эрхийг зохицуулсан журмыг боловсруулах;</p> <p>7.10 Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоход чиглэсэн олон улсын гэрээ конвенцод нэгдэн орох чиглэлээр хамтран ажиллах, судалгаа хийх. Тухайлбал, “Олон Улсын хэмжээнд хүүхэд хулгайлахтай холбогдон үүсэх иргэний асуудлын тухай конвенц” хэрэгжилтийг хангахын тулд үндэсний эрх зүйн баримт бичгүүдийг уялдуулахад хамтран ажиллах;</p>	
8. Бүс нутгийн хамтын ажиллагааг бэхжүүлэх	<p>8.1 ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр олон улсын болон бүс нутгийн хамтын ажиллагааг сайжруулах, дэмжлэг үзүүлэх</p> <p>8.2 ХХГХ-тэй тэмцэхэд чиглэсэн олон улсын байгууллагуудын Монгол Улсад өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд чиглэсэн нөлөөллийн ажлыг иргэдийн оролцоонд тулгуурлан хийх;</p>	ГХЯ Дэд зөвлөл
9. Зарим улс оронтой эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээ байгуулах	<p>9.1 Монгол Улсын иргэд ХХГХ-ийн хохирогч болсон Норвеги, Швед, Бельги, Камбож, Герман, Хонконг, Япон, Малайз, Филиппин, АНУ зэрэг улсуудтай Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээг байгуулах;</p> <p>9.2 Хилийн чанадад ХХГХ-ийн хохирогчид илэрсэн тохиолдолд эх орондоо эгүүлэн авчрах ажлыг удирдан зохион байгуулах, салбар дундын уялдааг хангах;</p>	ГХЯ Дэд зөвлөл
10. Бүртгэлгүй дотоодын шилжин ирэгчдийн эмзэг байдлыг буруулах	<p>10.1 ОУШХБ-аас гүйцэтгэсэн “Улаанбаатар хотын шилжилт хөдөлгөөний хязгаарлалтын үр нөлөө болон шилжин суурьшигчдын эмзэг байдлын судалгаа” болон түүнтэй ижил төстэй судалгааны үр дүнд тулгуурлан дотоод шилжилт хөдөлгөөнийг үр дүнтэй зохицуулах урт хугацааны шийдлүүдийг боловсруулж хэрэгжүүлэх;</p> <p>10.2 Бүртгэлгүй шилжин ирэгсдийн эмзэг байдлыг буруулах, тэдгээр иргэдэд чиглэсэн хорооны түвшний хяналт, сургалт, холбон зуучлах үйлчилгээг чиглүүлэх, шинээр ирсэн газраа дасан зохицох хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөршийн холбоог сайжруулах.</p>	Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар Аймаг, дүүргийн ЗДТГ-ууд

Ашигласан материалын жагсаалт

Мэдээллийн сан (ҮСХ)

- 2019–2020 Үндэсний статистикийн хороо (ҮСХ). Эх сурвалж: www.1212.mn
Хүн ам, өрхийн бүртгэлийн мэдээлэл, ҮСХ, 2019–2020. Эх сурвалж: [Хүн ам \(1212.mn\)](http://www.1212.mn)
Насанд хүрэгчдийн бичиг үсэг тайлагдалтын түвшин. Эх сурвалж: http://1212.mn/tables.aspx?TBL_ID=DT_NSO_0400_068V1
- 2010 Монгол Улсын хүн ам, орон сууцны тооллого. Brian J. Grim et al-д тэмдэглэгдсэн өгөгдөл. *Олон улсын шашны демографийн жилийн эмхэтгэл* 2014. BRILL, 2014. Хуу 152.
- 2019 *Монголын ядуурлын төрх*, ҮСХ, Дэлхийн банк
- 2020 Тус суурь судалгаанд зориулан бэлтгэж өгсөн албан бичиг, Эрүүгийн цагдаагийн алба, ЦЕГ, 2020 оны 8 сарын 20-ны өдөр
- 2020 “Гэр бүлийн хүчирхийлэл” статистикийн тойм судалгаа, ҮСХ, ЦЕГ
- 2020 *Монгол улсын боловсролын статистикийн өнөөгийн байдал*, ҮСХ

Хууль, тогтоомж

- 1930 ОУХБ-ын Албадан Хөдөлмөрийн тухай 1930 оны 29 дүгээр Конвенц
- 2005 ОУ-ын хүний эрхийн хууль, хүмүүнлэгийн тухай хуулийг ноцтой зөрчсөний төлөө хохирогчийн эрхийг сэргээх үндсэн зарчим, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн шийдвэр 60/147, 2005, Y-8. Эх сурвалж: [OHCHR | Basic Principles and Guidelines on the Right to a Remedy and Reparation](http://www.unhcr.org/refugees/article/49c49626.html)
- 2006 “Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”, Засгийн газрын 263 дугаар тогтоол
- 2013 “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх журам” Гадаад харилцааны сайдын 2013 оны А/91-р тушаал
- 2013 “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод сэтгэцийн нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ үзүүлэх журам”, Эрүүл мэндийн сайдын 2013 оны 462-р тушаал
- 2013 “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэх журам”, Хөдөлмөрийн сайдын 2013 оны А/142 тоот тушаал
- 2014 Хууль зүйн сайдын А/114 дүгээр тушаал
- 2014 Хууль зүйн сайдын А/112 дугаар тушаал
- 2014 Хууль зүйн сайдын А/113 дугаар тушаал
- 2014 Эрүүл мэндийн сайд, Хууль зүйн сайдын хамтарсан 2014 оны А/356, А/182 дугаар тушаал
- 2015 Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/135 тоот тушаал
- 2015 “Гэрч, хохирогчийг хамгаалах туслалцаа үзүүлэх үндэсний хөтөлбөр”, 346-р тогтоол
- 2016 Засгийн газрын 204 дүгээр тогтоол
- 2016 Донорын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн танилцуулга
- 2017 “Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр”, Засгийн газрын 48-р тогтоол
- 2019 ХХГХ-ийн хохирогчид нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага (MNS 6418:2013), Стандарт, хэмжил зүйн газар

- 2020 *Цагдаагийн байгууллагын хөгжлийн хөтөлбөр, Засгийн газрын 141-р тогтоолын хавсралт*
- 2020 УЕПГ-ын 9/5472 дугаартай албан бичиг
- 2019 Төрийн мэдээллийн эмхэтгэл, №42
- 2012 Төрийн мэдээллийн эмхэтгэл, №7

Судалгааны тайлан, материал

- Эрүүгийн хэргийн төв архивт хадгалагдаж буй эрүүгийн хэргийн материалууд
3Ps: Хэрэг хянан шийдвэрлэх, Хохирогч хамгаалал, Урьдчилан сэргийлэх, АНУ-ын Төрийн департамент. Эх сурвалж: <https://www.state.gov/3ps-prosecution-protection-and-prevention/>
- 2007 *"Хүн худалаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх шууд тусламжийн гарын авлага"* ОУШХБ, НҮБ-ын Хүүхдийн сан, ХТЭТ, Улаанбаатар хот.
- 2007 *Хүн худалдаалах гэмт хэргийн шийдвэрлэлт: Хавтас хэргийн судалгаа, Хууль зүйн үндэсний хүрээлэн*
- 2008 *"Монголын уурхайн газар дах биеэ үнэлэлт ба хүний наймаа"* судалгаа, Азийн сан. Эх сурвалж: [All publications | The Asia Foundation](#)
- 2010 *"Монгол Улс дах хүн худалдаалах гэмт хэргийн зураглал"* тайлан, хуудас 23, Б.Батзориг,
- 2010 *"Монгол улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн зураглал"*, ХТЭТ, Улаанбаатар хот
- 2010 *"Биеэ үнэлэгч болон бэлгийн мөлжлөгт өртсөн хүүхдийн судалгаа"*, ҮСХ, ОУХБ
- 2014 *Монгол улс дахь жендэрийн эрх тэгш байдал: Нөхцөл байдлын товч үнэлгээ, баримт бичгийн судалгаа, ШХА, IRIM*
- 2016 *"Монгол Улсын хүчин төгөлдөр хууль, холбогдох захиргааны хэм хэмжээний актад тусгасан төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллагаас шийдвэр гаргахад иргэдийн оролцоог хангах аливаа зохицуулалтын өнөөгийн хэрэгжилтийн байдалд хийсэн үнэлгээний тайлан"*, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газар, ШХА
- 2017 *"Уул уурхайгаас үүдсэн шилжилт хөдөлгөөн, хүүхдэд үзүүлэх нөлөөлөл"*, НҮБ-ын Хүүхдийн сан
- 2017 НҮБ-ын Хөгжлийн тусламжийн хүрээ 2017-2021 Монгол улс
- 2017 *"Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хохирогч төвтэй аргачлалыг хэрэглэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж болон сургалтын гарын авлагыг харьцуулах, албан хаагчдыг чадавхыг үнэлэх судалгааны тайлан"*, ХЗДХЯ, Азийн сан, ХТЭТ,
- 2018 *"Өсөлтийг хангах төсвийн орон зай. Улсын хөрөнгө оруулалтын үр өгөөж"*, Монгол Улсын эдийн засгийн мэдээлэл.
- 2018 *"Монгол Улс, Хүн амын дотоод шилжих хөдөлгөөний судалгаа"*, ОУШХБ. Эх сурвалж: [mongolia_internal_migration_study.pdf \(iom.int\)](#)
- 2018 *"Ядуурлын дүр төрх"*, ҮСХ, Дэлхийн банк
- 2018 *"Хүн худалдаалах гэмт хэргийн дэлхийн тайлан"*, НҮБ-ын Гэмт хэрэг, мансууруулах бодистой тэмцэх газар (UNDOC), Нью Йорк хот. Эх сурвалж: [GLOTIP_2018_BOOK_web_small.pdf \(unodc.org\)](#)
- 2018 *"ХХГХ-ийн хохирогч төвтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гарын авлага"*, ХЗДХЯ, АНУ-ын Төрийн департамент, ХСИС, Азийн сан, УБ.
- 2018 *"Хотод шилжин ирэгсдийн эмзэг байдлын судалгаа"*, ОУШХБ,

- 2019 *"2012-2016, 2017-2021 оны хөтөлбөрүүдийн хүртээмжтэй суурь боловсролын үнэлгээ", НҮБ-ын Хүүхдийн сан. Эх сурвалж: [2019 Mongolia: Evaluation of Inclusive Basic Education in the UNICEF Country Programmes 2012-2016 and 2017-2021 | UNICEF Global Development Commons](#)*
- 2019 *"Хүний хөгжлийн тайлан", НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр*
- 2019 *"Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээний тайлан", ХЗДХЯ, SICA, УБ*
- 2019 *"Хүний эрхийн төлөв байдлын ээлжит дүгнэлт, хэлэлцүүлэг, мэдээллийн хуудас", Эх сурвалж: http://www.upr-mongolia.mn/images/xupld/201910/Humantrafficking_UPR.pdf*
- 2019 *"Дамжин өнгөрөх ажиглалт төслийн тайлан", Unbound*
- 2019 *"Хүн худалдаалах төлөв байдлын тайлан", АНУ-ын Төрийн департамент. Эх сурвалж: <https://mn.usembassy.gov/our-relationship/official-reports/2019-trafficking-persons-report/>*
- 2019 *"МУ-ын жендэрийн нөхцөл байдлын дүн шинжилгээ 2005 оноос өнөөг хүртэлх ололт амжилт ба сорилт, сургамж" судалгаа, Жендэрийн үндэсний хороо, ХНХЯ, АХБ*
- 2019 *Авлигын төсөөллийн индексийн 2019 оны үр дүн. Эх сурвалж: <https://www.iaac.mn/news/awligiin-tusuulliin-indeksiin-2sh19-onii-ur-dun#>*
- 2019 *"Биеэ үнэлэлт болон бэлгийн мөлжлөгт өртөх эрсдэл: Судалгааны тайлан", ХНХЯ, ХТЭТ*
- 2019 *Хүчирхийлэл, мөлжлөгт өртөмтгий шилжилт хөдөлгөөнд оролцогчдыг хамгаалах, тусламж үзүүлэх гарын авлага, ОУШХБ, Женев. Эх сурвалж: <https://publications.iom.int/books/iom-handbook-migrants-vulnerable-violence-exploitation-and-abuse> IOM Handbook on Protection and Assistance for Migrants Vulnerable to Violence, Exploitation and Abuse. IOM, Geneva.*
- 2020 *Тоолоогүйг тоолсон нь – Малчин өрхийн судалгаагаар нэг ч хүнийг орхигдуулахгүй хамруулсан тухай, Дэлхийн банк. Эх сурвалж: [Counting the uncouted – How the Mongolian nomadic survey is leaving no one behind \(worldbank.org\)](#)*
- 2020 *"Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан", АНУ-ын Төрийн департамент*
- 2020 *"Шилжилт хөдөлгөөний нэр томъёо", ОУШХБ. Эх сурвалж: www.iom.int/key-migration-terms. IOM Key Migration Terms section.*

Нэр томьёоны жагсаалт

	Нэр томьёо	Тайлбар
1.	Хүн худалдаалах гэмт хэрэг/Хүний наймаа	Монгол Улсын Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 3.1.1-д “Хүнийг биеийг нь үнэлүүлэх, бусад хэлбэрээр бэлгийн мөлжлөг, хүчирхийлэлд оруулах, боолчлох, түүнтэй ижил төстэй нөхцөлд байлгах, хууль бусаар албадан хөдөлмөрлүүлэх, эс, эд эрхтэнийг нь авч ашиглан мөлжих зорилгоор хүнд хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх, хулгайлах, залилах, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах, эмзэг байдлыг нь далимдуулах, түүнчлэн өөр хүнийг хяналтдаа байлгаж байгаа этгээдийн зөвшөөрлийг авахын тулд төлбөр төлөх, хахуульдах аргаар хүнийг элсүүлсэн, тээвэрлэсэн, нуун далдалсан, дамжуулсан, хүлээн авсан хууль бус үйлдлийг” хүн худалдаалах гэж тодорхойлсон. Энэхүү заалтыг 2018 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн хуулиар нэмэлт оруулсан.
2.	Албадан хөдөлмөрлүүлж мөлжих	Монгол Улсын Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ийн 13.13 дугаар зүйлд “Бусдад хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, илт хохиролтой болзол, нөхцөл тулгаж, эсхүл хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулан эрхшээлдээ оруулж цалин хөлсгүй хөдөлмөр эрхлүүлсэн” үйлдлийг албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан.
3.	Аймаг	Монгол Улсын дээд түвшний засаг захиргааны нэгж. Одоогийн байдлаар Монгол Улс нийт 21 аймагтай. Аймгууд нь сумдад хуваагддаг.
4.	Баг	Орон нутгийн засаг захиргааны хамгийн бага нэгж. Сумд нь багт хуваагддаг.
5.	Банк, санхүүгийн үйлчилгээ	Хадгаламж, зээл, карт, цахим банкны үйлчилгээ, гадаад төлбөр тооцоо, даатгал, батлан даалт, үнэт зүйл хадгалах, хувьцаа, бонд, хөрөнгө оруулалт, валют арилжаа, барьцаа хөрөнгө зэрэг үйл ажиллагааг багтаан ойлгоно.
6.	Бүртгэлгүй шилжин ирэгч	Сүүлийн 3 жилийн хугацаанд орон нутгаас хот руу чиглэсэн шилжилт хөдөлгөөн орсон хэдий ч одоо амьдарч буй орон нутагтаа түр болон байнгын оршин суугчаар албан ёсоор бүртгүүлээгүй иргэд
7.	Бэлгийн цөөнх	Хүн өөрийн бэлгийн чиг баримжаа болон хүйсийн баримжаа, илэрхийллийн хувьд цөөнх болсон хүмүүсийг хэлнэ. ЛГБТИК + гэдэг нь бэлгийн цөөнхийг нэрлэх олон улсын нэр томьёоны товчлол юм.
8.	Бэлгийн мөлжлөг	Монгол Улсын Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ийн 12.3 дугаар зүйлд “Хохирогчид хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж; эд хөрөнгө, албан тушаал, бусад нөхцөл байдлын улмаас эрхшээлдээ байгаа байдлыг далимдуулан зорчих эрхийг хязгаарлахгүйгээр бусадтай бэлгийн харьцаанд албадан оруулсан” үйлдлийг Бэлгийн мөлжлөгийн гэмт хэрэг хэмээн хуульчилсан.
9.	Ган, зуд	Цаг уурын нөхцөл байдлаас шалтгаалан бэлчээрлэх боломжгүйгээс мал ихээр хорогдоход хүрдэг байгалийн гамшгийн нэг төрөл. Өвлийн улиралд цас орохгүйгээс, зуны цагт бороо хургүйгээс малын бэлчээр бүрдэхгүйгээс шалтгаалдаг.
10.	Гэр	Монгол үндэстний уламжлалт сууц
11.	Гэр бүлийн хүчирхийлэл	Монгол улсын Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 5.1.1-д зааснаар 5.1.1. “гэр бүлийн хүчирхийлэл” гэж энэ хуулийн 3 дугаар зүйл ¹⁵⁵ -д заасан этгээд энэ хуулийн үйлчлэлд хамаарах хүний сэтгэл санаанд дарамт учруулах, эдийн засаг, бэлгийн эрх чөлөө, бие махбодод халдсан үйлдэл, эс үйлдэхгүйг хэлнэ гэж заасан.

¹⁵⁵ 3.1.1.эхнэр, нөхөр, гэр бүлийн бусад гишүүн, хамтран амьдрагч, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, тэдгээрийн асрамж, хамгаалалтад байгаа этгээд, тухайн гэр бүлд хамт амьдарч байгаа этгээд;

3.1.2.тусдаа амьдарч байгаа төрүүлсэн, үрчлэн авсан хүүхэд, төрсөн, үрчлэн авсан эцэг, эх, ах, эгч, дүү.

3.2.Энэ хуулийн зохицуулалтад гэрлэлтээ цуцлуулсан эхнэр, нөхөр, хамтран амьдарч байсан, эсхүл хамтран амьдарч байгаагүй ч гэр бүлийн харилцаатай байсан, дундаасаа хүүхэдтэй этгээд нэгэн адил хамаарна.

12.	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил	Монгол улсын Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 3.1-т "Гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээллийг судалсны үндсэн дээр гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхэд нөлөөлж байгаа шалтгаан, нөхцөл, хүчин зүйлсийг тогтоож, түүнийг арилгахад чиглэсэн эдийн засаг, нийгэм, эрх зүйн болон зохион байгуулалтын бусад арга хэмжээний нийлбэр цогц мөн" гэж заасан.
13.	Дотоод шилжилт хөдөлгөөн	Шинээр суурьших зорилгоор тухайн улс дотроо нэг засаг захиргааны нэгжээс өөр засаг захиргааны нэгж рүү шилжин суурьшиж буй хүмүүсийн хөдөлгөөн. Шилжин суурьших хөдөлгөөн нь түр болон бүрмөсөн байж болно. Дотоодын шилжин суурьшигчид нь шилжилт хөдөлгөөнд оролцдог боловч тухайн улс орныхоо хил хязгаар дотор шилжин суурьшдаг. Энэхүү ойлголтод улс дотоодод шилжин суурьшиж буй Монгол Улсын иргэд болон бусад үндэстний иргэдийг мөн адил хамруулж авч үзнэ.
14.	Иргэний бүртгэл	Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу иргэний оршин суугаа хаягаар Иргэний улсын бүртгэлийн мэдээллийн санд бүртгүүлэх үйл явц. (Монгол, Төрийн ордон, 2018)
15.	Мөлжих	Хэн нэгний эрх ашгийн төлөө бусдыг шударга бусаар ашиглах (IOM: 2020).
16.	Нийгмийн үйлчилгээ	Төр, иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын оролцоотойгоор өрх, иргэнд дэмжлэг туслалцаа, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг хэлнэ. Уг тодорхойлолтын хүрээнд тус судалгаанд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамж, хамгаалал болон санхүүгийн үйлчилгээг зэргийг нийгмийн үйлчилгээнд хамааруулж авч үзсэн.
17.	Оюутан	Суурь болон бүрэн дунд боловсролтой болж, мэргэжлийн сургалт, коллеж, их дээд сургуульд элсэн боловсролын зэрэг горилон суралцаж буй иргэнийг хэлнэ.
18.	Орлогын эх үүсвэр	Гүйцэтгэсэн ажлын хөлс цалин, бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд борлуулсан орлого, өрхийн бизнесийн орлого (газар тариалан, мал аж ахуй) тэтгэвэр, тэтгэмж болон бусад хэлбэрээр өрхийн орлогыг бүрдүүлж буй эх үүсвэрүүд бүгд багтана.
19.	Өмгөөллийн үйл ажиллагаа	Монгол улсын Өмгөөллийн тухай хуулийн 6.1.1-т "Өмгөөлөгчөөс үйлчлүүлэгчийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор үзүүлж байгаа хууль зүйн мэргэжлийн туслалцаа, үйлчилгээг" өмгөөллийн үйл ажиллагаа гэж тодорхойлсон.
20.	Хүний эд, эрхтэний наймаа	Монгол Улсын Донорын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 3.1.1 дүгээр зүйлд "хүний эрхтэн, эрхтэний хэсэг, эс болон эдийн нийлмэл бүрдлийг" хүний эс, эд, эрхтэн гэж тодорхойлсон бөгөөд Монгол Улсын Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-д хүний цус эд, эрхтэнийг хууль бусаар авах гэмт хэргийг хуульчилж өгсөн.
21.	Хохирогч	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 3.1.2-т "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэсэн, хохирогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаалан хүн худалдаалахын улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсөн хүнийг " хохирогч гэж тодорхойлсон.
22.	Эрсдэлт түвшний иргэд	Бэлгийн мөлжлөг, хөдөлмөрийн мөлжлөг, эд эрхтэний наймаа зэрэг ХХГХ-ийн төрлүүдэд өртсөн, эсвэл өртөх магадлалтай иргэдийг тодорхойлох шалгуурыг (Хавсралт 2) хангасан судалгаанд оролцогчид
23.	Эмзэг байдлын загвар	Хүчирхийлэл, дарамт, хөдөлмөрийн мөлжлөгт өртөх эрсдэлтэй, өртсөн иргэдийг тодорхойлох, хамгаалах, туслах, тэдгээр иргэдийн эмзэг байдлыг бууруулахад чиглэсэн интервенц боловсруулж, хэрэгжүүлэхэд чиглэсэн ОУШХ-ын боловсруулсан загвар юм. Уг загварын дагуу иргэдийн эмзэг байдлыг нэмэгдүүлж буй эрсдэлт хүчин зүйлс эрсдэлийг даван туулах чадварыг нэмэгдүүлдэг хамгаалалтын хүчин зүйлүүдийг хувь хүн, өрх, гэр бүл, олон нийт, болон бүтцийн түвшинд авч үздэг.

24.	Статистик ач холбогдол	Судалгааны үр дүн нь түүврийн эсвэл хувьсагчуудын санамсаргүй шинж байдлаас үүдэн гарч ирсэн эсэхийг шалгах, хамааран болон үл хамааран хувьсагч хооронд бодитой хамаарал бий эсэхийг шалгадаг. Өгөгдсөн таамаглал нь батлагдаж буй эсэхийг хувьсагчийн р-утгад үндэслэн тооцдог.
25.	Сум	Монгол Улсын орон нутаг дахь засаг захиргааны 3-р шатлалын нэгж. Нэг сумд ойролцоогоор 5000 хүн ноогддог.
26.	Улирлын чанартай ажил эрхлэгч/шилжин суурьшигч	Улирлын онцлогоос хамаарч жилийн тодорхой хугацаанд л ажил, үйлчилгээ эрхэлдэг хүнийг/шилжин суурьшигчийг хэлнэ. ¹⁵⁶
27.	Үйлчилгээ үзүүлэгч	ХХГХ-ийн хохирогчийг эргэн нийгэмшүүлэх, нөхөн сэргээх, дасан зохицож эргэн хэвийн амьдралд ороход шаардлагатай нийгэм, сэтгэл зүйн, эрүүл мэндийн, болон хууль эрх зүйн туслалцаа, хамгаалалтын үйлчилгээг цогцоор үзүүлдэг, үйлчилгээ үзүүлэх чадавхтай, энэ чиглэлд мэргэшсэн, тусгай зөвшөөрөлтэй төрийн болон төрийн бус байгууллага (ТББ)
28.	Хагас цагаар ажил эрхлэгч	Хөдөлмөрийн болон ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ байгуулан ажиллаж, хөдөлмөрийн харилцаа нь Хөдөлмөрийн тухай болон Иргэний хуулиар зохицуулагддаг. Долоо хоногийн ажлын 8 цагаас бага хугацаагаар ажиллаж, цалин хөлс, орлого олдог, татвар, нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогч болон өөрөө хариуцан төлдөг ажиллагчийг ойлгоно.
29.	Хамгаалагч хүчин зүйлс	ХХГХ-т өртөмтгий байдлын индексэд эергээр нөлөөлж буй буюу индексийн тоон утгыг бууруулж буй, статистикийн хувьд ач холбогдолтой болох нь батлагдсан хамааран хувьсагч хүчин зүйлс.
30.	Хороо	Монгол Улсын нийслэл, Улаанбаатар хотын засаг захиргааны нэгж. Улаанбаатар хот нь 9 дүүрэг, тэдгээр нь 152 хороонд хуваагддаг.
31.	ХХГХ-т өртөмтгий байдлын индекс	ХХГХ-т өртөх эмзэг өртөмтгий байдлыг илэрхийлэх тоон үзүүлэлт. Индекс утга нь 0-1-ын хооронд хэмжигдэнэ. ХХГХ-ийн аль нэг элементэд дор хаяж нэг удаа өртөж байсан бол 1, огт өртөж байгаагүй бол 0 гэсэн утгыг илэрхийлнэ.
32.	ХХГХ-ийн хохирогч хүүхэд/ Худалдагдсан хүүхэд	Хүч хэрэглэх, хууран мэхлэх, эрх мэдлээ урвуулан ашиглах болон хүчирхийллийн бусад хэлбэрийг ашиглаагүй ч гэсэн тухайн улс дотор болон гадаадад мөлжлөгт ашиглах зорилгоор элсүүлэн, тээвэрлэсэн, шилжүүлсэн, байрлуулсан эсвэл хүлээн авах процессийг дамжсан 18 насанд хүрээгүй хүн (Haldorsson et al, 1997).
33.	Хөгжлийн бэрхшээлтэй хүн	ХБХ-ий эрхийн тухай хуулийн 4.1.1-д заасны дагуу Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэгт бие махбодь, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хэлнэ.
34.	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа	Монгол улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 4.1-т " хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол болон бусад байдал, хуулийн этгээдийг өмчийн хэлбэр, эрх хэмжээгээр нь ялгаварлахгүй эрх тэгш байх зарчимд үндэслэн явагдана" гэж заасан.

¹⁵⁶ Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой нэр томъёоны тайлбар, ОУШХБ, 2019 (https://publications.iom.int/system/files/pdf/iml_34_glossary.pdf)

35.	Шилжилт хөдөлгөөн	<p>Олон улс хооронд хил дамнан эсвэл улс дотооддоо засаг захиргааны нэгж доторх хувь хүмүүс эсвэл бүлэг хүмүүсийн шилжих хөдөлгөөн³. Шилжилт хөдөлгөөн нь түүний үргэлжлэх хугацаа, бүтэц, шалтгаанаас хамааран ямар ч хэлбэрээр явагдаж болно. Тухайлбал, дүрвэх, иргэдийг нүүлгэн шилжүүлэх, тодорхой эдийн засгийн болон бусад зорилго шалтгаантайгаар (гэр бүлтэйгээ эргэн нэгдэх г.м) шилжин нүүх зэрэг.</p> <p>Шилжилт хөдөлгөөн нь мөн мөлжлөг болон хүн худалдаалах гэмт хэрэг зэрэг гэмт хэрэгтэй холбогддог. Хүмүүс эх нутаг, аялаж буй, дамжин өнгөрч буй, нэвтрэн орж буй улс орны баримталж хууль журмын дагуу хууль ёсны дагуу шилжилт хөдөлгөөнд орохоос гадна, орхиж буй болон нэвтэрч буй, хүлээн авч буй улсад мөрдөгддөг дүрэм журмаас гадуур хууль бусаар шилжих хөдөлгөөнд орж байдаг.</p>
36.	Шилжилт хөдөлгөөний түүх	Нэг байршлаас нөгөө газар руу шилжсэн, шилжилт хөдөлгөөний байршлын чиглэл, хөдөлгөөнийг хэлнэ.
37.	Шилжилт хөдөлгөөний зорилго	Шилжилт хөдөлгөөн хийхэд хүргэж буй гол хүчин зүйл. Шилжилт хөдөлгөөний зорилго нь олон янз байж болох ба ихэнх тохиолдолд иргэд суралцах, ажил эрхлэх, эдийн засаг, амьжиргааны нөхцөл байдлаа сайжруулах, нийгмийн үйлчилгээ авах хэрэгцээ шаардлага, хүсэл зорилгын үүднээс шилжилт хөдөлгөөнд ордог.
38.	Эрсдэлт хүчин зүйлс	ХХГХ-т өртөмтгий байдлын индексэд сөргөөр нөлөөлж буй буюу индексийн тоон утгыг нэмэгдүүлж буй, статистикийн хувьд ач холбогдолтой болох нь батлагдсан хамааран хувьсагч хүчин зүйлс
39.	Эргэн нийгэмшүүлэх	ХХГХ-ийн хохирогчийг өмнө нь амьдарч байсан орон нутагт нь эргэн нийгмийн харилцаанд хэвийн оруулахын тулд, найз нөхөд, хамаатан садан, хөршүүдийн дунд харилцаа үүсгэж, эдийн засаг болон иргэний нийгмийн үйл ажиллагаанд оролцоотой байлгах замаар эргэн нийгмийн хэвийн амьдралд оруулахад чиглэсэн үйл ажиллагаа
40.	Эмзэг шилжин суурьшигч	Шилжин суурьших үйл явцынхаа хүрээнд хүчирхийлэл, мөлжлөг, дарамтад өртөж, хувь хүн, өрх/гэр бүл, олон нийт, бүтцийн түвшний хүчин зүйлсийн харилцан үйлчлэлийн үр дүнд тухайн эрсдэлээс зайлсхийх, эсэргүүцэх, даван туулах, нөхөн сэргэх чадвар нь хязгаарлагдмал нөхцөлд орсон шилжин суурьшигч хувь хүн эсвэл бүлэг иргэд.

¹⁵⁷ ОУШХБ-ын үндсэн баримт бичиг, 2019.

Хавсралт 1. Ажлын даалгавар

CALL FOR PROPOSALS

Baseline assessment into the causes, dynamics, vulnerability and resilience levels to trafficking in Mongolia

The International Organization for Migration (IOM) invites proposals for a baseline assessment into the underlying causes, dynamics, vulnerability and resilience levels to trafficking in Mongolia. Interested research centres and non-governmental organizations must submit a profile and a Research Proposal in accordance with the guidance provided in this Call for Proposals.

1. Research description

This baseline assessment will look into the underlying causes, dynamics, vulnerability and resilience levels to trafficking in Mongolia to produce policy and programme recommendations for the government and NGOs. Linkages between internal migration and TIP will be further assessed to provide a common foundation on which to base prevention and protection activities, filling a significant knowledge gap on trafficking in persons in Mongolia to inform the future counter-trafficking programming¹⁵⁸. The selected research institution/NGO will conduct the baseline assessment in close coordination with IOM and under IOM technical support. The findings will lead to the publication and dissemination of a report.

2. Research Objective

The baseline assessment will be guided by the following objectives:

- Explore socio-economic, political and other contextual factors that create vulnerability and resilience to human trafficking in Mongolia, using the IOM Determinants of Vulnerability model¹⁵⁹;
- Identify priority programmes and policy interventions that may be effective in combating external and internal trafficking for forced labour and sexual exploitation;
- Outline TIP routes, trends and patterns within and outside Mongolia;
- Explore the support needs of people who have experienced trafficking from and within Mongolia.
- Identify specific needs of vulnerable groups including female VoTs and children.

2. Research questions

In pursue of the above objectives, the baseline assessment will seek to answer to the following questions:

- Why people in Mongolia are vulnerable to human trafficking?
- Based on the IOMs Determinants of Vulnerability model, how its risk and protective factors across the four different levels work in the context of cases of human trafficking in Mongolia?

¹⁵⁸ The last initiative to generate trafficking related data was conducted under MoJHA in 2018. However, the poor quality of surveys focused on basic knowledge on human trafficking did not bring any added value to counter-trafficking initiatives in the country.

¹⁵⁹ The determinants of migrant vulnerability model was developed to identify, protect and assist migrants who have experienced or are vulnerable to violence, exploitation and abuse before, during or after migrating, and to guide the development and implementation of interventions to reduce such vulnerability. It considers both risk factors (which contribute to vulnerability) and protective factors (which improve capabilities to avoid, cope with or recover from harm), and the way that the two interact, based on 4 dimensions: individual factors, household and family factors, community factors and structural factors. This model is similar to the ecological model developed by Urie Bronfenbrenner in The Ecology of Human Development (Harvard University Press, 1979).

- How VoTs are trafficked from and to Mongolia? What are the main trafficking routes and patterns?
- What kind of assistance is required by people who have experienced trafficking within Mongolia or have returned from abroad after a trafficking experience?
- What are the gaps, areas of intervention and the policies that the government should prioritise for an effective anti-trafficking response?

4. Target regions

The baseline assessment will have to be conducted on 3-4 selected regions particularly prone to the phenomenon of internal and trans-national trafficking of both Mongolian and non-Mongolian nationals. The rationale behind the selection of the designated target regions will have to be clearly justified in the submitted proposal.

5. Methodology

The baseline assessment will have to be based on a sound qualitative approach including semi-structured interviews, questionnaires and focus group discussions with key informants and adults who have experienced human trafficking. Upon coordination with IOM, workshops on vulnerability, resilience and good practice in relation to the IOM Determinants of Vulnerability factors may be facilitated to complement the collection of the data.¹⁶⁰

The qualitative approach will have to be substantivized by available quantitative data from official trafficking and migration databases and from other data held by accredited sources and research institutions.

¹⁶⁰ The costs for these workshops will have to be borne by the selected research team and will have to be clearly indicated in the Budget section of the proposal.

Хавсралт 2. Тоон судалгааны хэрэглэгдэхүүн

ЗОРИЛТОТ ИРГЭДИЙГ ТОДОРХОЙЛОХ ХУУДАС

Хаягийн хэсэг		
A1. Судлаачийн дугаар: _____	A2. Асуулгын дугаар: _____	
A3. Оролцогчийн нэр, нас: НЭР _____	A4. Хүйс: 1. Эрэгтэй 2. Эмэгтэй 3. Бусад/Тодорхойгүй	
A5. Өрхийн хаяг: 	A6. Утасны дугаар: Өөрийн дугаар 1: Холбогдох хүний дугаар 2:	
A7. Ярилцлага авсан огноо (он/ сар/ өдөр): 2020 / ____ / ____	A8. Ярилцлага эхэлсэн цаг:	ЦАГ : МИНУТ ____ : ____

Та дараах асуултуудад өөрийн хөдөлмөр эрхэлж байсан өнгөрсөн хугацааны туршлагадаа үндэслэн хариулна уу.

1.	Та хэн нэгний зүгээс санал болгосон ажлыг эрхэлж байсан уу?	1. Тийм (Уг асуултыг үнэлгээнд оруулж тооцохгүй) 2. Үгүй
2.	Таныг ямар нэгэн ажлыг хийлгэхийн тулд хэн нэгэн ятгаж, нөлөөлж байсан уу?	1. Тийм (тооцох) 2. Үгүй
3.	Та ямар нэгэн гэрээ хийлгүйгээр хөдөлмөр эрхэлж байсан уу?	1. Тийм (тооцох) 2. Үгүй
4.	Танд гэрээ, хэлэлцээрээр тохирсон ажлын хөлсөө олгохгүй байх, шалтгаангүйгээр бууруулах тохиолдол гарч байсан уу?	1. Тийм (тооцох) 2. Үгүй
5.	Ажил олгогч таны бичиг баримтыг хурааж авах, барьцаалах тохиолдол гарч байсан уу?	3. Тийм (тооцох) 4. Үгүй
6.	Ажил олгогч анх тохирсноосоо өөр ажил хийхийг шаардаж, шахаж байсан уу?	1. Тийм (тооцох) 2. Үгүй

7.	Таны эрхэлж буй болон эрхэлж байсан ажилтай холбоотой дараах тохиолдлууд тулгарч байсан уу?	#	Тийм	Үгүй	
		1	Хуурч мэхэлсэн үү?	1	2
		2	Дарамталж, айлган сүрдүүлсэн үү?	1	2
		3	Хүч хэрэглэх, хэрэглэхээр заналхийлсэн үү?	1	2
		4	Хорьж цагдаж, хянаж байна уу?	1	2
8.	Та ажил олгогч эсвэл ажил санал болгосон хүндээ өртэй байсан уу?	1. Тийм (тооцох) 2. Үгүй			
9.	Та ажиллаж амьдарч буй орчноосоо өөрийн дураар чөлөөтэй гарч орох боломжтой байсан уу?	1. Тийм 2. Үгүй (тооцох)			
10.	Нэмэгдэл хөлс төлөхгүйгээр таныг илүү цагаар ажиллуулж байсан уу?	1. Тийм (тооцох) 2. Үгүй			
11.	Танд хэн нэгний зүгээс өөр орон нутагт эсвэл гадаадад ямар нэгэн ажиллах санал тавьж байсан уу?	1. Тийм (тооцох) 2. Үгүй			
12.	Танд хэн нэгэн дараах болзлыг тавьбал зөвшөөрөх үү?	#	Тийм	Үгүй	
		1	Өндөр цалинтай ажилд зуучлах	1	2
		2	Тодорхой хөлсөөр гадаад улс оронд зорчих виз гаргаж өгөх	1	2
		3	Гадаад улс оронд явах зардлыг зуучлалын байгууллага даан, дараа нь ажиллаж төлөх хувилбар санал болгох	1	2
		4	Тодорхой төлбөртэй эд эрхтэний донор болох	1	2
		5	Гадаад хүнтэй гэр бүл болоход зуучлах	1	2
13.	Та өөрийн гэр бүлд тохирох шинжийг сонгоно уу?	#	Тийм	Үгүй	
		1	Шилжин суурьшсан, албан ёсны бүртгэлгүй	1	2
		2	Өрх толгойлсон эсвэл олон хүүхэдтэй	1	2
		3	Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой	1	2
		4	Хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй	1	2
		5	Их хэмжээний өр зээлтэй	1	2
		6	Архи, мансууруулах бодисны хамааралтай	1	2
		7	Гэр бүлийн хүчирхийлэлтэй	1	2

ХХГХ-т өртөх эрсдэл бүхий иргэнийг таних шалгуур:

1. Сааралтуулсан асуултуудын аль нэгт нь "Тооцох" гэсэн тэмдэглэгээтэй хариултыг сонгосон бол
2. Цагаан хэсгийн асуултуудын 3-аас дээшихид нь "Тооцох" гэсэн тэмдэглэгээтэй хариултыг сонгосон бол тухайн оролцогчийг ХХГХ-т өртөх эрсдэлтэй гэж үзэж хоёрдугаар шатны судалгааг эхлүүлнэ.

ИРГЭДИЙН ЭМЗЭГ БАЙДАЛД НӨЛӨӨЛЖ БУЙ ХҮЧИН ЗҮЙЛСИЙГ ТОДРУУЛАХ АСУУЛГА

Судалгааны зорилго:

